



Legum servi esse debemus, ut Liberi esse possimus

ХУУЛЬ ҮЙН ЭРГЭМ ШИНЖЛЭГЭЭ, СУДАЛГАА, ОНОЛ, ПРАКТИКИЙН СӨГҮҮЛ

ХУУЛЬ дээдлэх ЁС

- Үндсэн хуулийг тайлбарлах цорын ганц субъект цэц мөн үү?
- Монгол Улсын хууль тогтоох байгууллагын түүхэн хөгжил
- Ашиг сонирхлын зөрчилд өртсөн төрийн албан хаагчид хүлээлгэх хариуцлагын асуудал
- Спортын эрх зүй: Төрийн алба ба спорт
- Эрүүгийн хэрэг үүсгэх шатанд байцаан шийтгэх зарим ажиллагааг хэрэгжүүлэх нь
- Шүүх хуралдааны аюулгүй байдал ба шүүх хуралдааныг нээлттэй явуулах хууль зүйн харилцан хамаарлын зарим асуудал
- Хүний эрхийг хангах шүүх эрх мэдлийн зарим асуудал
- Үндсэн хуульт ёсны төлөвшилтөд ердийн болон дагнасан шүүхийн оролцоо
- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг боловсронгуй болгох зарим асуудал
- Сонгинохайрхан дүүргийн прокурорын газрын түүхэн товчоон
- Иргэний эрх зүй дэх эд хөрөнгийн хязгаарлагдмал эрх, түүний эрх зүйн зохицуулалтын зарим асуудал
- Эрх зүй ба аж ахуйн нэгжийн үүсэл хөгжил
- Гэр бүл ба хөрөнгө
- Хамтран амьдрагчийн эрх зүйн зохицуулалтын асуудал
- Хэвлэл мэдээллийн эрх чөлөө
- Цэвэр абстракт хяналт ба Монгол Улсын Үндсэн хуулийн хяналтын систем харьцуулсан судалгаа
- Төр, түүний өмчийн дархан эрхийн онол. Албадлагын арга хэмжээ авагдахаас ангид байх улсын дархан эрх
- Монгол Улсад цаазаар авах ялыг халах уу, аль эсвэл...
- Хууль бусаар Монгол Улсын хил нэвтрэх гэмт хэргийн шалтгаан, нөхцөл
- ШШҮХ-ийн Шүүх-ДНХ шинжилгээний зарим үр дүнгээс
- Орон нутаг дахь "Эрх зүйн туслалцааны төв"-ийн одоо ба ирээдүй
- Хууль зүйн англи нэр томъёо

Сэтгүүлийн зөвлөл

Сонин, сэтгүүлийн зөвлөлийн дарга

Академич Ж.Амарсанаа

Гишүүд:

Л.Баасан

Хууль зүйн шинжлэх ухааны доктор,

"Отгонтэнгэр" Их сургуулийн эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал

Г.Банзрагч

Хууль зүйн доктор

Ц.Батцэрэн

Нийслэлийн шүүхийн шүүгч

Ж.Бямбаа

Хууль зүйн доктор,

Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн Эрүүгийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч

Л.Бямбаа

Хууль зүйн доктор, Улсын дээд шүүхийн шүүгч

Н.Гантулга

Хууль зүйн доктор, Цагдаагийн академийн дэд захирал

Д.Даваа-Очир

Хууль зүйн доктор,

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэд дарга бөгөөд Тогтоол гүйцэтгэх газрын дарга, хурандаа

И.Дашням

Хууль зүйн шинжлэх ухааны доктор

Д.Зүмбэрэллхам

Хууль зүйн доктор, Төрийн албаны зөвлөлийн дарга

Т.Мэндсайхан

Хууль зүйн доктор,

Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн Олон улсын эрх зүйн тэнхимийн эрхлэгч

Ц.Сарантуяа

Хууль зүйн шинжлэх ухаан доктор, Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш

С.Сүхбаатар

Хууль зүйн доктор, дэд профессор,

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хууль зүйн сургалтын төвийн эрхлэгч

Б.Цэрэнбалтав

Улсын ерөнхий прокурорын орлогч

С.Цэрэндорж

Хууль зүйн доктор

Б.Чимид

Монгол Улсын Ардын багш, гавьяат хуульч, хууль зүйн доктор, профессор

Ч.Энхбаатар

Хууль зүйн шинжлэх ухааны доктор,

Удирдлагын академийн Ерөнхий эрдмийн тэнхимийн эрхлэгч

Дугаарыг эрхэлсэн:

С.Алтантуяа

Сэтгүүлийн хариуцлагатай нарийн бичгийн дарга

Эрхлэн гаргагч:



Хууль зүйн үндэсний хүрээлэн

Редакцийн хаяг:

Улаанбаатар-46, Чингэлтэй дүүрэг,
Сүхбаатарын талбай-7

Утас: 315736, 99083007 Факс: 315736

Вэб сайт: www.legalcenter.mn

И-мэйл хаяг: altantuyas_9@yahoo.com

Улсын бүртгэлийн дугаар: 279

ЭНЭ ДУГААРТ:



Хууль зүйн албаны 100 жилийн ойд

Монгол Оросын 1912 оны найрамдлын гэрээ
/ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн, Түүхийн шинжлэх
ухааны доктор, профессор **О.Батсайхан**/.....3-12



Төрийн байгуулалтын хууль тогтоомж

Үндсэн хуулийг тайлбарлах цорын ганц субъект цэц мөн
үү?
/МУИС-ийн Хууль зүйн сургуулийн оюутан **О.Мөнхцэцэг**/.....13-16

Монгол Улсын хууль тогтоох байгууллагын түүхэн
хөгжил
/ШУА-ийн Философи, социологи, эрх зүйн хүрээлэнгийн
"Хууль зүйн судалгааны төв"-ийн эрдэм шинжилгээний
ажилтан **Б.Батбаяр**/.....17-27

Ашиг сонирхлын зөрчилд өртсөн төрийн албан хаагчид
хүлээлгэх хариуцлагын асуудал
/Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газрын Албаны
дарга, Хууль зүйн доктор, профессор **Л.Батжав**/.....28

Спортын эрх зүй: Төрийн алба ба спорт
/Хууль зүйн магистр, Самбо бөхийн олон улсын хэмжээний
мастер **Г.Баттулга**/.....29-31



Шүүх эрх мэдэл

Эрүүгийн хэрэг үүсгэх шатанд байцаан шийтгэх зарим
ажиллагааг хэрэгжүүлэх нь
/НЦГ-ын Гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн хэргийн газрын
үзлэгийн чиглэлийн ахлах мэргэжилтэн, Цагдаагийн дэд
хурандаа **Б.Жаргалсайхан**/.....32-36

Шүүх хуралдааны аюулгүй байдал ба шүүх
хуралдааныг нээлттэй явуулах хууль зүйн харилцан
хамаарлын зарим асуудал
/Цагдаагийн Академийн Иргэний эрх зүйн тэнхимийн багш
Б.Даваажав/.....37-40

Хүний эрхийг хангах шүүх эрх мэдлийн зарим асуудал
/МУИС-ийн Хууль зүйн сургуулийн оюутан **М.Мөнхжаргал**/.....41-45

Үндсэн хуульд ёсны төлөвшилтөд ердийн болон
дагнасан шүүхийн оролцоо
/МУИС-ийн Хууль зүйн сургуулийн оюутан **П.Баттулга**/.....46-49

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг
боловсронгиу болгох зарим асуудал
/МУИС-ийн Хууль зүйн сургуулийн ахлах багш, докторант
Д.Хуяг/.....50-53



Прокурорын хяналт

Монгол Улсын Прокурорын байгууллагын 80 жилийн
ойд
Сонгинохайрхан дүүргийн прокурорын газрын түүхэн
товчоо.....54-55



Иргэний хууль тогтоомж

Монгол Улсад Прокурорын байгууллага байгуулагдсаны түүхт
80 жилийн ойд 2010 онд тэмдэглэнэ

Иргэний эрх зүй дэх эд хөрөнгийн хязгаарлагдмал
эрх, түүний эрх зүйн зохицуулалтын зарим асуудал
/ОТИС-ийн Хууль зүйн сургуулийн Иргэн, бизнесийн эрх
зүйн тэнхимийн багш **Г.Жаргал**/.....56-62

Эрх зүй ба аж ахуйн нэгжийн үүсэл хөгжил
/Harvard Law Review" сэтгүүлээс орчуулсан Хууль зүйн
үндэсний хүрээлэнгийн Иргэн, эдийн засгийн эрх зүйн
секторын эрдэм шинжилгээний ажилтан **Ц.Одмаа**/.....63-66

Гэр бүл ба хөрөнгө
/Цагдаагийн Академийн Иргэний эрх зүйн тэнхимийн
багш **О.Отгонтуяа**/.....67-71

Хамтран амьдрагчийн эрх зүйн зохицуулалтын
асуудал
/МУБИС-ийн Түүх, нийгмийн ухааны сургуулийн
Философи, дидактикийн тэнхимийн эрх зүйн тэнхимийн
багш **Э.Чулуунцэцэг**/.....72-74

Хэвлэл мэдээллийн эрх чөлөө
/Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Иргэн, эдийн засгийн
эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ажилтан
Б.Солонго/.....75-78



Олон улсын эрх зүй, харьцуулсан эрх зүй

Цэвэр абстракт хяналт ба Монгол Улсын Үндсэн
хуулийн хяналтын систем: харьцуулсан судалгаа
/Японы хүүхдийг ивээх сангийн ажилтан, судлаач
Н.Энхцэцэг/.....79-82

Төр, түүний өмчийн дархан эрхийн онол: Албадлагын
арга хэмжээ авагдахаас ангид байх улсын дархан эрх
/МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Олон улсын эрх зүйн
багш **Б.Тамир**/.....83-87



Криминологи

Монгол Улсад цаазаар авах ялыг халах уу, аль эсвэл...
/Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрүүгийн эрх зүй,
криминологийн судалгааны секторын эрдэм
шинжилгээний ажилтан **Г.Оюунболд**, Хууль зүйн
үндэсний хүрээлэнгийн Захиргаа, хүмүүнлэгийн эрх зүйн
секторын эрдэм шинжилгээний ажилтан, магистр
А.Түвшинтулга/.....88-91

Хууль бусаар Монгол Улсын хил нэвтрэх гэмт хэргийн
шалтгаан, нөхцөл
/Тагнуулын Ерөнхий газрын Дорнод аймаг дахь газрын
дарга, хурандаа, докторант **Ц.Доржням**/.....92-94

ШШХХ-ийн Шүүх-ДНХ шинжилгээний зарим үр дүнгээс
/Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн
лабораторийн тасгийн дарга, биологийн ухааны доктор
С.Ганболд, магистрант **Р.Баярмаа**/.....95-97



Эрх зүйн үйлчилгээ

Орон нутаг дахь "Эрх зүйн туслалцааны төв"-ийн одоо
ба ирээдүй
/Сэлэнгэ аймгийн ЗДТГ-ын Хууль зүйн хэлтсийн Эрх зүйн
сургалт, сурталчилгаа хариуцсан ахлах мэргэжилтэн,
магистр **Д.Ёндонжамц**/.....98-100



Нэр томъёо

Хууль зүйн англи нэр томъёо.....101-102

CONTENT:



The 100th anniversary or the Justice sector

1911 Peace Treaty between Mongolia and Russia /O.Batsaikhan, Ph.D, Institute of International Studies, The Mongolian Academy of Sciences/.....	3-12
--	------



Legislation on state structure

Is Constitutional Tssets the Sole Subject to Interpret the Constitution /O.Munkhtsetseg, Student of School of Law, National University of Mongolia/.....	13-16
---	-------

Historical Development of Legislative Body Of Mongolia /B.Batbayar, Researcher of "Legal Research Center", Institute of Philosophi, Sociology and Law, The Mongolian Academy of Sciences/.....	17-27
---	-------

The Issues of Liability of Public Servants in case of Conflict of Interests /L.Batjav, Ph.D, Head of Division, Office of the President of Mongolia/.....	28
---	----

Sports Law: Public Service and Sport /G.Battulga, LLM, International Master of Sport in Sambo/	29-31
--	-------



Judicial power

Implementation of Certain Procedural Measures at the Stage of Initiating a Criminal Case /B.Jargalsaikhan, The Lieutenant colonel of police, The Senior specialist of Metropolitan Police Department/	32-36
---	-------

Some Aspects of the Interdependence between Security of Court Hearing and Public Trials /B.Davaajaw, Lecturer of Civil Law Department, Police Academy/.....	37-40
--	-------

Some Issues Relating to Implementation of Human Rights by the Judiciary /M.Munkhjargal, Student of School of Law, National University of Mongolia/.....	41-45
--	-------

The Role of Specialized and Ordinary Courts in Development of Constitutionalism /P.Battulga, Student of School of Law, National University of Mongolia/.....	46-49
---	-------

Some Issues on Improving the Law on Civil Procedure /D.Huyag, Ph.D candidate, Senior lecturer of School of Law, National University of Mongolia/.....	50-53
---	-------



Prosecutors supervision

On The Occasion of the 80th anniversary of Mongolian Prosecutor's Office' Brief History of the Prosecutor's Office of Songinokhairkhan District.....	54-55
---	-------



Civil legislation

Legal Regulation of Limited Proprietary Rights in Private Law /G.Jargal, Lecturer of Civil and Business Law Department, Otgontenger University/.....	56-62
---	-------

Law and the Rise of the Firm /Translated by Ts.Odmaa, Researcher of Civil and Economic Law Sector, National Legal Institute/.....	63-66
---	-------

Family and Asset /O.Otgontuya, Lecturer of Civil Law Department, Police Academy/.....	67-71
---	-------

Legal Regulation of Cohabitation /E.Chuluuntsetseg, Lecturer of Philosophi and Didactic Department, School of History and Social Science, Mongolian State University of Education/.....	72-74
--	-------

Freedom of The Press /B.Solongo, Researcher of Civil and Economic Law Sector, National Legal Institute/.....	75-78
--	-------



International law and comparative law

Pure Abstract Judicial Review and Constitutional Review in Mongolia and Comparative Study /N.Enkhtsetseg, Staff member of Save The Children Fund Japan/.....	79-82
---	-------

Theory of Immunity of States and Their Property: The State Immunity from Compulsory Measure /B.Tamir, Lecturer of International Law Department, School of Law, National University of Mongolia/.....	83-87
---	-------



Criminology

Should Mongolia Abolish a Death Penalty or not... /G.Oyunbold, Ph.D candidate, Researcher of Criminal law and Criminology Research sector, National Legal Institute, A.Tuvshintulga, LLM, Researcher of Administrative and Humanitarian Law Sector, National Legal Institute/.....	88-91
---	-------

Causes of Crimes Involving an Illegal Entry into Mongolia /Ts.Dorjnyam, Ph.D, Head of Office in Dornod Aimag, General intelligence Agency/.....	92-94
--	-------

Some Results of Forensic DNA Analysis Done by the National Forensic Investigation Institute /S.Ganbold, Ph.D, Head of laboratory of National Institute of Forensic Investigation, R.Bayarmaa, LLM candidate/	95-97
--	-------



Legal service

"Local Legal Aid Centers": Present and Future /D.Yondonjants, LLM, Senior Specialist of Law Division, Governor's Office of Selenge aimag/.....	98-100
--	--------



Law term

Legal Terms in English.....	101-102
-----------------------------	---------

МОНГОЛ ОРОСЫН 1912 ОНЫ НАЙРАМДЛЫН ГЭРЭЭ¹

Зорилго

1912 оны 11 дүгээр сарын 3-нд байгуулсан Монгол Оросын Найрамдлын гэрээний чухам үнэн байдлыг тодруулж, уг гэрээний учир холбогдол, Монголын түүхэнд оруулсан түүхэн үүргийг үнэлж, дүгнэлт өгөхөд энэхүү өгүүллийн зорилго оршино.

Оршил болгох нь

1911 оны зун цаг Халхын Жавзандамба хутагт ба дөрвөн хаадаас бүх монгол үндэстэн нь манж хятадын дарлал дор тэсэшгүй болсон учрыг гаргаж, тусгаар улс байгуулахад тусламжийг гуйж Орос улсын хаанд бичиг өргөжээ. Энэхүү бичигт: Шашныг мандуулах амьтныг жаргуулагч Жавзандамба лам, Халхын Түшээт хан Дашням, Сэцэн хан Навааннэрэн, Засагтхан Содномравдан, Сайн ноён Намнансүрэн нар хичээнгүйлэн Их Орос улсын их цагаан хааны амгаланг эрж: «ойрноос нааш хятад түшмэд эрх барьж улсын хэргийг элдвээр самууруулахын дотор ялангуяа шинэ засгийн дүрэм хэмээн нэрийдэж завшаан дор монгол газрыг ашиг тариа хэмээх зэргээр эзлэн хуучин хэв суртлыг халж эрх хүчийг бууруулан бүрэлгэх нь үнэхээр гашуун» хэмээн тэмдэглэж: «Их Орос улс дор шүтэж бага улсын ёсоор харилцан туслалцваас бидний хуучин хэв суртал алдагдах үгүй» хэмээгээд «агуу өршөөлөөр нигүүлсэн үзэж даруйхнаа хамгаалан туслыхыг их ганд бороог хүсэх мэт сүсэглэн гуйж» бичиг өргөн тусгайлан жанжин чин ван Ханддорж, да лам Цэрэнчимэд түшмэл Хайсан нарыг элч төлөөлөгчөөр зарж явуулсан хэмээн дурьджээ.²



*ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн, Түүхийн шинжлэх ухааны доктор, профессор
О.Батсайхан*

Орос улсын эзэн хаанд өргөсөн энэхүү айлтгал бичгээс гадна манж, хятад түшмэд «эрт эдүгээ дор олон монголыг хилс бэрхээр дарлан зовоож хашруулан бүхий учрыг эдүгээ бидний мэдсэн амссан төдийгээс товчлон гаргаж мэдүүлэх нь» хэмээсэн 21 зүйл тайлбар буюу санамж бичгийг Хаант Оросын Гадаад явдлын яамнаа илгээсэн байна. Энэхүү тайлбар 21 зүйлийн дотор Монголын дотоод байдал, гадаад нөхцөлийн талаар нэлээд бодитой үндэслэлтэйгээр дүрсэлсэн байх бөгөөд ирээдүйд Оросын эзэнт улсад үзүүлж болох хөнгөлөлт дэмжлэгийн талаар хүртэл дурьдсан байна. Өөрөөр хэлбэл Орос улсыг түшихэд манай монголчуудад ашигтай байхаас гадна Оросын ашиг сонирхолд нийцэх боломжтой болохыг учирлан тайлбарласан юм. Эл бичгийн нэгдүгээр зүйлд: «Манай монгол хан вангуудаас дараалан засаг ба засаг бус олон түшмэд хэргэм тушаал залгамжлах зэрэг

жинхэнэ хууль ёсоор явуулбаас зохих хэрэг зүйлд хятад түшмэд ямагт өчнөөн түмэн мянган лан мөнгө албадан хяхан авч сая айлтгаж залгамжлуулах болсон бөгөөд хэрэв мөнгө зоос үлэмж хараахан тушааж чадахгүйг нь боогдуулан хойшлуулсаар энэ хэр зэргэ залгамжлан чадаагүй өчнөөн төчнөөн жилээр хүлээсэн засаг ба засаг бус ихээхэн бага түшмэд маш олон» гэж мэдүүлжээ.

Мөн гуравдугаар зүйлд, «Иргэн Монгол харилцан холбогдсон хэрэг зүйл байхул чухам алины үнэн ташааг магадлахгүй ямагт монголыг дарлан мушгиж, эд юмыг аван хилс гүжир ял оноон алах цөлөх зэргээр шийтгэх нь нэн олон болж» манж хятадын дураар аашлах нь хэрээс хэтэрснийг тоочин хэлжээ.

Эл бичгийн дөрвөөс ёсдүгээр зүйлүүдэд «монгол газар олон иргэний элсэн хуруулж, муж байгуулан олон хятад түшмэдээр эрхийг бариулан Монголын олон засгуудын эрх хүчийг бууруулан хасаж» монголчуудын «эрхэмлэх шарын шашины үндэс охь манлайн баруун зуугийн зальхай хэдэн түшмэд эзлэн завшиж», манжийн төрийн шинэ засгийн бодлого явуулахдаа Монголын шарын шашины сүр хүчийг бууруулж, шүтээн хахилгыг нь сүйтгэж «манай шарын шашинг үнэхээр үнэ үгүй хөнгөн болгож» эхэлсэн нь монголын ноёд нам нар төдийгүй жирийн сүсэгтэн олны дургүйцэлийг хүргэсэн байна. Ийхүү 21 зүйл бичгийн эхний хэсэгт монголчуудын аж амьдрал доройтож, «монгол иргэн харилцан ураг барилдах ёсонгүй бөгөөтөл одоо шинэ засгаар шалтгаалж

¹ Монгол Оросын хооронд дипломат харилцаа тогтоосны ойд зориулан Гадаад хэргийн яам, ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгээс зохион байгуулсан олон улсын эрдэм шинжилгээний хуралд тавьсан илтгэл. 2006 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр.

² Л.Дэндэв Автономит Монгол Улсын үеийн онцлог баримт бичгүүд. УБ., 1945 он. Түүхийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан. 89-90 дэх тал.

хуучин хуулийг халах» зэргээр үндэсний зан заншил алдагдахад хүрэх аюул бодитойгоор тулж ирснийг тайлбарлан, монголын нийгэм бүхэлдээ хөдөлгөөнд орсныг тэмдэглэсэн байна.

Орос Монголын хил залгаа орших газарт «хятадаар тариа тариулж завдмагц харуулын монгол цэргийг татаж хятад цэрэг суулгаваас орос монгол харилцан найралдаж чадахгүй болно хэмээн зөвлөж буй» төдийгүй «Хөлөн буйрын захын арван илүү харуулын монгол цэргийг татаад хятад цэрэг суулгасаар хэдэн жил болсон» нь манай орос монгол хоёрын харилцан туслалцах явдлыг таслая хэмээсэн маш хортой санаа мөн хэмээн тэмдэглэжээ.

Мөн бичгийн 11 дүгээр зүйлд «Манай монгол манж улсад газар орсоноос хойш олон зальхай иргэд наймаа худалдааны учир өөрсдийн юмьг онц их үнээр худалдан өгөх бөгөөд манай монголын мал юмьг боогдуулан хялбар үнэ дор авах ба мөнгө зээлдүүлээс хүүгээс хүү үржүүлж авсаар манай монголыг нэгэнт яс чөмгөнд хүртэл ядруулсан бөгөөт одоо шинэ засаг хэмээн нэрийдэж олон зүйлийн юмьас цөм гааль татвар хурааж улмаар мөлжин элдэв зүйлээр үрэгдүүлэн бүхий нь манай монголын хүчин яахин тэсэх билээ» хэмээн манж хятадын талхидал Монголд юу үлдээснийг үнэн мөнөөр нь дүрслэн харуулжээ. Иймээс монгол үндэстэн өөрийн эрх чөлөө тусгаар тогтнолын төлөө тэмцэлд нийтээрээ эрслэн босох болсныг тэмдэглэжээ.

Цаашид манж хятадын дарлалыг тэвчихүйеэ бэрх болсоноос үүдэж монголын ноёд, засгуудын бодол санаа уул улсаа сэргээн мандуулах талаар нэгдэн улмаар «Богд лам эхлэн дөрвөн хан олон ноёдын зөвөлгөөнийг» хийлгэсэн талаар мэдээлж, энэ

талаар «манж хятадын этгээд сонсож мэдсэн нь магад буй за» гэж манж хятадын зүгээс хараа хяналттай тулгарч байгаагаа дурссан байна.

Монгол нийтээр тусгаар улс болохоор шийдвэрлэсэн тухай өгүүлэхдээ: «Манай олон хан ван засгууд олноор санаа нийлж монгол бүхний оройн чимэг Богдыг хаанд өргөмжилж Монгол Улс болон Их улс дор түшиглэн ач тусыг шүтэж ашиг зовлонг хамтатган үүрд найртай сайнаар явахыг хүссэн билээ» гээд боломжоор Их улс «дээрээс нигүүлсэн толилж» туслах ажаам уу хэмээн санамж бичгийн 15 дугаар зүйлд тэмдэглэжээ.

Монгол Орос хоёр ойрын ирээдүйд Нууц болзоорны гэрээ өгүүлж байхад болох бөгөөс тэр гэрээнд монголын газар яахин Оросын худалдаа гүйлгээ, төмөр зам хийх өртөө байгуулах, алт мөнгө зoorь нээлгэх, бичиг цэргийн сургууль байгуулах зэрэг зүйлийг нарийвчлан хэлэлцэж тогтоож болох тухай ч бас энэхүү санамжид өгүүлжээ. Монголын тал орос худалдааг монгол газар өрнүүлэхэд урьдаас бэлтгэн авбаас болох болбу гэх зэргээр өгүүлсэн байна.³

Монголчууд 1911 онд тусгаар тогтнолоо тунхаглан зарласан нь

Түр Засгийн газраас Монголын төр засгийг төвхнүүлэх ажлын хүрээнд Богд гэсэн Жавзандамбыг залж суулгах их ёслол хийх өдрийг бүх Монгол даяар зарласнаас гадна Хүрээнд суугаа Орос улсын консулд албан ёсоор мэдэгджээ. 1911 оны өвлийн тэргүүн сард Түр засгийн газраас Их Орос улсын ерөнхий консулд явуулсан бичигт: «энэ жил зуны цаг, манай Халхын дөрвөн аймгийн хан ван, гүн, олон засгууд шарын шашныг өрнөөн дэлгэрүүлэх ба улс төрөө бататгахыг бүгдээр

санаа нийлж, зөвлөлдөн Богд гэгээнийг Монгол Улсын хаанд өргөмжилж эрдэнийн сууринд залж ёслол мөргөж, их төрийн ёслолыг гүйцэтгэх өдрийг энэ цагаачин гахай жилийн өвлийн дунд сарын шинийн 9-ний өдрийн барс цагт тогтоосон учрыг Оросын эзэн хааны засгийн газарт уламжилна уу» хэмээжээ.⁴

Эрдэнэ ван Ханддорж, Да лам Цэрэнчимэд, Гүн Хайсан нар Орос улсын нийслэл Петербург хотод хүрч, Орос улсын Засгийн газарт өөрсдийн зорьж ирсэн тусгаар улс төрийг байгуулан тогтоох явдлыг зөвшөөрөн хүлээж, батлан хамгаалах тусламж үзүүлэхийг гуйсан хэргээ танилцуулан, тусламж эржээ.⁵ Орос улс уг хэргийг зөвшөөрөн хүлээж, даруй батлан хамгаалж, туслах явдлыг илэрхийлсэн байна.

Монголчууд сайн өдрийг сонгон хүлээж, Монголын төрөө тунхаглан зарлахад хэн хүнгүй бэлдэгцээсэн байна. Холынхоос нь хэмээвэл, «Халхын өмнө, умар хязгаарын ойр зэрэгцэн суусан Дарьганга, Хөвсгөл нуурын Урианхайн бүгдийн дарга Сономдовдон, Хишигжаргал нараас тус тусын Богдын дундэн зарлигийг чин үнэнхүүгээр итгэн биширч соёлд батгахыг харьяа ардуудаа зарлаад өршөөлийн дотор агуулах явдлыг хичээнгүйлэн гуйсугай»⁶ хэмээсэн бичгийг Хүрээний хэргийг шийтгэх газарт ирүүлсэн байв.

Халхын дөрвөн аймгийн хан, чуулганы дарга, жанжин, дэд чуулганы дарга, хэбэй, олон засаг ван, гүн, хутагт, хувилгаад, тайж түшмэд ардуудын төлөөлөгчид Хүрээнд цугларан «Монголын төрийн орд, Дотоод, Гадаад, Цэрэг, Сан, Шүүх таваан яамны байгуулалтыг урьдаар засацгаан бэлтгэхэд төв гэрүүдийг цөм монгол гэр үйлдэн»⁷ бэлджээ.

¹ Мөн тэнд, 97 дахь тал.

² Үндэсний төв архив, ф.4, д.1, х.н.136.

³ Л.Дэндэв. Автономит Монгол Улсын үеийн онцлог баримт бичгүүд. УБ., 2003 он. Эмхтгэсэн О.Батсайхан.

⁴ Н.Магсаржав. Монгол Улсын шинэ түүх. УБ., Сүхбаатар хэвлэх үйлдвэр. 1994 он. 12 дахь тал.

⁵ Н.Магсаржав. Монгол Улсын шинэ түүх. УБ., Сүхбаатар хэвлэх үйлдвэр. 1994 он. 12 дахь тал.

Ийнхүү товлосон ёсоор Монголын цагагчин гахай жилийн өвлийн дунд сарын шинийн есөн бөгөөд европ тооллын 1911 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн 11 цагт Монгол Улсын хаан ширээнд Богд Жавзандамба хутагтыг өргөмжилснөөр төрийн их ёслол эхэлж байжээ. Мөн шавь охин эрдэнэ сэцэн Цагаан Дара Дондогдуламыг улсын эхэд өргөмжилсэн байна.⁸

Энэ бол Монгол Улс Манжаас салж тусгаар улс болсноо тунхаглан зарласаны илэрхийлэл байлаа.

Найрамдлын гэрээ байгуулахын өмнөхөн үе

Дөнгөж тусгаар тогтносон Автономит Монголд өөрийн хувь заяаг Орос оронтой холбох үндэслэл байсан бол Орос орон ч гэсэн Монголыг гойд сонирхох хангалттай үндэслэл байсан юм хэмээн И.Майский 1921 онд бичжээ.

Тухайлбал, Монгол орон Орост юугаар хэрэгтэй байсан талаар хоёр зүйлийг хэлж болох юм. Нэгдүгээрт, эдийн засгийн хувьд Монгол орон мал болон мал аж ахуйн түүхий эд Оросын зах зээлд нийлүүлэгч байхаас гадна уул уурхай, байгалийн баялгийн эх сурвалж болж байсан юм. Хоёрдугаарт, Монгол орон Оросын хувьд улс төрийн онцгой ач холбогдолтой байсан. Хятад энэ үед дотооддоо хагаралтай байж, европийн соёлд дасан зохицох гэж зовж байсан билээ. Дээр дурьдсан зүйлүүдэд үндэслэн Орос улсаас Монголын талаар баримтлах ерөнхий чиг шугамыг харж болох бөгөөд тэр нь Орос орны хувьд Монголын төрийн тусгаар тогтнолыг гадархай хэмжээгээр хадгалах нь онцгой чухал байсан. Монгол орныг буфер маягаар барьж байх сонирхол Оросын төрд байсан хэмээн И.Майский үзэж байжээ.⁹

Хятадын эрхтэнүүд Оросын элчингийн хооронд монголын асуудлаар маргаан болж байх завсар Бээжин дэх Оросын элчингийн дэвшүүлсэн саналыг Оросын Гадаад явдлын яам нааштай хүлээн авч, Орос Халхын хооронд байгуулж болох хэлэлцээрийн төслийг боловсруулан Засгийн газраар хэлэлцэж, эзэн хаан хоёрдугаар Николайд танилцуулахад «Яаравчлах хэрэгтэй» хэмээн тэрээр цохжээ. Эзэн хааны өгсөн зааврын дагуу Оросын Сайд нарын Зөвлөлийн тусгай хуралдаанаар 1912 оны 8 дугаар сарын 2-ны өдөр хэлэлцэж Гадаад явдлын яамны сайдын саналаар Монголын асуудлаар Хятадтай явуулж буй хэлэлцээг тасалж, Хүрээтэй нууц хэлэлцээг эхлэх шийдвэр гаргажээ.¹⁰ Орос улсын Сайд нарын Зөвлөл 1912 оны 8 дугаар сарын 2-ны өдрийн хуралдаанаар Монголтой байгуулах гэрээний асуудлыг «Хүрээний хутагт ба халхын ноёдтой байгуулах гэрээний тухай» гэсэн нэрийн дор авч хэлэлцэн, гаргасан шийдвэртээ «Монголын асуудлаар азнах явдал улам бүр осолтой болсоор» байна гээд энэ байдлаас гарах «сайн арга шийдвэр гэвэл Орос, Халхын хооронд дипломат гэрээ байгуулах явдал мөн» гэж заасан байна. Бэлтгэж байгаа гэрээг Монгол Улстай байгуулах гэрээ хэмээн нэрлэхгүйгээр зөвхөн «Хүрээний хутагт ба халхын ноёдтой байгуулах гэрээ» гэж томъёолохын хамт гэрээгээр Монголын тунхаглан зарласан тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрч бататгах бус тодорхойгүй, бүрхэгдүүхэн «Халхын ёс журам» гэдгийг хадгалан байлгахыг Орос улс амлах, «Дотоод Монгол ба Баргаас Хүрээний засгийн газарт дагаар орох тухай зарлан тунхагласан зарим зүйлийг одоохондоо уг хэлэлцээрийн гадна орхи» зэрэг

үндэслэлийг баримтлах чиглэлийг уг шийдвэрт тусгасан байна.¹¹

Энэхүү шийдвэр нь Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөхөөс зайлсхийсэн боловч гэрээ байгуулах субъект нь «Орос ба Монгол» гэсэн хоёр этгээд байх бөгөөд хэлэлцээнээс гарах баримт бичиг нь олон улсын хууль зүйн хэм хэмжээнд ямар нэгэн байдлаар нийцсэн дипломат гэрээ байх нь магад тул Монголын хувьд олон улсын харилцааны талбарт гарах чухал ач холбогдолтой байх нь эргэлзээгүй хэрэг байлаа.

Энэ нь асуудал Монголын талд ашигтай эргэх нэг шижим болсон юм. Мэдээж Орос улс өөрийн ашиг сонирхлын асуудлыг урьдач болгож байсан хэдий ч монголчуудын хувьд ийм замыг сонгох нь ашигтай байлаа. Үүнийг Монголын төрийн зүтгэлтнүүд сайтар ухаарч байсан юм. Орос улсын төрийн зүтгэлтнүүд, Гадаад яамны сайд Монголтой шууд харилцаж, хоёр орны хооронд хэлэлцээр байгуулах асуудлыг түргэвчилж эхэллээ. Чингэхдээ үүнээс өмнө ч Орос Монголын хооронд шууд харилцаа нэгэнт эхэлсэн байсныг тэмдэглэх нь зүйтэй.

Орос улс Монголтой шууд хэлэлцээр хийхээр нэгэнт шийдсэн тул даруй ажилдаа орж, энэ хэлэлцээг явуулах тусгай төлөөлөгчөөр туршлагатай дипломатч И.Я.Коростовецийг томилсон тухайгаа 1912 оны 8 дугаар сард Монголын Засгийн газарт мэдэгдсэн байна. Монгол Улсын Хаан Богд Жавзандамба, Сайн ноён хан Намнансүрэн тэргүүтэй Засгийн газар хоёр улсын хооронд Найрамдлын гэрээ байгуулах тухай умард хөрсийн саналыг таатай хүлээн авч, эл хэлэлцээрийг явуулахаар тусгай элчин сайд И.Я.Коростовецийг

⁸ О.Батсайхан. Монголын сүүлчийн эзэн хаан. VIII Богд Жавзандамба хутагт. УБ., 2008 он.

⁹ И.Майский. Современная Монголия. Ир., 1921г., с.330-331.

¹⁰ Е.А.Белов. Как возникли тройственные русско-китайско-монгольские переговоры в Кяхте в 1914 г. Китайская традиционная культура и проблемы модернизации. Часть 1. М., 1994, с.176.

¹¹ Международные отношения в эпоху империализма. Документы из архивов царского и временного правительства (1878-1917). М.-Л. 1931, серия 2, т.20, ч.2, с.7.

илгээсэнд Орос улсын хаан эзэнд талархаж буйгаа илэрхийлжээ.¹²

Энэ бол дөнгөж саяхан тусгаар тогтнолоо тунхаглан зарлаад дэлхийн улс орнуудад өөрийн бие даасан байдлаа хадгалах үүднээс дэмжлэг эрээд байсан Монголчуудын хувьд том завшаан болсон юм.

Монголтой гэрээ байгуулах талаар Оросын Засгийн газраас хийсэн дараагийн арга хэмжээ нь Оросын Гадаад явдлын яамнаас 1912 оны 8 дугаар сарын 23-ны өдөр Оросын бүрэн эрх барих төлөөлөгч И.Я.Коростовецад өгсөн заавар байлаа. Тэрхүү зааварын эхэнд: Монголын асуудлаар Орос улс Хятадтай хэлэлцэн тохироход чиглэсэн үйл ажиллагаа "ямар нэгэн мэдэгдэхүйц үр дүнд хүрсэнгүй", энэ нь хятадууд "Монголын тусгаар тогтнолыг хүчээр устгах" зорилгоор "Монголын ноёдын дунд яс хаях", Монголд "цэргийн ангиудыг явуулахаар бэлтгэх" зэрэг үйл ажиллагаатай холбоотой, үүнээс үндэслэн Орос улс Монгол дахь байдал өөрчлөгдсөнийг үл харгалзагч хятадуудтай хэлэлцээ хийж болохгүй боллоо" гэж тэмдэглэжээ.¹³

Цааш нь бичихдээ: Оросын эзэн хааны Засгийн газар Хүрээний Засгийн газартай шууд харилцах замд орж түүнтэй гэрээ байгуулахаар шийдвэрлэлээ гээд Хаант Оросоос Монголд явуулах бодлогыг "манай хязгаартай хил дэрлэх энэ мужид цэргийн хүчтэй улс байгуулахгүй байхыг эрмэлзэх" явдал хэмээн тодорхойлоод "тавьсан зорилгоо хэрэгжүүлэхийн тулд 1. халхад үндэсний эрхийг олгох, 2. тэнд хятадын цэргүүдийг оруулахгүй байх, 3. Халхыг хятадуудаар колончуулахгүй байх гэсэн гурван нөхцөлийг хангахаар

төлөвлөж байна"¹⁴ хэмээн мөн заавартаа дурьдсан байна.

Оросын худалдаа, үйлдвэрийн чиглэлийнхэн улс төрийн сонирхлоос илүү эдийн засгийн ашиг сонирхлоо урьтал болгож, Монголын түүхий эдийг дангаар ноёрхох бодлого агуулж байсан бөгөөд үүний улмаас Засгийн газраасаа Монгол дахь оросуудын худалдааны илүү таатай нөхцөл, онцгой эрхийг хуульчилж өгөхийг шаардаж байсан юм. Энэ нь 1912 оны 10 дугаар сард Монгол Оросын хооронд байгуулсан Найрамдлын хэлэлцээр, 1915 оны Хиагтын гэрээнд тусгалаа олсон гэдгийг тэмдэглэх нь зүйтэй юм.

1911 оны дараах үеийн Монголын байдал

Энэ үеийн Монголын тусгаар тогтнол, бие даасан байдлын асуудал чухам ямар байсныг Оросын монгол судлаач эрдэмтэн В.Л.Котвичийн тодорхойлсноор үзэх аваас, тэрээр, Монголын дотоод болон гадаад нөхцөл байдлыг хэлээд бодитой мэдэрч байсан хэмээн үзэж болох мэт. В.Л.Котвич 1911 оны 12 дугаар сарын 30-ны өдөр А.В.Бурдуковт бичсэн захидалдаа: "Монголчууд өөрийн тусгаар тогтнолоо хадгалж, хамгаалж чадах эсэх талаар хэлэхэд тун хэцүү байна. Бүрэн хэмжээгээр бараг л үгүй болов уу. Хэрэв Орос орон бага зэрэг туслах аваас нэг хэсэг эрх олж авч чадах буй эр. Гэвч Бээжингийн Засгийн газраас бага хэмжээнд ч гэсэн хамаарч байх бололтой, үнэхээр хятадууд монголын дотоод хэрэгт оролцохгүй тохиолдолд шүү"¹⁵ хэмээн бичиж байсан бол 1912 оны зун Монголд ирснийхээ дараа тэрээр: "Улс төрийн өөрчлөлт ард түмний амьдралд өөрчлөлт авчирсангүй. Маш ядуу, хүнд байдалд байна. Өөрийн тусгаар тогтнолоо

тунхагласан боловч тэд харах хандах хүнгүй хүүхдүүд шиг л байна" хэмээн бичсэн байна. Оросын нэрт эрдэмтэн, монгол судлаач Б.Я.Владимирцов 1912 оны 6 дугаар сарын 25-ны өдөр А.В.Бурдуковт бичсэн захидалдаа: Орос орон Монголд юм хийх гээд байгаа мэт боловч үнэн хэрэг дээрээ гадаадын хүчнүүд, түүний дотор Японы эсэргүүцлээс айгаад юу ч хийж чадахгүй байна гээд "Монгол орон Орос оронд, Сибирьт ямар их чухал хэрэгтэй болохыг Орост хэн ч ойлгохгүй байна. Монголын тухай мэддэг хүн ч байхгүй шүү дээ. Монгол чинь Манжуур биш гэдгийг ойлгохгүй. Гэвч сүүлийн үед аажмаар нийгмийн дунд ойлгож эхэлж байх шиг байна" гэжээ.

Үнэн хэрэг дээрээ Оросын Монголын талаар баримталж байсан бодлого 1907, 1910, 1912 оны Орос Японы Алс дорнод дахь нөлөөллийн бүс хуваах тухай нууц хэлэлцээрүүдийн агуулгаар тодорхойлогдож байлаа. 1907 оны 7 дугаар сарын 30-ны өдөр байгуулсан Орос Японы улс төрийн гэрээ нь Алс Дорнод дахь их гүрнүүдийн шинэ харьцааг тусгаж, Манжуур, Солонгос, Монголыг нөлөөнийхээ хүрээнд хуваарилсан энэхүү баримт бичиг нь нээлттэй, нууц хоёр хэсгээс бүрдэж байсан бөгөөд нууц хэсгийн 3 дугаар зүйлд: "Гадаад Монгол дахь Оросын тусгай сонирхлыг хүлээн зөвшөөрөхийн хамт эдгээр сонирхолд харшилж болзошгүй оролдлогоос түдгэлзэх үүрэг авсан" байна.¹⁶ 1910 онд хоёр этгээд уг гэрээгээ дахин баталсан билээ. 1912 оны 6 дугаар сарын 25-нд мөн асуудлаар Орос Япон хоёр улсын байгуулсан гурав дахь нууц гэрээний 2 дугаар зүйлд заахдаа: "Өвөр Монгол нь Бээжингийн уртраг (Гринвичээс зүүн тийш өргөрөг 116°27')-ийн зүүн баруун хоёр хэсэгт хуваагдана. Оросын эзэн хааны

¹² Монголын ард түмний 1911 оны үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэл. Баримт бичгийн дэмтгэл. 1900-1914 он. УБ, 1982 он. 170 дахь тал.

¹³ Сборник дипломатических документов по Монгольскому вопросу. Спб. 1914, с. 1-2.

¹⁴ Сборник дипломатических документов по монгольскому вопросу. Спб., 1914, с. 1.

¹⁵ А.В.Бурдуков. В старой и новой Монголии. М. 1969, с.265.

¹⁶ Э.Д.Гримм. Сборник документов по монгольскому вопросу. Т.169,180.

засгийн газар нь дээр дурьдсан уртрагаас зүүн тийш орших Өвөр Монголын хэсэг дэх Японы тусгай ашиг сонирхлыг зөрчихгүй үүргийг хүлээнэ. Японы эзэн хааны засгийн газар нь дурьдсан уртрагаас баруун тийш оршдог Өвөр Монголын хэсэгт Оросын тусгай ашиг сонирхлыг зөрчихгүй үүргийг хүлээнэ¹⁷ гэсэн байна. 1911 оны 8 дугаар сарын 2-ны өдөр А.А.Нератов В.Н.Коковцевт хандан: "Алс дорно дахины манай бодлогын үндэс нь Японтой байгуулсан хэд хэдэн хэлэлцээр болон Манжуурт бий болсон үйл ажиллагааны нийтлэг нөхцөл байдлаас үүдэлтэй юм. Алс Дорнод дахь энэхүү амгалан тайван, аюулгүй байдлын гол хүчин зүйлийг эрсдэлд оруулах нь болчимгүй хэрэг болох буй за"¹⁸ хэмээн бичсэн байдаг. 1912 оны 3 дугаар сард Орос улс Дундад Иргэн улсын Засгийн газарт мэдтүгэй хэмээх нот бичиг илгээж: Дундад иргэн улс Хар мөрнөөс цэрэг томилж, Монголд оруулбал Орос улс зүгээр харж суухгүй хэмээн мэдэгдэж байжээ.¹⁹ 1912 оны 10 дугаар сард Монголтой Найрамдлын хэлэлцээр байгуулахдаа ч, 1913 оны 10 дугаар сарын 23-нд Орос Хятадын тунхаглалд гарын үсэг зурахдаа ч, 1915 оны Гурван этгээдийн Хиагтын хэлэлцээрийн туршид ч Оросын засгийн газар дээрх байр сууриа тууштай баримталж байв.

Монгол Оросын хооронд Найрамдлын гэрээ байгуулагдсан нь

Харилцан тохирсон ёсоор Оросын бүрэн эрх барих төлөөлөгч И.Я.Коростевх 1912 оны 9 дүгээр сард Нийслэл Хүрээнд хүрэлцэн иржээ. Оросын бүрэн эрх барих төлөөлөгч өөрийн Засгийн газрын шийдвэрийн ёсоор Монгол Улсыг автономит улс болгон хүлээн зөвшөөрүүлэх үндсэн санаа бүхий хэлэлцээрийг

боловсруулсан төсөлтэй ирж, түүнийгээ Монголын төлөөлөгчид гардуулсан байна. Гэрээний төсөлтэй Монголын төлөөлөгчид танилцаад Монгол Улсыг автономит болгох гол санааг үл зөвшөөрч өөрсдийн нэмэлт засварыг оруулсан хариу төслийг санал болгожээ. Монголын төлөөлөгчдийн боловсруулсан хэлэлцээрийн төслийн үндсэн санаа нь: Нэгэнт тунхаглан зарласан Монголын тусгаар тогтнолыг хэвээр хадгалан, түүнийг автономит болгон бууруулахгүй байх, Монгол Улсад Өвөр Монгол, Баргыг оруулах, Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгчийг Оросын нийслэлд суулгах зэрэг байлаа. Хэлэлцээр хоёр талын оруулсан төслийг тойруулан нэлээд маргаантай болж, гол нь хэлэлцээрийн үндсэн санааг өөр өөрсдийн байр сууринаас хадгалах үүднээс нэлээд ширүүн маргаан үүсгэж, заримдаа хэлэлцээ тасарч болох тийм байдалд хүртэл хүрч байжээ. Гэвч хугацаа сунжирч хэлэлцээр тасрах нь монголчуудад ашиггүй байх байсан тул монголын төлөөлөгчид тухайн үед их гүрэнтэй хийж буй чухал хэлэлцээрийн ач холбогдлыг зохих ёсоор тооцон үзэж, Монголын тухайн үеийн дотоод гадаад нөхцөл байдал, энэхүү хэлэлцээрээр олдож болох боломжийг харгалзан цаашид Орос улсад төрийн төлөөлөгчид илгээх, дэлхийн улсуудад хандан дэмжлэг эрэх зэрэг нааштай алхам хийж болох төлөвт найдан зохих буулт хийсэн байна. Оросын төлөөлөгч 4 гэсэн зарим зүйл дээр буулт хийж, «Гадаад Монгол» гэсэн томъёоллоос «гадаад» гэсэн үгийг хасч, өргөн утгаар ойлгож болох «Монголия» гэсэн үгийг орос эхэд, «Монгол Улс» гэсэн томъёоллыг монгол эхэд хэрэглэхийг зөвшөөрч, бас «автономия» гэсэн грек гаралтай франц үгийг монгол эхэд «өөртөө тогтнох», «өөрөө эзэрхэх»-ыг бас журам хэмээн хөрвүүлэхийг үл татгалзахаар болжээ.

Ийнхүү хоёр талаас буулт хийсний

дүнд 1912 оны 11 дүгээр сарын 3-ны өдөр Оросын Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгч И.Я. Коростевх Монголын Ерөнхий сайд сайн ноён хан Намнансүрэн болон түүний Монголын Засгийн газрын 5 сайдтай Нийслэл Хүрээнд Найрамдлын гэрээ байгуулан, шинэ тутам байгуулагдсан Монгол Улс Орос улсын харилцаа ямар байхыг тодорхойлсон юм.

Гэрээний оршилд монголчууд Монголын нутаг дэвсгэрээс хятадын захиргаа ба цэргийг зайлуулсан, Богд Жавзандамба хутагтыг Монголын ард түмний хаанаар өргөмжилсөн, Монгол хятадын урьдын харилцаа нэгэнт тасарсан зэрэг байдал болон Орос, Монгол хоёр улс эртнээс найрамдалтай байсан хийгээд орос монголын хооронд эдийн засаг арилжаа өргөжиж, худалдааны журам тогтоох шаардлага гарсан эзргийг харгалзан гэрээ байгуулж буйг дурьджээ.

Хэлэлцээрийн нэгдүгээр зүйлд: Оросын эзэн хааны Засгийн газар Монгол Улсад «өөрөө тогтнож, өөрөө эзэрхэх»-ыг ёс журмаа хадгалан сахиж, мөн түүнчлэн «өөрийн нутаг дэвсгэрт хятад цэрэг»-ыг ба «нүүдлийн иргэдийг үл оруулан», «өөрийн улсын цэрэг байгуулах» эрхийг эдлэхэд цөм тусална, харин гэрээний монгол эхэд, энд дурьдсан дээр хоёр талын засгийн газрыг харилцан хүлээн зөвшөөрсөн гэсэн санаа туссан байгаа юм. Гэрээний хоёрдугаар зүйлд: Монгол Улсын эзэн хаан ба Монгол Улсын засгийн газар өөрийн эзэмшил газарт Оросын харьяат нар ба Оросын худалдаанд хэлэлцээрт хавсаргасан Протоколд жагсаан заасан онц эрхийг (эрх ба давуу талыг) хуучин ёсоор олгон хэрэгжүүлнэ. Монголд Оросын харьяат нарт олгосноос илүү эрхийг гадаад бусад орны харьяат нарт үл олгоно. Гуравдугаар зүйлд: хэрэв Монгол

¹⁷ Мөн тэнд.

¹⁸ «Международные отношения», сер. 2, т. 18, часть 1, с. 227.

¹⁹ Л. Жамсран. Диссертация. 82 дахь тал.

Улсын засгийн газар хятад ба гадаад бусад улстай тусдаа гэрээ байгуулах хэрэгтэй гэж үзвэл шинэ гэрээгээр энэхүү хэлэлцээр ба хавсаргасан протоколд заасан зүйлүүдийг Оросын эзэн хааны Засгийн газартай урьдаар зөвлөлдөхгүйгээр зөрчих буюу өөрчилж үл болно. Дөрөвдүгээр зүйлд: хэлэлцээр усзүг зурсан өдрөөс хүчин төгөлдөр болно гэсэн заалтууд оржээ.²⁰

Эл гэрээний хавсралт протокол нь Монгол дахь Оросын худалдааны эрхийг давуу байдлаар хуульчилж өгсөн юм. Эл гэрээгээр Оросын эдийн засгийн давуу талыг дараах байдлаар тодорхойлсон байна. Тухайлбал, Орос улсын иргэд Монголын аль ч нутагт худалдаа эрхлэх, чөлөөтэй зорчих, үйлдвэр, үйлчилгээ гээд боломжтой бүх төрлийн бизнес явуулах, эзэмшил харгалзахгүйгээр гэрээ, контракт байгуулах, гааль татваргүйгээр Монголоос бараа гадаадад гаргах, гадаадаас оруулж ирэх, хувийн өмчийг чөлөөтэй хөгжүүлэх, Оросын санхүү, зээлийн байгууллагууд өөрийн салбараа Монголд нээн ажиллуулах зэрэг эрхийг Оросууд дангаар дэлэх болсон юм.

Оросын бүрэн эрхт төлөөлөгч Иван Яковлевич Коростовец Хүрээнд зорчсон тухай өдрийн тэмдэглэлдээ²¹ болон "Чингис хаанаас Зөвлөлийн засагт Бүгд Найрамдах улс хүртэл" хэмээх номондоо Орос, Монголын хооронд гэрээ хэрхэн байгуулсан тухай сонирхолтой дурсамж үлдээсэн буй. Тэрээр анх Монголын засгийн газрын ноёдуудтай уулзсан талаар өгүүлэхдээ: "Консулын газар болсон хэлэлцээрийн эхний хуралдаанд эрх баригч ноёдууд бүгд ирсэн ба тухайлбал, Сайн ноён хан, Гадаад

хэргийн сайд Ханд ван, Дотоод хэргийн сайд Да лам, Сангийн яамны сайд Түшээт хан, Шүүх яамны сайд Эрдэнэ ван Намсрай, Цэргийн сайд Далай ван нар байв. 1911 онд Петербургт очсон төлөөлөгчид болох Да лам, Ханд ван нарын тухай урьд ярьсан билээ. Засагт ханыг нас барсаны дараа Сайн ноён хан саяхан сайд болсон.

Ноёдууд гоёлын хүрэм өмсч, булган малгай тавьж, мориор ирцгээв. Тэднийг бараа бологч олон тооны туслагчид хашаа үүдэнд ирцгээсэн байв.

Хуралдаанд манай талаас надаас гадна, Ерөнхий консул Луба, Попов, Эльтеков болон консулын газрын орчуулагч буриад Церемпилов нар оролцов. Дараа нь энэ буриадаас нэг бус удаа би дэмжлэг авч байв. Тэрбээр Хутагтын ордонд ойр дотно байв.²²

Монголд үргэлж нөхөрсөг хандаж ирсэн Орос орон ба Цагаан хаан Хятадаас салсаны дараа учирч буй бэрхцээлийг мэдээд та бүхэнд туслахаар шийдвэрлэсэн юм хэмээн би мэдэгдэв. Хэрэв монголчууд бидэнтэй Монгол, Оросын хэлхээ холбоог бэхжүүлэх, Монголд өөрийнхөө автономийн төлөө тэмцэх бололцоо олгосон тийм хэлэлцээр байгуулвал Орос орны зорилт биелэхэд хөнгөн байх болно. Бээжинд элчин сайдаар байхдаа монголын хэрэгтэй ойр танилцаж байсан болохоор намайг хэлэлцээр хийх төлөөлөгчөөр томилсон юм.

Ноёдын өмнөөс нүцгэн толгойтой (бусад нь гээгтэй байв), ширүүн харцтай Да лам үг хэлэв. Тэрбээр монголчууд Орос улстай хэлэлцээр байгуулахад бэлэн байна, гэхдээ юуны өмнө Хятадтай

харилцах харилцаанд хэрхэн нөлөөлөх талаар тодруулахыг хүсэж байна. Хятадууд бас хэлэлцээр хийхийг санал болгоод буй. хэлэлцээр хийлгэхээр монгол ноён Наянтыг ирүүлэхийг хүсэж байна. Орос улсын цаашдын алхмуудыг хүлээнэж, Монголын Засгийн газар Наянтыг хүлээн авахаас одоохондоо татгалзаад байгаа. Монголын Засгийн газар Гадаад Монголыг нэгтгэх төдийгүй Дотоод Монголыг ч бас нэгтгэхийг эрмэлзэж байна.

Надад зөвхөн Халхын тухай л хэлэлцээр хийхийг даалгасан бөгөөд Дотоод Монголын асуудлыг одоохондоо босгон тавихгүй байсан нь дээр хэмээн би тайлбарлав. Хятадын тухайд тэдний монголчуудтай хийх хэлэлцээр бол тусгаар тогтнолыг тань солихтой адилхан болж магад. Бид хоёр талын ашиг тусын тулд монголчуудтай ойртохыг хүсэж байна. Учир нь Монгол нь буфер улсын хувьд манай хил дээр хятадын нэвтрэн орохын эсрэг түшиг тулгуур болж болох юм хэмээн бид үзэж байгаа юм. Бидний энэ алхам нь Бээжингийн засгийн газрын үйл ажиллагаанаас үүдэлтэй бөгөөд бидний саналыг хүлээн авч ашиглах нь монголчуудаас хамаарах болно.

Дуугүй сууж байсан Сайн ноён хан хариулахдаа монголчууд бид даван туулж буй энэ үеийн чухал хэмээхийг мэдэрч байна. Таны үг болон хэлэлцээрийн төсөл Богд хутагтад шууд айлтгах болно хэмээнсээр бидний эхний уулзалт өндөрлөв"²³ хэмээсэн байна.

И.Я.Коростовец Орос Монголын гэрээ байгуулсан тэр өдөр чухам юу болсон талаар тэмдэглэж үлдээсэн нь нэн сонирхолтой юм.²⁴ Тэрбээр

²⁰ Монголын ард түмний 1911 оны үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэл. Баримт бичгийн эмхтгэл. 1900-1914 УБ. 1982он. 174-175 дахь тал. Гримм Э Сборник договоров и других документов по истории международных отношений на Дальнем Востоке (1842-1925) М. 1925он. с. 181-183.

²¹ Иван Яковлевич Коростовец, ДЕВЯТЬ МЕСЯЦЕВ В МОНГОЛИИ. Дневник русского уполномоченного в Монголии Августа 1912-Май 1913 г. Составитель О. Батсайхан. Редакторы О. Батсайхан, Ольга Бакич. Накаши Тамсуо. УБ., 2009 г.

²² И.Я.Коростовец. От Чингис хана До Советской республики. УБ., 2004г. v.211

²³ И.Я.Коростовец. От Чингис хана До Советской республики. УБ., 2004г. с.212

²⁴ Иван Яковлевич Коростовец ДЕВЯТЬ МЕСЯЦЕВ В МОНГОЛИИ Дневник русского уполномоченного в Монголии Августа

өгүүлэхдээ: "Аравдугаар сарын 21-ний өдөр гэрээ байгуулах явдал болов. Энэхүү түүхэн үйл явдал хэрхэн болсон талаар одоо өгүүлье. Бид тэднийг ирэхээ больсон байх хэмээн бодож байтал, ноёдууд Консулын газар үдэш орой хүрэлцэн ирцгээв. Тэдний саадсан явдал нь гарын үсэг зурах сайн өдрийг сонгосон мэргэчийн төлөг буулгасан явдал байжээ. Энэ өдөр сайн өдөр байсан тухай ноёдууд сэтгэл хангалуун надад өгүүлж байв. Бид шууд л текстыг нийлүүлэн уншиж, гарын үсэг зурах үйл явцаа эхэлцгээв. Ийм үйл явдлыг анх удаа үзэх буй монголчууд үүнд ихээхэн ач холбогдол өгч хариуцлагатайгаар хандаж байв. Тэд текстыг маш анхааралтай сонсч, өөрсдийн нэрсээ бийрээр зурахдаа маш хичээнгүйлэн хандаж байв.

Дараа нь шампанск задалж, Автономит Монголын сайн сайханы төлөө, Орос Монголын найрамдлын төлөө би хүндага өргөв. Ноёдууд баярлацгааж, миний гарыг чангаар атгаж, "заа" хэмээн талархлаа илэрхийлж байв. Сайн ноён бүр жижигхэн үг хэлж, харин Сангийн сайд Монголчууд Оросыг дайлснаас хойш энэ үйл явдал бол Монгол Оросын хооронд шууд харилцаа тогтоож буй анхны алхам хэмээн ёжлон тэмдэглэж байв. Одоо бол Монголчууд өөрийн орны хувь заяаны төлөө сэтгэл амар байж болно, учир нь Орос орон, цагаан баатар буюу Цагаан хаан түүнийг хэнд ч өгөхгүй.

Бидний ярианы үеэр ноёдууд тэдний эргэлзээ сүүлчийн момент хүртэл үргэлжилж, харин Богд хааны өөрийнх нь шаардснаар хэлэлцээрт гарын үсэг зурахаар шийдвэрлэснээ хэлж байжээ. Учир нь саяхан Бээжингээс ирсэн Ларсоны ярианаас эргэлзээ төрж эхэлсэн байжээ. Гарал үүслээрээ норвег

Ларсон нь америкийн библийн нийгэмлэгийн төлөөлөгч бөгөөд Хүрээнд нийгмийн ажлаар ирсэн хэмээвч үнэн хэрэг дээрээ Орос улстай хийж буй хэлэлцээрийг таслахыг монголчуудад ятгахаар Бээжингийн засгийн газраас томилогдсон байв.

Гэвч монголчууд түүний бүх саналыг үгүйсгэж, Орос улстай хэлэлцээр байгуулсаны дараа л Хятадтай тэгш харилцааны үндсэн дээр хэлэлцээр байгуулахад болно хэмээн мэдэгдсэн байна"²⁵ гэжээ.

Орос Монголын хооронд гэрээ байгуулсаны маргааш нь Оросын консулын газар Хан ван ирж, хэлэлцээр байгуулсантай холбогдуулан Богд хаанаас баяр хүргэсэнийг уламжилсан байна.

Мөн хэсэг хугацааны дараа Оросын Гадаад хэргийн яамнаас И.Я.Коростовецэд цахилгаан ирсэн бөгөөд түүнд Монголын Засгийн газартай байгуулсан хэлэлцээрийн тухай Эзэн хаанд айлтгаж, Эзэн хаан уг илтгэл дээр өөрийн гараар "И.Я.Коростовцад миний талархлыг илэрхийлж байна. Эзэн хааны ивээлийг хүлээн авна уу" хэмээн бичсэн байжээ.

1912 оны Найрамдлын гэрээ байгуулагдсаны дараах үе

Орос Монголын хооронд Найрамдлын гэрээ байгуулагдсанаас хойш гурав хоногийн дараа Оросын Гадаад яамны сайд Сазанов эл гэрээний талаар Хятадын Засгийн газарт мэдээлэхийг албан ёсоор өөрийн элчин сайд Крупенскийд үүрэг болголоо. Эл үүргийн дагуу Оросын элчин Крупенский Хятадын Гадаад явдлын яамны сайдад 1912 оны 10 дугаар сарын 26-ны өдөр Бээжинд уламжлахад, Хятадын Гадаад яамны сайд «Орос улс Монголын

Засгийн газрыг хүлээн зөвшөөрчихлөө» шүү дээ «харин Дундад Иргэн улсыг хүлээн зөвшөөрөөгүй л байгаа шүү» хэмээн сануулсан байдаг.²⁶ Энэ бол Орос улсын засгийн газраас Монгол Улсыг хүлээн зөвшөөрсний үндсэн дээр 1912 онд Найрамдлын гэрээ, худалдааны протокол байгуулсан хэмээн дэлхийн улс орнууд ойлгож байсаныг илтгэж буй хэрэг юм.

Үүнээс хэдхэн хоногийн дараа Хятадын Гадаад яамны сайд Санкт Петербургт айлчилж, Оросын Гадаад яамны сайд лугаа уулзан Хятад улс Монгол, Оросын хооронд байгуулсан гэрээг хүлээн зөвшөөрөөгүй гэдгээ мэдэгдсэн байна. Үүний хариуд Сазанов тайлбарлахдаа: Орос улс Монголын тусгаар тогтнолыг бүрэн гүйцэд зөвшөөрөөгүй юм, гэхдээ бид Хятадыг гурван улсын гэрээнд оруулан хятадын сюзеренитетийг хүлээн зөвшөөрч болох юм гэж мэдэгдсэн байна.²⁷

Хятадын Засгийн газар Хятадын нэгэн хэсэг болсон Монголтой байгуулсан аливаа гэрээг хүлээн зөвшөөрөхөөс эрс татгалзаж байгаагаа илэрхийлж Монголын тухай аливаа асуудлаар Хятадын төв Засгийн газартай гэрээ байгуулахыг сануулсан байна. Чингэхдээ Хятадын Засгийн газар Оросын Засгийн газраас эхлээд Монголтой байгуулсан гэрээгээ цуцлахыг шаардаад үүний дараа бид танайтай эл асуудлаар хэлэлцээр хийхэд бэлэн байх болно хэмээн мэдэгдсэн байна. 1912 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр Хятадын сайд Санкт Петербургт Оросын гадаад яамны сайд лугаа уулзаж, Хүрээтэй байгуулсан гэрээгээ цуцлахыг бас дахин гуйсан байна. Гэвч эл бүхэнд Сазанов, Крупенский хоёр «Хятадын санал дэндүү оройтож ирлээ» хэмээн хариулсан байдаг.²⁸

1912-Май 1913 г. Составитель О. Батсайхан. Редакторы О. Батсайхан, Ольга Бакин, Накаму Татсую. УБ. 2009 г.

²⁵ И.Я.Коростовец. От Чингис хана до Советской республики. УБ., 2004 г. с. 234-235.

²⁶ Сборник дипломатических документов по Мон. Вопросу 23 авг. 1912г.– 2 нояб. 1913г. С. Петербург, 1914. с. 32.

²⁷ Peter S.H. Tang Russian and Soviet policy in Manchuria and outer Mongolia 1911- 1931 Duke university press Durham, North Carolina. 1959 p. 314.

²⁸ Мөн тэнд, p. 315.

Оросын Гадаад Яамны сайд Сазанов Монгол, Оросын хооронд байгуулсан гэрээнийхээ талд ийнхүү баттай зогссон нь Оросын Засгийн газар Монгол Улс, түүний тусгаар тогтнолыг тодорхой хэмжээгээр дэмжсэний илэрхийлэл мөн. Нөгөө талаас, Хятадын засгийн газар удаа дараа Орос улсаас Монголтой байгуулсан гэрээгээ цуцлахыг шаардаж, гүйж байсан явдал бол Монголын тусгаар тогтнол эргэлт буцалтгүй замд орж байсныг илтгэсэн хэрэг юм.

Монголын Засгийн газартай хэлэлцээр хийх бүрэн эрхт төлөөлөгчөөр томилогдсон Оросын эрх баригч И.Я.Коростовец өөрийн Гадаад яамны сайдад 1912 оны 9 сарын 27-ны өдөр илгээсэн цахилгаандаа «Монголын Засгийн газар миний өгсөн гэрээний төсөлд ямар нэгэн өөрчлөлт оруулаагүй боловч тэд харин Хятадаас төдийгүй ерөөс аливаа улсаас өөрийн бүрэн тусгаар тогтнолыг тогтоосон заалт нэмж оруулахыг» хүсэж байна хэмээн Монголчуудын байр суурийн талаар мэдээлж байжээ.²⁹

"1912 оны 11 дүгээр сарын 3-ны өдөр Оростой найрамдлын гэрээ байгуулснаас хойш үеийн Монгол нь бие даасан улс байсан юм, учир нь хоёр орны харилцаа Хятадаар дамжих бус шууд явагдаж байсан билээ" хэмээн М.Волосович тэмдэглэсэн байна.³⁰ Тухайн үеийн Оросын хэвлэлүүд энэхүү гэрээ бол улс биш байсан бол байгуулагдахгүй байсан, нэгэнт байгуулагдсан болохоор Монголыг сюзеренитет болгохын эсрэг байгуулсан гэрээ болж таарна хэмээн бичиж байжээ. Түүгээр ч үл барам 1912 оны Монгол Оросын хооронд байгуулсан гэрээгээр Монгол Улсын нэрийг Гадаад Монгол гэж бус Монгол хэмээн бичиж байхаар Орос улс баталгаажуулсан юм хэмээн Петер

Тан бичжээ.³¹ Харин газар нутгийн тухайд ямар нэгэн зүйл эл гэрээнд тусгагдаагүй юм хэмээн тэрээр бичжээ.

Орос Монголын хооронд байгуулсан гэрээг гадаадын ажиглагчид янз бүрээр тайлбарлаж байсан байна. «Орос улс ийнхүү гэрээ байгуулснаар шинэ улс байгуулагдахад тусдэм боллоо» гэж буюу эсвэл «Монгол нь Хятадаас салан тусгаарлаж эрх чөлөөтэй болсон Оросын колони болчихгүй» хэмээн бичиж байжээ.³²

Хаант Орос улс Богд хаант Монгол Улс хоёр хоорондоо Гэрээ байгуулж, баримт бичгүүд солилцсоноор Монголд эзлэх Хаант Оросын нөлөө ихсэх болсон нь Орос, Дундад Иргэн улсын хүчний харьцаанд урьд байснаас нэлээд өөрчлөлт орж, улмаар хоёр тал монголын асуудлаар хэлэлцээр хийх хэмжээний асуудал болсон байна. Энэ нь Хятадууд монголыг урьдын адил дангаар эзэрхэх гэсэн хятадын байр сууринаас хальж, Монголын асуудлыг Оростой ярилцах болсон нь монголчуудын хувьд багагүй дэвшил болсон хэмээн үзүүштэй. Нөгөө талаар, Орос Монголыг хэлэлцээр хийх эрх бүхий этгээд хэмээн үзсэн нь Монгол өөрийн тусгаар тогтнолын төлөө асуудалдаа өөрийн саналаа оруулж, түүнийхээ төлөө тэмцэх боломжоор хангагдаж эхэлсэн ололт байлаа. Энэ бол Богд Хаант Монгол Улсын төрийн удирдагчдын асар их ухаан, хүчин чармайлтын үр дүн хэмээн үзмээр санагдана.³³

Хаант Орос улс Монгол Оросын 1912 оны гэрээгээр олж авсан өөрийн давуу талуудыг хэвээр хадгалах нөхцөлд Монголын асуудлаар Хятадтай тохиролцоход бэлэн байсан билээ. Монгол Оросын

Найрамдлын гэрээнд 1912 оны 11 дүгээр сарын 3-ны өдөр Хүрээнд гарын үсэг зурсаны дараахан энэхүү баримт бичгийн тухай Оросын Гадаад Явдлын яамнаас Англи, Франц, Япон зэрэг орны элчин сайд нарт албан ёсоор мэдээлэл хийж тайлбарлахдаа, сайд Сазанов: "Хэрэв Хятад улс энэ гэрээний зарчмуудыг хүлээн зөвшөөрвөл түүний зүгээс Монголтой ямар нэгэн гэрээ хэлэлцээр байгуулж Монголд эзэн эрх (сюзеренитэт) тогтооход татгалзахгүй"³⁴ гэсэн нь Оросын байр суурийг тодорхой илэрхийлсэн хэрэг байлаа.

Хэдийгээр хятадууд Монгол Оросын 1912 оны Найрамдлын гэрээ бичиг болон, харилцан солилцсон бусад баримт бичгүүдийг хууль бус зүйл хэмээн эсэргүүцэж хүлээн зөвшөөрөхөөс татгалзаж байсан хэдий ч Оросууд энэ талаарх өөрийн байр суурийг ягштал баримталж байлаа. Иймээс ч Бээжин дэх Хаант Оросын төлөөлөгч Засгийн газрынхаа нэрийн өмнөөс Дундад улсын Гадаад Явдлын Яамны сайдтай уулзаж, Монгол, Оросын хооронд байгуулсан Найрамдлын гэрээ болон бусад баримт бичгийн талаар танилцуулж, Орос улсын зүгээс Хүрээний засгийн газрын өмнө хүлээсэн үүргийг сануулж, эдгээр баримт бичгийг Дундад Их улсаас хүлээн зөвшөөрөхийг шаардсан байна. Чингээд зогссонгүй Оросын зөвлөх Хятадын гадаад явдлын яаманд очиж, 1912 оны 11 дүгээр сард Монголын тал элчингээ томилон Оросын нийслэл Петербург хотод явуулсан хэмээн худал мэдээлэл хийж байсан нь Оросууд Монгол дахь өөрийн ашиг сонирхолыг алдахыг хүсэхгүй, улмаар бэхжүүлж, хятадаар хүлээн зөвшөөрүүлэхийн тулд тэдэнд

²⁹ Сборник дипломатических документов по Монгольскому вопросу 23 авг 1912г - 2 ноября 1913 г.) С Петербург, 1914, с.5.

³⁰ М.Волосович. Россия и Монголия-Вестник Азии №31-32. 1914г. с.42.

³¹ Peter S.H. Tang Russian and Soviet policy in Manchuria and outer Mongolia 1911- 1931 Duke university press Durham, North Carolina, 1959 p. 313

³² Peter S.H. Tang Russian and Soviet policy in Manchuria and outer Mongolia 1911- 1931 Duke university press Durham, North Carolina, 1959 p. 316.

³³ Монгол үндэстэн бүрэн эрхт улс болох замд. (1911 - 1946) Судалгааны зохиол. УБ., 2005 он. 350 дахь тал (22 х.х.).

³⁴ Б.Санжмятов. Гурван улсын Хиагтын гэрээний тухай түүхэн үнэн. УБ., 1991 он. 7 дахь тал.

шахалт үзүүлсэн хэлбэр байв.

Ийнхүү Орос, хятадууд өөр хоорондоо хэд хэдэн удаа ноот солилцож, өөр өөрсдийн байр суурийг илэрхийлсний эцэст Монголын асуудлаар хэлэлцээр хийхээр харилцан тохиролцжээ.

Орос Монголын 1912 оны гэрээ болон түүний хавсралт Оросын худалдааны эрхийг баталгаажуулсан 17 заалт бүхий протоколыг эсэргүүцэж байсан хэдий ч Монголын асуудлыг Оростой тохиролцох үүднээс Хятадын Засгийн газар эцэст нь тэрхүү Монгол Оросын хооронд байгуулсан худалдааны протоколыг хүлээн зөвшөөрсөн юм. Албан ёсоор 1913 оны Орос, Хятадын тунхагийн дөрөвдүгээр заалтад энэ тухай өгүүлсэн байдаг. Мөн түүнчлэн 1915 оны Хятад, Орос, Монгол гурван улсын гэрээний 21 дүгээр зүйлд эл асуудлыг баталгаажуулсан юм. Энэ нь 1912 оны Орос Монголын хооронд байгуулсан гэрээ, худалдааны протокол хүчин төгөлдөр болохыг тодорхойлсон хэрэг билээ.

Энэхүү найрамдлын гэрээ нь ямар нэгэн зөрчилгүй явагдсан хэмээн үзвэл бодит байдлаас ташаа болох билээ. Оросын талын санал болгосон гэрээний төсөлд «Гадаад Монгол» хэмээн бичигдсэн байсан бөгөөд Монголын тал үүнийг эс зөвшөөрч, эсэргүүцсэн тул «Монгол» хэмээх нэрийг хэрэглэхээр тогтжээ. Чингэхдээ «Монгол» хэмээх нэр нь улсын нэр байж болох ба бас газар нутгийн нэр зааж болох хоёрдмол утгатайгаас гадна Ар Монголыг буюу эсвэл нийт Монгол үндэстнийг хамруулан хэрэглэсэн ойлголт болж болох салаа утгаар уг гэрээний орос хэзд хэрэглэгдсэн байдаг.³⁵ Ийнхүү

Монголын нэрийн талаар хоёр тал харилцан тохиролцсон баримтыг үзвээс,

Их Орос улсын хаан эзний засгийн хэрэг шийтгэх газраас тусгайлан гаргасан бүрэн эрх барих сайдын бичиг.

Сайн ноён хан ба Монгол Улсын сайд нарт илгээв. Мэдтүгэй хэмээн явуулахын учир: Орос, Монгол хоёр улсын засгийн газраас энэ өдөр хэлэлцэн тогтоосон найрамдлын гэрээ ба хавсарган тогтоосон тусгай гэрээ бичиг дотор Гадаад Монгол хэмээсэн үгийг Монгол Улс хэмээхийг зөвшөөрч, найрамдлын ёсоор мэдтүгэй хэмээх нь монголчуудын өөрөө зээрхэх эрхийг халхад өгснөөс гадна бусад ямар газар орныг өөртөө тогтнож, өөрөө зээрхэх ёс журмыг алдагдахгүй сахихад манай Орос улсын эзэн хааны засгийн газраас өөрөө тогтоон тусална. Үүний тул илгээв. Нэг мянга есөн зуун арван хоёрдугаар он, октябрь хэмээх сарын хорин хоёр.

Олноо өргөгдсний хоёрдугаар он, намрын сүүл сарын хорин таван хэмээсэн байна.

Энэ тохиролцсон ёсоор гэрээний монгол хэзд «улс» гэдэг үг нэмж «Монгол Улс» гэж хэрэглэсэн байдаг билээ. Энэ нь Богд тэргүүтэй Монголын төр засгийн удирдагчид тулгар байгуулагдсан төр нь бусад улс гүрнүүдийн нэгэн адил эрх бүхий бие даасан улс болохыг харуулахын зэрэгцээ Ар Монголын төдий бус нийт монгол үндэстний гал голомт болсон улс гэсэн санаагаар ойлгож, ийм бодлогыг хэрэгжүүлэхийг хичээж байсны илрэл юм. Мөн түүнчлэн «Монголын Засгийн газар» хэмээх нэрийг хэрэглэснээс гадна хоёр гэрээ байгуулагч этгээд хоёр улсын засгийн газрыг харилцан хүлээн зөвшөөрсөн явдал монголчуудын хувьд үнэхээр онцгой ач холбогдолтой байсан юм. Мөн гэрээ байгуулах үеэр Монгол Улсын эдлэх эрх хэмжээний тухай асуудал

санал зөрөлдсөн асуудлуудын тоонд орж байв. Гэрээний орос хэзд Оросын тал нэгэнт тогтсон автономит байгууллыг хамгаалахад Оросын эзэн хааны Засгийн газар туслах болно гэсэн ахул, монгол хэзд автономит байгуулал хэмээх үгийг хэрэглэхгүйгээр тусгаар тогтнол гэсэн утгаар ойлгох үг хэрэглэн: «Их Орос улсын эзэн хааны Засгийн газраас Монгол Улсыг туслахад өөртөө тогтнож өөрөө зээрхэх ёс журам сахихад тусламуй» гэжээ.³⁶

Мөн 1912 оны гэрээ Монголд өөрийн үйл ажиллагаагаа өргөжүүлэн цэцэглүүлэх бүрэн эрх чөлөөг Оросуудад олгосон юм. Чингэснээр «Монголыг бүхий л чиглэлээр онгичих, дарангуйлахад» хүргэсэн юм хэмээн Е.М.Даревская бичжээ. Оросын Засгийн газрын дэмжлэгийг албан ёсоор хүлээсэн худалдаа, арилжааныхан алт мөнгө гээд бүхий л бололцоотой бүх ашигт малтмалыг эрж хайх, олборлох «Нийгэмлэг», «Нөхөрлөл»-ийг олноор нь Монголд байгуулж, Монгол руу улсын болон хувийн бүхий л барааг оруулан худалдаалж байжээ. Монголын үндэсний банк хүртэл байгуулсан нь буй ажээ. Оросын рубль хятадын мөнгийг бага багаар шахаж эхлэх болжээ.³⁷ Монгол дахь Оросын худалдаа тооны хувьд өсөхийн хэрээр чанарын хувьд ч мөн өсөж байв.

Ийнхүү оросууд Монголыг эдийн засгийн хувьд эзлэн түрэмгийлж эхэлсэн энэ үеийг Оросын төрөөс Монголын талаар явуулсан бодлогын хэрэгжилт хэмээн үзүүштэй юм. Мэдээж энэ бүхэнд хил залгаа байдал, удаан жилийн түүхийн улбаа, уламжлал, эдийн засгийн харилцан сонирхол зэрэг нь Орос гүрний зүгээс Монголын талаар түүхийн удаан хугацааны турш тодорхой бодлого баримталахад хүргэсэн бөгөөд 1911 оны дараа Орос улс бусад их

³⁵ Сборник договоров России с другими государствами 1856-1917. М., 1952. с.411.

³⁶ Үндэсний төв архив. Ф.1. д.1, х.н.74.

³⁷ Н.Е.Единархова. Русские в Монголии. Основные этапы и направления деятельности в 1861–1919 гг.-Материалы конференции «Россия и Монголия в многополярном мире». Часть 1. вып.2. Иркутск, 2000. с.62.

гүрнээс өрсөж, өөрийн боломжийг ашиглан Монголд ашиг сонирхлоо өргөтгөх нь стратегийн хувьд ч чухал байсан юм. Орос Японы гэрээ ёсоор олж авсан өөрийн нөлөөний бүсээ хэн нэгэнд алдах, хэн нэгэнтэй хуваалцах сонирхол Оросын төрийн эрх баригчдад байгаагүй юм.³⁸

Эл гэрээ Оросын талд давуу эрх олгосон зарим талаар нэг талыг барьсан Хүчирхэг гүрний тулган хүлээлгэсэн гэрээ байсан хэмээн хэлж болох боловч Монголын талд улс төрийн ач холбогдолтой байсан юм. Энэ талаар 1968 онд хэвлэгдсэн БНМАУ-ын түүхийн дэд ботид өгүүлэхдээ: «Орос Монголын 1912 оны гэрээ бичиг Орос талаас империалист чанар бүхий нь эргэлзээгүй. Гэхдээ монгол талаас харвал зарим ахицтай тал буйг орхиж үл болно. Тэр үеийн томхон гүрнүүдийн нэгэн болох Хаант Орос улстай Богд хаант Монгол Улс гэрээ байгуулсан энэ баримт бол улс төрийн ач холбогдолтой зүйл маргаангүй мөн» хэмээн дүгнэжээ.³⁹ 1912 онд Монгол Оросын хооронд байгуулагдсан эл гэрээ Монголыг олон улсын талбар дээр дахин төр улс болж гарч ирсэний нэгэн илэрхийлэл болсон юм.

ДҮГНЭЛТ

Энэхүү гэрээ байгуулагдсан нь Монгол Хятадын хооронд явж ирсэн урьдын харилцааг тодорхой хэмжээгээр сулруулж, монголчуудын эдийн засаг, нийгмийн амьдралд оросын оролцоог нэмэгдүүлэх боломж нээсэн билээ.

Хэдийгээр 1912 оны Монгол Оросын найрамдлын гэрээ, худалдааны протоколыг эдийн засгийн асуудлыг голлон шийдвэрлэхэд чиглэсэн хэмээн тодорхойлдог боловч эл гэрээ Монголын хувьд улс төрийн онцгой ач холбогдол агуулсан юм. Орос Монголын хооронд ийм гэрээ байгуулагдсан явдал нь өөрөө Монгол Хятадын хооронд тогтсон байсан урьдын харилцаа үл болж, түүнд цэг тавьсан төдийгүй, Шинэ Монгол Улс дэлхийн аль ч улс оронтой эн тэгш харилцах боломж нээж өгсөн юм.⁴⁰

Энэ гэрээ нь Монгол Улс тусгаар тогтнолоо тунхаглан зарласнаас хойш Монгол Улсын олон улсын харилцаанд эзлэх статусыг тодорхойлоход хууль эрхийн анхны бодитой баримт бичиг болсон юм. Энэ хэлэлцээрээр:

1. Монгол бол эзэн хаантай, Засгийн газартай улс мөн;
2. Монгол нь өөрийн улсын цэрэг байгуулах эрхтэй;
3. Монгол нь «өөртөө тогтнож, өөрөө эзэрхэх» ёс журамтай;
4. Монгол нь өөрийн нутгаас Хятадын цэрэг ба эрх баригчдыг үлдэн гаргасан бөгөөд дахин өөрийн газарт Хятадын цэрэг ба нүүдлийн иргэдийг үл оруулах эрхтэй.

Монгол нь Хятад болон бусад гадаад улстай хэлэлцээ хийж өөр гэрээ байгуулах эрх бүхий этгээд мөн гэдгийг Орос улсын Засгийн газар хүлээн зөвшөөрч эдгээрийг «алдагдалгүй сахихад» цөм тусална гэж Орос улс өөртөө үүрэг авсан байлаа. Гэрээ нь Монголын тусгаар

тогтнолыг Орос улс хүлээн зөвшөөрснийг нэг талаар илэрхийлсэн бөгөөд тухайн тодорхой нөхцөлд Монголд нэлээд дэвшилттэй алхам болсоныг тэмдэглэх учиртай. Эл хэлэлцээрээр монголчуудын санал болгосон Өвөр Монгол, Баргыг Монголд дагаар орох асуудлыг хэлэлцэхээс оросууд эрс татгалзаж, Петербургт Монголын элчин суулгах тухай асуудал мөн татгалзсан хариу авчээ. Өвөр Монголын асуудал нь урьд нь Орос Японы хооронд байгуулсан нууц гэрээгээр нэгэнт шийдэгдсэн байсан бол Оросын нийслэлд Монголын элчин нээх асуудал нь Орос улс нэгэнт Монголын тусгаар тогтнох эрхийг Хятадын харьяаны автономииор хязгаарлах бодолтой байсан учраас татгалзсан санал авсан байна.

Орос улс энэ 1912 оны Найрамдлын гэрээгээр Монголын Засгийн газрыг албан ёсоор хүлээсэн бөгөөд ийм ч учраас Монголыг гэрээ байгуулах эрхтэй хууль ёсны субъект хэмээн үзсэн хэрэг юм. Орос Монголын хооронд байгуулсан эл гэрээ дэлхий нийтэд зарлагдсан явдал өөрөө Монгол Улсын нэрийг «Монгол» хэмээн хүлээн зөвшөөрч тунхагласнаас ялгаагүй хэрэг байлаа. Үүнд мэдээж хятадууд дуртай байгаагүй юм. Ийнхүү дэлхий нийтээр Монгол Улс тухайн үед хүчирхэг Оросын эзэнт улстай гэрээ байгуулсан нь Монголынхоо тусгаар тогтнолын төлөө тэмцлээ үргэлжлүүлэн явуулахад ихээхэн дөхөм үзүүлсэн явдал байлаа.



³⁸ Монгол үндэстэн бүрэн эрхт улс болох зам. (1911 - 1946 он) Судаггааны зохиол. 350 хуудас (22 х.х.) УБ. 2005 он

³⁹ БНМАУ-ын түүх дэд боть УБ. 1968 он. 470 дахь тал

⁴⁰ О.Батсайхан. Монголын тусгаар тогтнол ба Хятад. Орос. Монгол гурван улсын 1915 оны Хиагтын гэрээ. (1911 - 1916 он) УБ. 2002 он. 259 дэх тал

*Монгол Улсын хөдөлмөрийн баатар, ардын багш, гавьяат хуульч,
доктор, профессор Б.Чимидийн нэрэмжит илтгэлийн
уралдаанд оюутны шилдгээр шалгарсан илтгэл*

ҮНДСЭН ХУУЛИЙГ ТАЙЛБАРЛАХ ЦОРЫН ГАНЦ СУБЪЕКТ ЦЭЦ МӨН ҮҮ

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн оюутан О.Мөнхцэцэг



*О.Мөнхцэцэг Монгол Улсын хөдөлмөрийн баатар, ардын багш, гавьяат хуульч,
доктор, профессор Б.Чимидээс шагналыг гардав.*

I. Хураангуй

Эрх зүйт ёс бүхий ардчилсан нийгэмд Үндсэн хуулийг хэрэгжүүлэх явцад нэг талаас Үндсэн хуулийн шүүх, нөгөө талаас хууль тогтоогчийн хооронд зүй ёсны зөрчилдөөн үүсдэг. Хэм хэмжээний хяналтыг хэрэгжүүлж байдаг ардчилсан тогтолцоотой бүхий л орны хувьд хууль тогтоох байгууллага, шүүхийн хооронд бодит тэнцлийг тогтоох шаардлагатай тулгарах бөгөөд энэ тохиолдолд аливаа улс орны Үндсэн хуулийг тайлбарлах эрх мэдлийг хууль тогтоогч, эсхүл шүүхээс хэрэгжүүлэх асуудал эхний ээлжинд тавигддаг юм.¹ Нөгөөтэйгүүр, сүүлийн 10-аад жил "парламент Үндсэн хуулийг тайлбарлах явдал нь

тоталитар дэглэмийн хэв шинжийн илрэл ба энэ нь дэлхийд нэгэнт хоцрогдсонд тооцогддог" хэмээн туйлшрах хандлага манай судлаач, эрдэмтдийн дунд түгээмэл боллоо. Хэдийгээр 200 гаруй жилийн тэртээ хуулийг Үндсэн хуульд нийцэж буйг хянах тухай Мэрбюри эсрэг Мэдисоны хэргийг АНУ-ын Дээд шүүхээс шийдвэрлэснээр Үндсэн хуулийг тайлбарлах эрх мэдлийг шүүх эрх мэдлийн байгууллага анх олж авсан нь маргаангүй үнэн боловч энэ нь "Үндсэн хуулийг албан ёсоор тайлбарлах эрхтэй цорын ганц субъект нь Үндсэн хуулийн шүүх мөн үү?" гэсэн асуултад бүрэн дүүрэн хариулт өгч чадахгүй л болов уу. Иймд миний илтгэлийн үндсэн зорилго Үндсэн хууль ёсны онолын

үүднээс дэлхий нийтийн хандлагыг баримжаалан энэхүү асуултад хариулт өгөх явдал юм.

II. Үндсэн хууль ёсны үзэл баримтлал

Орчин үед энэхүү эрх зүйт төрийн үзэл Үндсэн хууль ёс (Constitutionalism) болон нэгэнтээ хэлбэршин тогтсон төдийгүй Үндсэн хууль ёс гэдэгт: хууль (эрх зүй) бол эцсийн бөгөөд дээд хүчинтэй, төр засгийн эрх мэдэл ард түмнээс үүдэлтэй, засгийн үйл ажиллагаа хуулиар хязгаарлагдсан, хууль нь хүний эрхэд үндэслэгдсэн² байхыг ойлгодог болж. Өөрөөр хэлбэл, хувь хүний эрх чөлөө төрөөс олгож тогтоодог зүйл биш, хүнээс салшгүй жам ёсны юм. Засгийн аливаа эрх тэгш эрхэд суурилсан ард түмний хүсэл зоригоос үүдэлтэй. Төр нь гагцхүү ард түмний төлөөлөгчдөөс тогтоосон хуулийн дагуу ажиллана. Төлөөлөгчдийн хууль тогтоох үйл ажиллагаа Үндсэн хуульд захирагдах ёстой гэсэн үзэл онолоор Үндсэн хууль ёс илрэлээ олж байна.³ Энэ утгаар нь Үндсэн хууль ёсны тулгуур багана нь нэг талаас ардчилал (улс төр) нөгөө талаас эрх зүйт ёс (эрх зүйг дээдлэх зарчим) юм. Үүнээс үүдэн Үндсэн хуулийг улс төр, эрх зүйн баримт бичиг гэх нь ч бий. Иймийн учир Үндсэн хуулийг тайлбарлах эрхийг Үндсэн хууль төрийн тогтолцоотой улс орнуудаа нэг талаас ардчиллын

¹Рудольф Меллингхофф "Үндсэн хуулийн шүүх хууль тогтоох байгууллага хоорондын зүй ёсны зөрчилдөөнт харилцаа ба ардчилсан эрх зүйт төр дэх хамтын хариуцлага. Монгол Улсын Үндсэн хуулийн хяналт. Төлөв байдал цаашдын хандлага сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын эмхтгэл. 33 дахь тал.

²The New Encyclopedia Vol. 25 p.979

³Ч.Энхбаттар, Х.Тэмүүжин "Үндсэн хуулийн дархлаа ба хамгаалалт. Үндсэн хуулийн үзэл баримтлал. УБ, 2005 он.

институци болох парламент нөгөө талаас эрх зүйт ёсны институци болох Үндсэн хуулийн шүүх хэрэгжүүлдэг нь зүй ёсны хэрэг юм.

Гэтэл хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор С.Жанцан "Үндсэн хуулийг парламент тайлбарлах нь олон улсын жишгээс хазайсан нэн даруй засах ёстой гажуудал"⁴ гэцд "Үндсэн хуулийг парламент биш гагцхүү Үндсэн хуулийн шүүх тайлбарлах эрхтэй"⁵ хэмээн үзжээ. Үүнийг доктор Д.Лүндээжанцан дэмжиж "Манай улсад Үндсэн хуулийг зөвхөн УИХ тайлбарлаж байна. Ийм тайлбар 1993, 1998 онд гарсан. Хууль тогтоогчоос Үндсэн хуулийг тайлбарлах үед хүчний харьцаа гэнцвэргүй байгуулагдсан парламент байвал тухайн үеийн нөхцөл байдалд тохирсон тайлбар гаргачихаад асуудлаа шийдвэрлүүлэхээр тулгах явдал гарч болох юм"⁶ гэжээ. Яг үүнтэй ижил санааг доктор Ц.Сарантуяа Үндсэн хуулийн процессын эрх зүй бүтээлдээ дэлгэрэнгүй тайлбарласан байдаг.⁷ Үүний сэрэг байр суурийг ХБНГУ-ын Үндсэн хуулийн шүүгч, доктор Р.Меллингхофф "Үндсэн хуулийг тайлбарлах эрхийг Үндсэн хуулийн шүүх дангаар эдлэхгүй. Үндсэн хуулийг тодорхойлох эрхийг хууль тогтоогч мөн адил хэрэгжүүлнэ. Хууль тогтоогчийн зохицуулалт Үндсэн хуулийн агуулгатай холбоотой байх үедээ түүнийг тайлбарлаж байдаг" гэсэн бол АНУ-ын Дээд шүүхийн шүүгч Сандра Дэй О Коннор "АНУ-д Үндсэн хуулийг

хууль тогтоогч тайлбарлах эрхтэй байдаг"⁸ гэжээ. Харин Монгол Улсын гавьяат хуульч, доктор, профессор Б.Чимид "Үндсэн хуулийг зөв тайлбарлах замаар Цэцийн эрх, үүргийг үндсэн хуульчилсан актаар дэлгэрүүлэн тогтоож, түүний үйл ажиллагааны цар хүрээ, онолын түвшин, практик үндэслэлийг дэвшүүлэх шаардлагатай байна"⁹ гэсэн нь парламентын Үндсэн хуулийг тайлбарлах бүрэн эрхийг хүлээн зөвшөөрсөн хэрэг бус уу.

III. Парламентаас Үндсэн хуулийг тайлбарлах асуудал

Арга зүйн онолд парламент шүүхийн адил хуульд тайлбар хийх эрхтэй хэмээн хүлээн зөвшөөрөгдсөн байдаг. Энэхүү тайлбар нь хуулийг бий болгогчоос үүдэн гардаг учраас аутентик тайлбар гэж нэрлэдэг. Аутентик тайлбар нь хэлбэрийн хувьд ч утга агуулгын хувьд ч хязгаарлагдмал байдаг. Хууль тогтоогч хуульд аутентик тайлбар хийнэ гэдэг нь тэрээр хууль тогтоох үйл ажиллагаагаар буюу хуульд нэмэлт, өөрчлөлт хийх замаар өөр хэлбэртэй болгоно гэсэн үг.¹⁰ Тухайлбал, Үндсэн хуульд "Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана" гэснийг Шүүхийн тухай хуулиар хэнээс хараат бус байх вэ? Юунаас чөлөөлөгдсөн байх вэ? Хуульд захирагдана гэсэн нь юу вэ? гэсэн асуултад хариулт өгөхүйц тайлбарыг УИХ өгөх учиртай юм. Гэвч манайд хууль тогтоох байгууллага Үндсэн хуулийн зүйл,

заалтыг тайлбарлахаасаа илүүтэй шууд хуулбарлаж тавих нь түгээмэл байна. Энэ нь эрх зүйт ёсны хэлбэрийн шаардлага болох хэмнэлттэй байх зарчимтай зөрчилддэг.

Харин парламентаас хуулийг тогтоолын хэлбэрээр тайлбарлах эрхгүй болно. Үндсэн хуулийн зохицуулалтыг хэд хэдэн арга, хэлбэрээр тайлбарлах буюу тодорхойлох боломж байгаа бол түүнийг тайлбарлах эрх мэдлийг хууль тогтоогч эдэлдэг. Энэ утгаараа хууль тогтоогч нь Үндсэн хуулийг тайлбарлах анхдагч, харин Үндсэн хуулийн шүүх нь хяналт тавих үүрэгтэй тайлбар гаргах хоёрдогч субъект юм.¹¹

Үндсэн хуулийн шүүх нь хууль Үндсэн хуульд нийцсэн эсэх тухай шийдвэр гаргахаас бус хууль тогтоох эрх эдэлдэггүй буюу парламентын шийдвэрийн доголдлыг нөхөж чаддаггүй. Тиймээс хууль тогтоогч нь Үндсэн хуулийн хэм хэмжээг хэрэгжүүлэх, тайлбар гаргах анхдагчийн үүрэгээ, ялангуяа үндсэн эрхийг тайлбарлах үүрэгээ Үндсэн хуулийн шүүхэд шилжүүлж болдоггүй. Эс бөгөөс Үндсэн хуулийн тухайн хэм хэмжээг хуулиар тодорхойлогдохгүй буюу анхдагч тайлбарын гадна үлдэх болно. Дээрхээс дүгнэхэд, Үндсэн хуулиар хязгаарлагдаж, түүний зохицуулалтыг энгийн хуулиар тодруулах үүрэг бүхий хууль тогтоогчид Үндсэн хууль өөрийг нь тайлбарлах өргөн орон зайг олгож байдаг.¹²

⁴ С.Жанцан, Монгол Улсын Үндсэн хуулийн хяналт, Төлөв байдал, цаашдын хандлага сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын эмхтгэл, 65 дахь тал.

⁵ Мөн тэнд, 67 дахь тал.

⁶ Д.Лүндээжанцан, Үндсэн хуулийн цэцийн шийдвэр, Улсын Их Хурлын шийдвэрийн хууль зүйн хүчин чадлын харьцааны шагуурын асуудал, Үндсэн хуулийн шүүх, парламент хоорондын харилцааны эрх зүйн болон ес зүйн үндэс" симпозиум, 62 дахь тал.

⁷ Ц.Сарантуяа, Үндсэн хуулийн процессын эрх зүй, УБ, 2005 он, 51 дэх тал.

⁸ Сандра Дэй Коннор, Шүүх эрх мэдлийн хараат бус байдлын асуудал, Эрх зүй сэтгүүл, УБ, 2002, №8-9.

⁹ Б.Чимид, Үндсэн хуулийг эдэлдэг шүтэх ёс Ханс Зайделлийн сан, ГТХАН, Конрад Аденауэрын сангаас хамтран зохион байгуулсан "Арджилсан эрх зүйт төр" сэдэвт симпозиумд тавьсан илтгэл.

¹⁰ Хайнрих Шоллер, Дээд шүүхийн шүүгчдийг сонгон шалгаруулах ажиллагаа ба парламентын эзлэх байр суурь, Шүүх эрх мэдэл-Шинэ зуун, Олон улсын онол, практикийн бага хурал, УБ, 2001, 114-115 дахь тал.

¹¹ Р.Меллингхофф, Үндсэн хуулийн шүүх, хууль тогтоох байгууллага хоорондын зүй ёсны зөрчилдөөнт харилцаа ба арджилсан эрх зүйт төр дэх хамтын хариуцлага, Монгол Улсын Үндсэн хуулийн хяналт, Төлөв байдал, цаашдын хандлага сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын эмхтгэл, 39 дэх тал.

¹² Мөн тэнд, 34-35 дахь тал.

IV. Үндсэн хуулийн шүүхээс Үндсэн хуулийг тайлбарлах нь

Орчин үеийн Үндсэн хуульт ёсны зорилго улс төрийн эрх мэдлийг аль болох хуульчлах, эрх зүйн арга хэлбэрт оруулах явдал мөн.¹³ Хэрэв хууль тогтоох байгууллага Үндсэн хуулийн шүүхийн хяналтаас гадуур байх аваас түүний хязгааргүй эрх мэдэл Үндсэн хуульт төрийн тулгуур баганыг ганхуулах аюултай. Иймд төрөөс батлан гаргасан эрх зүйн акт Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх талаар эцсийн шийдвэр гаргах эрх парламентад биш, харин бие даасан, хараат бус шүүхэд хадгалагддаг. Энэ бол Үндсэн хуульт ёсны зарчим. Үүний эсрэг парламент ардчилсан ёсны зарчмын тухай яриад ч нэмэргүй. Учир нь нэг талаас ардчилсан ёсны зарчим гэдэг бол парламент бусад эрх мэдэлтэй харьцуулахад давуу эрх эдэлнэ гэсэн хэрэг биш, нөгөө талаас төрийн бүх эрх мэдэл Үндсэн хуульд захирагдах бөгөөд олонхийн саналаар ч парламент нь Үндсэн хуулийг давж гарах эрхгүй байдаг.¹⁴ Энэ нь парламентаар төлөөлөгддөг ард түмний тусгаар тогтнолыг эрх зүйн тусгаар тогтнолоор солилгоо ч хүчин төгөлдөр¹⁵ байна гэсэн үг.

Иймд Үндсэн хуулийн шүүх нь ердийн шүүхийг бодвол эрх зүй болон улс төрийн хооронд үүсдэг зөрчлийн талбарт оршдог. Тодруулбал, ердийн шүүхүүд парламентаас баталсан хуулиудыг хэрэглэх замаар иргэний эрх, эрх чөлөөг хангаж, эрх зүйт төрийн суурь зарчмуудыг баталгаажуулах л үүрэгтэй байдаг. Харин Үндсэн хуулийн шүүх нь Үндсэн хуульд

холбогдох аливаа маргааныг улс төрийн хувьд онцгой ач холбогдолтой байсан ч түүний суурь зарчмуудыг хэмжүүр болгон шийдвэрлэдэг.

Үндсэн хуулийн шүүх нь парламентын нэг бүрдэл институт биш, харин эрх зүйт төрийн сүүлчийн логик үр дагавар¹⁶ бөгөөд энэ утгаараа Үндсэн хуульт ёсны гол баталгаа болдог. Тиймээс чөлөөт ардчилалын үндсэн дэг журмыг хүндэтгэх явдал нь хууль тогтоогчийн үүрэг бөгөөд, Үндсэн хуулийн шүүхийн хяналтгүйгээр энэ нь хоосон мөрөөдөл юм.¹⁷ Хууль тогтоох эрх мэдэл хяналт тавих Үндсэн хуулийн шүүхийн эрх хэмжээ нь Үндсэн хуульт ёсны зарчмуудаар баталгаажсан байдаг. Ардчилсан легитимт зарчмаар буй болсон парламентын баталсан хэм хэмжээг хүчингүй болгох өргөн эрх хэмжээтэй Үндсэн хуулийн шүүхийн хувьд үргэлж шүүмжлэлд өртдөг ч, тэрээр гаргасан шийдвэрийнхээ нийгэмд хүлээн зөвшөөрөгдөх байдлаар өөрийн нэр хүндийг улам бүр өсгөн нэмэгдүүлж байдаг. Иймд Үндсэн хуулийн шүүх гаргасан шийдвэрийнхээ хууль зүйн үндэслэлийг нарийн тодорхой зааж өгөх, тайлбарлах үүрэгтэй.

Үүний зэрэгцээ төрийн эрх мэдлийн хуваарилалт нь шүүхийн болон Үндсэн хуулийн шүүхийн оршин тогтнох үндсэн нөхцөл болж өгдөг.¹⁸ Иймд Үндсэн хуулийн шүүх нь Үндсэн хуультай холбоотой хэрэг маргаан гарсан үед Үндсэн хуулийн эрх зүйг тайлбарлаж, хэрэглэх талаар эцсийн шийдвэр гаргах үүргийг ард түмнийхээ өмнө хүлээдэг. Орчин үед эрх зүйт төрийг

хууль зүйн нарийн техникийн аргуудаас бүрдсэн систем гэж ойлгох бол Үндсэн хуулийн шүүн таслах ажиллагаа нь энэ тогтолцоонд төрийн амьдралыг цэгцлэх зорилготой голлох элемент төдийгүй хувь хүнийг хууль тогтоогч болон төр засгийн дур зоргоос хамгаалж буй эрх зүйн илэрхийлэл, мөн иргэний Үндсэн эрхийг тодорхой маргаанд тулгуурлан шүүхийн журмаар хамгаалах явцдаа Үндсэн хуулийг тайлбарлаж "амьд" Үндсэн хуулийг бий болгож байдаг чухал хэрэглэгдэхүүн байдаг билээ.¹⁹ Энэ ч утгаараа ХБНГУ-ын Үндсэн хуулийн 93.1-т "Хэрэг маргааныг шийдвэрлэж Үндсэн хуулийг тайлбарлаж болно" хэмээн заасан байдаг.

Манай улсын хувьд Цэцээс Үндсэн хуулийн маргаантай асуудлаар дүгнэлт гаргах, маргаан бүхий хэргийг хянан шийдвэрлээд тогтоол гаргахдаа Үндсэн хуулийн тодорхой заалтыг үндэс болгон, түүнийг аль нэг этгээд зөрчсөн эсэхийг хянан хэлэлцээд тэр тохиолдолд уг заалтыг тайлбарлан хэрэглэдэг. Энэ бол уг заалтыг хэрхэн ойлгож хэрэглэх талаар эрх зүйн мэргэжлийн үнэлгээ өгч байгаа хэрэг мөн.²⁰

V. Үндсэн хуулийн шүүх болон парламентын хамтын хариуцлага

Нэг талаас улс төрийн хариуцлага хүлээж хууль батлан гаргаж буй парламент, нөгөө талаас хуулийг Үндсэн хуульд нийцэж буй эсэхийг хянадаг Үндсэн хуулийн шүүхийн хооронд зүй ёсны зөрчилдөөн бүхий харилцаа үүсдэг.

¹³ Х.Шоллер. Үндсэн хуулийн шүүх гурав дахь эрх мэдлийн бүрэлдэхүүн хэсэг болох тухай. "Үндсэн хуулийн шүүх, парламент хоорондын харилцааны эрх зүйн болон ес зүйн үндэс" симпозиумд тавьсан илтгэл. Тус симпозиумын эмхтгэл. УБ., 1998 он. 129 дэх тал.

¹⁴ Рудольф Меллингхофф. Үндсэн хуулийн шүүх, улс төр, ердийн шүүхийн тогтолцооны зөрчилдөөний тайлбар. Монголын төр, эрх зүй сэтгүүл. УБ. 2004 он. 25 дахь тал.

¹⁵ Х.Шоллер. Дээд шүүхийн шүүгчдийг сонгон шалгаруулах ажиллагаа ба парламентын эзлэх байр суурь. "Шүүх эрх мэдэл-Шинэ зуун" олон улсын онол, практикийн бага хурал. УБ., 2001 он. 122 дахь тал.

¹⁶ Bethge in Mauz/Schmidt-Bleibtreu/Klein/Ulsamer, BVerfGG, Vorb Rn 2

¹⁷ Karl Doehring. The Special Character of the Constitution of the Federal Republic of Germany as a Free Democratic Basic Order. 1988 p35.

¹⁸ Ханс-Иоахим Иенч. Үндсэн хуулийн шүүх ардчилсан эрх зүйт төрийн зохион байгуулалтын түгшрэл чөлүү мөн. Монголын төр, эрх зүй сэтгүүл. 2002 он. №03. 26 дахь тал.

¹⁹ Х.Тэмүүжин. Үндсэн хуулийн дархлаа ба хамгаалалт.

²⁰ Б.Чимид. Үндсэн хуулийн мэдлэг. УБ., 2008 он. 47 дахь тал.

Энэ нь олон шалтгаантай ч Үндсэн хуулийн шүүх, хууль тогтоогчийн аль алиных нь удирдлага болгодог Үндсэн хуулинд бусад хэм хэмжээтэй харьцуулбал тодруулах шаардлагатай, зохицуулагдаагүй нөхцөл байдал илүү олон тохиолддогтой энэ тэргүүнд холбоотой бөгөөд тэдгээрийг Үндсэн хуулийн шүүх хууль тогтоогчоос өөрөөр тодорхойлсон, өөрөөр тайлбарласан тохиолдолд зөрчилдөөн зайлшгүй үүсдэг.²¹ Ийм жишээ олныг дурьдаж болно. Германд гэхэд хууль тогтоогч нь аюулгүй байдлыг хангах үндэслэлээр иргэдийн эрх, эрх чөлөөг хязгаарлах, түүнийг нь Үндсэн хуулийн шүүх үл зөвшөөрөх гэсэн зөрчилдөөн үүсээд байна. Жишээлбэл, Холбооны Үндсэн хуулийн шүүхээс Цагдаагийн байгууллага олон нийтийг хамарсан мөрдөх ажиллагаа явуулж болох тухай хуулийн заалт нь хувь хүний мэдээлэлд халдаж, өөрийгөө тодорхойлох Үндсэн эрхийг зөрчиж байгаа тул Үндсэн хуульд нийцэхгүй байна гэсэн шийдвэр гаргажээ. Үндсэн хуулийн шүүх олон нийтийг хамарсан мөрдөх ажиллагааг гагцхүү үндэсний аюулгүй байдал, хувь хүний амь нас, эрүүл мэнд, эрх чөлөөнд бодит аюул учирсан тохиолдолд хэрэгжүүлэхээр заажээ. Энэ тухай хууль тогтоогчид Холбооны Үндсэн хуулийн шүүхийн хувьд мэдээллийг хамгаалах нь хүн амыг алан хядагчдаас хамгаалахаас илүү ач холбогдолтой байгаа нь буруу хэмээн хурцаар шүүмжилжээ.

Дээрх зөрчилдөөнийг даван туулахын тулд эцсийн шийдвэрийг Үндсэн хуулийн шүүх дангаар гаргах бус шийдвэр гаргах орон зайг харилцан хүлээн зөвшөөрөх нь чухал юм. Хэм хэмжээг хянах явцад тухайн хууль нь Үндсэн хуульд нийцэж байгаа, эсхүл түүнийг зөрчиж буйн улмаас хуулийг хүчингүйд тооцох тухай шийдвэрийн

аль нэгийг Үндсэн хуулийн шүүх гаргадаг бөгөөд аль ч тохиолдолд Үндсэн хуулийн шүүхээс хууль тогтоогчийн шийдвэр гаргах эрх мэдлийн хүрээг хүлээн зөвшөөрөх боломж гардаг. Үүнийг дараах байдлаар тайлбарлаж болох юм.

Аливаа хэм хэмжээг Үндсэн хуульд нийцэж байгааг хянах явцад Үндсэн хуульд нийцсэн хэлбэрээр тайлбарлах тухай зарчим нэн чухал ач холбогдолтой. Хуулийг хэрэглэж буй этгээд нь арга зүйн хувьд хичнээн хүчин чармайлт гаргасан ч тухайн хэм хэмжээг хэд хэдэн хэлбэрээр тайлбарлах боломж байсаар байдаг нь эрх зүйн мөн чанар юм. Тиймээс энэ тохиолдолд хуулийг тайлбарлаж буй этгээд нь Үндсэн хуулийн нэн чухал зохицуулалтын (үндсэн эрхийн хувьд) агуулгыг тодорхойлохын тулд хэм хэмжээг тайлбарлах аргыг үзэмжээрээ бус харин Үндсэн хуульд хамгийн ойр утгатайг нь сонгох шаардлагатай. Ийнхүү Үндсэн хуульд нийцүүлэн тайлбарлах боломжтой бол хэм хэмжээг тухайн шийдвэрийн хүрээнд Үндсэн хуульд нийцэж байна гэж үзнэ. Үндсэн хуульд нийцүүлэн тайлбарласнаар хуучингүй болох хуулийн тоог цөөрүүлдэг зэрэг үр дагавартайгаас гадна хууль тогтоогчид шинэ хууль батлах бус зохицуулалтын бусад аргыг хэрэглэх боломжийг буюу тодорхой шийдвэр гаргах эрх мэдлийг олгодог.

Үндсэн хуулийн шүүхээс шийдвэр гаргах нөгөө нэг хувилбар нь хуулийг хүчин төгөлдөр бусад тооцох тухай юм. Хуулийг хүчин төгөлдөр бус гэж тооцооноор Үндсэн хуульд нийцсэн хуулийг баталтал тухайн хуулиар зохицуулагдаж байсан нийгмийн харилцаа зохицуулалтгүй үлдэх зэрэг бэрхшээл тулгардаг. Тиймээс зарчмын хувьд хуулийг хүчин төгөлдөр бус гэж тооцохгүйгээр гагцхүү Үндсэн хуульд нийцэхгүй болохыг тогтоох нь оновчтой. Ингэснээр тухайн хууль нь тодорхой

хугацааны туршид үйлчилж улмаар хууль тогтоогчид Үндсэн хуульд нийцсэн хууль батлах боломжийг олгодог.²²

VI. Санал, дүгнэлт

Эдүгээгээс 200 жилийн тэртээ Наполеон хэлэхдээ: "энэ дэлхий дээр илдийн болон оюун санааны гэсэн хоёр их хүчин оршиж байна. Хэтдээ оюун санааны хүчин ялан дийлнэ" гэсэн юм. Үндсэн хуульд ёсны үзэл санаа оюун санааны хүчин чадалтай мөнхийн уялдаатай билээ. Өдгөө улс орнуудын ардчиллын чанарыг шалгахдаа ч энэ хэмжүүрийг гол баримжаа болгох нь нэгэнтээ түгээмэл зүйл болжээ. Цаашид ч Үндсэн хуульд ёсны ялалтыг зогсоох аргагүй юм. Нэгэнтээ энэ үнэн бол Монгол Улсад Үндсэн хуульд ёсыг төлөвшүүлэхэд ард түмний төлөөлөл болсон Улсын Их Хурал, Үндсэн хуулийн манаач болох Үндсэн хуулийн цэцийн хамтын үйл ажиллагаа хийгээд хариуцлага хамгаас чухал юм. Үүний тулд:

- Үндсэн хуулийг гагцхүү Үндсэн хуулийн шүүх тайлбарладаг гэх өөрөөсгөл олол, үзэл баримтлалыг халах ажлыг Үндсэн хуулийн цэц өөрөөсөө эхлүүлэх;
- Үндсэн хуулийн эрх зүй судлаач, эрдэмтэн, мэргэжилтнүүдийн дунд энэ талаар нээлттэй хэлэлцүүлэг хийж, ойлголтын зөрүүг арилгах;
- Хууль зүйн салбарын сургалтад шинэ хандлагаар Үндсэн хуулийн эрх зүй хичээлийг заах.

Эдгээр арга хэмжээг амжилттай хэрэгжүүлж чадвал Үндсэн хуульд ёс цаасан дээр биш бодит биелэл болоход нэг алхам ойртох гэдэгт эргэлзэхгүй байна.

□ □ □

²¹ Р. Меллингхофф Үндсэн хуулийн шүүх, хууль тогтоох байгууллага хоорондын зүй ёсны зөрчилдөөнт харилцаа ба ардчилсан эрх зүйт төр дэх хамтын хариуцлага. Монгол Улсын Үндсэн хуулийн хяналт. Төлөв байдал, цаашдын хандлага сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын эмхтгэл. 39 дэх тал.

²² Мөн ном. 45 дахь тал

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООХ БАЙГУУЛЛАГЫН ТҮҮХЭН ХӨГЖИЛ

"Хурал"-ын байгууллага, түүний эрх зүйн үндэс, түүхэн хөгжлийн асуудал эрх зүй судлалд чухал байр суурь эзэлдэг. Дэлхийн улс үндэстнүүд төрөө засах арга ухаан хийгээд төрийн аливаа тулгамдсан хэрэг явдал, чухал асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхдээ тодорхой зохион байгуулалтын нэгдэл буюу "хурал"-ын тогтсон дэг ёс бүхий үйл ажиллагааны хүрээнд явуулсаар ирсэн түүхтэй.

Эл өгүүлэлд түүхэн хөгжлийн явцад эе, хуралдай, чуулган гэх мэтээр олон янзаар нэрлэж байсан түүхэн нэрийдлийг агуулгын хувьд адил болох үүднээс нь зарим тохиолдолд ерөнхийлөн "хурал" гэж нэршүүлэн авч үзсэн бөгөөд "хурал"-ын байгууллагын түүхэн хөгжлийг эртний түүхэн хэлбэрээс нь авхуулан 1990 он хүртэлх хугацааг хамран өгүүлэхийг зорьсон болно.

Нэг. "Хурал"-ын байгууллагын түүхэн хэлбэрүүд

МЭӨ III зууны үед хүчирхэгжин мандаж асан Хүннү улс нь өөрийн нутаг дэвсгэр хил хязгаартай, эзэн хаантай, аравтын ёсыг үндэс болгосон, нутаг орноо захирах тогтолцоотой, өөрийн гэсэн хууль цаазтай, бие даасан гадаад харилцаатай, төрийн том бүрдэл байв. Хүннүгийн төрийн үйл ажиллагааны нэг хэлбэр нь "хуралдаан".

Судлаач Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан нар "Цагаан сард Шаньюйн өргөөнд бүх дарга бага хуралдаанд цугларч, тахилга үйлдэнэ. Тавдугаар сард Луу хотод их хуралдаанд цугларч, өвгөд, тэнгэр, дэлхий, онгон хайрханд тахилга үйлдэнэ. Намар морь гаргалахаар Дайлинд их хуралдаанд цугларч хүн малын тоог бүртгэн шалгадаг" гэсэн баримтыг үндэслэн Хүннүд их, бага хоёр хуралдаан байсан бөгөөд бага



*ШУА-ийн Философи, социологи,
эрх зүйн хүрээлэнгийн "Хууль зүйн
судалгааны төв"-ийн эрдэм
шинжилгээний ажлант
Б.Батбаяр*

хуралдаан нь Шаньюйгийн өргөөнд гүмтийн дарга нар цугларч шинэ оны амгаланг айлтган, төрийн томоохон хэргийг хэлэлцдэг, их хуралдаан нь Хүннү улсын нийт иргэн оролцдог улс нийтийн том тахилга төдийгүй, овгийн байгууллын үеийн ард нийтийн хуралдааныг хэлбэрийн хувьд ёс төдий ч болсон хадгалж байсан¹ гэсэн дүгнэлтийг хийжээ.

Эл үеийн төрийн байгуулалд хуралдай ямар үүрэг гүйцэтгэж байсныг авч үзвэл, Хүннүгийн хаан Шаньюй нь түшмэдийн зөлэлдээнээр төрийн хэргийг удирдах хэлэлцэх, түмтийн дарга зэрэг томоохон албан тушаалтныг томилох, огцруулах, шийтгэх, тэр ч байтугай цаазлах, улсын сан хөмрөгийг арвижуулах, харьяат албатаа төвшитгөн засах зэрэг төрийн дотоод чиг үүрэг, харь улсын хаадтай бичиг солилцох, гэрээ хэлэлцээр байгуулах, харь орны элч төлөөлөгчдийг хүлээн авах, үдэх, бусад улстай дайтах, найрамдах зэрэг гадаад бодлогын асуудлыг

шийдвэрлэх бүрэн эрхтэй байжээ. Хүннүгийн төрийн үйл ажиллагааны нэг хэлбэр, зонхилгогчдын зөлэлдээн буюу зөвлөл нь аажимдаа дээр дурдсан их, бага хоёр хуралдайд шилжсэн бололтой. Их, бага хуралдай нь асуудлыг эцэслэн шийдвэрлэдэггүй, харин Шаньюйд зөвлөх эрхтэй байгууллага байсан байна. Төрт ёс гүнзгийрэх тусам төрийн зөвлөл буюу бага хуралдайн үүрэг өсч хожмын их хуралдайн суурийг бага багаар тавьсаар байжээ.

Хуралдай нь Хүннү улсын дараагаар Сянби улсад үндсэн шинэ чанараа алдаж, ноёлогч язгууртны хуралдаан болон хувирч, улмаар Нирун улсын үед язгууртны их хуралдай болон өргөжсөн байна. Эл үед язгууртны их хуралдай нь хаан өргөмжлөх, дайтах, найрамдах зэрэг төрийн бодлогын том том асуудлыг шийдвэрлэхэд хаанд зөвлөх үүрэгтэй байв. Үүнээс гадна язгууртны их хуралдайгаас арай явцуу хүрээнд асуудал хэлэлцдэг түшмэдийн зөлэлдээн байсан.

Хожмын монголын ханлиг аймгуудын үед их, бага хуралдай нь нөлөөтэй хэвээр байв. Хамаг монголын үед ноёдын хуралдай цөөн хүнтэй ч гэсэн өмнөх үеэсээ нэлээд боловсронгуй болж, хаан сонгох, дайн зарлах зэрэг асуудал хэлэлцдэг байжээ. Ийнхүү анхлан овгийн зөвлөлийн байдлаар үүссэн хуралдай нь Хамаг Монгол Улсын үед язгууртны зөвлөл маягийн их хуралдайн төрхийг нэгэнт олсон байв.

Чингис хааны төрийн байгуулалтад "хуралдай" хэмээх ноёдын чуулган чухал байр эзэлж байв. Их хуралдай нь Чингисийн үеэс үүрэг, ач холбогдол нь өндөржиж, их хуралдайгаас хаан төрийн тэргүүнийг өргөмжилдөг

¹ Монголын засаг төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагын уламжлалт нэр. 2. БНМАУ-ын 1924 оны Үндсэн хуулиар тогтоосон төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагын нэр. С.Нарангэрэл. Эрх зүйн эх толь бичиг. Анхны хэвлэл. УБ. 2007 он. 544 дэх тал.

² Г.Сүхбаатар. Монголчуудын эртний өвөг. УБ. 1980 он. 73-74 дэх тал.

³ Ж.Болдбаатар. Д.Лүндээжанцан. Монгол Улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал. УБ. 1997 он. 18 дахь тал.

заншлын эрх үйлчлэх болжээ.

Түүхээс үзвэл, 1206 оны хуралдайгаар цэрэг дайны асуудал, 1219 оны хуралдайгаар хааныг залгамжлагчийн асуудал, 1210, 1218 оны хуралдайгаар Их засагт нэмэлт оруулах тухай, 1228, 1246, 1251 оны хуралдайгаар дайны болон алба гувчуурын тухай хэлэлцэж байжээ.

Судлаачдын бүтээлээс үзвэл хуралдайгаар:

- Хаан орд суулгах;
- Дайн найрамдлын асуудал;
- Улс орны төр, эрхийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэдэг нь нийтлэг болж хэвшсэн байдал ажиглагдаж байна.

Мөн хуралдай нь хаанд зөвлөх шинжтэй байв. Энэ талаар Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан нар "хааныг сонгож, төр улсын тулгамдсан асуудалд ончтой хариу эрэлхийлж, нягтлан магадласны үндсэн дээр их хаанд зөвлөх эрх, үүрэг бүхий төрийн байгууллага"⁴ байсан гэжээ. Тэрээр энэ үеийн их хуралдай нь эртний улсуудын үеийнхээс зохион байгуулалт, хэлбэрийн хувьд тун боловсронгуй болж, төрийн дээд байгууллагын шинжийг илүүтэй агуулах болсон бөгөөд чухам энэ утгаар нь их хуралдай парламентат ёсны дээд өвөг байсан гэж үздэг зарим судлаачдын саналыг дэмжсэн байна⁵.

Тухайн асуудлын цар хүрээнээс хуралдайг хураах хугацаа, газар орон, оролцох бүрэлдэхүүн нь тодорхойлогддог байв. Монголын түүхэнд их, бага олон хаад ээлж дараалан хуралдайгаар албан ёсоор Хаанд өргөмжлөгдөх ёслол гүйцэтгэд хааны суурин орд суух эрхийг авч ордны эрх барих буюу төр улсынхаа жолоог атгаж байв.

Хубилай хааны үеэс хуралдай зарчмын шинжтэй өөрчлөлт орсон байна. Хубилай Монголын хаан ширээг хүчээр булаан авч, хууль бусаар өөрийгөө хаанд

өргөмжлүүлэхдээ хуралдайд Чингис хааны алтан ургийнхны дийлэнхи оролцох ёстои хэмээн үздэг зарчмыг огоорч, удирдлагадаа байсан хэдэн цэргийн жанжин нараар өөрийгөө хаан болгуулжээ. Ийнхүү Хуралдай Хубилайн үеэс Чингисийн алтан ургийнхны их цугларалт байхаа больсон байна⁶.

Хуралдай нь хөгжлийн тодорхой үеүүдэд нийгэм улс төрийн амьдралын чухал асуудлыг шийдвэрлэхэд гол үүрэгтэй байжээ. Энэ нь ялангуяа улс төрийн бутралын үед илүүтэй тусгалаа олсон гэж үзүүштэй Учир нь феодалын бутралыг даван туулах гэсэн Монгол, Ойрадын нөлөө бүхий ноёд хамтран чуулган хуралдуулж, түүхэнд 1640 оны Их цаазыг батлан гаргасан явдал болно.

XIV зуунаас Монголын "хурал"-ын байгууллага "ноёдын чуулган" гэсэн нэртэй болсон бөгөөд Монгол орон харьцангуй биеэ даасан хэдэн хэсэгт хуваагдан орших болсны улмаас тэр үеийн хурал (чуулган)-ын хамрах хүрээ үлэмж хумигдаж, эрх үүрэг нь буурсаны зэрэгцээ тухайн үеийн хааны эрх мэдэл, сүр хүчээс шалтгаалан бүх монголыг хамарсан юм уу, эсвэл нэгэн түмтийн хүрээнд чуулах болсон байна. Их хуралдай хурал байсан их хаадын үеийг бодвол чуулганд оролцогчдын тоо цөөн, чуулах хугацаа алдаг оног байв. Хурлын байгууллагын үүрэг, нөлөө нийт улсын асуудлаас тухайлсан орон нутгийн асуудлыг хэлэлцэх болтлоо хумигдсан байна.

Хэдий тийм боловч "чуулган" хурлын байгууллагын үндсэн үүргээ биелүүлж, хууль хэлэлцэн батлах, монголчуудыг нэгдэн нягтруулах талаар бараггүй зүйл хийжээ. Эдгээрээс дорвитой зарим "чуулган"-ыг дурдвал, монголчуудыг нэгэн үзэл суртал-шашны тугийн дор нэгдэн нягтруулах зорилгоор зөвшилцөн Халхын шарын шашны тэргүүнийг өргөмжилсөн 1639 оны Цагаан нуурын чуулган, нийт Монгол

даяар мөрдөх "Их цааз"-ыг батлан гаргасан 1640 оны дөчин дөрвөн хоёрын ноёдын чуулган зэргийг дурдаж болох байна.

Монголчууд удаа дараагаар Манжид эзлэгдэж, төрийн тусгаар тогтнолоо алдсан 200 гаруй жилийн хооронд Монголын хурлын байгууллага бүрмөсөн устан арилсангүй. Манж нар Монголын уламжлалт "чуулган"-ыг эзэлдэн авч, монголчуудыг баримтлан захирах бодлогодоо ашигласан юм. Тэр үеийн "чуулган" нь Манжийн жанжин, сайд нарын хяналтын дор тухайн аймгийн бүх хэргийг зөвлөлдөн шийдвэрлэдэг газар байв. Түүнээс гаргасан шийдвэр нь Гадаад Монголын төрийг засах явдлын яам, заримдаа Манжийн хааны танилцаж зөвшөөрсөний дараа хэрэгжих тохиолдол ч байв. Манж нар монголчуудыг эрхшээлдээ оруулсны дараа "аймаг" хэмээх бие даасан засаг захиргааны нэгжийг байгуулснаар "чуулган" үүсэх анхны эхлэлийг тавьсан⁷ талаар судлаачид дурдсан нь буй. Манжийн төрийн байгууллага 1691 оноос хойш монголд нэгд, газар нутаг засаг захиргааг нэгтгэн захирсан төв байгууллагууд, хоёрт, засаг захиргааны нэгж болох аймаг, хошууны дотоод нэгж гэсэн үндсэн хоёр үе шаттайгаар төрийн байгууллагын тогтолцоог бий болгон хөгжүүлсэн байна. Энэхүү байгууллагууд нь манжийн хаанаас хэрэгжүүлж буй төрийн бодлогыг Монголд хэрэгжүүлдэг гүйцэтгэх шинжтэй захиргааны байгууллагууд байсан бөгөөд өөрийн бодит мөн чанарыг илэрхийлж манж хууль цаазыг тогтоон бэхжүүлж, нийгмийн харилцааг зохицуулах, түүний үр нөлөөг дээшлүүлэн боловсронгуй болгох үүрэгтэй төрийн байгууллага байсан юм⁸.

Манж нар монголын төрийн нэгэн хэлбэр болох "чуулган"-ыг засаг захиргааны нэгжийн хэлбэр болгон өөрчилж, чуулган чуулах

⁴ Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан, Монгол Улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал, УБ, 1997 он, 52 дэх тал.

⁵ Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан, Монгол Улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал, УБ, 1997 он.

⁶ М.Санждорж, Монгол төрийн түүхээс, Бүтээлийн эмхэтгэл, Гутгаар дэвтэр, УБ, 2007 он, 32 дэх тал.

⁷ Б.Баярсайхан, Манжийн ноёрхлын үе дэх монгол чуулган, түүний эрх зүйн зохицуулалт, Mongolia. An international annual of mongol studies, Vol. 9 (30), 1999 он, 123 дэх тал.

⁸ Б.Баярсайхан, Дурдсан өгүүлэл, 124 дэх тал.

болон түүний эрх зүйн үндсийг "Монгол цаазын бичиг", мөн "Зарлигаар тогтоосон гадаад монголын төрийг засах явдлын яамны хууль зүйлийн бичиг"¹⁰-ээр зохицуулж байхаар тусгаж өгчээ. Манж чин улсаас Монголын нийгмийн харилцааг зохицуулсан хууль цааз тогтоох бүрэн эрх нь Гадаад Монголын төрийг засах явдлын яаманд байсан бөгөөд түүнийг амьдралд хэрэгжүүлэх үүргийг Монгол дахь манж сайдын газар яамдуудаараа дамжуулан хэрэгжүүлдэг байв. Гэвч хууль тогтоох байгууллага дан ганц манжийн эдгээр байгууллагууд байсан гэж үзэж болохгүй.

Тухайн үед Халхын нөлөө бүхий ноёдын чуулган гэж байжээ. Энэ нь манжийн төрийн байгууллагатай зэрэгцэн оршиж, үйл ажиллагаагаа явуулан, хууль цаазаа тогтоож байсан билээ. Үүний нэгэн илрэл нь Халх журам хэмээх монгол хуулийг Халхын өөр өөр хошуудад удаа дараа тогтоон мөрдүүлж байснаас мэдэж болно. Эл үеийн монгол чуулганы эрх зүйн үндэс, үйл ажиллагаа, дэг ёсны талаар дурдсан баримт ховор боловч чуулганы бүтэц бүрэлдэхүүн, чуулганы хэзээ хаана, ямар үндэслэлээр чуулах болсон, чуулганы үйл явц, дэг, хэлэлцсэн асуудал, хүлээлгэх хариуцааг зэргийг уламжилж ирсэн хууль цаазын эх сурвалжуудаас олж үзэж болно.

Ямартай ч манжийн эрхшээлийн үеийн монгол чуулган нь өөрийн гэсэн онцлог шинжтэй, тодорхой зохион байгуулалт бүхий бүлэг хүмүүсийн идэвхтэй үйл ажиллагааны үр дүнд боловсрон, нийгмийн харилцааг зохицуулж чадахуйц эрх зүйн хэм хэмжээ тогтоосон актыг батлан гаргадаг байжээ.

1911 оны Үндэсний хувьсгалаар

монголчууд төрийн тусгаар тогтнолоо сэргээж, нэгдсэн Монгол Улс байгуулах хүнд бэрх тэмцэлд орсон билээ. Үүгээр 1911 оны 12 дугаар сарын 29-нд Богд Жавзандамба хутагтыг шинэ тулгар улсын хаанд өргөмжилж, Монгол тусгаар улс болсныг зарлан тунхаглажээ.

1914 оны хоёрдугаар сард Богд хааны "...Манай улс хурлын тэргүүн, төлөөний хүн энэ удаа сонгон гаргасангүй хэмээвч харьяат сайд түшмэд нийтээр газар орны байдлын төлөвийг төсөвлөн мэдэж чадахын тул, зүй нь урьдаар Улсын Дээд, Доод хэмээх хоёр хурлыг үүсгэн шийтгэсүгэй"¹¹ хэмээн зөвшөөрөн цохсоноор "улс төрийн аливаа хүнд чухал хэргийг бүгдээр нийлж шүүмжлэн хэлэлцэж, олны бодлогыг гаргасангүй" зорилго бүхий Улсын дээд, доод хурлыг байгуулав.

"Улсын хурал" нээхийн зорилго, ач тусыг "...аливаа улс төрийн бүхий л хэрэгт эрх үгүй хэрэг бүр санаа эрж шүүмжлэн хэлэлцэж санаа бодлогыг нэгтгэн улсын хүчин чийрэг бат, эдийн засаг сэлбэг дэлбэг, хүн бүр хүрэлцэхээр бүр баян талбиу, дотоодод ариун тодорхой, гадаадад найртай түвшин болох явдлыг өдөр бүр эрмэлзэн цаг бүр чармайн шийтгэвээс зохимуй"¹² хэмээн тодорхойлжээ. Хурлын дүрмийн 2 дугаар зүйлд Дээд, Доод хурлын эрх, үүргийг "Дээд хурлын олон сайд, ноёд болбоос улс төрийн чухал хэрэгт бодлого гарган зөвлөн хэлэлцээд айлтахыг айлтгаг. Таслан шийтгэхийг нь таслан шийтгэмүй. Доод хуралд тушаан өгч хэлэлцүүлэхийг нь хянан хэлэлцүүлмүй. Доод хуралд хэлэлцсэн хамаг хэргийг нягтлан тогтоож гүйцэтгэн шийтгэмүй. Доод хурлын олон түшмэд, бичиг данс бүхий ба үгүй, улс төрд тустай болох хэрэгт санаа гаргаж зөвлөн хэлэлцээд Дээд хуралд өргөж

тогтоомуй. Дээд хурлаас тушаан өгсөн хэргийг хянан хэлэлцээд, саналыг илтгэн мэдүүлж тогтоомуй. Хэрэв хэлэлцсэн хэргийн дотор хараахан нэгэн адил үгүй болохул тус тусын учрыг гаргаж мэдүүлмүй"¹⁴ хэмээн тодорхойлсон байна.

Улсын хурал байгуулахаар Монгол Улсын хаанд өргөн мэдүүлсэн бичгийг Бүгд ерөнхийлөн захирах яамны сайд буюу Ерөнхий сайд Т.Намнансүрэн, Сэцэн хан Ц.Наваансэрэн, Цэргийн хэргийг бүгд захиран шийтгэх яамны дэд сайд Жамъяандорж нар хамтран үйлдсэн бөгөөд Богд хаан уг бичигтэй танилцаад "гуйсан ёсоор болгогтун" хэмээн цохиж, мутрын тэмдгээ даржээ. Монгол Улсын хаанаас "Улсын хурлын газар"-ыг нээхийг гуйсан бичигт "олон яамны тэргүүн дэд сайдууд өөр хэргийн учир бүгдээр хуралдан зөвлөж" хэмээн өгүүлсэн нь уг асуудлыг бүх яамдын сайдууд хэлэлцэн шийдвэрлэснийг илтгэж байна.

Улсын дээд, доод хуралыг мөн "улсын хурлын яам" хэмээн нэрлэж байсан.

Эл хурлын талаар судлаач Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан нар "ийнхүү улсын дээд, доод хурал үйл ажиллагаа явуулж байсан нь нэгд, "Их хуралдай", "ноёдын чуулган", "хошуу чуулган" хийж ирсэн монгол төрийн уламжлалтай, хоёрт, олон улсын жишгийн дагуу парламентат ёсны туршлагыг авч хэрэглэх эрмэлзэлтэй, гуравт, ер нь тус оронд хөрөнгөтний бүгд найрамдах байгууллын үзэл санаа нэвтэрч эхэлсэнтэй тус тус холбоотой байлаа. Харин улсын хурал нь сонгуулийн бус гол төлөв язгуур угсаа, албан тушаалын зарчмыг баримтлан байгуулагдсан билээ" хэмээн дүгнэсэн байна.

Улсын хурлын статусыг Засгийн газарт зөвлөх эрхтэй тусгай

¹⁰ Монгол цаазын бичиг. Дөтөөр дэвтэр. Тэргүүн дэвтэр. Галиглаж, үгийн хэлхээ үйлдэн, эх бичгийн судалгаа хийсэн Б.Баярсайхан. УБ, 2004 он. 102-116 дахь тал.

¹¹ Зарлигаар тогтоосон гадаад монголын төрийг засах явдлын яамны хууль зүйлийн бичиг. Гучдугаар дэвтэр. Чуулган чуулах нь. Монголын төр, эрх зүйн түүх (дээж бичиг). IV дэвтэр. Эмхэтгэсэн Б.Баярсайхан, Б.Батбаяр. УБ, 2008 он. 253-255 дахь тал.

¹² Монголын төр, эрх зүйн түүх (дээж бичиг). III дэвтэр. Эмхэтгэсэн Б.Баярсайхан, Б.Батбаяр. УБ, 2006 он. 168 дахь тал.

¹³ Монголын төр, эрх зүйн түүх (дээж бичиг). III дэвтэр. Эмхэтгэсэн Б.Баярсайхан, Б.Батбаяр. УБ, 2006 он. 164 дэх тал.

¹⁴ Монголын төр, эрх зүйн түүх (дээж бичиг). III дэвтэр. Эмхэтгэсэн Б.Баярсайхан, Б.Батбаяр. УБ, 2006 он. 166 дахь тал.

¹⁵ Монголын төр, эрх зүйн түүх (дээж бичиг). III дэвтэр. Эмхэтгэсэн Б.Баярсайхан, Б.Батбаяр. УБ, 2006 он. 166 дахь тал.

байгууллага¹⁵, хааны дэргэдэх зөвлөх эрхтэй байгууллага¹⁶ байсан хэмээн судлаачид өөр өөрөөр авч үзсэн байдаг. Ямар боловч Монголд шашин, төрийг хослон барих хэмжээгүй эрхт хаант засаглал тогтсон тэр үед хоёр шат бүхий хурлын байгууллагыг байгуулсан нь барууны эрх зүйн соёлыг өөрийн улсад нэвтрүүлэх түүхэн эхлэлийг тавьсан анхны тохиолдол байв.

Дээрх бүгдээс дүгнэн үзвэл, нэн эртнээс хэмжээгүй эрхт Богд хаант Монгол Улсын үе (1920) хүртэл Монгол нутагт байсан эртний, дундад эртний болон шинэ түүхийн үеийн феодалын улсууд нь өөр өөрийн онцлог бүхий боловч мөн нэгэн адил хаант засагтай байсан нь тодорхой бөлгөө. Овгийн байгуулалын үеийн "нөхөд", "зе", Хүннугийн үеийн "хорин дөрөвний зөвлөл", "хуралдаан", "зэлэлдээн", Их Монгол Улсын үеийн "Их хуралдай", умард Юан болон бага хаадын үеийн "ноёдын чуулган", Манжийн эрхшээлийн үеийн "аймгийн чуулган" ("хошуу чуулган", "монгол чуулган"), хэмжээгүй эрхт Богд хаант Монгол Улсын үеийн "Дээд, Доод хурал" эд бүгд цөм нэгэн адил "төр улсын тунгавдсан чухал асуудлыг хянан хэлэлцэж, дээш өргөн толилуулах"-аас бус, хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлж байсангүй. Иймд Монгол төрийн 2000-гаад жилийн хугацаанд хууль тогтоох эрх мэдэл гагцхүү Хаанд хадгалагдаж байв. Харин төрийн дээд эрх хийгээд төрийн аливаа чухал асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэх бүх эрх "хурал"-д олгогдож байсан нь "хурал" хамгийн нэр хүнд бүхий онцгой эрхтэй байгууллага байсан нь илэрхий.

Хоёр. Үндсэн хуультай төрийн байгуулал тогтоохын төлөө тэмцлийн үеийн Улсын Их, Бага хурал (1921-1924 он)

1919 оны сүүлчээр Монгол орон

хятадын түрэмгийлэлд автан тусгаар тогтнолоо бүрмөсөн алдахын сэргээх монголд хятадын цэргийн эрхтний харгис дэглэм тогтсон байв. Үүнтэй зэрэгцэн монголын үндэсний ухамсар хүчтэй болж Нийслэлд Д.Бодоогийн толгойлсон Консулын бүлэг, С.Данзангаар удирдуулсан Хүрээний бүлэг, мөн да лам Пунцагдорж, жалханз хутагт Дамдинбазар зэрэг хар, шар ноёдоор удирдуулсан "Ноедын бүлэг"-үүд үүсч улмаар Бодоо, Данзан нарын бүлэг 1920 оны 6 дугаар сарын 25-нд "Монгол ардын нам" хэмээх хувьсгалт байгууллагад нэгдсэн бөгөөд тэр нь 1921 оны 3 дугаар сарын 1-нд байгуулагдсан Монгол Ардын намын эх үүсвэр нь болсон билээ.

1920 оны 2 дугаар сард Барон Унгерний оролцоотойгоор хятадын цэргээс Нийслэл хүрээг чөлөөлж, гадаад монголын автономийг дахин сэргээсний зарлан, Богдыг хаан ширээнд өргөмжилсөн бөгөөд мөн Засгийн газрыг таван яамын хамт байгуулсан түүхтэй. Эл засгийн газрыг түүхэнд "Хүрээний засгийн газар" хэмээн нэрлэж байсан боловч түүний үйл ажиллагаа, түүхэнд гүйцэтгэсэн үүргийг гаднын ганц нэг судлаачдыг¹⁷ эс тооцвол дагнасан судалгаа өнөө хэр үгүй болзолтой.

Ийнхүү автономит Засгийн газрыг дахин сэргээхээс 7 хоногийн дараа буюу 3 дугаар сарын 1-нд Ардын намын хурал болж 1921 оны 3 дугаар сарын 13-нд Монгол ардын түр Засгийн газрыг байгуулж, үндэсний ардчилсан хувьсгалын бэлтгэл ажлыг хийж эхэлсэн бөгөөд үүний үр дүнд Монгол Улсад хэмжээт цаазат хаант төр тогтсон юм. Ардын түр засгийн газрыг байгуулсан тогтоолд "түр зуурын засгийн газарт тулган даалгах нь, ... манай ардын төлөөлөгчдийн их

хурлыг зарлан хуралдуулж, үүрд байх засгийг олж, улсын үндсэн цааз дүрмийг тогтоолгосугай"¹⁸ гэжээ. Ардын түр засгийн газрыг 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан бөгөөд бүтцийн хувьд Дотоод, Цэргийн, Сангийн гэсэн гурван яамтай, Дотоод яам нь засах захирах, шүүх таслах, харилцан нэвтрэлцэх, гадаад хэрэг эрхлэх нийт дөрөв, Цэргийн яам нь байлдааны, цэрэг элсүүлэх, цэргийн шүүх нийт гурав, Сангийн яам нь худалдааны, хоол хүнсний нийт хоёр хэлтэстэй байв. 1921 оны 4 дүгээр сарын 23-нд Ардын түр Засгийн газрын дотоод зохион байгуулалтын тухай дүрэм, 5 дугаар сарын 23-нд албан хаагчид, ардын цэргийн дарга, цэрэг нэрт олгох цалингийн журам, мөн сарын 20-нд ажлын цагийг 7 цагаар тогтоож, 7 хоногт амралтын 1 өдөр бий болгох тухай тогтоолууд гарчээ.

Ардын түр Засгийн газар байгуулагдсан цагаасаа эхлэн нийслэл эдийн засгийн шинжтэй өөрчлөлтийг хэрэгжүүлж, мөн гэрхүү үйл ажиллагаагаа баталгаажуулсан хууль тогтоомжийн шинжтэй арга хэмжээнүүдийг бололцооны хэрээр авч байв. 1921 оны 7 дугаар сарын 10-нд "Хүрээний Засгийн газар"-ыг татан буулгаж яамдын тамга хэргийг Ардын Засгийн газраа шилжүүлэн авч, Ардын түр Засгийн газрыг Монгол Улсын Засгийн газар болгон өөрчилж, эмхлэн байгуулав. Энэ үеийн Засгийн газрыг зарим судлаач "үндэсний нэгдлийг эрхэмлэсэн, шилжилтийн шинжтэй Засгийн газар байсан"¹⁹ гэж дүнгэсэн нь буй. 1921 оны 7 дугаар сарын 23-ны Ардын Засгийн газрын тогтоолд "хааны зүгээс Засгийн газрын тогтоосныг эвдэх зүйлгүй бөгөөд засгийн газар түр цагийн буюу их хуралдаанаар хэлэлцүүлэн зөвлөлдөж бүх хууль дүрмийг тогтоож, хаанд айлтгаж явуулах тул,

¹⁵ Б.Содовсүрэн. Хувьсгалын өмнөх монголын төр ба хууль цааз. (1911-1920). УБ. 1989 он. 26 дахь тал.

¹⁶ Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан. Монгол Улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал. УБ. 1997 он. 181 дэх тал, Ц.Балхаажав. Төрийн тухай асуудал ба ардын төрийн хувьсгалт үйл ажиллагаа. УБ. 1966 он. 31 дэх тал, Монголын төрийн байгуулал улс төрийн сэтгэлгээний хөгжил. (МЭӨ III – МЭ XX зуун). Тэргүүн боть. УБ. 1995 он. 114 дэх тал, Т.Сэнгэдорж. Төгрөг зүйн онол түүх үндсэн салбарууд. УБ. 2005 он. 65 дахь тал, Д.Лүндээжанцан, Л.Өлзийсайхан. Парламентат ес. УБ. 2005 он.

¹⁷ Тачибана Макото. Хоёр засгийн газартай 1921 оны Монгол. УБ. 2006 он.

¹⁸ Монголд ардын бүгд найрамдах засаг тогтоон явуулсан нь. (1921-1926). УБ. 1970 он. 7 дахь тал.

¹⁹ М.Сангдорж. Монгол төрийн түүхээс. Бүтээлийн эмхтгэл. дэд дэвтэр. УБ. 2007. 40 дэх тал. Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан. Монгол Улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал. УБ. 1997 он. 213 дахь тал.

бас олон яам хязгаарын сайд нар айлтгах зүйлийг гагцхүү Засгийн газраар дамжуулан илтгэж байвал зохино"²² гэсэн нь хааны эрх хэмжээг хязгаарлаж, харин Ардын Засгийн газар гол эрх мэдлийг мэдэж байхаар болсон байна.

Ардын Засгийн газраас 1921 оны 11 дүгээр сарын 1-ний өдөр "Тангарагийн гэрээ" хэмээх дүрмийг баталж, Богд хаан, Ардын Засгийн газрын тус тусын эрх хэмжээ, хоорондын харилцааны зарчмыг тодорхойлжээ. Эл дүрмээр Богд улс төрийн холбогдолгүй, шашны талаарх бүх эрх мэдлийг хязгааргүй эдлэх, Ардын Засгийн газар нь хууль дүрмийг зарлах (гэхдээ Богдод айлтгана) гэх мэт улс төрийн эрхийг эдлэх талаар заажээ.

1921 оны 8 дугаар сард олон хошууны ард, түшмэд, ноёд, лам нар, Монгол ардын намын төлөөлөгчид оролцсон хуралдаан болж ардын эрхт хэмжээг цаазат засгийг дэмжиж буйгаа илэрхийлээд, Улсын Их Хурлыг хуралдуулахын янар зөвлөх эрх бүхий Улсын түр цагийн хурлыг байгуулахаар тогтож, мөн тэр оноо 9 дүгээр сарын 20-нд Ардын Засгийн газар Улсын түр цагийн хурлын дүрмийг баталж, хууль тогтоох бус зөвлөх эрхтэй байгууллага болохыг тодорхойлжээ. Энэ дүрэм ёсоор Улсын түр цагийн хурал ард, цэрэг, түшмэл, ноёд нийт 56 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдаж, 1921 оны 10 дугаар сарын 28-нд анхдугаар хуралдаанаа хийсэн байна. Эл хуралдаанаар лам нарын сахилга журам, яам, газруудын бичиг хэргийн зардлыг хэмнэх, цэргийн дүрэм журмыг боловсронгуй болгохтой холбоотой асуудлыг хэлэлцэн, зохио арга хэмжээ авахыг Ардын Засгийн газарт санал болгосон байна. Улсын түр цагийн хурал Ардын Засгийн газраас ирүүлсэн болон өөрсдийн санаачилсан асуудлыг хэлэлцэнэ. Уг хурал Улсын Их Хурлыг хуралдуулж бэлтгэл хангах түүхэн

үүргээ гүйцэтгээд 1923 оны эцсээр тарсан ажээ.

Ардын Засгийн газар болон Түр цагийн хурал нь оршин тогтнох хугацаандаа нэлээд олон хууль тогтоомжийн шинжтэй aktuудыг батлан гаргаж байв. Тухайлбал, дээр дурдсан aktuудаас гадна "Монголын олон засаг ба засаг бус ван гүнүүдийн эрх хэмжээний дүрэм", "Монгол Улсын нутгийн захиргааны дүрэм", "Бүх цэргийн зөвлөлийн дүрэм", "бүх цэргийн жанжны дүрэм" "Шүүх явдлын яамны дүрэм" гэх мэт²³. Гэвч энэ нь эдгээр байгууллагууд хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлж байсан гэсэн үг биш.

Судлаачдын бүтээлд "Ардын түр Засгийн газраас хууль тогтоох талаар авсан томоохон арга хэмжээ бол ..."²⁴, "АЗГ-аас 1921-1924 оны хооронд хууль тогтоох эрх мэдэл хэрэгжүүлж байсан"²⁵ гэх зэргээр дурдсан нь бий. Баримтаас үзвэл Ардын Засгийн газрын оршин байх хугацаанд нэлээд хэмжээний эрх зүйн aktuуд гарч байсан нь үнэнхэй боловч "хууль" гарч байсангүй. Иймээс хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлж байсан гэж үзэх нь учир дутагдалтай юм.

1921-1924 онд төрөөс хэрэгжүүлсэн улс төр, нийгэм эдийн засгийн арга хэмжээ нь Монголд үндсэн хуультай бүгд найрамдах байгуулал тогтоох үндэс болж өгчээ. Төрийг удирдах хэрэгт олон түмнийг өргөнөөр оролцуулах хэлбэр арван гэр, баг, сум, хошуу, аймаг, шавийн төлөөлөгчдийн хурал шат дараалан байгуулагдаж, ардын төлөөлөгчдийн байгууллагын нэгдмэл тогтолцоо төлөвшин хөгжи үндсийг бүрдүүлсэн байна. Засгийн газар, төлөөлөгчдийн их хурлыг зарлан хуралдуулж, улсын Үндсэн хуулийг боловсруулж хэлэлцүүлэх үүргээ биелүүлэхийн тулд нэлээд хэдэн арга хэмжээг авч хэрэгжүүлжээ. Улсын Их Хурлын дүрэм, Улсын Их Хурлын хуралдах

зааврыг баталж, Үндсэн хуулийн төсөл болон Их Хуралд хэлэлцүүлэх тайлангуудыг боловсруулж, Их Хурлын төлөөлөгчдийг сонгох ажиллагааг явуулж дуусгав.

Улсын Их Хурлын дүрэмд "Энэхүү Улсын Их хурал нь БНМАУ-ын дээд эрхийг хадгалах газар болно."²⁶ гэж тодорхойлсон бөгөөд түүний зохион байгуулалтын зарчим, эрх, үүрэг, үйл ажиллагааны хэлбэр, журмыг заажээ. Улсын Их Хурлын үйл ажиллагаа явуулах үндсэн хэлбэр нь "хуралдаан" бөгөөд түүнийг хурлын төлөөлөгчдийн гуравны хоёр нь хүрэлцэн ирснээр нээж, тэдгээрийн сонгосон хурлын дарга, дэд дарга, нарийн бичгийн дарга удирдан явуулна.

Их хурал Үндсэн хууль батлах, төрийн дээд байгууллагуудын илтгэл тайланг сонсох, тэдгээрийг байгуулах, үйл ажиллагаанд хяналт тавих, улсын дотоод, гадаад бодлогыг хэлэлцэж, тогтоол заалтыг батлахдаа төлөөлөгчдийн гуравны хоёр хүртэл эхвийн санал нийлж зөвшөөрснөөр батална. Эл дүрмийн үндсэн дээр Улсын анхдугаар Их Хурал 1924 оны 11 дүгээр сарын 8-нд Нийслэл хүрээнд 77 төлөөлөгч оролцон Засгийн газар, яамдын тайлан, Үндсэн хуулийн төсөл, Улсын Бага Хурлыг байгуулах зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэжээ. Энэ хурлаас Улсын Бага Хурлыг 30 гишүүнтэйгээр, мөн тус бага хурлаас Улсын Бага Хурлын тэргүүлэгчдийг 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр, Засгийн газрыг 12 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан байна. Улсын Их, Бага Хурал, түүний тэргүүлэгчид байгуулагдсанаар төрийн эрх барих дээд байгууллагын тогтолцоо бүрджээ.

Улсын Их Хурал 11 дүгээр сарын 26-ны өдөр Монгол Улсын анхны Үндсэн хуулийг баталсан бөгөөд "Улсын дээд эрхийг барих газрын тухай" гэсэн 2 дугаар бүлэгт Улсын

²² 1921-1924 онд авсан хувьсгалт арга хэмжээүүд. УБ. 1954 он. 22 дахь тал.

²³ Б.Баярсайхан, Б.Батбаяр, Б.Лхагважав, М.Сүхбаатар. Монгол Улсын хууль тогтоомжийн хөгжлийн түүхэн товчоон. (1911-2008). УБ. 2008 он. 47-64 дэх талд дэлгэрэнгүй буй.

²⁴ Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан. Монгол Улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал. УБ. 1997 он. 210 дахь тал.

²⁵ Д.Солонго. Төрийн эрх зүйн тайлбар толь. УБ. 2003 он. 68 дахь тал.

²⁶ Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Хурлын дүрэм. Монголд ардын бүгд найрамдах засаг тогтоон явуулсан нь (1921-1926).

УБ. 1970 он. 39 дэх тал

Их Хурал, Улсын Бага Хурал, түүний тэргүүлэгчид, Засгийн Газар, эдийн засгийн зөвлөлийн бүрэн эрх, бүрэлдэхүүн, бүтэц, байгуулах журмын үндсийг бататган бэхжүүлсэн байна.

Ингэж 1924 онд хуралдсан Улсын анхдугаар Их Хурлаар баталсан Үндсэн хууль Монгол дахь төлөөлөлийн ардчилалыг хуульчлан баталгаажуулж, үүний үр дүнд Монгол оронд ард түмэн өөрсдөө удирдлагаа хэрэгжүүлэх эхлэл тавигдсан билээ.

1921-1924 оны хооронд бие даасан нэг ч "хууль" гарч байгаагүй бөгөөд мөн засгийн газрын өргөн барьсан эрх зүйн актыг Богд хаанд толилуулж байсан, мөн Богдын зөвшөөрөн цохсон гэсэн баримт олдоогүй тул энэ үеийн Засгийн газар (хэдийгээр дүрмэндээ Засгийн газар нь хэмжээт эрхт хаантай зөвшилцсөний үндсэн дээр хууль дүрмийг батлах... гэж заасан ч) нь "хууль" баталж байсангүй. Харин дүрэм, тогтоолыг эрх хэмжээнийхээ хүрээнд тогтоон мөрдүүлж байсныг хууль батлахтай хутган ойлгож болохгүй юм. Иймээс эл үеийн Засгийн газрыг хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлж байсан гэж үзэх нь эргэлзээтэй.

Гурав. Анхдугаар Үндсэн хууль үйлчлэх үеийн Улсын Их, Бага Хурал (1924-1940 он)

1924 оны 3 дугаар сарын 24-нд БНМАУ-ын шинэчлэн тогтоосон Улсын Их Хурлын дүрэм, БНМАУ-ын Их Хурлын төлөөлөгчдийг сонгох дүрэм, 1925 оны 3 дугаар сарын 24-нд Улсын Их, Бага хурлын гишүүдийн эрх хэмжээний дүрэм, 1933 оны 1 дүгээр сарын 17-нд Улсын Бага Хурлын гишүүдийн тухай дүрмийг тус тус баталсан нь Монгол Улсын төрийн дээд эрх барих төлөөлөгчдийн байгууллагын зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндэс болжээ. 1924 оноос өмнө засаг захиргааны хувиарлалтын хувьд цэрэг захиргааны шинжтэй байсан бөгөөд эл үед аж ахуй захиргааны шинжээр зохион байгуулагдах болсон байна. Энэ талаар судлаач

М.Санждорж өөрийн бүтээлдээ түүхэн цаг хугацаагаар нь дэлгэрэнгүй авч үзсэн билээ²⁵. Засаг захиргаа нутаг дэвсгэрийн хуваарьт гарсан өөрчлөлтийг даган төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагын тогтолцоо мөн өөрчлөгджээ. 1931 онд батлагдсан шинэ хуваарь ёсоор тус улсад бүрэлдэн тогтсон Ардын хурлын тогтолцоо нь багийн ба хорины, сумын ба хорооны, аймгийн ба хотын, Улсын Их Хурал гэсэн шаттай болсон байна.

Эл үеийн ардын хурлын зорилт нь улс орны нийгэм, улс төр, эдийн засаг, соёлыг хөгжүүлэх тодорхой бодлого зорилтыг тогтоох ба түүний биелэлтийг хянан шалгах, төрийн гүйцэтгэн захирах байгууллагыг сонгон байгуулж, тэдгээрийг өөртөө бүрэн захирах зарчмыг хэрэгжүүлэхэд оршиж байв. Ардын хурлын үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байв. Хурлууд нь байнгын ажиллагаатай биш боловч тогтмол хугацаанд нэлээд урт хугацаагаар хуралдана. Улсын Их Хурлын хэлэлцэх асуудлыг Улсын Бага Хурлын тэргүүлэгчид ба Ардын Засгийн газраас төлөөлөн оруулж байсан бөгөөд аль ч шатны хурлын төлөөлөгчид өөрийн санаачлагаар хуралд асуудал оруулан хэлэлцүүлэх эрхтэй байв.

Улсын Их Хурал нь улсын дээд эрх барих байгууллагын хувьд Үндсэн хуульд өөрчлөлт, нэмэлт оруулах, төрийн дотоод, гадаад бодлогын үндсийг тодорхойлох, төрийн дээд, төв байгууллагын үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх. Их Хурлын ба Засгийн газрын гишүүдэд асуулт тавих, хариулт авах, хууль батлах, түүний биелэлтэд хяналт тавих бүрэн эрхтэй. Улсын Их Хурал ажлаа дуусмагч төрийн бүх асуудлыг Улсын Бага Хуралд шилжүүлнэ. Улсын Их Хурлын чөлөө цагт төрийн дээд эрхийг Улсын Бага хурал барих бөгөөд Улсын Бага Хурал нь хууль, дүрэм батлах, биелэлтэд нь хяналт тавих, төрийн захиргааны дээд, төв байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих, Улсын Бага Хурлын Тэргүүлэгчид,

Засгийн газрыг байгуулах асуудлыг шийдвэрлэж, Улсын Их Хуралд ажлаа тайлагнана. Улсын Бага Хурлын үйл ажиллагааны хэлбэр, журам нь Улсын Их Хурлынхтай үндсэндээ адил. Тус бага хурлын бүрэн эрхийн хугацааг 1934 он хүртэл 1 жил байсан бол 1934 оноос хойш 3 жил болов. Үндсэн хуульд Улсын Бага Хурлын ээлжит чуулганыг жилд 2 удаа хуралдуулж байхаар заажээ.

1925-1939 онд БНМАУ-ын Бага Хурал 7 удаа байгуулагдаж, 22 удаа чуулж, улсын дотоод, гадаад олон чухал асуудлыг шийдвэрлэсэн байна²⁶. 1925, 1930, 1933 онд баталсан БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн дүрэмд тэргүүлэгчдийн бүтэц, бүрэлдэхүүн, бүрэн эрх, ажиллах журмыг заажээ. Бага Хурлын тэргүүлэгчид нь бага хурлыг хуралдуулах, бага хуралд хэлэлцэх асуудлыг боловсруулах, Их, Бага Хурлын тогтоолын биелэлтэд хяналт тавих, гадаад улстай байгуулсан гэрээ хэлэлцээрийг батлах, цуцлах, ял хэлтрүүлэх, өршөөл үзүүлэх, гавьяа байгуулсан хүнийг өөрийн санаачилгаар буюу Засгийн газрын хүсэлтээр төрийн дээд шагналаар шагнах, түүнчлэн Бага Хурлын чөлөө цагт төрийн захиргааны төв байгууллагын сайд, дарга нарыг томилох, огцруулах зэрэг бүрэн эрхийг хэрэгжүүлж байв.

Эл үед монголд хаант засгийг халж бүгд найрамдах засгийг тунхагласан хэдий ч бүгд найрамдах засаг жинхэнэ утгаар хэрэгжээгүй. Гэхдээ Монгол Улс анх удаа Үндсэн хуультай болж монголд парламентат эс бий болох эх үндэсийг тавьснаараа түүхэн ач холбогдолтой болсон юм. Анхдугаар Үндсэн хууль болон Их хурлын сонгуулийн тухай дүрэмд ард түмнээс сонгогдох ёстой байсан төрийн удирдлагыг хөсөрдүүлсэн заалтууд орж хуульчлагдсан нь сонгох, сонгогдох эрх, амьд явах, итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, өмч хөрөнгө эзэмших, эрүү шүүлтэд тулгагдахгүй байх зэрэг эрх үндсэндээ эерхцгидэж эхэлсэн байна. Тэрчлэн төрийн дээд

²⁵ М.Санждорж. Монгол төрийн түүхээс. Бүтээлийн эмхтгэл, дэд дэвтэр. УБ, 2007 он. 173-182 дахь тал.

²⁶ Ж.Болдбаатар. Д.Лүндэжжанцан. Монгол Улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал. УБ, 1997 он. 240 дэх тал.

эрхийг олон этгээдэд (Улсын Их Хурал, түүний чөлөө цагт бага хурал, түүний чөлөө цагт Бага Хурлын тэргүүлэгчид ба Засгийн газар) олгосныг үндэслэн судлаач Д.Лүндээжанцан "...Улсын Их Хурал хуралдахаа больж, Бага Хурлын гишүүдийн тоо цөөрч, нэг хүний гарт төрийн гол албан тушаалууд төвлөрч, дотоод яамыг төрийн хяналтаас гаргаж, шүүн таслах дээд эрхтэй онцгой бүрэн эрхт комисс ажилласан нь парламентат ёсны гажуудал, хууль ёсны алдаа завхрал гарах нөхцөлийг бүрдүүлсэн"²⁷ хэмээн оновчтой дүгнэсэн нь буй.

Хоёрдугаар Үндсэн хууль үйлчлэх үеийн Улсын Их, Бага Хурал (1940-1960 он)

1940 он гэхэд монголд нийгэм, эдийн засгийн хөгжилд үндсэн өөрчлөлт гарсны дагуу анхдугаар Үндсэн хуулийг нийгмийн хөгжлийн зорилтод нийцүүлэн шинэчлэн батлах шаардлагатай болсон байна. 1940 оны 3 дугаар сард МАХН-ын арвадугаар их хурал хуралдаж тус намын мөрийг хөтөлбөрийг батлан, улмаар 6 дугаар сард улсын наймдугаар их хурал хуралдаж шинэ Үндсэн хуулийг баталжээ. Шинэ Үндсэн хуулиар "БНМАУ-ын засгийн дээд эрхийг барих газар нь Улсын Их Хурал болно"²⁸ гэжээ. Улсын Их Хурал нь хот ба аймгийн хурлуудаар хүн амын 1500 хүн тутмаас нэг төлөөлөгчөөр сонгогдсон хот, аймгийн хөдөлмөрчин ард олон ба ардын хувьсгалт цэргийн албан хаагчдын төлөөлөгчдөөс байгуулагдана. Улсын Их Хурлыг Улсын Бага Хурлаас гурван жилд нэг удаа зарлан хуралдуулах, онц их хурлыг Улсын Бага Хурлын үзмэжээр буюу бүх хүн амын гуравны нэг хувиас доошгүйг төлөөлөн орон нутгийн засаг захиргааны байгууллагын шаардсанаар зарлан хуралдуулахаар тогтоожээ.

Улсын Их Хурал нь: 1. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын

Үндсэн хуулийг батлах ба өөрчлөх; 2. Гадаад, дотоодын улс төрийн бодлогын талаар үндсэн зарчим ба арга хэмжээнүүдийг тогтоох; 3. Бага Хурлын гишүүдийг сонгох бүрэн эрхтэй байв.

Улсын Их Хурлын чөлөө цагт засгийн дээд эрхийг Улсын Бага Хурал барих бөгөөд Бага Хурлыг Их Хурлаас хүн амын 10000 хүн тутмаас нэг гишүүнээр хэмжээ тогтоон 3 жилийн хугацаагаар сонгоно. Бага Хурал: "1. Улсын Их Хурлыг зарлан хуралдуулах; 2. Сайд нарын Зөвлөлийг байгуулах, шинээр байгуулагдсан яамд ба улсын төсвийн байгууллагуудыг батлах, өөрчлөх хэргийг эрхэлнэ; 3. Шалтгаан тохиолдвол Сайд нарын Зөвлөлийн тогтоол ба тушаалыг хүчингүй болгоно; 4. Бага Хурлын чөлөө цагт Бага Хурлын Тэргүүлэгчдээс гаргасан хууль дүрмүүдийг батлах; 5. Улсын орлого, зарлагыг хянах ба батлах; 6. Бага Хурлын Тэргүүлэгчид ба Сайд нарын Зөвлөлийн илтгэлүүдийг сонсох ба үлс төр, аж ахуй, соёл боловсролын байгууллын асуудлуудыг хянан хэлэлцэх; 7. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Дээд Шүүхийг сонгох; 8. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Прокурорыг томилох"²⁹ бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

Бага Хурал долоон гишүүний бүрэлдэхүүнтэй ба Бага Хурлын тэргүүлэгчид нь Бага Хурлын чөлөө цагт улсын засгийн дээд эрхийг барих байгууллага байв. Бага Хурлын тэргүүлэгчид нь Бага Хурлыг зарлан хуралдуулах, Бага Хурлын гишүүдийг сонгох, Бага Хурлаас батлах хүртэл шинэ хуулийг гаргах, хуульд тайлбар өгөх, өршөөл үзүүлэх, одон тэмдгээр шагнах, дипломат төлөөлөгчийг томилох, чөлөөлөх гэх мэт Үндсэн хуульд заасан бүрэн эрхийг эдэлж, үйл ажиллагаагаа Бага Хуралд гаргаж, Бага хурал нь Их хуралд тайлагнана. Эл Үндсэн хуульд төлөөллийн ардчилалын үндсэн зарчмыг хуульчлан тогтоосон боловч

энэ нь хэрэг дээрээ хэлбэрийн төдий байсан билээ.

1944 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр хуралдсан Бага Хурлын тэргүүлэгчдийн тогтоолоор³⁰ анхдугаар Үндсэн хуулиар эрх нь хасагдсан хүмүүст сонгуулийн эрхийг нь олгож Үндсэн хуулинд өөрчлөлт оруулахаар шийдвэрлэжээ. Үүний үндсэн дээр 1949 онд Улсын 9 дүгээр Их Хурлын сонгууль болж тус Их Хурлаас насанд хүрсэн нийт иргэн, засаг төрийн төлөөлөгчдийг нийт, шууд, тэгш эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж сонгох шинэ тогтолцоог хуульчлан баталжээ.³¹

Тэрчлэн Улсын Бага Хурал, түүний Тэргүүлэгчдийг татан буулгаж, Төрийн эрх барих дээд байгууллага-Улсын Их хурал сонгуулийн тойрог бүрээс сонгосон депутатуудаас бүрэлдэх болов. Улсын Их хурлаас үйл ажиллагаагаа явуулах гол хэлбэр нь "чуулган" гэж тогтоожээ. Улсын Их хурлын чуулганы чөлөөт цагт төрийн дээд эрхийг Улсын Их хурлын тэргүүлэгчид барина. 1957 оны 7 дугаар сарын 6-нд Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөөр Улсын Их хурлын бүрэн эрхийн хугацааг 4 жил болгож Их Хуралд мандатын, гадаад хэргийн, хуулийн, төсвийн байнгын комиссууд байгуулахаар тогтоожээ. Үүний үндсэн дээр Улсын Их Хурлын бүтэц, бүрэлдэхүүн, үүрэг есөн өргөжсөн байна.

Гуравдугаар Үндсэн хууль үйлчлэх үеийн Ардын Их Хурал (1960-1990 он)

1940-1960 оны хооронд бий болсон улс төр, нийгэм, эдийн засгийн өөрчлөлтүүд нь 1940 оны Үндсэн хуулийг дахин өөрчлөх шаардлагыг бий болгосны улмаас 1960 оны 5 дугаар сард Үндсэн хуулийн төсөл боловсруулах комиссыг байгуулжээ. Ингээд 1960 оны 7 дугаар сард шинэ Үндсэн хуулийг баталсан бөгөөд түүхэнд

²⁷ Д.Лүндээжанцан, Монгол Улс дахь төрийн эрх мэдлийн хуваарилалт, УБ, 2001 он, 140 дэх тал.

²⁸ Монгол Улсын Үндсэн хууль, Эмхэтгэж, тайлбар бичсэн Ж.Амарсанаа, О.Батсайхан, УБ, 2004 он, 144 дэх тал.

²⁹ Монгол Улсын Үндсэн хууль, Эмхэтгэж, тайлбар бичсэн Ж.Амарсанаа, О.Батсайхан, УБ, 2004 он, 145 дахь тал.

³⁰ Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Үндсэн хууль түүнд холбогдох актын эмхэтгэл, (1941-1970) Хоёрдугаар дүгээр, УБ, 1974 он, 49 дэх тал.

³¹ Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Их, Бага хурлын тогтоол, Үндсэн хууль, тунхагууд, Эмхэтгэсэн Ц.Насанбалжир, УБ, 1996 он, 247-248 дахь тал.

гравдугаар Үндсэн хууль хэмээн нэршжээ. Эп хууль нь 1921-1960 он хүртэлх хугацаанд шийдвэрлэсэн зорилтуудыг дүгнэж, цаашид социализмын материал техникийн баазыг байгуулж, улмаар коммунизмд дэвшин орох зорилготой МАХН-ын ролийг гүнзгийлгэсэн жинхэнэ социалист Үндсэн хууль байсан бөгөөд нийгмийн социалист байгуулалтын ба эдийн засгийн үндсэн зарчим, үүргүүдийг бэхжүүлж өгсөн юм.³²

Тус Үндсэн хуульд "БНМАУ бол ажилчид, хоршоолсон ардууд (малчин, тариачид), хөдөлмөрч сэхээтний социалист улс бөгөөд түүний үндэс нь ажилчин анги, хоршоолсон ардын холбоо мөн"³³ гэж улсын шинж чанар, ангийн бүрэлдэхүүнийг хуульчлан тодорхойлсон бөгөөд Үндсэн хууль ёсоор БНМАУ-ын улс төрийн үндэс нь бүх шатны Ардын Депутатын Хурал болсон байна. БНМАУ-ын Ардын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага, хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Ардын Их Хуралд хадгална, Ардын Их Хурлын чуулганы чөлөө цагт Ардын Их Хурлын тэргүүлэгчид төрийн эрх барих дээд байгууллага байхаар Үндсэн хуулиар хуульчлан тогтоожээ. БНМАУ-ын Ардын Их Хурлын бүрэн эрх, гишүүний бүрэн эрх, үндсэн үүрэг, үйл ажиллагааны зарчим, зохион байгуулалтын бүтцийг мөн адил хуулиар бататгасан байна. Тодруулбал, Ардын Их Хурал нь бүх шатны Ардын депутатын хурлын системийг толгойлж улс орныг төрийн үзгээс удирдах бүрэн эрхийг хэрэгжүүлж, төрийн бусад дээд, төв байгууллагын бүтэц, бүрэлдэхүүнийг тогтоож, үйл ажиллагааг нь хянаж удирдан, Үндсэн хууль, бусад хуулиудыг батлах эрхийг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ.

Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн бүрэлдэхүүн нь Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн дарга, орлогч дарга нар, нарийн бичгийн дарга, тэргүүлэгч гишүүнээс бүрдэнэ. Ардын Их Хурлын тэргүүлэгчид

Ардын Их Хуралд ажлаа хариуцна. Ардын Их Хурлын тэргүүлэгчид нь Ардын Их Хурлын гол эрх хэмжээг илэрхийлдэг зарим чухал асуудлыг Ардын Их Хурлын чуулганы чөлөө цагт өөрийн бүрэн эрхэд хамааруулан шийдвэрлэдэг байв. Жишээ нь, Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн зарлигаар хууль батлаад, дараа нь Ардын Их Хурлын чуулганд оруулж баталгаажуулдаг байсан кишиг нь Ардын Их Хурлын хууль тогтоох үйл ажиллагааг хэлбэрлэхэд хүргэж байжээ.

Ардын Их Хурлын бүрэн эрхийн хугацааг 1980 онд 5 жил болгожээ. Мөн Ардын Их Хурлын сонгуулийн тойрог 370 байхаар тогтоов. Үүнтэй уялдан Ардын Их Хурал 370 депутатаас бүрэлдэх болсон байна. 1981 онд Ардын Их Хурлын 10 дахь удаагийн сонгуулийн анхдугаар чуулган БНМАУ-ын Ардын Их Хурлын регламентыг 12 бүлэг, 70 зүйлтэйгээр баталжээ. Энэхүү Регламентаар Ардын Их Хурлын бүтэц, бүрэлдэхүүн, үйл ажиллагааны зохион байгуулалт, ажиллах журмыг нарийвчлан заасан байна.

Үндсэн хуулийн заалтууд болон судлаачдын бичсэнээс үзвэл хууль тогтоох эрх мэдэл гүйцэтгэх дээд байгууллага болон түүнийг бүрдүүлдэг Намын төв хороо, түүний улс төрийн товчоонд хадгалагдаж байсан нь монголоор төр дэх томоохон гажуудал болсон байна.

1980-аад оны сүүлч 1990 оны эхээр дэлхий дахины улс төрийн хөгжилд эрс өөрчлөлт гарч, социалист орнуудад хүн төрөлхтний улс төрийн үнэт зүйлсийг хүлээн авч хэрэгжүүлэх нөхцөл бололцоо аажмаар бүрэлдэж эхэлсн бөгөөд манай улсад ч энэ үйл явц бий болох эхлэл тавигджээ.

Өмнөх гурван Үндсэн хуулийн үеийн хууль тогтоох байгууллагын талаар судлаач Д.Лүндээжанцан шударга ардчилсан сонгуулиар байгуулагдах төрийн эрх барих дээд байгууллага болох парламентын төлөөллийн тогтолцоо хэлбэрийн,

ёс төдий шинжтэй, улс төрийн тогтолцооны цөм болсон нэг намын бодлого төрийн бодлогоос дээгүүр тавигдаж, сонгодог парламентын гол шалгуур болох ард түмний хүсэл зориг төлөөллийн байгууллагаар илэрхийлэгдэх зарчим алдагдаж, гагцхүү намын бодлогын "үг дуугүй" биелүүлэх, захиргаадаль газар авсан, гүйцэтгэх эрх мэдэл бүхий байгууллага нь зарим үед хууль тогтоох байгууллагаасаа ч дээд эрх мэдэлтэй байсан гэж хэлж болохоор байна³⁴ гэсэн дүгнэлттэй санал нийлж байна.

Үндсэн хуулийн шилжилтийн зурвас үеийн Улсын Их, Бага Хурал (1990-1992 он)

1990 оны 5 дугаар сарын 10-нд БНМАУ-ын Ардын Их Хурлын 11 дэх удаагийн сонгуулийн 9 дүгээр чуулган болж, уг чуулганаар БНМАУ-ын төрийн эрх барих дээд байгууллагын бүтцийг өөрчлөн шинэчлэх тухай БНМАУ-ын Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуулийн төслийг хэлэлцэн батлав. Энэ хууль Ардын Их Хурлын зохион байгуулалт бүрэн эрхийг шинэчлэн тогтоож, Монгол Улсыг Ерөнхийлөгчтэй болгож, Улсын Бага Хурлыг байгуулж парламентын чиг үүрэгтэйгээр ажиллуулах, Сайд нарын зөвлөлийг шинэчлэн зохион байгуулахаар заасан байна.

Мөн Улсын Бага Хурал нь хууль тогтоох, хянан шалгах, зохион байгуулах бүрэн эрх бүхий төрийн эрх барих дээд байгууллага мөн гэж заав. Улсын Бага Хурлын бүтэц, бүрэлдэхүүн, байгуулах журам, бүрэн эрхийн үндсийг хуульчлан бэхжүүлжээ. БНМАУ-ын Үндсэн хуулийн нэмэлтийн хуулийн дагуу 430 депутатаас бүрэлдсэн БНМАУ-ын Ардын Их Хурал байгуулагдав. БНМАУ-ын Бага Хурлыг байгуулж, БНМАУ-ын анхны Ерөнхийлөгчөөр П.Очирбатыг сонгосон байна. Ийнхүү Улсын Их, Бага Хурлын зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндэс, баталгаа бий болж, төрийн эрх барих дээд байгууллагын тогтолцоо тогтов.

³² Д.Батаа. Монгол Улсын Үндсэн хуулиудад орсон нэмэлт, өөрчлөлтүүд. УБ., 1998 он. 1 дэх тал.

³³ Монгол Улсын Үндсэн хууль. Эмхтгэж, тайлбар бичсэн Ж.Амарсанаа, О.Батсайхан. УБ., 2004 он. 248 дахь тал.

³⁴ Д.Лүндээжанцан. Монгол Улс дахь төрийн эрх мэдлийн хуваарилалт. УБ., 2001 он. 143 дахь тал.

Төрийн эрх барих байгууллагыг шинэчлэхдээ нам, төрийн үүргийг зааглах, улс төрийн тогтолцооны гол цөм нь төр байх, түүний чиг үүргийг бүх талаар өндөржүүлж, эрх хэмжээг өргөтгөх, хуулийн үүргийг хүчтэй болгох, парламентын нэгдмэл тогтолцоог бүрдүүлэн төлөвшүүлэх, ардчилалыг хөгжүүлэх зэрэг чиглэлийг баримталжээ. Төрийн эрх барих уламжлалт дээд байгууллага-Ардын Их Хурал, парламентат ёсны шинэ байгууллага-Улсын Бага Хурал, төрийн тэргүүн-Ерөнхийлөгчийн институтыг бий болгож, тэдгээрийн хооронд эрх мэдлийн харилцан хамаарал, тэнцэлийг бий болгохыг зорьсон байна.

АИХ-ын талаар УБХ-ын тэргүүлэгчдийн дарга П.Очирбатын "БНМАУ-ын төрийн эрх барих дээд байгууллагын бүтцийг өөрчлөн шинэчлэх тухай БНМАУ-ын Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуулийн төсөл" илтгэлд "Шинээр байгуулагдах Ардын Их Хурлаас улс орны дээд жолоодлогын гол зангилаа, зарчмын асуудлыг шийдвэрлэх, төрийн дотоод, гадаад бодлогын үндсийг тогтоож, нийгмийн дээд хяналт шалгалтыг хэрэгжүүлж байхаар бодож түүний бүрэн эрхийг тодорхойлох. Гэхдээ одоогийнх шиг аливаа хууль гаргах, жил бүрийн улсын төлөвлөгөө төсөв, тэдгээрийн гүйцэтгэлийн тайланг үзэж батлах, яамдыг байгуулах, татан буулгах, өршөөл үзүүлэх зэрэг аливаа том жижиг асуудал авч хэлэлцээд байх шаардлагыг гэж үзлээс²⁵ гэснээс үзвэл АИХ-ын парламент байх шинжийг үгүйсгэж байна.

Ардын Их Хурал БНМАУ-ын иргэдээс 5 жилийн хугацаагаар сонгосон депутатуудаас бүрдэнэ. Ардын Их Хурал зөвхөн 1. БНМАУ-ын Үндсэн хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах; 2. БНМАУ-ын Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгчийг сонгох, чөлөөлөх; 3. БНМАУ-ын Бага Хурлын бүрэлдэхүүнд нь өөрчлөлт оруулах; 4. БНМАУ-ын Үндсэн хуулийн хяналтын зөвлөлийг байгуулах,

бүрэлдэхүүнд нь өөрчлөлт оруулах; 5. БНМАУ-ын Ерөнхийлөгчийн санал болгосноор БНМАУ-ын Ерөнхий сайд, БНМАУ-ын Ерөнхий прокурорыг БНМАУ-ын Дээд шүүхийн даргыг сонгох, чөлөөлөх; 6. БНМАУ-ын нийгэм, эдийн засгийн хөгжлийн үндсэн чиглэлийг тодорхойлох асуудлыг өөрийн онц эрхийн хэмжээнд хэлэлцэн шийдвэрлэнэ.

Эдгээрээс гадна БНМАУ-ын Ардын Их Хурал төрийн дотоод, гадаад бодлогын ямар ч асуудлыг санаачлагаараа хэлэлцэн шийдвэрлэж, хууль, тогтоол гаргаж болно. Ардын Их Хурлын зохион байгууллалт, үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь түүний хуралдаан болно. Хуралдааныг Ардын Их Хурлын бүрэн эрхийн хугацаанд 4 удаа хийнэ. Ээлжит бус хуралдааныг Ардын Их Хурлын депутатуудын олонхийн шаардлага, эсхүл Улсын Бага Хурал, Ерөнхийлөгчийн санаачлагаар хийж болно.

БНМАУ-ын Ардын Их Хурал нь дарга, орлогч дарга нартай байх ба тэдгээрийг хуралдаан бүрээс сонгоно. Депутатуудын 75 хувиас доошгүй нь ирсэн бол Ардын Их Хурлын хуралдаан хүчинтэй болно. Тэрчлэн мөн хуульд зааснаар Улсын Бага Хурал дор дурдсан асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх эрхтэй. Үүнд: ... 1. Хууль гаргах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, ... 12. Улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн төлөвлөгөө, нэгдсэн төсөв, тэдгээрийн гүйцэтгэлийн тайланг батлах, ... 17. БНМАУ-ын олон улсын гэрээг соёрхон батлах, цуцлах, ...²⁶ гэх мэт 20 заалтыг дурдсан байдаг.

Тэрхүү дурдсан бүрэн эрхийн 1, 12, 17-д дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлэх болсноороо Улсын Бага Хурал нь парламентийн үндсэн шинжийг олжээ. Өөрөөр хэлбэл Ардын их хурал дээд эрхийг хадгалуулсан атлаа мөн чанартаа хязгаарласан бөгөөд харин тэрхүү эрхийг Улсын Бага Хурал эдлэх болсон нь хоёрдмол шинжийг агуулж байна гэж үзэж болох таатай. Тодруулбал, хууль тогтоох эрх мэдлийг Ардын Их Хурал бус Улсын

Бага Хурал хэрэгжүүлж байсан гэсэн үг.

Үндсэн хуулийн шилжилтийн зурвас үеийн парламентат ёсны тогтолцоонд Улсын Бага Хурал онцгой байр суурьтай бөгөөд хууль тогтоох, хянан шалгах, зохион байгуулах бүрэн эрхийг хэрэгжүүлэх болсноороо Улсын Бага Хурал нь парламентат ёсыг жинхэнэ утгаар хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэв. Улсын Бага Хурал нь хагас жил тутам нэг удаа тус бүр 75 хоног хүртэл хугацаагаар ээлжит чуулган хийнэ. Улсын Бага Хурал парламентын үндсэн хэлбэр болохын хувьд улс төрийн намууд сонгуульд авсан саналын нийт дунд үндэслэн хуваарилсан зохих тооны мандаттай болсноор парламентын гишүүнээр нэр дэвшүүлнэ. Нэр дэвшигч нь Ардын Их Хурлын депутатуудын дотроос буюу депутат бус, намын гишүүн ба гишүүн бус хүн байж болно. Ардын Их Хурал нэр дэвшигч нэг бүр дээр хэлэлцэж, олонхийн санал авсан хүн Улсын Бага Хурлын гишүүн болно. Саналыг нууцаар явуулна.

Улсын Бага Хурал дарга, орлогч дарга, нарийн бичгийн дарга, 50 гишүүнээс бүрэлдэх бөгөөд эдгээрийн дөрөвний гурван хувь нь Ардын Их Хуралын депутатуудын дотроос сонгогдсон байх ёстой. Улсын Бага Хурлын дарга нь БНМАУ-ын Дэд ерөнхийлөгч байна. БНМАУ-ын Бага Хурал нь эдгээрээс гадна Ардын Их Хурлын эрх хэмжээнд хамаарахаас бусад төрийн дотоод, гадаад бодлогын ямар ч асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх эрхтэй. Улсын Бага Хурал нь БНМАУ-ын Ардын Их Хурлаас сонгогддогийн хувьд түүнд ажлаа хариуцан тайлагнана. БНМАУ-ын төрийн дээд эрх барих ёсыг хэрэгжүүлэхэд Ерөнхийлөгч чухал үүрэг гүйцэтгэнэ. Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн, БНМАУ-ын тусгаар тогтнол, монголын ард түмний эв нэгдлийн баталгаа мөн.

1992 онд Монгол Улсад шинэ үзэл баримтлал бүхий Үндсэн хуулийг баталснаар тус оронд ардчилал жинхэнэ утгаараа

²⁵ Монгол Улсын Үндсэн хууль. Эмхэтгэж, тайлбар бичсэн Ж.Амарсанаа. УБ, 2004 он. 345 дахь тал.

²⁶ Монгол Улсын Үндсэн хууль. Эмхэтгэж, тайлбар бичсэн Ж.Амарсанаа. УБ, 2004 он. 335-336 дахь тал.

хэрэгжиж, хүний эрх, эрх чөлөө баталгаатай хангагдах, төрийн эрх мэдэл зүй ёсоор хуваарилагдах нөхцөл бүрдсэн билээ.

Эцэст нь Монголын хууль тогтоох байгууллага 1924 онд байгуулагдан 1949 он хүртэл бүгд 9 удаа хуралдсан Улсын Их Хурал, түүний чөлөө цагт Улсын Бага Хурал, түүний чөлөө цагт Бага Хурлын тэргүүлэгчид, 1949 (1951)³⁷ оноос 1960 онд сонгуулийн шинэ системээр сонгогдсон депутатаас бүрддэг, жилд нэг удаа 1-2 хоног чуулдаг Улсын Их Хурал, 1960 оноос 1990 оны 7 дугаар сар хүртэл мөн Ардын Их Хурал, түүний чөлөө цагт Ардын Их Хурлын тэргүүлэгчид, 1990 оны 7 дугаар сараас 1992 оны 7 дугаар сар хүртэл өмнөх үеийн Ардын Их Хурлын үндсэн шинжийг хадгалсан, ардчилсан, олон намын оролцоотой сонгуулиар байгуулагдсан, шинэ хуучин таван намын төлөөлөл оролцсон, Үндсэн хууль батлах, түүнд нэмэлт өөрчлөлт оруулах, Улсын Бага Хурал ба төрийн гүйцэтгэх дээд, төв байгууллагуудыг байгуулах, улсын ерөнхийлөгч, улсын дээд зүүнхий бүрэлдэхүүнийг сонгох, ерөнхий прокурорыг томилох зэрэг төрийн удирдлагын зохион байгуулалтын үндсэн асуудлыг шийдвэрлэх бүрэн эрх бүхий Ардын Их Хурал, түүний чөлөө цагт хууль тогтоох, хянан шалгах, зохион байгуулах бүрэн эрхтэй, Ардын Их Хурлаас намуудад мандат хуваарилах замаар байгуулагдсан Улсын Бага Хурал гэсэн хоёр шатны төлөөлөх байгууллага болон өргөжин хөгжсөн байна.

Дүгнэлт

Парламент бол хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлдэг, ард түмнээс сонгуулиар байгуулагдадаг, хамтын зарчмаар ажилладаг, ард түмний төлөөллийн дээд, төв байгууллага. 1992 онд шинэ үзэл баримтлал бүхий Үндсэн хууль батлагдаж, түүнд "Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их хуралд хадгална" гэж заасан нь Монголд

парламент жинхэнэ ёсоор орших болсны баталгаа. Тэгвэл үүнээс өмнө Монгол Улсад хууль тогтоох байгууллага чухам ямар байсан, тэр нь хэрхэн хөгжиж ирсэн зүй тогтлыг судлах үүднээс "хурал"-ын байгууллагын түүхэн хөгжлийг эртний түүхэн хэлбэрээс нь авуулан 1990 он хүртэлх хугацааг хамран авч үзсэн бөгөөд үүнд дараах дүгнэлтэд хүрч байна.

1. Монголын хууль тогтоох байгууллага нэн эртнээс аваад өдгөө хүртэл энгийнээс дунд, дээд шатанд шилжих замаар хөгжиж иржээ. Гэхдээ дан ганц хөгжлийн замаар авсангүй. Тодорхой цаг үед, нийгмийн хөгжлийн зүй тогтлыг даган чиг үүрэг, эрх хэмжээний хүрээ нь хумигдан зарим үед тасалдах явдал ч байсан билээ. Мөн хөгжин боловсрох явц нь уламжлал, шинэчлэлийн байнгын хэлхээ холбоосон дээр түшиглэж байсан бөгөөд хөгжлийн зөв, буруу аль аль замыг туулсан байна.

2. Нэн эртнээс хэмжээгүй эрхт Богд хаант Монгол Улсын үе (1920) хүртэл Монгол нутагт байсан эртний, дундад эртний болон шинэ түүхийн үеийн феодалын улсууд нь өөр өөрийн онцлог бүхий боловч цөм нэгэн адил хаант засагтай байсан нь тодорхой бөлгөө. Овгийн байгуулалын үеийн "нөхөд", "зе", Хүннүгийн үеийн "хорин дөрөвийн зөвлөл", "хуралдаан", "зөлзлэдээн", Их Монгол Улсын үеийн "Их хуралдай", умард Юан болон бага хаадын үеийн "ноёдын чуулган", Манжийн эрхшээлийн үеийн "аймгийн чуулган" ("хошуу чуулган", "монгол чуулган"), хэмжээгүй эрхт Богд хаант Монгол Улсын үеийн "Улсын Дээд, Доод хурал" эд бүгд цөм нэгэн адил "төр" улсын тулгамдсан чухал асуудлыг хянан хэлэлцэж, дээш өргөн толилуулах"-аас бус, хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлж байсангүй. Иймд Монгол төрийн 2000-гаад жилийн хугацаанд хууль тогтоох эрх мэдэл гагцхүү Хаанд хадгалагдаж байв. Харин төрийн дээд эрх хийгээд төрийн аливаа чухал асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэх бүх эрх

"хурал"-д олгогдож байсан нь "хурал" хамгийн нэр хүнд бүхий онцгой эрхтэй байгууллага байсан нь илэрхий.

3. Хэмжээт эрхт хаант засаг бүхий Монгол Улсын үед буюу 1921-1924 оны хооронд бие даасан нэг ч "хууль" гарч байгаагүй бөгөөд мөн Засгийн газрын өргөн барьсан эрх зүйн актыг Богд хаанд толилуулж байсан, мөн Богдын зөвшөөрөн цохсон гэсэн баримт олдоогүй тул энэ үеийн Засгийн газар (хэдийгээр дүрмэндээ Засгийн газар нь хэмжээт эрхт хаантай зөвшилцсөний үндсэн дээр хууль дүрмийг батлах... гэж заасан ч) нь хууль баталж байсангүй. Харин дүрэм, тогтоолыг эрх хэмжээнийхээ хүрээнд тогтоон мөрдүүлж байсныг хууль батлахаг хутган ойлгож болохгүй юм. Иймээс эл үеийн Засгийн газрыг хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлж байсан гэж үзэх нь бололцоогүй юм. Харин эл үеийн Засгийн газрын статусыг тус засгийн газрын дүрэмд зааснаар авч үзвэл хууль тогтоох эрх олгогдсон, түүнээс хэмжээт эрхт хаантай зөвшилцсөний үндсэн дээр батлах эрх бүхий төрийн захиргааны дээд байгууллага байсан гэж үзэж байна. Мөн эл үед "хууль", "дүрэм", "тогтоол"-уудын хоорондын ялгаа заагийг тухайн үеийн сэхээтнүүд сайн мэддэг байсан төдийгүй тиймдээ ч Засгийн газар эрх хэмжээнийхээ хүрээнд гаргаж буй эрх зүйн актуудаа "дүрэм", "тогтоол" гэсэн нэрээр гаргаж байв. Эл үед хууль тогтоомжийн "хууль" гэсэн төрөл бий болоогүй байсан гэж зарим судлаачийн бичсэнтэй санал нийлэхгүй байна. Үүнийг Монголын эрх зүйн түүхэнд урьд өмнө нийгмийн харилцааг ерөнхийд нь зохицуулсан шинжтэй "хууль"-иуд гарч байсныг та бид бэлхнээ мэдэх билээ.

4. 1924-1990 он хүртэл үйлчилж байсан гурван үндсэн хуулийн үеийн хууль тогтоох байгууллагын талаар судлаачид шударга ардчилсан сонгуулиар байгуулагдах төрийн эрх барих дээд байгууллага болох парламентын төлөөллийн тогтолцоо хэлбэрийн, ёс төдий

³⁷ Хууль нь 1949 онд гарч, сонгууль нь 1951 онд болсон

шинжтэй, улс төрийн тогтолцооны цөм болсон нэг намын бодлого төрийн бодлогоос дээгүүр тавигдаж, сонгодог парламентын гол шалгуур болох ард түмний хүсэл зориг төлөөллийн байгууллагаар илэрхийлэгдэх зарчим алдагдаж, гагцхүү намын бодлогын "үг дуугүй" биелүүлэх, захиргаадалт газар авсан, гүйцэтгэх эрх мэдэл бүхий байгууллага нь зарим үед хууль тогтоох байгууллагаасаа ч дээд эрх мэдэлтэй байсан гэж хэлж болохоор байна гэсэн нийтлэг дүгнэлттэй санал нэг байна.

5. 1990 онд Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуулийг батлан гаргаж түүндээ хуучин Ардын Их Хурлын бүрэлдэхүүнийг шинэчлэн, мөн бүрэн эрхийг нь хязгаарлан, заримыг нь Улсын Бага Хуралд шилжүүлсэн байна. Улсын Бага Хурал хууль тогтоох, төсөв батлах, олон улсын гэрээг соёрхон батлах зэрэг бүрэн эрхийг хэрэгжүүлэх болсноороо парламентын үндсэн шинжийг олжээ. Тус хуульд зааснаар "Ардын Их Хурал дээд эрхийг хадгалах" атал мөн чанартаа эрхийг нь хязгаарласан байх бөгөөд

харин тэрхүү эрхийг нь Улсын Бага Хурал эдлэх болсон нь хоёрдмол шинжийг агуулж байна гэж үзэж болох талтай. Тодруулбал, хууль тогтоох эрх мэдлийг Ардын Их Хурал бус Улсын Бага Хурал хэрэгжүүлж байсан гэсэн үг. Эл үеийн парламентат ёсны тогтолцоонд Улсын Бага Хурал нь голлох байр суурьтай байсан бөгөөд хууль тогтоох, хянан шалгах, зохион байгуулах бүрэн эрхийг хэрэгжүүлэх болсноороо парламентат ёсыг жинхэнэ утгаар хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэжээ.

6. Монголын хууль тогтоох байгууллага Үндсэн хуультай болсноос хойш 1924 онд байгуулагдан 1949 он хүртэл бүгд 9 удаа хуралдсан Улсын Их Хурал, түүний чөлөө цагт Улсын Бага Хурал, түүний чөлөө цагт Бага Хурлын тэргүүлэгчид, 1949 (1951) оноос 1960 онд сонгуулийн шинэ системээр сонгогдсон депутатаас бүрддэг, жилд нэг удаа 1-2 хоног чуулдаг Улсын Их Хурал, 1960 оноос 1990 оны 7 дугаар сар хүртэл мөн Ардын Их Хурал, түүний чөлөө цагт Ардын Их Хурлын тэргүүлэгчид, 1990

оны 7 дугаар сараас 1992 оны 7 дугаар сар хүртэл өмнөх үеийн Ардын Их Хурлын үндсэн шинжийг хадгалсан, ардчилсан, олон намын оролцоотой сонгуулиар байгуулагдсан, олон намын төлөөлөл оролцсон, Үндсэн хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, Улсын Бага Хурал ба төрийн гүйцэтгэх дээд, төв байгууллагуудыг байгуулах, улсын ерөнхийлөгч, улсын дээд шүүхийн бүрэлдэхүүнийг сонгох, ерөнхий прокурорыг томилох зэрэг төрийн удирдлагын зохион байгуулалтын үндсэн асуудлыг шийдвэрлэх бүрэн эрх бүхий Ардын Их Хурал, түүний чөлөө цагт хууль тогтоох, хянан шалгах, зохион байгуулах бүрэн эрхтэй, Ардын Их Хурлаас намуудад мандат хуваарилах замаар байгуулагдсан Улсын Бага Хурал гэсэн хоёр шатны төлөөлөл байгууллага болон өргөжин хөгжсөн байна.



ЗАЛРУУЛГА

"Хууль дээдлэх ёс" сэтгүүлийн 2009 оны №4(27)-ийн 8-15 дугаар нүүрт "Монгол Улсад хууль тогтоомжийг хэвлэн нийтэлж ирсэн түүхэн тойм" эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлэгдсэн. Тус өгүүллийн буюу сэтгүүлийн 13 дугаар хуудсанд "1993 оны намын чуулганаар УИХ-ын тухай хуульд нэмэлт, мэдээллээс бусад хэвлэх ажлыг тусгай зөвшөөрлийн дагуу хийх ёстой билээ. Иймээс аль нэг дурын байгууллага хуулийн эмхтгэлийг хэвлэн нийтэлснээс үүдэн хожим ямар нэгэн сөрөг үр дагавар бий болохыг үгүйсгэхгүй. Өөрөөр хэлбэл хууль бол тодорхой харилцааг зохицуулж байдгай албан ёсны акт учраас тухайн хэвлэгдэн гарсан хууль тогтоомжийн найдвартай байдлын баталгаа зайлшгүй чухал юм. Иймд энэ ажлыг хуульд заасны дагуу тусгай зөвшөөрлийн үндсэн дээр тодорхой шаардлага шалгуурын дагуу эрхэлдэг байх нь чухал." гэсэн хэсгийг "1993 оны намын чуулганаар УИХ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудлыг авч хэлэлцсэний дотор "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн статусыг өөрчилсний дагуу 1994 оноос эхлэн "Төрийн мэдээлэл" эмхтгэлийг сар тутам гаргах болжээ. "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн газраас эрхлэн Монгол Улсын хууль тогтоомжуудын тухай тайлбар, зөвлөмжүүд болон сэтгүүлийн хавсралт болон "Төр, засгийн ажилтанд тусламж" сэтгүүлийг 1995 оны 1 дүгээр сараас эхлэн, улиралд тус бүр 3 дугаарыг УИХ-аас батлан гаргасан хууль тогтоомжуудын агуулгыг хураангуйлан олон түмэнд хүргэх, хэрэгжүүлэх арга хэлбэр сэлтийг аман ухуулгад зориулан тайлбарлах, бүх шатны Иргэдийн төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газрын ажил үйлсийг сурвалжин бусдад туршлага болгох, санаа авахуулах зорилгоор гаргаж байв. Нэмэн дурдахад 1996 оны 12 дугаар сарын 27-ны өдөр УИХ-ын Тамгын газраас "Парламентын мэдээлэл" нэртэй сонинг туршилтын дугаарыг анх гаргаж улмаар дотоод мэдээллийн зориулалттай энэ сонинг долоо хоног тутам 400 хувь хэвлүүлж үнзгүйгээр уншигчдад тарааж байсан удаатай." хэмээн залруулан уншихыг эрхэм уншигч танаас хүсье.

АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛД ӨРТСӨН ТӨРИЙН АЛБАН ХААГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГЫН АСУУДАЛ

Ажил, үйлчилгээ гүйцэтгэж байвчдаа, үүрэг даалгавар биелүүлж байх үедээ ашиг сонирхлын зөрчилд өртсөн төрийн албан хаагчид хариуцлага хүлээлгэх нь зүй ёсны асуудал мөн. Гэхдээ хэнд ямар хуулийг баримталж ямар хариуцлага хүлээлгэхийг зөв тогтоох явдал эрх зүйн болоод практикийн чухал ач холбогдолтой. Тиймээс ашиг сонирхлын зөрчилд өртсөн төрийн албан хаагч гэдэгт хэнийг хамруулах ёстой юуны өмнө тогтоох шаардлага гарч ирнэ. Төрийн алба дахь ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн үйлчлэлд дор дурьдсан төрийн албан хаагчийг хамруулах нь зүйтэй. Тухайлбал, Төрийн албаны тухай хуульд заасан улс төрийн, захиргааны, тусгай албан тушаал эрхэлж байгаа төрийн албан хаагч юуны өмнө энэ хуулийн үйлчлэлд хамрагдах ёстой. Энэ бүхэлтэи уялдуулан Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшигч, төрийн жинхэнэ алба (төрийн захиргааны болон төрийн тусгай алба)-ны удирдах албан тушаалд нэр дэвшигчийг мөн энэ хуулийн үйлчлэлд хамруулах шаардлагатай. Харин төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байгаа төрийн албан хаагчийн ашиг сонирхлын зөрчилтэй холбогдсон асуудлыг Төрийн алба дахь ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, бусад хууль тогтоомжийг үндэслэн Төрийн үйлчилгээний албан хаагчийн эс зүйн дүрмээр зохицуулж болно гэж үзэж байна.

Энэ нь хуулийг зөрчсөн хөнгөн, хүнд гэсэн байдлаар нь өөрөөр хэлбэл, төрийн албан хаагчийн гэм бурууд нь тохирсон хариуцлага хүлээлгэх ёстой гэж хэлэх гэсэн санаа билээ. Эндээс үүдэн ашиг сонирхлын зөрчилхөн зэрэглэл, хэлбэрийн асуудал яригдаж байгаа юм. Тухайлбал, ашиг сонирхлын зөрчлийн зэрэглэл, хэлбэрийг зөв ангилж, ямар эрх зүйн актаар зохицуулах ёстойг нарийн тогтоож, тэр дагуу хууль боловсруулах, боловсронгуй болгох арга хэмжээ авснаар ашиг сонирхлын зөрчилд өртсөн төрийн албан хаагчид хүлээлгэх



*Монгол Улсын Ерөнхийлөгчийн
тамгын газрын Албаны дарга,
Хууль зүйн доктор, профессор
Л.Батжаяа*

хариуцлагын хэм хэмжээг өнөөчтой хуульчилж өгөх нөхцөл бүрдэх болно.

Энэ талаар хуульчилж тогтоосон эрх зүйн баримт бичиг одоогоор манайд хараахан байхгүй ч Төрийн алба дахь ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль боловсруулахтай холбогдуулж ашиг сонирхлын зөрчлийн зэрэглэл, хэлбэрийг нарийвчлан тогтоох шаардлагатай.

Олон улсын энэ чиглэлийн хууль тогтоомж, судалгааны материалаас үзэж байхад ашиг сонирхлын зөрчлийг зэрэглэл, хэлбэрээр нь тус тус гурав ангилж болохоор байгаа юм. Тухайлбал, хөнгөн, хүндэвтэр, хүнд зэрэглэлийн ашиг сонирхлын зөрчил гэж зэрэглэлийн хувьд, эс зүйн хэлбэрээр илрэх зөрчил, ашиг сонирхлын хэлбэрээр илрэх зөрчил, авлигын хэлбэрээр илрэх зөрчил гэж хэлбэрийн хувьд тус тус ангилж боловсруулж байгаа, боловсронгуй болгож байгаа хуульдаа зэрэглэл өгөх нь зүйтэй санагдана. Ашиг сонирхлын зөрчилтэй холбогдсон хууль тогтоомжийн гол зангилаа асуудал нь энэ байх ёстой. Эс зүйн зөрчлийн хэлбэрээр илэрдэг хөнгөн зэрэглэлийн ашиг сонирхлын зөрчилд юу хамаарах, ашиг сонирхлын хэлбэрээр илэрдэг хүндэвтэр зэрэглэлийн ашиг сонирхлын зөрчилд юу хамаарах, авлигын хэлбэрээр илэрдэг хүнд

зэрэглэлийн ашиг сонирхлын зөрчилд юу хамаарахыг тус тус нарийвчлан тогтоож, тухай бүрт нь ямар хариуцлага хүлээлгэх ёстойг сайтар гадархойлж, чиглэл чиглэлээр нь Авлигын эсрэг хууль, Төрийн алба дахь ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн жинхэнэ албан хаагчийн эс зүйн дүрмд тусгах хэрэгтэй. Ингэснээр ашиг сонирхлын зөрчил, түүнд холбогдох хариуцлагын аливаа асуудал ямар нэгэн давхардал, хийдэлгүйгээр хууль тогтоомжид тусгалаа олж чадах болно.

Төрийн албан хаагч ашиг сонирхлын зөрчилд санаатай болон санамсаргүй байдлаар өртсөн тохиолдолд гэм буруугийн хөнгөн, эсхүл хүндэд нийцүүлж хариуцлага хүлээлгэх нь ойлгомжтой. Тухайлбал, хөнгөн зэрэглэлийн ашиг сонирхлын зөрчлөөс хүндэвтэр зэрэглэлийн, хүндэвтэрээс хүнд зэрэглэлийн ашиг сонирхлын зөрчилд шилжихийн хэрээр ашиг сонирхлын зөрчил нь эс зүйн хэлбэрээс ашиг сонирхлын, ашиг сонирхлоос авлигын хэлбэртэй ашиг сонирхлын хэлбэрт шилжин өөрчлөгддөг гэсэн үг. Үүнээс улбаалан эс зүйн зөрчлийн хэлбэрээр илэрдэг хөнгөн зэрэглэлийн ашиг сонирхлын зөрчлийг Төрийн жинхэнэ албан хаагчийн эс зүйн дүрэм (Засгийн газрын 1999 оны 58 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны болон гушаалтны эс зүйн хэм хэмжээний тухай дүрэм"-ийг одоо өөрчлөн шинэчилж ийм нэртэй болгох хэрэгтэй)-ээр, ашиг сонирхлын хэлбэрээр илэрдэг хүндэвтэр зэрэглэлийн ашиг сонирхлын зөрчлийг Төрийн алба дахь ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль (шинээр боловсруулж Улсын Их Хуралд өргөн барих)-аар авлигын хэлбэрээр илэрдэг хүнд зэрэглэлийн ашиг сонирхлын зөрчлийг Авлигын эсрэг хууль (нэмэлт, өөрчлөлт оруулж шинэчлэн боловсронгуй болгох)-аар тус тус зохицуулах нь зүйтэй гэж үзэж байна. Ийнхүү нэр дурьдсан гурван төрлийн эрх зүйн актаар ашиг сонирхлын зөрчлийн хүрээ, заагийг зөв, өнөөчтой тогтоох нь нэн хариуцлагатай бөгөөд чухал асуудал мөн.

СПОРТЫН ЭРХ ЗҮЙ: ТӨРИЙН АЛБА БА СПОРТ

Спортын эрх зүй гэж юу вэ?

Спортын эрх зүй гэж байдаг уу? гэх мэт асуултыг спортын салбарт ажиллаж буй хуульч, судлаачид байнга өөрсдөө тавьдаг. Спортод хамааралтай харилцаа бүрийг зохицуулдаг, бие даасан салбар эрх зүй байдаг гэж хэлэхийн аргагүй² бөгөөд харин гэрээний эрх зүй, захиргааны эрх зүй, хөдөлмөрийн эрх зүй, оюуны өмчийн эрх зүй, өрсөлдөөний эрх зүй зэргийн хэм хэмжээг ашигладаг, спортын харилцаанд хэрэглэгдэх эрх зүйн зохицуулалтууд байж болно.³ Гэсэн хэдий ч спортын харилцаа нь бие даасан салбар эрх зүйгээр зохицуулагдахгүй боловч, ангиар sporting law, sport law хэмээн нэрлэгдэж нэгэнтээ олон оронд хэрэглэгдэж байгаа томьёолоод бөгөөд монгол ч спортын эрх зүй хэмээх нэр томьёо хэрэглэгдэх болжээ.

Нийгэмд эрх зүйт ёсыг төлөвшүүлэхэд спортын эрх зүйн үүрэг, нөлөөг үнэлж баршгүй. Нэн ялангуяа спорт нь шударга өрсөлдөөн дундаас ялагчийг шударгаар тодруулж, зөв санааны нэгдлийг илэрхийлж байгаа явдал нь иргэдийн эрх зүйн ухамсарт шударга байдлыг хуулийн хүчээр бүс тэдний сонирхол, эрх ашгийн дагуу хэвшүүлэх үр нөлөөтэй аргын нэг болдог. Тухайлбал, Монгол Улсын Үндэсний Их баяр наадмын тухай хуулийг монголчууд ямар ч хуульчийн тусламж авалгүйгээр, уншилгүйгээр цээжээр мэддэг. Энэ нь тухайн ард түмний сонирхол, уламжлалт ёсыг даган заншлын болон орчин үеийн хэм хэмжээ нэгэн дор оршиж, бусад ямар ч хуулиас



Хууль зүйн магистр, Самбо бөхийн олон улсын хэмжээний мастер
Г.Баттулга¹

илүү ердийн ухамсрын түвшинд хүрсэн байдгаараа онцлог юм.

Энэ талаар Британийн Спорт ба Эрх зүйн нийгэмлэгийн ерөнхийлөгч Е.Грэйсон "Эрх зүйт ёс нийгэмд ямар их хэрэгтэй байдаг шиг спортод ч мөн адил эрх зүйт ёс хэрэгтэй. Үүнгүйгээр спортод эмх замбараагүй байдал ноёрхно"⁴ хэмээн спорт дахь эрх зүйн хэрэгцээ шаардлагыг онцлон тэмдэглэжээ. Нөгөө талаас спортод эрх зүйт ёс үгүй бол нийгэмд эмх замбараагүй байдал бий болно.

Спортын эрх зүйг тодорхойлохын тулд спорт гэж юу вэ? гэдгийг тодорхойлох ёстой. Спортын хөгжлийн түүхээс харахад спорт нь жишээ нь, эртний гүрнүүдэд иргэдийн цагаа зөв боловсон өнгөрөөх, хөгжих тоглох үүднээс entertainment буюу үзвэрийн шинжтэйгээр хөгжиж байсан бол нөгөө талаас байлдаан, тулаан, эр зоригийг хөгжүүлэх үүднээс цэргийн сургуулилт маягаар хөгжиж иржээ. Спортыг үзвэр, тоглоом, ажил,

сургуулилт, амралт, ан, чөлөөт цагийг өнгөрөөх хэрэгсэл гэх мэтээр олон өнцгөөс тодорхойлж болно.

Спорт бол нүсэр бизнес. Энэ нь дэлхий даяар тархсан бизнес бөгөөд дэлхийн худалдааны эргэлтийн 3 хувийг илүүг эзэлдэг бол Европын Холбооны дотоодын нийт бүтээгдэхүүний нэг хувийг шууд бүрдүүлдэг байна.⁵

Нөгөө талаас спорт бол улс төрийн шийдвэрт хамгийн хүчтэй нөлөөлдөг хүчин зүйлсийн нэг юм. Тухайлбал, жандерийн тэгш байдлыг хангахад эмэгтэй тамирчдын нөлөө маш их байсан. Эмэгтэй хүн эрэгтэй хүний адил спортын бүхий л төрлөөр хичээллэж чадаж байна гэдэг нь эмэгтэй хүний оюуны болоод биеийн чадавхи эрэгтэй хүнийхээс төдийлөн ялгаагүйг нотолж, нийгэмд эмэгтэйчүүдийн эрхийг хангах хөдөлгөөний өрнөлтөд нөлөөлжээ.⁶

Спортын эрх нь эрүүл мэндээ хамгаалуулах эрхээс үүдэлтэй.

Эрүүл мэндээ хамгаалуулах эрх (right to health protection) нь үндсэн хуулиар тогтоосон, иргэний үндсэн эрхийн нэг билээ. Энэ эрх нь хүн амын эрүүл мэндийг хамгаалах ба сахиулах, эрүүл мэндийг хамгаалах бүх төрлийн тогтолцоо болон биеийн тамир, спортыг хөгжүүлэхэд тус дөхөм үзүүлэх, эрүүл ахуйн таатай нөхцөлөөр хангах талаар төрөөс хүлээх үүргийг буй болгоно.⁷

Манай Улсын хувьд биеийн тамир, спортын эрх зүй нэгэнт бүрэлдэн бий болсон хэдий ч тухайн салбар эрх зүйд зохицуулагдаагүй, цаашид зохицуулан боловсронгуй болгох олон асуудал бий. Эдгээрийн нэг нь төрийн жинхэнэ албан хаагч

¹ Австралийн Мельбурний Их Сургуулийн Азийн эрх зүйн төвийн судлаач, доктор (PhD) Б. Гүнбилэгт арга зүйн зөвлөгөө өгч тусалсанд талархаж байгаагаа үүгээр илэрхийлж. Гомбын Баттулга

² Timothy Davis, Alfred D. Mathewson, Kenneth L. Shropshire, Sports and the law (A Modern Anthology), Carolina Academic Press 1999 p.3.

³ Charles Woodhouse, "The Lawyer in Sport, Some Reflections," Sport and the Law Journal Vol. 4, No. 3 (1996).

⁴ Grayson, E. President of the British Association for Sport and law, in his inaugural presidential address. Sport and the Law Journal 1(1), (1993).

⁵ European Commission, The European Model of Sport (1999).

⁶ Timothy Davis, Alfred D. Mathewson, Kenneth L. Shropshire, Sports and the law (A Modern Anthology), Carolina Academic Press 1999 p. 11.

⁷ С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг, УБ, 2007 он, 636 дахь тал.

тамирчид, тэдгээрийн харьяалагддаг байгууллагаас явуулж буй зарим үйл ажиллагаа нь Монгол Улсын төрийн албаны тухай хууль бусад хуультай хэрхэн зөрчилдөг, төрийн тусгай чиг үүрэг хэрэгжүүлдэг зарим байгууллагын дэргэдэх спортын клубын үйл ажиллагаа нь Төрийн бус байгууллагын тухай хууль болон бусад хуультай зөрчилдөж буй жишээ юм.

Монгол Улсад 1990 оноос хойш өрнөсөн нийгэм, эдийн засгийн өөрчлөлтийн нөлөөгөөр биеийн тамир, спортын байгууллагын тогтолцоонд томоохон өөрчлөлтүүд гарч, бие даасан спортын байгууллага, спорт клубууд байгуулагдаж, тамирчид тэдгээрт харьяалагдах болсноор тамирчин, дасгалжуулагч, спорт клубын хооронд үүсэх харилцааг зохицуулах шаардлага бий болсон юм. Энэхүү шаардлагын улмаас Биеийн тамир, спортын тухай хуулийг 2003 онд Улсын Их Хурлаас батлан гаргасан. Уг хуулиар төрийн тусгай чиг үүрэг хэрэгжүүлдэг байгууллагууд биеийн тамир, спортын талаар ямар чиг үүрэг хэрэгжүүлдэг болохыг авч үзье. Биеийн тамир, спортын тухай хуулийн 14.1-д "Монгол Улсын зэвсэгт хүчин, цагдаа, тагнуул, гамшгаас хамгаалах болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, хилийн цэргийн биеийн тамир, спорт нь цэргийн сургалт, бие бүрэлдэхүүний хүмүүжил, бэлэн байдлын салшгүй хэсэг болно" гээд 14.3-т "Энэ хуулийн 14.1-д дурдсан байгууллагад зохион тамир, спортын арга хэмжээ зохион явуулах салбар нэгж байгуулж болно" гэжээ.

Дээрх төрийн байгууллагууд бүгд дэргэдээ спортын үйл ажиллагаа явуулдаг нэгжтэй бөгөөд тэдгээрээс улс, олон улс, дэлхий, тивийн болон үндэсний хэмжээний спортын тэмцээн, наадамд оролцон амжилт гаргаж буй үе үеийн шилдэг тамирчид төрөн гарсныг бид мэднэ. Тухайлбал, Батлан хамгаалах яамны харьяа "Алдар" спорт хороо, Цагдаагийн ерөнхий газрын харьяа "Хүч" спорт хороо, ШШГЕГ-ын харьяа "Сүлд" спорт хороо, ХХЕГ-ын "Хилчин" спорт хороо юм. Эдгээр спорт хороо нь тухайн харьяа

байгууллагын ажилтан албан хаагчид, бие бүрэлдэхүүний биеийн тамир, спортын арга хэмжээг зохион байгуулах биеийн тамир, спортоор хичээллэх бололцоог хангахын зэрэгцээ "өндөр зэрэглэлийн тамирчид"-ийг спортын уралдаан, тэмцээнд тогтмол оролцуулдаг. Өндөр зэрэглэлийн тамирчид гэдгийг Биеийн тамир, спортын тухай хуулийн 3.1.6-д "спортын тодорхой төрлөөр системтэй хичээллэж, үндэсний болон олон улсын тэмцээнд тогтмол оролцдог, спортын төрөл, цол, зэргийн нэгдсэн ангиллын дагуу спортын мастераас доошгүй цол авсан тамирчин" гэж тодорхойлжээ. Тэгвэл дээр дурдсан төрийн тусгай албаны харьяа спортын нэгжүүдийн тамирчид нь бүгд цэрэг, цагдаагийн тангараг өргөсөн офицер, ахлагч нар байдаг бөгөөд төрийн тусгай албан хаагчид юм.

Төрийн албаны тухай хуулийн 11.1-д "Төрийн албан тушаалыг эрхэлж, бүрэн эрхээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс авч, ажиллах нөхцөл, баталгаагаар хангагдан ажиллаж байгаа этгээдийг төрийн албан хаагч гэнэ" гэжээ. Мөн хуулийн 5.2-т "төрийн захиргааны, төрийн тусгай албан тушаалыг төрийн жинхэнэ албан тушаал гэнэ" гэсэн бол 8.1.6-д "зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, тагнуул, цагдаа, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, онцгой байдлын байгууллагын офицер, ахлагч, шүүхийн шийдвэр гүйцэтгэгч" нь төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх эрх бүхий төрийн тусгай албан тушаалтан болохыг хуульчлан тодорхойлжээ. Эндээс харахад эдгээр тамирчид нь төрийн албан хаагч, эрхэлж буй албан тушаал нь "тамирчин" гэсэн ойлголтыг төрүүлж байна. Мэдээж хэрэг төрөөс цалин хөлс авч ажиллаж байгаа болохоор Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд заасны дагуу үр дүнгийн гэрээг эрх бүхий албан тушаалтантай байгуулж, тодорхой ажил хийж гүйцэтгэх үүргийг хүлээнэ. Харин тамирчин үндсэн үүрэг нь харьяа биеийн тамир, спортын байгууллагыг олон улс, улс, орон нутгийн тэмцээнд нэр

хүндтэйгээр төлөөлөн оролцох явдал юм.

Сүүлийн үед ихэнх төрийн тусгай албан хаагч тамирчид харьяа биеийн тамир, спортын байгууллагаа уралдаан тэмцээнд төлөөлөн оролцохоос гадна хувийн компани, аж ахуйн нэгж, байгууллагыг давхар төлөөлөн оролцох болсон.

Энэ нь нэг талаас тамирчин болон нөгөө талаас спортыг дэмждэг байгууллага, үйл ажиллагаагаа сурталчилах зорилготой компани, аж ахуйн нэгж, байгууллагаас нэмэгдэл цалин, урамшуулал бусад дэмжлэгийг авах замаар хамтран ажиллаж байгаа хэргээр юм. Ийм жишээ нэлээд олныг дурдаж болно. Тухайлбал: "Алдар" спорт хорооны тамирчин Б. группын бөх, "Хүч" спорт хорооны тамирчин С. компанийн бөх, "Хилчин" спорт хорооны тамирчин А. компанийн бөх гэх мэт олон жишээг үндэсний бөхийн барилдаан, Үндэсний баяр наадам болон спортын бусад уралдаан тэмцээнүүдээс үзэж, сонсдог.

Мөн тэдгээр тамирчдын дунд хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, нийгмийн хэв журам хамгаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндсэн ажил үүргээ гүйцэтгэхийн зэрэгцээ спортын уралдаан тэмцээнд оролцон тогтмол амжилт үзүүлдэг тамирчид олон бий. Ер нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, нийгмийн хэв журам сахиулдаг цагдаагийн албан хаагч, шүүхийн шийдвэр гүйцэтгэгч гэх мэт төрийн тусгай албан хаагч үндэсний баяр наадамд амжилттай барилдан үндэсний бөхийн улсын цол авч гэж бодье. Гэтэл түүнийг дэмжиж явдаг нутгийн иргэд болон аж ахуйн нэгж, байгууллагаас мөнгөн шагнал, цалин хөлс өгөх буюу өгөхөөр санал тавьж гэмээ нь энэхүү харилцаа нь чухам хууль зүйн ямар үр дагавар бий болгох вэ, үүнийг зохицуулах эрх зүйн орчин хэр тодорхой байна вэ, эсвэл хууль зөрчсөн үйлдэл болох уу гэсэн асуултауд урган гарна.

Дээрх байдал нь Төрийн албаны тухай хууль болон бусад хуультай хэрхэн зөрчилдөж байгааг авч үзье.

Төрийн албаны тухай хуулийн 15.1.6-д төрийн жинхэнэ албан

хаагч нь "албан тушаалынхаа бүрэн эрхийг хэрэгжүүлсний төлөө бусад байгууллага, аж ахуйн нэгж, иргэндээ мөнгөн шагнал, шан харамж, зээл авах, төлбөргүй буюу хөнгөлөлттэйгээр үйлчлүүлэх зэрэг хууль бус бусад хангамж эдлэх"-ийг хориглоно гэжээ. Тамирчин гэдэг нь бүрэн эрх хэрэгжүүлдэг албан тушаалтан биш гэж үзэж болох боловч, дээр дурдсан төрийн тусгай албаны харьяалалтай тамирчид шаардлагатай тохиолдолд тухайн төрийн тусгай албаны үндсэн үүргийг хэрэгжүүлэх явдал түгээмэл байдаг. Энэ тохиолдолд Төрийн албаны тухай хуулийн 15.1.6 дугаар зүйлийг зөрчиж байна. Мөн Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 36.4-т⁸ Цагдаагийн алба хаагч нь төрийн сонгуульд үүрэг хүлээсэн, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр ажил хавсаргаж цалин хөлс тогтоосон, түүнчлэн багшлах, зохион бүтээх, уран бүтээл, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийхээс бусад тохиолдолд ажил хавсран гүйцэтгэх цалин хөлс авахыг хориглоно⁹ гэж хуульчлан тодорхойлжээ. Энэ хэсэгт цагдаагийн байгууллагын ажилтан-тамирчин гэдэг ойлголтыг хуулиар зааж өгөөгүй байна. Түүгээр ч үл барам Монгол Улсын Ерөнхийлөгчөөс улсын баяр наадмаар зарим бөхөд үндэсний спортын цол олгох тухай гаргасан зарлиг нь дээрх хуулийн заалттай нийцээгүй гэж үзэж болохоор байна. Тухайлбал, Үндэсний баяр наадмын тухай хуульд зааснаар баяр наадмын зохион байгуулах хорооны саналыг үндэслэн бөхчүүдэд үндэсний спортын цол олгосон зарлигт "БХЯ-ны харьяа "Алдар" спорт хороо, Зэвсэгт хүчиний ... дугаар анги, ... компанийн бөх. ЦЕГ-н харьяа "Хүч" спорт хорооны тамирчин, ... компанийн бөх" гэх мэт.

Зарлиг нь "төрийн тэргүүний гаргагдах нэлээд чухал эрх зүйн акт" бөгөөд "нийтлэг журмын дагуу зарлиг нь тухайн улсын Үндсэн хууль ба бусад хуульд нийцсэн байх ёстой" бөгөөд хэрвэ "Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг хуульд нийцээгүй бол ерөнхийлөгч өөрөө

буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно".⁸

Төрийн алба нь дэргэдээ спортын нэгжтэй байж болох боловч, уг нэгжид хамрагдах тамирчид цэрэг, цагдаагийн цол, үнэмлэх хэрэглэж болох эсэх талаар нийтийн эрх зүйн зарчимд нийцсэн зохицуулалт үгүй байна.

Уг нь төр түүний байгууллагууд спортыг дэмждэг иргэд, компани, аж ахуйн нэгж, байгууллагаас дэмжлэг авч биеийн тамир, спортыг хөгжүүлэхэд хамтран ажиллах нь үр дүнтэй, чухал ач холбогдолтой гэдгийг сүүлийн жилүүдэд манай тамирчдын тив, дэлхий, олимпын тоглолтод үзүүлж буй амжилтуудаас харж болно. Иймд Монгол Улсын биеийн тамир, спортын эрх зүйн зүйн харилцааг зохицуулдаг буй холбогдох хуульд тухайлбал, Биеийн тамир спортын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Цагдаагийн байгууллагын тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулан тамирчин-албан хаагчийн статусыг тогтоож өгөх шаардлагатай гэж үзэж байна.

Мөн төрийн тусгай чиг үүрэг хэрэгжүүлдэг байгууллага болох Тангуулын ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газрын харьяа спорт клубууд үйл ажиллагаа явуулж, тэдгээрт харьяалагдах дасгалжуулагч, тамирчдыг төрийн албан тушаалтны шийдвэрээр томилож байгаа болон үйл ажиллагаа нь төрийн байгууллагаас хараат байгаа зэрэг нь төрийн бус байгууллагын тухай хуулийг зөрчижээ. Спорт клуб гэдэг нь төрийн бус байгууллага бөгөөд хуулийн дагуу Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлж хуулийн этгээдийн эрх эдэлдэг. Өөрөөр хэлбэл, төрийн байгууллагын дэргэдэх клуб нь нэршлийн болоод үүсэн байгуулагдсан хэлбэрийн хувьд төрийн бус байгууллага болж таарч байгаа юм. Тухайлбал, 2000 онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа "Сонор" спорт клуб байгуулагдан үйл ажиллагаа явуулж байсан бөгөөд төрийн бус байгууллага болохын

хувьд Хууль зүй дотоод хэргийн яаманд бүртгүүлж хуулийн этгээдийн эрх эдэлж байв. Гэтэл 2001 онд ШШГЕГ-т Төрийн аудитын байгууллагаас хийсэн шалгалтаар төсвийн мөнгөөр төрийн бус байгууллагыг санхүүжүүлж буй нь төсвийн тухай хууль зөрчиж байна гэсэн дүгнэлт гарч тухайн байгууллагын удирдлагын шийдвэрээр спорт клубын үйл ажиллагааг зогсоожээ. Хууль зүй дотоод хэргийн сайдын 2006 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 208 тоот тушаалаар ШШГЕГ-н харьяа "Сүлд" биеийн тамир спортын хороо хуулийн дагуу байгуулагдах үйл ажиллагаагаа явуулж байна.

Иймд төрийн байгууллагын дэргэд спорт клуб биш спорт хороог тухайн байгууллагын албан ёсоо нэгж болгон эрх бүхий байгууллагаас батлан гаргах ёстой.

Төрийн бус байгууллагын тухай хуулийн 14.1-д "төрийн бус байгууллага гэж иргэд, төрийн байгууллага (хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх байгууллага)-аас бусад хуулийн этгээдээс нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхлыг, үзэл бодлын үүднээс сайн дурын үндсэн дээр байгуулагдан үйл ажиллагаагаа төрөөс хараат бус, өөрийгөө удирдах зарчмаар явуулдаг ашгийн төлөө бус байгууллага" гэжээ.

Төрийн бус байгууллага нь "оюун санааны болон бусад эд баялагийн бус эрэлт хэрэгцээгээ хангахын тулд нийтлэг ашиг сонирхлын үндсэн дээр хуулиар тогтоосон журмаар нэгдсэн иргэдийн сайн дурын нэгдэл"¹⁰ бөгөөд бидний байгуулахыг зорьж буй иргэний нийгмийн илрэх хэлбэрийн нэг билээ.

Иймд төрийн болон төрийн бус зарим байгууллагад спортын эрх зүйн холбогдолтой хэм хэмжээнүүдийг чанд сахин биелүүлж, үйл ажиллагаагаа нэг мөр болгон хэлбэржүүлэн сахиж мөрдөх, төрөөс биеийн тамир, спортын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагтай нь харагдаж байна.

⁸ С Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг, УБ, 2007 он, 202 дахь тал

⁹ С Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг, УБ, 2007 он, 430 дахь тал

*Монгол Улсын хөдөлмөрийн баатар, ардын багш, гавьяат хуульч,
доктор, профессор Б.Чимидийн нэрэмжит илтгэлийн
уралдаанд шалгарсан багш, судлаачдын шилдэг илтгэл*

ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ҮҮСГЭХ ШАТАНД БАЙЦААН ШИЙТГЭХ ЗАРИМ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ

*НЦГ-ын Гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн хэргийн газрын үзлэгийн чиглэлийн ахлах мэргэжилтэн,
Цагдаагийн дэд хурандаа Б.Жаргалсайхан*



*Б.Жаргалсайхан Монгол Улсын хөдөлмөрийн баатар, ардын багш, гавьяат хуульч,
доктор, профессор Б.Чимидэе шалгарсан.*

Монгол Улсын ЭБШХ-ийн долдугаар хэсэгт багтдаг "эрүүгийн хэрэг үүсгэх" ажиллагаа бол байцаан шийтгэх ажиллагааг эхлэн явуулах гарцаагүй, хууль ёсны үндэслэлийг хангалттай тогтоох, түүнд үндэслэн процессын шийдвэр гаргахаар эрх бүхий субъектын явуулдаг, ЭБШ ажиллагааны бие даасан шат билээ. Манай эрдэмтэн мэргэд ч энэ шатыг бие даасан шат гэдгийг хүлээн зөвшөөрдөг.

ЭБШ ажиллагааны анхны, бие даасан энэ шат бусад бүхий л шатны нэгэн адил өөрийн гэсэн зорилготой ба тэр нь дээр дурьдсан:

1. Процессын ажиллагааг хэрэгжүүлж эхлэх гарцаагүй бөгөөд хангалттай үндэслэл бий эсэхийг тогтоох; 2. Энэ асуултаар үндэслэл бүхий шийдвэр гаргах явдал.

Энд, "байцаан шийтгэх ажиллагаа" ба "процессын ажиллагаа" гэсэн нэрийдэлд та бүхний анхаарлыг хандуулъя. Яг

байцаагаад, шийтгэхийдэг хуулиа бид "эрүүгийн хууль" гэдэг, харин байцаан шийтгэх ажиллагааны журмын тухай хуулиа "байцаан шийтгэх" гэж нэрлэдэг. Эрүү гэдэг үг Монгол Улс Манжид дагаар орж мөн хэлний "хаули" (Монгол бичгээр ингэж бичдэг) хэмээх үг Монгол хэлэнд одооны хууль гэдэг утгаар хэрэглэдэг байсан "журам, цааз, засаг" зэрэг үгийг халж орж ирсэн цагаас, Манжууд хэрэг хүлээлгэхдээ хэрэглэдэг байсан шаахайдах аргыг Монголчууд "эрүүний мах зулгаах" гэж жишин ярьдаг байснаас гарсан үг. Өнөөдөр "эрүүддэггүй" хууль хэрэглэж байгаа бид энэ үгийг хэрэглэх нь хэр зохимжтой вэ гэдгийг судлаач, эрдэмтэн та бүгдийн сонорт хүргэх гэсэн юм. Хэрэв оноочих үг олдохгүй бол олон орны жишгээр процессын хууль гэдгээрээ явах нь арай дээр.

ЭБШ эрх зүйн онолоор энэ шатны зорилтыг мөрдөн

байцаалтын ажиллагаагаар бус, эрх зүйн өвөрмөц шинжтэй аргыг хэрэглэн шийддэг гэж үздэг ч тэрхүү өвөрмөц арга өөрөө процессын зарим ажиллагаа байдаг. Дэлхий дахин нийгмийн хоёр системд хуваагддаг байсан тэр үед "Херенготен орон иргэдийнхээ эрх чөлөөг уландаа гишгэдэг, харин манай социалист системд тийм биш, бид эрүүгийн хэрэг үүсгэхээс өмнө мөрдөн байцаалтын ямар ч арга хэмжээг хэрэгжүүлдэггүй" гэдэг байсан энэ үзэл баримтлалд орчин цагт шүүмжтэй хандаж, дээрх зорилтыг мөрдөн байцаалтын аргаар шийдэж байгааг бид өнөөдөр хүлээн зөвшөөрөх ёстой. Өвөрмөц арга хууль бус байх боломжгүй, тэгвэл мөнөөх үндэслэл, шийдвэр маань хүчин төгөлдөр бус болчихно. Тиймээс эрүүгийн хэрэг үүсгэх гарцаагүй үндэслэлийг хангалттай тогтоох, үндэслэл бүхий аль нэгэн шийдвэрийг гаргах, тухайн мөчид үйлдэж байгаа гэмт үйлдлийг таслан зогсоох, үйлдэхээр бэлтгэж, завдаж буй гэмт хэргийг урьдчилан сэргийлэх арга хэмжээ гагцхүү хууль ёсны ажиллагаанд үндэслэх ёстой.

Эрүүгийн хэрэг үүсгэх үндэслэл бий эсэхийг шалгасан эрх бүхий субъект бодит үндэслэлийг тогтоовол эрүүгийн хэрэг үүсгэх (ЭБШХ-ийн 172.1.1); эс тогтоовол эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал гаргах, татгалзах (172.1.2), гомдол, мэдээллийг шалгуулахаар харъяаллын дагуу шилжүүлэх (172.1.3) гэсэн төгс шийдвэрийн аль нэгийг гаргаж, энэ тухай гомдол, мэдээлэл гаргагчид мэдэгдэхээр

хуульд заасан. Ийм шийдвэрийг гаргахын тулд тэдгээрийг нутлах¹ зайлшгүй шаардлагатай ч манай ЭБШХ-ийн 80 дугаар зүйлд түүнийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүх хуралдааны үед л хэрэгжүүлэхээр заасан нь учир дутагдалтай хэрэг. Доктор Ж.Болдбаатар: "...эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны эхний шат буюу эрүүгийн хэрэг үүсгэх үед нотолгоо явагддаггүй гэж үзэхээр байна"² гэсэнд дүгнэлт хийж энэ шатанд нутлах ажиллагаа явуулах эрх зүйн үндсийг бүрдүүлж өгөх зайлшгүй шаардлагатай.

Энэ шат эрүүгийн хэрэг үүсгэх шалтгаан эрх бүхий субъектэд тодорхой болсон цагаас эхлэх бөгөөд уг субъект түүнийг процессын зарим ажиллагаа явуулан шалгаад тийм үндэслэл бий эсэхийг тодорхойлж өгсөн шийдвэр гаргаснаар төгсдөг. Доктор Ж.Болдбаатар: "Эрүүгийн хэрэг үүсгэх ажиллагаа нь эрүүгийн хэрэг үүсгэх үндэслэл бий болоход эхлэн, энэ талаар гарсан шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болоход дуусна"³ гэж үздэг нь тун зүйтэй үзэл баримтлал гэж бид үзэж байна.

Процессын энэ шатны хамгийн гол онцлог нь эрүүгийн хэрэг үүсгээгүй байгаа үед байцаан шийтгэх зарим арга хэмжээг энэ шатанд хэрэгжүүлж эхлэх шаардлага тулардагт оршино.

Манай ЭБШХ-ийн 166.1-д зааснаар эрүүгийн хэрэг үүсгэх үндэслэл нь: а) гэмт хэрэг гарсныг хангалттай нотлох баримт байх, б) байцаан шийтгэх ажиллагаа явуулж болохгүй нөхцөл байдал үүсээгүй байх явдал. Тэгж байж эрүүгийн хэрэг үүсгэх шийдвэр гаргах үндэс бүрдэнэ. Эрүүгийн хэрэг үүсгэх

үндэслэлийг хангалттай байгааг тогтоовол эрүүгийн хэргийг заавал үүсгэн шалгана, түүнээс татгалзах эрх хэнд ч байхгүй.

Харин мөн зүйлийн 1.1-ээс 1.5-д заасан:

-гэмт хэрэг гарсан талаар иргэн гомдол гаргасан буюу мэдээлсэн;

-гэмт хэрэг гарсан талаар аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан мэдээлсэн;

-гэмт хэрэг үйлдсэн хэмээн өөрийгөө илчилж ирсэн;

-хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор гэмт хэргийн шинж тэмдгийг өөрсдөө шууд илрүүлсэн;

-гэмт хэргийн талаар гүйцэтгэх ажлын шугамаар авагдаж, баримтжуулагдсан мэдээ баримт байгаа зэрэг нь эрүүгийн хэрэг үүсгэх үндэслэл биш, зөвхөн шалтгаан нь. Өөрөөр хэлбэл, энэ таван шалтгааны аль нэг нь тодорхой болмогч дээрх үндэслэл байгаа эсэхийг тогтоох ажиллагааг хэрэгжүүлж эхлэнэ, аль нэг шалтгаан хараахан мэдэгдээгүй байгаа бол ийм ажиллагааг хийж болохгүй гэсэн үг. Тодорхой болсон аль нэг шалтгаанд тулгуурлан шалгаад эрүүгийн хэрэг үүсгэх үндэслэлийг тогтоогоогүй бол эрүүгийн хэрэг заавал үүсгэх албагүй, үүсгэхгүй байж ч (татгалзаж) болно. Үүгээрээ дээрх таван шалтгаан эрүүгийн хэрэг үүсгэх үндэслэлээс ялгарч байгаа хэрэг, хэрэв үндэслэл байсан бол түүнд үндэслэн эрүүгийн хэргийг заавал үүсгэх ёстой.

Энэ зүйлд "Гэмт хэрэг гарсан талаар..." гэж заасанд мөн шүүмжтэй хандаас зохино. Тийм ч учраас практикт үүнийг одоо болон ирээдүй цагт ойлгож хэрэглэдэг.

Тэгэхээр үүнийг цаг заалгүйгээр "Гэмт хэргийн талаар..." гэж оруулж өгөөл илүү ойлгомжтой.

Бас 1.5-д: "...гүйцэтгэх ажлын шугамаар авагдаж, баримтжуулагдсан мэдээ баримт..." гэсэн нь Монгол хэлний идэвхгүй хэвийн нөхцлийг ашигласнаас Европын аль нэг хэл мэт сонстож байгаад шүүмжтэй хандууштай. Оросоор "Протокол прочитан следователем и прослушан мною" гэснийг "Тэмдэглэл мөрдөн байцаагчаар уншигдаж надаар сонстов" гэж хэлдэггүй. Эсвэл Мираандагийн сануулгад ордог "Your words will be taken down, and may be used against you" гэдгийг "Таны хэлсэн үг таны эсрэг ашиглагдах болно" гэж хэлдэггүй.

Доктор Б.Бат-Эрдэнэ "...эрүүгийн хэрэг үүсгэх ажиллагаа нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа шинээр бий болох хууль зүйн факт бий болдог"⁴ гэсэн бий. Тэгэхээр эрх бүхий субъектэд эдгээр шалтгааны аль нэг нь тодорхой болсон нь энэ фактыг зааж буй учир тэр үеэс ЭБШХ-ийн 1.1-д зохицуулахаар заасан: "ЭБШ ажиллагаа явуулахтай холбогдон үүсэх харилцаа" үүсэж, цаашид хэрэгжүүлэх ажиллагааг мөн хуулиар зохицуулах шаардлага гардаг тул "эрүүгийн хэрэг үүсгэх" шатанд хийх ажиллагаа энэ үеэс процессын шинжийг агуулж, процессын тодорхой шийдвэр гаргахын тулд тэд ЭБШ зарим ажиллагааг хэрэгжүүлж эхэлдэг.

Эрүүгийн процессын харилцаа үүссэнээр эрх бүхий субъектууд мөрдөн байцаалтын шаардлагатай ажиллагааг хийх, таслан сүргийлэх зэрэг процессын арга хэмжээг авах

¹ Б.Шагжа "Монгол үсэг-үн дүрим-үн толи" Хөх хота. 1997. 216 дахь тал. Я.Цэвэл Монгол хэлний товч тайлбар толь. УБ. 1966 он. 390 дэх тал.

² Энэ үгийн талаар Б.Ринчин авгай "Монгол хэлэнд л-н харилцан солигддог учраас навч-навч, нуух-нуух, лут-нут гэдэг ажээ. Зарим нэгэн орчуулагч нар нутгийнхаа аялгууг дагаж нутыг нот гэж боловч лутыг арай лот гэхийг би дуулаагүй. Хүрээлэнгээс 1936 онд гаргасан толь бичигт энэ байдлыг харгалзан, утга зохиолын дуудлагыг нэгэн мөр болохын учир, нэлээд хянаж тогтсон нь нут-нутлах гэсэн билээ. Монголч эрдэмтний эрдэм шинжилгээний зохиолд ч нут-нутлах гэж дуудлагыг магадлан тогтоосон тул, одоогийн хэвлэлд о-гоор дуудагддаг орчуулагч нарын дуудлагыг баримтлан нот, нотлох гэж бичдэг нь, монгол хэл, хэлний шинжлэлийн баримттай нийлүүлэлт, баахан ташаа болох тул, үзэн зөөвөр нь нутлах гэж бичлээ" гэсэн бий.

³ Ж.Болдбаатар Эрүүгийн хэрэг үүсгэх шатан дахь нотолгооны онцлог. "Гэмт явдалтай тэмцэх асудал" сэтгүүл. 2004 он №4. 22 дахь тал.

⁴ Мөн тэнд.

⁵ Б.Бат-Эрдэнэ. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй. Тусгай анги. УБ. 1999 он. 3 дахь тал.

болон өөрсдийн тогтоосон гэмт үйлдлийн шинжийг урьдчилан зүйлчилдэг. Өөрөөр хэлбэл, эрүүгийн хуулийг ч энэ шатанд хэрэглэж эхэлдэг.

ЭБШХ-ийн 126 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар бүх төрлийн үзлэгийг болон 172 дугаар зүйлийн 3 дэх хэсэгт заасан, хойшлуулшгүй дараах тодорхой ажиллагааг хэрэгжүүлж болохыг хуульд заасан. Үүнд:

172.3.1. хүний нэр хаягийг тодруулах зорилгоор баримт бичгийг үзэж шалгах;

172.3.2. хүний бие, тээврийн хэрэгсэл, ачаа тээшид үзлэг хийх;

172.3.3. аж ахуйн нэгж, байгууллага, иргэний эд зүйл, эд хөрөнгө, мөнгө агуулсан байр савыг битүүмжлэх;

172.3.4. хэрэгт ач холбогдол бүхий тээврийн хэрэгслийг саатуулах, эд зүйл, мөнгийг түр хугацаагаар хурааж авах;

172.3.5. шүүх эмнэлэг, криминалистикийн болон бусад шинжилгээнд зориулж дээж, хурууны хэв, ул мөрний хэв авах;

172.3.6. иргэн, албан тушаалтнаас тайлбар авах, шаардлагатай тохиолдолд шинжээч томилж, дүгнэлт гаргуулах;

172.3.7. нутаг дэвсгэр, орон байранд нэвтрэн орох, гарахад хяналт тогтоох;

172.3.8. гэмт хэргийг таслан зогсоох, гэмт этгээдийг мөрдөх үед байгууллага, иргэний орон байранд нэвтрэн орох;

172.3.9. согтууруулах ундаа, мансууруулах, хордуулах бодис хэрэглэсэн эсэхийг шалгах зэрэг болно.

Эрүүгийн хэрэг үүсгэх үндэслэл бий болж, хуульд заасан, эрүүгийн хэрэг үүсгэх шалтгаан тодорхой болмогц түүний бодитой⁶ эсэхийг процессын зарим ажиллагааг хэрэгжүүлж байж нутлаж өгөхийн тулд ЭБШХ-ийн 172.5-д зааснаар: "...172.3.2, 172.3.3, 172.3.4, 172.3.5-д заасан ажиллагааг гагцхүү энэ

хуульд заасан журмаар явуулна".

Улсын Ерөнхий прокурорын 2008 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 123 тоот тушаалын хавсралтаар баталсан "Гэмт хэргийн талаархи гомдол, мэдээлэлд хойшлуулшгүй ажиллагаа явуулах журам"-д зааснаар: "...ЭБШХ-ийн 172 дугаар зүйлийн 172.3.2-оос 172.3.6 дахь хэсэгт заасан ажиллагаануудыг явуулахдаа тэмдэглэл үйлдэх ба тэмдэглэлийг мөн хуулийн холбогдох зүйлүүдэд заасан журмын дагуу үйлдэнэ".

Түүнчилэн, ЭБШХ-ийн 38 дугаар зүйлийн 3-д: "Энэ хуулийн 172.3-т заасан хойшлуулшгүй ажиллагаа явуулж эхэлсэн... үеэс эхлэн эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд өмгөөлөгч оролцох эрхтэй" гэж зааж өгсөн. Энэ заалт мөн л уг шатанд ЭБШ ажиллагаа явуулж болохыг хууль зөвшөөрснийг харуулж байна.

Хууль ийнхүү "...гагцхүү энэ хуульд заасан журмаар явуулна", "...заасан ажиллагаануудыг явуулахдаа тэмдэглэл үйлдэнэ..." гэсэн болон "хойшлуулшгүй ажиллагаа явуулж эхэлсэн үеэс өмгөөлөгчийг оролцуулахаар заасан дээрх заалтуудыг гаргаж, энэ шатанд ЭБШХ-ийг хэрэгжүүлэхийг зөвшөөрсөн. Процессын зарим ажиллагааг хэрэгжүүлж, гэмт хэрг мөн эсэх тухай нутлаж байж эрүүгийн хэрэг үүсгэх үү, татгалзах уу гэдэг асуудлыг шийдэх боломж энэ шатанд сая гарч ирнэ, тэгэхгүйгээр процессын шийдвэр гарах үндэс бүрдэхгүй. Ийм шийдвэрийг аль болох түргэн хугацаанд гаргах шаардлагатай бөгөөд ингэснээр иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын хууль ёсны эрх ашгийг шуурхай хамгаалж чадна. ОХУ-ын ЭБШХ энэ хугацааг 3 хоног, шаардлагатай тохиолдолд 10 хоног хүртэл сунгахаар заасан нь авууштай зүйл (ОХУ-ын ЭБШХ-ийн 144.1 ба 144.3.).

Энэхүү хуулийг бүхэлд нь мөрдөх гэж л баталсан тул дээр дурдсан, ЭБШХ-ийн 172.5-д "...172.3.2,

172.3.3, 172.3.4, 172.3.5-д заасан ажиллагааг гагцхүү энэ хуульд заасан журмаар явуулна" гэсэн илүүц зүйл. Хэдхэн арга хэмжээг ингэж жилэн үзүүлж байгаа нь бусад ажиллагааг явуулахдаа хуулийг баримтлах албагүй мэт буруу ойлголт төрүүлж мэдэх тул энэ заалтад шүүмжтэй хандах хэрэгтэй.

Практикаас харахад хуулийн ажилтнуудад эрүүгийн хэрэг үүсгэх шатанд процессын ажиллагаа хийж болохгүй гэсэн ойлголт нэлээд байдаг бөгөөд эрүүгийн хэрэг үүсгэх шалтгаан нь ЭБШ ажиллагааг хэрэгжүүлж эхлэх үндэс болно гэдгийг дутуу ойлгодог. Цагдаагийн газар, хэлтсүүдэд ажиллаж буй мөрдөн байцаагч нараас 60 хүн хамруулан явуулсан судалгааны дүнгээс:

1. МУ-ын ЭБШХ-ийн 166 дугаар зүйлийн 1-д заасан эрүүгийн хэрэг үүсгэх үндэслэл тодорхой болсон нь ЭБШ ажиллагааг явуулж эхлэх үндэс мөн үү? гэсэн асуултанд 73,3% мөн, 26,7% нь биш буюу мэдэхгүй гэж хариулсан байгаа нь манай мөрдөн байцаагчдын дийлэнх нь дээрх үндэслэл тодорхой болсон цагаас эхлэн ЭБШ ажиллагааг хэрэгжүүлж болно хэмээн ойлгож явдаг гэсэн;

2. "Эрүүгийн хэрэг үүсгэх шалтгаан хууль хэрэгжүүлэгч субъектэд тодорхой болсон цагаас эхлэн, эрүүгийн хэрэг үүсгэх тухай тогтоол гарахаас өмнө эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулж эхэлж болох уу?" гэсэн асуултанд 53,3% нь болно гэж, 46,7% нь болохгүй буюу мэдэхгүй гэж хариулсан байгаа нь цагдаагийн мөрдөн байцаагчдын бараг тэн хагас нь ЭБШХ-ийн 172 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн талаар буруу ойлголттой байна гэсэн;

3. "Эрүүгийн хэрэг үүсгэх шалтгаан хууль хэрэгжүүлэгч субъектэд тодорхой болсон цагаас эхлэн, эрүүгийн хэрэг үүсгэх тухай тогтоол гарахаас өмнө эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулж

⁶ Б. Шагжа "Монгол үсэг-үн дүрм-үн толи" Хөх хота 1997 259 дэх тал; Я.Цэвэл "Монгол хэлний товч тайлбар толь" УБ 1996 он 87 дахь тал

хариулсан байгаа нь тийм шаардлага амьдралд бодитоор байгаа гэсэн;

4 "Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг хэдийд хэрэглэж эхлэх ёстой вэ?" гэсэн асуултанд "ЭБШ харилцаа үүсэж эхэлмэгц" гэж 65%, "Эрүүгийн хэрэг үүсгэсний дараа" гэж 35% хариулсан байгаа нь мөрдөн байцаагчдын дийлэнх нь ЭБШХ-ийг тус хуулиар зохицуулах эрх зүйн харилцаа үүсч эхэлмэгц хэрэглэнэ гэж үздэг байна гэсэн дүгнэлтийг тус тус хийж болохоор байна.

Гэмт хэргийн талаархи мэдээлэлд хийсэн судалгааны дүнгээс үзэхэд тэдгээрийн дийлэнхийг хохирогчид (иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан) гаргасан байдаг. Энэ онд, нийслэлийн нэгэн дүүргийн цагдаагийн хэлтэст түдгэлзүүлсэн байгаа эрүүгийн 20 хэрэгт хийсэн судалгааны дүнгээс харвал гэмт хэргийн тухай бүх мэдээллийг хохирогч-иргэд-байгууллага гаргасан байна.

Хохирогчид гэмт хэргийн золиос болчихсон тухайгаа мэдээлж ирсээр атал, тэрхүү мэдээлэл хуульд зааснаар эрүүгийн хэрэг үүсгэх шалтгааны нэг гэдэг нь тодорхой байсаар байтал, мөнхүү мэдээлэл ЭБШ эрх зүйн харилцааг үүсгэж, түүний бодитой үнэнийг тогтоохын тулд ЭБШ ажиллагаа явуулах шаардлага илт тулгарсаар атал уг мэдээллийг үгүйсгэж, төр иргэндээ итгэхгүй байгаа мэтээр түүнийг бэхжүүлэх хуульд заасан арга хэмжээг хэрэгжүүлж эхэлдэггүй нь манай гаж тогтолцооны нэг.

Дээр дурьдсан судалгааны дүнгээс харвал: өргөдөл, гомдлыг хүлээн аваад 10 хэрэгт буюу 50%-д нь 5 хоногийн дотор, 5 хэрэгт буюу 25%-д нь 14 хоногийн дотор, үлдсэн 5 хэрэгт буюу 25%-д нь 19 хоног, түүнээс дээш хугацаанд эрүүгийн хэрэг үүсгэсэн байна. Хэрвэ ОХУ-ын ЭБШХ шиг эхний хугацааг 3 хоног, сунгах хугацааг 7, нийт 10 хоногт болгон шуурхай шийддэг болчихвол энэ үзүүлэлт буурах нь дамжиггүй.

5 хоногийн дотор эрүүгийн хэрэг үүсгэсэн 4 хэрэгт эрүүгийн хэрэг шууд

үүсгэн ЭБШ ажиллагаа явуулж, үлдсэн бүх хэрэгт буюу судалгаанд хамарсан нийт хэргийн 80%-д хохирогч болон гэрчүүдийг эрүүгийн хэрэг үүсгэсний дараа байцааж, гүүрүүнд "тайлбараар" авсан тэмдэглэлээ байцаалтын тэмдэглэл болгон хуулж бичсэн байна. 1 хэрэгт хохирогчийг огт асуулгүй байсаар 4 хоногийн дараа эрүүгийн хэрэг үүсгэх тогтоол гарснаас хойш шууд байцаасан (эсвэл өмнө тайлбараар асуусан тэмдэглэлийг эрүүгийн хэрэг үүсгэсний дараа хэргийн материалаас сугалж авсан), 1 хэрэгт гүүрүүнд "тайлбараар" авсан тэмдэглэлийг сар өдрийг зассан, 2 хэрэгт өргөдөл гомдол шалгах хууль ёсны хугацааг хэтрүүлсэн байна. Дээрхи 80%-д буюу 16 хэрэгт хохирогч, болон гэрч 54 хүнийг эрүүгийн хэрэг үүсгэснээс хойш байцааж, хохирогч болон иргэний нэхэмжлэгчээр тогтоосон байгаа нь тэр хүртэл хууль ёсны эрх, ашиг сонирхол хөсөрдөж, төр иргэндээ итгэхгүй явсныг харуулж байна. Тэрчлэн энэ 20 хэрэгт 54 тэмдэглэлийг 2 дахин бичсэн байна гэсэн үг.

Хяналтын прокурорууд эрүүгийн хэрэг үүсгэггүй байж мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж байна гэж үзэн эрүүгийн хэрэг үүсгэх шатанд хийсэн ажиллагааг буруутгадаг. Иймээс практикт, иргэд гэмт хэргийн талаар мэдээлж ирмэгц түүнээс ЭБШХ-д зааснаар тайлбар авч байна. Зүй нь тайлбарыг байцаалтаар авч тэмдэглэлээр бэхжүүлж байж ЭБШХ-ийн 79.2-т заасан мэдүүлгийн шинжийг олж нутлагааны эх сурвалж болох учиртай. Тайлбар авч тэмдэглэл хөтөлж байгаа нь үнэн хэрэгтээ түүнийг байцааж, тэмдэглэл хөтөлж байгаа хэрэг боловч үүнийгээ байцаалтын бус, "тайлбар авсан тэмдэглэл" гэж гарчигладаг нь ЭБШХ-д огт байхгүй зүйл. Тэгсэн хэрнээ хууль сануулж, зурвас цаасан дээр, тусад нь гарын үсэг зуруулна. Хожим, эрүүгийн хэрэг үүсгэвэл энэ цаасыг хэрэгт хавсаргана, эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзахаар бол

түүнийг сугалж авна. Дээрх судалгаанд хамарсан хэргийн 80%-д тайлбараар асуухдаа тэмдэглэлд хууль сануулаагүй байгаа нь үүнийг даруй батлана. Эрүүгийн хэрэг үүсгэхээр бол зохих шийд гарсаны дараа мөнөөх "тайлбар"-ын тэмдэглэлээ цэг таслал ч орхилгүй хуулан байцаалтын тэмдэглэл болгодог. Зарим гэрч, хохирогч: "Наадахыг чинь би өмнө нь танд хэлсэн шүү дээ, хичнээн дахин бичдэг юм?" гэх мэтчилэн загнахаас эхлээд, түрүүчийн хийснээ бүгдийг дахин хийх, хугацаа алдах, мэдүүлэг өгсөн хүн гадаадад олон жилээр явах, ЭБШ ажиллагааг хэрэгжүүлж болдоггүйгээс (шинжээчийн дүгнэлт хүлээх г.м) шийдвэр гаргаж чадаагүй, түүнээс болж гэмт хэргийн золиос болон өртсөн иргэдийн эрх ашиг хохирох мэт хүндрэл энэ үед гардаг.

Мэдээллийг хүлээн авахдаа мэдээлэл өгөгчид санаатайгаар худал мэдээлбэл хуульд заасан харицлагаа хүлээлгэхийг сануулахыг хууль зөвшөөрдөг тул (ЭБШХ-ийн 170.2) "тайлбар"-ыг байцаалтын тэмдэглэлээр авч түүндээ хуулиа сануулдаг байвал хожим худал мэдээлснийг тогтоосон тохиолдолд хуулийн харицлагаа оноох үндэслэл бий болж, энэ хүндрэлээс гарч болно. Хохирогчид гомдол гаргаж ирмэгц хууль сануулан хатуурхаж ханддаг боловч гэрч зэрэг бусад хүмүүст зөвхөн эрүүгийн хэрэг үүсгэсний дараа хууль сануулдаг нь хуулийн өмнө бүгд эрх тэгш байх Үндсэн хуулийн зарчмыг алдуулж байгаагаар барахгүй энэ шатанд хууль сануулаагүй хүмүүс худал мэдээлж болохыг зөвшөөрч буй хэрэг мэт.

Хуулийн дээрх заалт, журмыг зөв ойлгож, хэрэгжүүлбэл ЭБШ эрх зүйн харилцаа үүссэн цагаас эхлэн хуульд заасан, процессын ажиллагааг хэрэгжүүлж эхэлж болохоор байна. Эрүүгийн хэрэг үүсгэх хуульд заасан үндэслэл бий болсон үед, тийм үндэслэл үнэхээр байгаа эсэхийг тогтоохоор хийх процессын ажиллагаа өөрөө хууль ёсны ажиллагаа мөн. Тиймээс

хуульд заасан хугацаанд эрүүгийн хэрэг үүсгэх үндэслэл тогтоогдохгүй байсан ч тэр хүртэл хийсэн ЭБШ ажиллагаа тийм үндэслэл алга буйг албан ёсоор тогтоож өгч буй баримт тул эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах тогтоолоор өмнө хийсэн ЭБШ ажиллагаа хүчингүй болох учиртай. Харин манайд одоо хэрэгжиж буй практик үүнийг үгүйсгэж, эрүүгийн хэрэг үүсгэх бодит шалтгаан гарч ирчихээд байхад "эрүүгийн хэрэг үүсгээгүй" хэмээн ЭБШ тодорхой ажиллагаа явуулахыг хориглож байна.

Дүгнэлт

1. Эрүүгийн хэрэг үүсгэх шат өвөрмөц зорилт бүхий, процессын бие даасан шат мөн;

2. Эрүүгийн хэрэг үүсгэх үндэслэл бий болмогц эрүүгийн процессын харилцаа үүсэж бий болдог нь процессын арга хэмжээг хэрэгжүүлж эхлэх үндэс мөн;

3. Эрүүгийн хэрэг үүсгэх үндэслэлийг тогтоож, процессын шийдвэр гаргахын тулд ЭБШХ-ийн хэм хэмжээг мөрдөхийг уг хууль зөвшөөрсөн байна;

4. ЭБШХ-ийн 80 дугаар заалт энэ шатанд нутлах ажиллагаа явуулах үндсийг бүрдүүлээгүй байна;

5. Манай практик ажилтнууд ЭБШХ-ийн заалтыг гүйцэд ойлгож, хэрэгжүүлж чадахгүй байна.

Санал

1. Эрүүгийн байцаан шийтгэх харилцаа үүссэн цагаас эхлэн

процессын ажиллагааг хэрэгжүүлж болох тухай заасан ЭБШХ-ийн заалтыг зөв мөрдөх;

2. Эрүүгийн хэрэг үүсгэх шатанд процессын арга хэрэглэн шалгаад тийм бодтой үндэслэлийг тогтоогоогүй бол эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах тогтоолоор өмнө хийсэн ЭБШ ажиллагааг хүчингүй болгодог байх;

3. ЭБШХ-ийн 80 дугаар зүйлийн 80.1-д "Эрүүгийн хэрэг үүсгэх шат, ..." гэж, мөн зүйлийн 80.1.1-д "Эрүүгийн хэрэг үүсгэх үндэслэл бий эсэхийг тогтоох..." гэж тус тус нэмж оруулах зэрэг болно.



Энэхүү асуулт, хариултын товхимолыг бэлтгэхдээ сонирхосон тодорхой үйлчилгээ, харилцаанд ороход тань зайлшгүй тус дөхөм болох хууль тогтоомжийн төрөл харилцаагаар бүлэглэн авч үзсэн болно.

Мэдээж нийгмийн харилцаа баялаг болохоор тухай харилцаа болгоныг зохицуулсан эрх зүйн зохицуулалт асуудал бүрийг бүрэн багтаах боломжгүй тул түүгэмэл нийтэд хэрэгтэй болов уу гэснийг түүвэрлэн оруулсан болно. Ингэхдээ асуудлыг товч тодорхой хариулахын тулд хууль тогтоомжийн зохицуулалтыг аль болохоор амьдралын жишээ, энгийн үгээр илэрхийлж асуулт-хариултын хэлбэрээр бэлтгэж хэвлүүлэв.

Энэхүү номонд орсон асуулт-хариултыг 2009 оны 12 дугаар сарын 30-ны байдлаар хүчинтэй хууль тогтоомжийг үндэслэн бэлтгэв. Гэхдээ иргэд Та бүхэн энэхүү хууль зүйн асуулт хариултын эмхтгэлийг ашиглахдаа эргэлзээ гарвал тухайн хууль тогтоомжийг нь лавлан шалган үзэж байхыг зөвлөж байна.

Зохиож эмхтгэсэн: А.Түвшинтулга (ХЗҮХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, өмгөөлөгч)


Цаасны хэмжээ: 15х21 /А5/

Хэвлэсэн он: 2010

Худалдах үнэ: 10,000 төг

ISBN 978-99929-1-867-5

Утас: 315736, 88007557



*Монгол Улсын хөдөлмөрийн баатар, ардын багш, гавьяат хуульч,
доктор, профессор Б.Чимидийн нэрэмжит илтгэлийн
урилдаан оролцсон багш, судлаачдаас III байрт шалгарсан илтгэл*

ШҮҮХ ХУРАЛДААНЫ АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА ШҮҮХ ХУРАЛДААН НЭЭЛТТЭЙ ЯВУУЛАХ ХУУЛЬ ЗҮЙН ХАРИЛЦАН ХАМААРЛЫН ЗАРИМ АСУУДАЛ

Цагдаагийн академийн Иргэний эрх зүйн тэнхимийн багш Б.Даваажав

Эрх зүйт төр, иргэний нийгмийг цогцлоон хөгжүүлэхийг эрхэм зорилгоо болгож хүний эрх, эрх чөлөө, ардчилсан ёс, шударга ёс, энэрэнгүй ёс нь нийгмийн этолон болж буй өнөө үед төрийн үйл ажиллагаа түүн дотроо шүүхийн нээлттэй байдлын асуудал, тэдгээрт иргэд болон иргэний нийгмийн зүгээс тавих хяналтыг сайжруулж шаардлагыг өндөр түвшинд хүргэхийг нийгмийн хөгжлийн өнөөгийн байдал шаардаж байна.

Илтгэчийн зүгээс тухайн сэдвийг бүх талаас нь бүрэн дүүрэн судалж гаргалгаа дүгнэлт хийхийг зориугүй бөгөөд шүүх хуралдааны аюулгүй байдальтай холбоотой хууль зүйн учир холбогдол бүхий дараахь тодорхой асуудал, нөхцөл байдалд холбогдох судалгаа, дүн шинжилгээ хийж өөрийн санал, дүгнэлтээ илэрхийлэн гаргахыг зорьсон.

1. Шүүх хуралдааны аюулгүй байдлын тухай ойлголт, түүнд хамаарах асуудлууд

Шүүх хуралдааны аюулгүй байдлын асуудал нь “Аюулгүй байдал” болон эрх зүйн бусад тодорхой ойлголтуудтай холбоотой.

Аюулгүй байдлын тухай асуудлыг онолын үүднээс авч үзвэл эрх зүйн эх толь бичигт дараахь байдлаар тодорхойлжээ.

Аюулгүй байдал гэдэг нь тухайн улсад улс төрийн эдийн

засгийн ба нийгэмшлийн тогтвортой байдлыг тогтоон хангах, хуулиудыг чанд сахин биелүүлэх ба эрх зүйн дэг журмыг хангуулах, олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх үндэс болсон улс төрийн, эдийн засгийн, нийгэмшлийн, цэргийн, экологийн, мэдээллийн ба бусад шинжтэй дотоод ба гадаад шинж чанартай аюул заналхийллээс бие хүн, нийгэм, төрийн амин чухал ашиг сонирхол хамгаалагдсан байдал юм.²

Харин эрх зүйн хийгээд үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын үүднээс авч үзвэл:

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт: “Монгол Улсын үндэсний аюулгүй байдал гэж Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсан байдлыг хэлнэ. Үндэсний аюулгүй байдлыг хангах бодлогын үзэл бодлын үндэс нь эх оронч үндэсний үзэл байна”³ хэмээн тодорхойлсон харин уг дефинитив хэм хэмжээг агуулгын хувьд ижил боловч хүчин чадлын



Б.Даваажав урилдааны үеэр илтгэлээ тавьж буй нь

хувьд дээрдүүлж Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 3-р зүйлийн 3.1 дэх хэсэгт “Үндэсний аюулгүй байдал” гэж Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсан байдлыг хэлнэ⁴,” хэмээн хуульчилжээ.

Харин шүүх хуралдааны аюулгүй байдлын тухай асуудал нь үндэсний аюулгүй байдлын тодорхой бүрэлдэхүүн хэсгүүдэд сөрөг нөлөөлж болох дараахь хүчин зүйлүүдтэй нягт уялдаа холбоотой гэж бидний зүгээс үзсэн. Үүнд:

- Нийгэм-төрийн аюулгүй байдлын хувьд:

- 5) Монгол Улсын төрийн эрх мэдлийг хуваарилах зарчим алдагдах;

¹ Я.Цэвэл. “Монгол хэлний товч тайлбар толь”. УБ. 1967 он.

² С.Нарангэрэл. “Эрх зүйн толь бичиг”. УБ. 2007 он. 54 дэх тал.

³ Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. УИХ-ын 1994 оны 56 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт.

⁴ Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хууль. Төрийн мэдээлэл. УБ. 2001 он.

8) нийгэмд хууль ёс, дэг журам сахилга, хариуцлага суларч, эмх замбараагүй байдал бий болох, төрийн удирдлага, сонор сэрэмж суларч, төрийн нууц алдагдах;

9) хээл хахууль газар авч гэмт хэрэг зохион байгуулалтын шинжтэй болох;

Эдгээр нь шүүх хуралдааны аюулгүй байдал болон шүүх хуралдаан нээлттэй явуулах зарчимтай холбоотой болохыг үзэл баримтлалын тухайн хэсэгт тусгасан үндэсний аюулгүй байдлыг хангах арга замын тодорхой хэсгүүдээс харж болохоор байна. Үүнд.

4) үндэсний аюулгүй байдлын үүднээс хуулиар хориолсноос бусад тохиолдолд төрийн үйл ажиллагааг ард олонд ил тод болгох. хэмээн заасныг дурдаж болно.

• **Иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдлын хувьд:**

1) Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомж, түүнчлэн Монгол Улсын нэгдэн орсон буюу байгуулсан олон улсын гэрээ, конвенцид заагдсан хүний эрх ноцтойгоор зөрчигдэх;

2) Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжоор олгогдсон Монгол Улсын иргэдийн эрх, эрх чөлөөг хангахуйц улс төр, эдийн засаг, нийгмийн болон бусад бодит баталгаа эс бүрдэх буюу алдагдах;

• **Мэдээллийн аюулгүй байдлын хувьд:**

1) аливаа хүчин хэвлэл, мэдээллийн хэрэгслийг улс орны байдлыг хурцатгах, хувь хүн хувийн тооцоо хийх, бусдын нэр хүндийг гутаах зэвсэг болгон ашиглах;

3) үндэсний аюулгүй байдал, улсыг батлан хамгаалах, нийгмийн хэв журмыг хангах зорилго бүхий төрийн нууц алдагдах;

4) хэвлэл мэдээлэлээр гүтгэгдсэн иргэн, байгууллага өөрийгөө хэвлэл мэдээллийн хэрэгслээр буюу шударга шүүхээр хамгаалуулах эрх хумигдах;

Эдгээрээс авч үзвэл шүүх хуралдааны аюулгүй байдал гэж Үндсэн хууль бусад хуулиар баталгаажсан шүүх эрх мэдлийг

хэрэгжүүлэх үйл ажиллагааны хэлбэр болох шүүх хуралдаан хэвийн явагдах нөхцөл баталгаатай хангагдсан нөхцөл байдлыг хэлж болохоор байна.

2. Шүүх хуралдаан нээлттэй явуулах үндсэн хуулийн үзэл, санаа:

Энэхүү үзэл санаа нь түүхэн хийгээд хууль зүйн үзэгдэл болохын хувьд эртний төрт улсуудад бий болж сэтгэгчдийн үзэл санаагаар боловсронгуй болж эх сурвалжуудад бичигдэн үлджээ. Эртний Афин болон бусад хот улсын иргэд гэмт этгээдийг шүүх, маргааныг таслахдаа хотын иргэд бүгд оролцдог байсан бол аажимдаа таван зуугийн зөвлөл болон бусад байгууллагуудад энэ эрхээ шилжүүлж хотын иргэд хөндлөнгийн хяналтын үүргийг гүйцэтгэх болсон. Эртний ромын эрх зүйн хөгжлийн бүхий л үе шатанд шүүх хуралдааны нээлттэй байдлын асуудлууд чухлаар хэлэлцэгдэж байжээ. Эдгээр түүхэн хийгээд хууль зүйн үзэгдэл нь дараа дараагийн үеийн шүүн таслах ажиллагааны хөгжилтөд чухлаар нөлөөлж рецепц хийгдэж ирсэн гэж үзэж болно.

Эрт үед ч гэлээ шүүх таслах ажиллагааг нээлттэй явуулах нь ард иргэдийг айлган цээрлүүлэх гэхээсээ илүү шударга ёс, тэгш эрх, шүүхийн ил тод байдлыг хангах үзэл санаа нь илт давамгайлж ирсэн болохыг судлаачид тэмдэглэсэн байдаг.

Харин дундад зууны үед эрх зүйн хөгжлийн хувьд харанхуй байдал бий болж шүүн таслах ажиллагаанд шашны инквизици бүрэн ноёрхож байх үед дээрх нь эсрэгээрээ байсан гэж ойлгож болно. Өөрөөр хэлбэл, тэнд шударга ёс, шүүхийн нээлттэй байдлын асуудал гэх мэт гэгээлэг гэхээсээ иргэдийг айлгах, нийгмийн айдасг агуулж дэг журмыг тогтооход чиглэгдэж байсан бөгөөд эдгээр нь сэргэн мандалт, дахин сэргэлтийн аймшигт дайсан нь байсан

Үндсэн хуулийн үзэл санаа болохын хувьд дахин сэргэлтийн үеийн сэтгэгчид болох

Ш.Л.Монтескье, И.Кант, Ф.Бекон нарын онол, бүтээлүүдээс улбаатай бөгөөд АНУ-ын Үндсэн хуульд тусгагдсанаар улам боловсронгуй болж хөгжих эх үндэс нь тавигдсан. Уг үзэл санааны гол агуулга нь ардчиллын хийгээд Үндсэн хуульд ёсны үнэт зүйлс болох шударга ёс, ил тод, нээлттэй байдлыг хангах үйл явцтай салшгүй холбоотой бөгөөд эдгээрийг шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч этгээдээс үйл ажиллагаандаа хэрхэн хэрэгжүүлж, сахин хамгаалж байгаад иргэд, олон нийтийн зүгээс хяналт тавих нээлттэй боломжийг хангасан байх явдлаар илэрхийлэгддэг.

Үүнийг орчин үед иргэний нийгэм, эрх зүйт төрийн нэг шинж, шалгуур гэж үзэх болсон.

Монгол Улсын Үндсэн хуулийн 54 дүгээр зүйлд "Хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд шүүх хэргийг ил таслан шийдвэрлэнэ" хэмээн тусгаснаар энэхүү үзэл санаа нь хууль зүйн хүчин чадалтай болж баталгаажсан. Энэ нь Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг болон 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт заасан хэм хэмжээтэй нягт уялдаа, холбоотойгоор бусад салбар эрх зүйд тусгагдан хэрэгжиж байна.

3. Эрх зүйн процессын салбарын гол эх сурвалжуудад шүүх хуралдааныг нээлттэй явуулах зарчмыг тусгасан байдал

Үндсэн хуулийн процесс:

Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт: "**Цэц нь хараат бус байх, Монгол Улсын Үндсэн хуульд захирагдах, гишүүд эрх тэгш байх, асуудлыг шударга шийдвэрлэх, үйл ажиллагаа нь ил тод байх үндсэн зарчмыг баримтална**" мөн 12 дугаар зүйлд "**Цэц маргаан ханан шийдвэрлэхдээ хуралдааныг хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд илээр, шууд, тасралтгүй явуулах, талуудыг эрх тэгш, чөлөөтэй мэтгэлцүүлэх, асуудлыг хамтран хэлэлцэж, олонхийн**

саналаар бодитой, энэ хуульд чанд нийцүүлэн шийдвэрлэх зарчмыг баримтлална.”⁵ гэж тусгасан бол Үндсэн хуулийн Цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг ил тод явуулна. Төрийн болон байгууллага, хувь хүний нууцыг хамгаалах, иргэдийн аюулгүй байдлыг хангах онцгой шаардлагатайгаас бусад тохиолдолд Цэцийн хуралдааныг нээлттэй хийнэ”⁶ хийнэ гэж тусгажээ.

Иргэний процесс:

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт “Бүх шатны шүүхийн шүүх хуралдааныг нээлттэй явуулна.”

8.2 дахь хэсэгт “Хэргийн нотлох баримт, эсхүл үйл явдал төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарах бол хэргийн оролцогчдын хүсэлтээр шүүх хуралдааныг бүрэн буюу түүний зарим ажиллагааг хаалттай явуулж болно.”

8.3 дахь хэсэгт “Иргэний эрх зүйн чадамжгүй, согтуурсан буюу мансуурсан, хэргийн оролцогч биш бол 18 насанд хүрээгүй этгээдийг шүүх хуралдааны танхимд байлгаж болохгүй.”

Эрүүгийн процесс:

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 235 дугаар зүйлийн 235.1 дэх хэсэгт: “Төр, байгууллага, хувь хүний нууцыг хамгаалах болон насанд хүрээгүй этгээдэд холбогдох хэрэг хянан шийдвэрлэхээс бусад бүх шатны шүүхийн шүүх хуралдааныг нээлттэй явуулна.”

Захиргааны процесс:

13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт “Захиргааны хэргийн шүүх захиргааны хэрэг хянан шийдвэрлэхдээ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай

хуулийн 4-11 дүгээр зүйлд заасан зарчмыг баримтлана.” гэж иш татсан байдлаар зааж өгсөн байдаг.

Эдгээрээс нэг зөрүүтэй зүйл ажиглагдаж байгаа нь шүүх хуралдаан нээлттэй явуулах Үндсэн хуулийн үзэл санаа процессын эрх зүйн салбар бүрт өөрөөр хэрэглэгдэх байдал ажиглагдаж байна. Өөрөөр хэлбэл, шүүх хуралдаан нээлттэй буюу хаалттай явуулах хууль зүйн үндэслэлийн асуудал хоорондоо хэт зөрүүтэй байгааг анхаарах шаардлагатай байна.

4. Шүүх хуралдааныг хаалттай явуулах хууль зүйн үндэслэлийн асуудал:

Шүүх хуралдааныг хаалттай явуулах хууль зүйн үндэслэлийн асуудлыг дээрх хуулийн зүйл заалтуудаас шууд хэрж болох бөгөөд нийтлэг байдлаар төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотойгоор хаалттай явуулахаар зохицуулжээ.

Энд нэг асуудал байгаа нь шүүх хуралдааныг хаалттай явуулах асуудал нь нууцын тухай хууль тогтоомжид үндэслэгдэх императив шинжтэй юм үү, оролцогчдын хүсэл зоригт үндэслэгдэх диспозитив шинжтэй юм үү гэсэн асуудал нь маргаантай юм.

Мөн шүүгч ямарч тохиолдолд аливаа хэрэг маргааныг хянан шийдвэрлэхдээ хараат бус байх ёстой. Гэтэл бодит байдал дээр хараат бус байдал алдагдаж түүнийгээ алхавчлахын тулд аливаа хэрэг маргааныг “Шалтаглах” байдлаар хаалттай шийдвэрлэх байдал багагүй гарах боллоо гэж иргэд олон нийт хийгээд судлаач, эрдэмтэд тэмдэглэн хэлэх болжээ. Энд бид гурван жишээг сонгон авлаа.

Жишээ 1: Центр пойнтынг гэж алдаршсан хэрэгт иргэн Э-г татаж шалган улмаар 8 хэрэг хүлээлгэсэн байдаг. Үг хэрэгт улс төр, бизнесийн

хүрээний сонирхол орж Э-г заавал яллах гэсэн чиг хандлага шүүн таслах ажиллагаанд давамгайлсан.

Эцэст нь шуугиан тарьсан шүүхийн процесс явагдахад хүрэхэд дээрх 8-н зүйл анги дээр нэмж хүчингийн хэрэг үйлдсэн гэж ялласан.

Үнэндээ хөөн хэлэлцэх гугацаа, хохирогчийн гомдол байхгүй зэрэг тухайн үеийн хууль тогтоомжоор хэрэгсэхгүй болгох ёстой үйлдлийг нэмсэн гол зорилго нь улсын яллагч, шүүгч нар төдийгүй тэднийг хараат байдалд оруулсан улс төрийн хүрээнийхэн хэргийг хаалттай явуулж яллах, өөрсдийн холбогдолтой үйлдлийг иргэд, олон нийтээс нуух явцуу ашиг сонирхолд оршиж байсан. Энэ талаар нэрт хуульч, өмгөөлөгч С.Нарангэрэл өөрийн “Амьд эрх зүй” бүтээлдээ готорхой дурдсан:

Жишээ 2: Хадгаламж зээлийн хоршоодын гэх цуврал шүүн таслах процессууд хэндээ нээлттэй явагдсан. Мөн л хараат бус байдал зарим талаар алдагдсан, шударга биш шүүсэн, шүүх гэж байна гэсэн иргэдийн бухимдал өрнөж зарим шүүх хуралдааны аюулгүй байдал илт алдагдсан. Бодит байдал дээрээ шүүх хуралдааны аюулгүй байдлыг хангах арга хэмжээг зохион байгуулах хүч дутагдсан уу, эсхүл түүгээр шалтаг хийе гэж бодсон уу, ерөөсөө шүүгчид айсан уу шүүх хуралдааныг нээлттэй нэрийн доор хаалттай бүсэд явуулсан. Үнэндээ тухайн хурлуудыг хаалттай явуулах хууль зүйн үндэс байгаагүйгээс шүүгчид дээрх залилм хэрэглэсэн. Энэ хэрэг дээр шүүх хуралдааны аюулгүй байдал хамгийн их алдагдаж, нээлттэй явуулах зарчим зөрчигдсөн гэж үздэг;

Жишээ 3: Сүүлийн процессууд нь Монгол Улсын дээд шүүхээр хэлэлцэгдэн дуусаж байгаа зарим нь түүнээс өмнө Өршөөлийн хуульд хамрагдан хэрэгсэхгүй болсон “7 дугаар сарын 01-ны” гэх цуврал шүүн таслах ажиллагаа улс төрөөс хэт

⁵ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хууль. Төрийн мэдээлэл. УБ., 1992 он.

⁶ Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль. Төрийн мэдээлэл. УБ., 1997 он.

⁷ Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль. Төрийн мэдээлэл. УБ., 2004 он.

хараат байсан гэх маргаан ид өрнөж байгаа билээ. Ийнхүү хараат байсан гэх хардлага төрүүлэх болсон гол шалтгаан нь хэд хэдэн хэргийг насанд хүрээгүй шүүгдэгч бүхий хэрэгтэй нэгтгэх байдлаар шүүх хуралдаануудыг хаалттай явуулж хэт улс төржсөн шийдвэр гаргасан гэсэн шалтгаанаас үүдэлтэй. Тухайн хаалттай шүүх хуралдаанууд дээр зарим улсын яллагч ялын дүгнэлтээ шүүх хуралдааны мэтгэлцээнд хамгаалж чадахгүйд хүрэхдээ дээрээс чиг өгсөн, дарга үүрэг өгсөн гэх мэтээр хэлсэн тухай баримт, мэдээллийг одоо Улсын Их хурлаас байгуулагдсан хоёр ч ажлын хэсэг шалгаж байна.

5. Шүүх хуралдааны аюулгүй байдлыг хангахтай холбоотой дүрэм, журмууд:

Өнөөдөр шүүх эрх мэдэл тэр дундаа шүүх хуралдааны аюулгүй байдалтай холбоотой цөөхөн дүрэм, журам үйлчилж байна. Энэ нь практикт олон хүндрэл бэрхшээлийг бий болгож шүүх хуралдааны аюулгүй байдлыг хангах асуудал хангалтгүй байгааг илэрхийлж байна. Энд материаллаг болон процессын хууль дахь хамгаалалтын хэм хэмжээнээс илүү нарийвчилсан дүрэм, журам, заавар түүнийгээ практикт нэг мөр хэрэгжүүлэх асуудал чухал байна. Шүүх хуралдааны аюулгүй байдалтай холбогдох дараахь хэдэн заавар, дүрэм, журам байна. Үүнд:

- Шүүх хуралдааны танхимын загварыг батлах тухай Шүүхийн Ерөнхий зөвлөлийн 2006 оны 3 дугаар сарын 06-ны өдрийн 16 дугаар тогтоолын 1 дүгээр хэсрэлт;

- Шүүх хуралдаанд хэвлэл, мэдээллийн болон бусад байгууллагын төлөөлөгч, иргэний оролцоулах тухай журам;

- Шүүхийн Ерөнхий зөвлөлийн даргын 2007 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 46 тоот захирамжийн 1 дүгээр хэсрэлт "МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН НУУЦЫН ТУХАЙ ДҮРЭМ";

- Шүүгч бие хамгаалах тусгай

хэрэгсэл хэрэглэх журам.

Шүүх хуралдааны танхимын стандартад тавигддаг хэд хэдэн шаардлага байдаг. Тухайлбал:

- Зай байрлалын стандарт;
- Ижилтгэх стандарт;
- Тавилга, хэрэгслийн суурилуулалтын стандарт;
- Гэрэлтүүлэг болон бусад техник хэрэгслийн стандарт;
- Барилга, байгууламжийн байршил, дотоод схемийн стандарт;
- Гадны халдлагаас хамгаалах системийн стандарт;
- Дуу, чимээ тусгаарлах хувиргах стандарт;
- Тусгаарлах байгууламж, хэрэгслийн стандарт.

Гэтэл дээрх дүрэм журамд уг стандартауд бүрэн тусгагдаж чадаагүй бөгөөд цаашид анхаарах асуудлын нэг болоод байна.

6. Шүүх хуралдаан ба хэвлэл мэдээллийн хэрэгсэл:

Монгол Улсын Эрүүгийн байцаан хуулийн 235 дугаар зүйлийн 235.1 дэх хэсэгт заахдаа **"Төр, байгууллага, хувь хүний нууцыг хамгаалахаас бусад тохиолдолд бүх шатны шүүхийн шүүх хуралдааныг нээлттэй явуулна."** гэж заасан байдаг. Үүнийг эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн эрдэмтэн, судлаачид тайлбарлахдаа: Шүүх хуралдааны ил тод байх зарчмыг хэрэгжүүлэхэд олон нийтийн мэдээллийн хэрэгслийг өргөн ашиглах нь чухал ач холбогдолтой. Жишээ нь: Шүүх хуралдааны явцыг шууд нэвтрүүлэх, сурвалжлага хийлгэх, шүүхийн тогтоол, шүүх хуралдааны тэмдэглэлийг хэвлэн нийтлэх, шийдвэрлэсэн хэргийн тойм тайлбарыг гаргах зэрэг нь ач холбогдолтой байж болно гэж авч үзсэн байдаг. Үүнтэй илтгэгч миний бие санал нэгдэхгүй байна. Учир нь энэ асуудал нь олон талаараа учир дутагдалтай юм.

Дэлхийн ихэнх улс оронд энэхүү асуудал нь байдаггүй. Учир нь хувь хүн, байгууллага, төрийн нууцын асуудлыг хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй нь холбон авч үзэж

түүнийг хэвлэл мэдээллээр цацах, нэвтрүүлэх, шүүх хуралдааны үед бичлэг хийхийг хүртэл хатуу хориглодог байна. Шүүх хуралдааны аюулгүй байдлын хүрзэн дэх хэвлэл мэдээллийн асуудал нь дараахь сөрөг хүчин зүйлийг бий болгоно гэж судлаачдын зүгээс үзэж байна. Эдгээрийг дараах байдлаар бүлэглэн авч үзэж судлаж болохоор байна:

- Хувь хүнд нөлөөлөх сөрөг нөлөөлөл;
- Нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөлөл;
- Эрх зүйн үнэт зүйлсийг үгүйсгэх нөлөөлөл.

Эдгээрээс нэгтгэн дүгнэвэл.

1. Шүүх хуралдааны аюулгүй байдлын тухай асуудал нь өнөөгийн нөхцөлд тулгамдсан, шийдлээ хүлээсэн олон асуудлыг хууль, судлаачдын өмнө бий болгож байна;

2. Шүүх хуралдааны аюулгүй байдлын асуудал болон шүүх хуралдаан нээлттэй хаалттай явуулах зарчмын асуудлуудын уялдаа холбоо, зааг ялгааг зөв зүйтэй тодорхойлох шаардлага бий болж байна. Ингэхгүй бол шүүхийн хараат бус байдал алдагдах, шүүх хуралдаан хийгээд шүүгчээс хууль хэрэглэх ажиллагаа хэн нэг оролцогчийн хийгээд шүүгчийн дүр зоргоор явагдах байдлыг бий болгох аюул холгүй байна;

3. Шүүх хуралдааны аюулгүй байдлыг хангахтай холбоотой дүрэм, журмуудыг шүүхийн хуралдааны танхимийн стандартуудыг тусгаж шинээр боловсруулах шаардлага бий болж байна.



*Монгол Улсын хөдөлмөрийн баатар, ардын багш, гавьяат хуульч,
доктор, профессор Б.Чимидийн нэрэмжит илтгэлийн
уралдаанд II байрт шалгарсан оюутны илтгэл*

ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ ШҮҮХ ЭРХ МЭДЛИЙН ЗАРИМ АСУУДАЛ

УДИРТГАЛ

Шүүх эрх мэдлийн утга агуулга нь хүний эрх, эрх чөлөөг хангахад болон хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн үйлдэл, явдал, шийдвэр нь эрх зүйд нийцсэн эсэхэд хяналт тавихад оршдог¹ билээ. Эрх зүйт ёсыг дээдэлдэг ардчилсан нийгэмд хүний эрх, эрх чөлөөг хангах нэгэн чухал арга зам бол хуулийн байгууллага, тэр дундаа шүүх, прокурорын байгууллага хүний эрхийг дээдэлж, шударга ажиллах явдал байдаг.

Монгол Улс 1992 онд ардчилал, эрх зүйт ёсонд суурилсан шинэ Үндсэн хуулиа баталснаар хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах ёстойг гүнхлгасан. Үүний зэрэгцээгээр Монгол Улс НҮБ-ээс батлан гаргасан хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой 50 орчим гэрээ конвенцод нэгдэн орж, эдгээр гэрээ конвенцод заасан хүний эрхийг хангах баталгааг биелүүлэх үүргийг дэлхийн хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн² юм. Эндээс үзвэл, хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэн дээдэлж, хууль ёсыг чандлан биелүүлэх нь шүүх, прокурорын байгууллагын үйл ажиллагаанд тавигдах эрхэм зорилго байх ёстойг илтгэж байна.

Гэтэл Үндсэн хуулиар баталгаажсан хүний эрх, эрх чөлөө шүүх болоод прокурорын байгууллагын үйл ажиллагаанд өнөөг хүртэл бодитойгоор хангагдаж чадахгүй, зөрчигдөж байгаа нь энэхүү сэдвийг судлах үндэслэл болсон юм. Тодруулбал, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд дахь таслан сэргийлэх онцгой арга



*МУИС-ийн Хууль зүйн
сургуулийн оюутан
М.Монхжаргал*

хэмжээ болох цагдан хорих арга хэмжээг өөрчлөх, хүчингүй болгох эрхийг сэжигтэн, яллагдагчийн өмгөөлөгчийн хүсэлтийг үл харгалзан шүүгч бус прокурор шийдэж байхаар УДШ-ийн Ерөнхий шүүгч, Улсын Ерөнхий прокуророос хамтарсан захирамж³ гаргасан бөгөөд уг захирамж эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хэрэгжсээр байна. Үүний улмаас эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа (ЭБША)-нд хүний эрх ноцтойгоор зөрчигдөж, Үндсэн хуулиар тогтоосон хүний эрхийн баталгаа устгахад хүрч байна.

Энэхүү илтгэлийн зорилго нь дээрх хуулиас давсан хамтарсан захирамжийн нөлөөгөөр цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг

өөрчлөх, хүчингүй болгох асуудал ЭБША-нд хэрхэн явагдаж байгааг судалж, шүүх эрх мэдлийн зүгээс хүний эрхийг хэрхэн бодитойгоор хангах учиртайг Үндсэн хуулийн үзэл баримтлалын үүднээс тодорхойлж, өөрийн зүгээс дүгнэлт, санал дэвшүүлэхэд оршино.

Илтгэчийн зүгээс сэдвийн хүрээнд хэрхэн зүйн зохицуулалтыг норматив аргаар, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны практикийг дискритив аргаар, мөн сурвалжлагын аргыг ашиглан профессор Ж.Бямбаа, МӨХ-ны өмгөөлөгч Д.Пүрэвбаатар нартай цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх, хүчингүй болгох асуудлаар ярилцаж судалгаагаа хийлээ.

НЭГ. СУДАЛГААНЫ ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

А. Хүний эрхийг хангах Үндсэн хуулийн үзэл баримтлал:

Хүний эрхийн талаарх Үндсэн хуулийн нэгэн чухал үзэл баримтлал нь хүний эрхийг хамгаалах, хангах баталгааг бүрдүүлэх үүргийг төрд ноогдуулсан⁴ явдал бөгөөд үүнийг хэрэгжүүлэх арга замыг УИХ-аас 2003 оны 10 дугаар сарын 24-нд баталсан "Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр"-өөр тодорхойлсон. Уг хөтөлбөрийн 1 дүгээр бүлгийн 1-д зааснаар шүүх, прокурор, өмгөөлөх зэрэг хүний эрхийг хангах шууд үүрэг зорилго бүхий төрөлжсөн байгууллагууд нь хүний эрхийг хангах үндэсний механизмыг бэхжүүлэх үйл

¹ Ю.И.Стецовский. "Судебная власть" изд. "Дело" М 1999, стр. 54. Дам ишлэл
Ж.Дашдорж: Эрүүдэн шүүх болон хэргийг хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийг хориглосон хууль тогтоохижийн хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдал. Хүний эрх сэтгүүл, 2006 он, №1, 24 дэх тал.

² Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын Ерөнхий прокурорын хамтарсан 2009 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 07, 26 тоот захирамж, тушаал. Эх сурвалж: www.supremecourt.mn/index.php?coi

³ Б.Чимид, Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс, УБ, 2006 он, 84 дэх тал.

ажиллагаанд нэн тэргүүд хамаардаг. Түүнчлэн ЭБША бол хүний эрхийн талаасаа их анхаарал татдаг, эрсдэл ихтэй үйл ажиллагаа учраас шүүх эрх мэдлийн зүгээс энэхүү ажиллагаанд оролцогчдын эрхийг хамгаалах⁵, хангах баталгааг бодитойгоор бүрдүүлэх нь хүний эрхийг хангах Үндсэн хуулийн үзэл баримтлалд төдий чинээ нийцэх учиртай.

Б. Олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөөг хангах нь:

МУ-ын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 2-д "Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахиж биелүүлнэ", мөн зүйлийн 3-д соёрхон баталсан олон улсын гэрээ нь дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил хүчинтэй үйлчлэхээр заасан нь Үндсэн хуулийн II бүлэгт тодорхойлон томъёолсон үндсэн эрх, эрх чөлөөнөөс гадна, МУ-ын нэгдэн орсон, байгуулсан олон улсын гэрээ, конвенцод заасан хүний эрх, эрх чөлөөг шүүх эрх мэдлийн зүгээс хангах учиртайг илтгэж буй хэрэг. Тэгвэл Үндсэн хуулийн энэхүү үндэслэлийн дагуу шүүх эрх мэдлийн байгууллага ЭБША-г явуулахдаа олон улсын баримт бичгийг удирдлага болгох, тэдгээрт нийцүүлэх шаардлага тавигдаж байна. Тодруулбал, ЭБША-нд шинэчлэлийн чухал хөшүүрэг⁶ болсон "Хүний эрхийн түгээмэл тунхаглал"⁷, "Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт"⁸, мөн хүний эрхийн ноцтой зөрчил болох эрүү шүүлтийн эсрэг "Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц"⁹

зэрэг олон улсын баримт бичгүүдэд заасан хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах, үүний баталгааг бүрдүүлэх¹⁰ явдал шүүх эрх мэдлийн үйл ажиллагаанд нэн чухал.

В. Хууль, шүүхийн өмнө тэгш эрх эдлэх зарчим:

МУ-ын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйл уг зарчмын гол баталгаа бөгөөд хуулийн өмнө эрх тэгш байх гэдэг нь МУ-ын хуулиар иргэдийн үндэс угсаа, арьсны өнгө, нас хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, шашин шүтлэг, боловсрол, албан тушаал, үзэл бодол зэргээр ялгаварлан тэгш бус байдал бий болгож үл болно гэсэн агуулгыг илэрхийлнэ.¹¹ Харин шүүхийн өмнө тэгш байна гэдэг нь эрх зүйн этгээдүүд, болон талууд шударга, хөндлөнгийн, хараат бус шүүхийн өмнө хуульчлан бүрдүүлсэн нөхцөл боломжид тулгуурлан өөрийн эрх, ашиг сонирхлоо хамгаалах явдал¹² бөгөөд ЭБША-д оролцогч талуудад шүүхийн өмнө мэтгэлцэх боломжийг нээж өгдөг.

ХОЕР.ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ
Монгол Улсын 1974 онд нэгдэн орсон "Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт"-ийн 9 дүгээр зүйлийн 9.3-д "...шүүхийн өмнөх шатанд байгаа хүнийг заавал цагдан хорьж байх нийтлэг журам байх албагүй" гэж заасан нь цагдан хорих ТСАХ бол зөвхөн онцгой тохиолдолд авах арга хэмжээ гэдгийг нотлож байна. Нотлогдоогүй бол гэм буруугүйд тооцох зарчим болон эрх чөлөөтэй байх хүний эрхийг хамгаалах үүднээс тухайн этгээдийг

цаашид хорих үндэслэл тогтоогдохгүй бол ТСАХ-г өөрчлөх, нэн даруй хүчингүй болгох ёстой.¹³

Цагдан хорих нь ЭБША-нд хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, эрүүгийн хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх явцад эрх чөлөөг нь мөрдөн байцаалтын тусгаарлах байранд албадан хязгаарлах таслан сэргийлэх арга хэмжээний нэг¹⁴ бөгөөд Үндсэн хуулиар баталгаажсан "халдашгүй чөлөөтэй байх" үндсэн эрхийг хязгаарлалдаараа ЭБША-г хэрэгжүүлэгчдийн зүгээс туйлын нягт нялбай¹⁵, хуулийн үндэслэлтэй хандахыг шаарддаг.

Тэгвэл цагдан хорих ТСАХ-г өөрчлөх, хүчингүй болгох асуудалд ч мөн адил дээрх шаардлага тавигдах бөгөөд МУ-ын 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хууль (ЭБШХ)-д дараах байдлаар зохицуулсан байна. Үүнд:

1. Цагдан хорих ТСАХ-г өөрчлөх, хүчингүй болгох үндэслэлийг: ЭБШХ-ийн 70.1-д: "Гэмт хэргийн ангилал болон сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн хувийн байдлыг харгалзан урьд авсан таслан сэргийлэх арга хэмжээг хүчингүй болгох буюу чангатгаж, хөнгөрүүлж болно";.

2. Цагдан хорих ТСАХ-г өөрчлөх, хүчингүй болгоход оролцох шүүгч, прокурорын эрх хэмжээг: ЭБШХ-ийн 70.2-д: "Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх, хүчингүй болгох асуудлыг өмгөөлөгчийн хүсэлт, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн саналыг харгалзан хяналт тавьж байгаа

⁵ П.Оюунчимэг. Сэжигтэн, яллагдагчийн эрхийг баталгаатай хангах зарим асуудал. Хүний эрх сэтгүүл. 2005 он.№1. 39 дэх тал.

⁶ Ж.Бямбаа. МУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн үндсэн асуудлууд. УБ., 2008 он. 27 дэх талаас дэлгэрүүлэн үзнэ үү.

⁷ НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 217 (A/III) тогтоолоор 1946 оны 12 дугаар сарын 10-ны өдөр баталсан.

⁸ НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2200A(XI) тоот тогтоолоор 1966 оны 12 дугаар сарын 16-ны баталсан. Монгол Улс 1968 оны 1 дүгээр сарын 5-ны өдөр гарын үсэг зурж. 1974 оны 11 дүгээр сарын 18-ний өдөр соёрхон батласан.

⁹ Уг конвенцийг 1984 оны 12 дугаар сарын 10-ны өдөр Нью-Йорк хотноо баталсан. Монгол Улс 2000 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр нэгдэж орсон.

¹⁰ Хүний эрх түүнийг хангах баталгаа хоёр нь нэг зоосны хоёр тал юм. М.М.

¹¹ Ж.Бямбаа. МУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн үндсэн асуудлууд. УБ., 2008 он. 73 дэх тал.

¹² Ж.Бямбаа. Шүүн таслах ажиллагаанд дахт мэтгэлцэх зарчим ба хүний эрх, эрх чөлөө. Хүний эрх сэтгүүл. 2005 он. №1. 54 дэх тал.

¹³ "Эрүүгийн эрх зүй дэх хүний эрх" (судалгааны илтгэл). УБ. 2009 он. 25 дэх тал.

¹⁴ С.Нарангэрэл. Эрх зүйн эх толь бичиг. УБ., 2008 он. 552 дэх тал.

¹⁵ Б.Оюутболд. Хүний эрх ба эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд дахь таслан сэргийлэх арга хэмжээ. Хүний эрх сэтгүүл. 2005 он. №2. 30 дэх тал.

прокурор санал гаргах ба шүүгч түүнийг үндэслэн захирамж гарган шийдвэрлэнэ. Уг хэрэг шүүхэд шилжсэн бол шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжаар шийдвэрлэнэ.” гэжээ.

Дээрх 2 заалтад сэдвийн хүрээнд хамааруулан товч тайлбар хийвэл: ЭБШХ-ийн 70.1-д заасан “шүүгдэгчийн хувийн байдал” гэдэгт тухайн этгээдийн зан төлөвийн байдал, үйлдсэн хэрэгтээ чин санаанаасаа гэмшсэн байдал, насны болоод эрүүл мэндийн байдал¹⁶, мөн практикт оршин суух байнгын хаягтай байгаа, байцаалт, мэдүүлгээ цаг хугацаанд нь өгч буй байдал¹⁷ зэргийг хамааруулан авч үзэж байна. Харин ЭБШХ-ийн 70.2-д цагдан хорих ТСАХ-г өөрчлөх, хүчингүй болгох асуудлыг өмгөөлөгчийн хүсэлтийг харгалзан хяналт тавьж байгаа прокурор санал гаргаж, уг саналыг үндэслэн шүүгч захирамж гаргаж шийдвэрлэхээр зохицуулсан нь ЭБША-д хүний эрхийг тууштай хамгаалагч болдог өмгөөлөгчийн эрхийг хумисан, прокурорт илүү эрх мэдлийг олгосон шинжтэй байна.

Хэдийгээр ЭБША-нд баримтлах прокурорын чиг үүрэг нь: а. Хуулийг сахин биелүүлэх; б. Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах байдаг ч түүний эцсийн зорилго нь яллах¹⁸ мөн чанартай билээ. Тиймээс цагдан хорих ТСАХ-г өөрчлөх, хүчингүй болгох асуудалд өмгөөлөгчийн хүсэлтийг үнэлэх эрх болоод уг асуудлаар санал гаргах эрхийг прокурорт байлгах нь хууль, шүүхийн эмнэ тэгш эрх эдлэх зарчмыг алдагдуулж буй хэрэг бөгөөд тэртээ тэргүй эрх нь хөндөгдөөд байгаа сэжигтэн, яллагдагчийн эрхийг бүр мөсөн зөрчих аюултай. Учир нь өнөөгийн эрүүгийн хэргийг нотлох ажиллагааны практикт хэрэг тулгах, хэрэг үлээлгэхийн тулд янз бүрийн арга саам хэрэглэх, дарамтлах,

зодох, уяаж байцаах, айлгах, хүнд суртал гаргах, хэрэгт хувийн сонирхолтой оролцох зэрэг байдал амь бөхтэй оршин байгаа нь нууц биш¹⁹ агаад эдгээрийг хэрэгжүүлэхийн тулд цагдан хорих ТСАХ-г өөрчлөлгүйгээр үргэлжлүүлэн удаан хугацаагаар хорих явдал түгээмэл байна.

Харин цагдан хорих ТСАХ-г өөрчлөх, хүчингүй болгох асуудалд цэвэр хөндлөнгийн байр суурьнаас хандах ёстой субъект бол шүүгч бөгөөд шүүгчийн эрх хэмжээ нь прокурорын санал (яллах тал), өмгөөлөгчийн хүсэлт (өмгөөлөх тал) хоёрыг ижил түвшинд үнэлэн, адил тэгш байдлаар авч үзэж, эцсийн шийдвэр гаргах агуулгаар тодорхойлогдоно. Нөгөөтэйгүүр, шүүгдэгчийн цагдан хорих арга хэмжээг өөрчлүүлэх, хүчингүй болгуулахаар өмгөөлөгчөөс хүсэлт гаргана гэдэг нь хүний эрхийг хамгаалах агуулгаар авч үзвэл уг асуудалд зайлшгүй анхаарлаа хандуулах шаардлагатайг илтгэж буй хэрэг бөгөөд шүүгч энэхүү маргаантай асуудалд прокурорын саналын зэрэгцээ өмгөөлөгчийн хүсэлтийг харгалзан үзэж шийдвэрлэх²⁰ нь зүйтэй юм. Дээрхээс үндэслэн цагдан хорих ТСАХ-г өөрчлөх, хүчингүй болгох асуудалд хамаарах шүүгч, прокурор, өмгөөлөгчийн эрх хэмжээг дараах байдлаар дүрсэлж байна. (Схем-1)

ХУУЛИАС ДАВСАН ЗАХИРАМЖ
Цагдан хорих ТСАХ-г өөрчлөх,
хүчингүй болгох асуудлыг зохицуулж

буй ЭБШХ-ийн 70.1, 70.2 дахь заалттай хамааралтайгаар 2008 оны 1 дүгээр сарын 30-ны өдөр Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын Ерөнхий прокуророос хамтран 07, 26 тоот захирамж, тушаал гаргаж, “Баривчлах, цагдан хорихтой холбогдсон зарим ажиллагааг зохицуулах тухай журам” гээчийг баталсан байна. Энэхүү журмын 5.5-д “Сэжигтэн, яллагдагчийн цагдан хорих ТСАХ-г өөрчлөх, хүчингүй болгох асуудлыг зөвхөн тухайн хэрэгт хяналт тавьж байгаа прокурорын саналыг үндэслэж шүүгч шийдвэрлэнэ. Прокурор энэхүү саналыг гаргахдаа хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн санал, өмгөөлөгчийн хүсэлтийг харгалзана. Энэ талаар прокурор санал гаргаагүй тохиолдолд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх, хүчингүй болгох талаар шүүхэд ирүүлсэн хүсэлтийг прокурорт шилжүүлнэ.” гэж заасан байна. Уг заалт дараах байдлаар хууль, шүүхийн эмнэ тэгш эрх эдлэх зарчмыг алдагдуулж, ЭБША-нд хүний эрх, эрх чөлөө хамгаалагдах баталгаа үгүйсгэж байна. Энэ нь:

Цагдан хорих ТСАХ-г өөрчлөх, хүчингүй болгох асуудлыг шүүгч шийдвэрлэхдээ өмгөөлөгчийн хүсэлтийг харгалзалгүйгээр зөвхөн прокурорын саналыг харгалзана гэж заасан байгаа нь сэжигтэн яллагдагчийн эрхийг (хүний эрхийг) хамгаалах баталгаагүй хийжээ.

Прокурор санал гаргаагүй тохиолдолд шүүхэд ирүүлсэн хүсэлтийг прокурорт шилжүүлнэ гэж

Схем 1.

Прокурорын санал

Шүүгч

Өмгөөлөгчийн хүсэлт

Цагдан хорих ТСАХ-г өөрчлөх, хүчингүй болгох эсэх тухай шийдвэр (хөндлөнгийн байр сууринаас)

¹⁶ Г.Совд, Монгол Улсын эрүүгийн хуулийн тайлбар, УБ, 2003 он, 77-78 дахь тал

¹⁷ МӨХ-ны өмгөөлөгч Д.Пүрэвбаатартай хийсэн ярилцлагаас тодруулсан болно.

¹⁸ Прокурор нь ЭБША-д яллах чиг үүргийг хэрэгжүүлж, яллах тал болдог билээ. Тухайлбал, шүүх хуралдаанд Улсын яллагчаар оролцдог.

¹⁹ П.Оюунчимэг, Цагдан хорих ажиллагаа ба хүний эрх, Хүний эрх сэтгүүл, 2005 он, №4, 14 дэх тал.

²⁰ Илтгэгч миний бие профессор Ж.Бямбаагийн баримталж буй энэхүү байр суурьтай санал нэг байна.

зааснаар прокурорын санал, өмгөөлөгчийн хүсэлтийг ижил түвшинд үнэлэн авч үзэж,²¹ уг асуудалд хөндлөнгийн байр суурьнаас хандах шүүгчийн мөн чанарыг алга болгожээ.

Эндээс үзвэл цагдан хорих ТСАХ-г өөрчлөх, хүчингүй болгох асуудлыг ЭБШХ-д зөрчилтэй байдлаар зохицуулсан²² нь хүний эрхийг хамгаалах баталгааг алдагдуулсан шинжтэй байхад ийнхүү дахин нарийвчлан журам баталж байгаа нэрийдлээр сэжигтэн яллагдагчийн эрхийг улам хаагдуулсан байгаа нь ЭБША-нд хүний эрх хангагдах баталгааг устгасан гэж үзэхээр байна.

ГУРАВ. ХҮНИЙ ЭРХ
ЗӨРЧИГДӨХӨД ХҮРЧ БҮЙ ҮР
ДАГАВАР

Хуулиар гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдоогүй бол гэм буруугүйд тооцдог учир буруугүй хүнийг хорьж мөрдөн эрүүдэж болохгүй. Азгүй нэгний булчин, шөрмөс дотор байгаа аятай бие махбодийг өвтгөн байж үнэнийг гаргаж авдаг нь, мөн хүнээс: яллагдагч атлаа нэгэн зэрэг өөрийнхөө яллагч байхыг шаардаад байвал бүх зүйл учир утгаа алдах биш. Ийм арга бие хат сайтай гэмт хэрэгтэнг цагаатгаад, харин гэм буруугүй сул дорой нэгнийг хилсдүүлэхэд л найдвартай үйлчилнэ.

Чезаре Беккариа

УДШ-ийн Ерөний шүүгч, Улсын Ерөнхий прокурорын 07, 26 тоот хамтарсан захирамж гарсан 2008 оны 1 дүгээр сарын 30-ны өдрөөс өмнө ЭБША-ны практикт цагдан хорих ТСАХ-г өөрчлүүлэх, хүчингүй болгуулах хүсэлтийг сэжигтэн, яллагдагчийн өмгөөлөгч шууд

шүүхэд гаргадаг байсан ба шүүгч үүнд прокурорын саналыг харгалзан үзэж, өмгөөлөх болон яллах талыг мэтгэлцүүлэх замаар өөрийн дотоод итгэлээрээ үнэлэн шийдвэрлэдэг²³ байжээ. Харин дээрх хамтарсан захирамж гарсны дараагаар уг захирамжийн 5.5-д заасанчлан прокурор санал гаргаагүй л бол шүүх өмгөөлөгчийн хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэхгүй болон төдийгүй цагдан хорих ТСАХ-г өөрчлөх, хүчингүй болгуулах тухай өмгөөлөгчийн хүсэлтийг шүүх шийдвэрлэхгүйгээр прокурор шийдвэрлэхээр хэрэглэх²⁴ болсон нь судалгааг хийх явцад тогтоогдсон болно. Үүний жишээ болгож хүний эрх зөрчигдсөн дараах тохиолдол (case)-ийг дурьдъя.

"Иргэн Б хүндэвтэр гэмт хэрэгт холбогдож, 2008 оны 7 дугаар сарын 2-ны өдрөөс эхлэн Ганц худаг дахь цагдан хорих 461 дүгээр ангид хоригдож эхэлжээ. Улмаар хоригдох явцад сэжигтэн Б элэгний үрэвсэл буюу гепатет (шарлах) өвчин тусаж, бие нь мууджээ. Түүний өвчнийг Ганц худгийн эмнэлэг эмчлэх боломжгүй байсан учир ХӨСҮТ-д эмчлүүлэх зөвлөлийн шаардлагатай болсон байна. Иймээс Б-гийн өмгөөлөгч П БГД-ийн хяналтын прокурорт цагдан хорих ТСАХ-г өөрчлүүлэх тухай хүсэлт гаргасан боловч хүсэлтийг хүлээж аваагүй байна. Иймд БГД-ийн шүүхэд өргөдөл гаргасан ба шүүхээс үүнд: "...цагдан хорих ТСАХ-г шүүх шийдвэрлэхгүй тул хүсэлтийг хүргүүлэх" гэсэн хариуг өгчээ. Улмаар Б-гийн бие муудсан хэвээрээ байсаар 2008 оны 10 дугаар сарын 9-ний өдөр БГД-ийн шүүхээс ял шийтгүүлж хорих анги руу шилжсэн байна".²⁵

Монгол Улсын хэмжээнд 2008

онд шүүхээс нийт 5921 хүнд цагдан хорих зөвшөөрөл олгож, 293 хүнд зөвшөөрөл олгохоос татгалзсан²⁶ ба цагдан хоригдсон хүний тоо 2007 оны харьцуулахад 23,7%-иар өссөн²⁷ байна. Энэ нь цагдан хорих ТСАХ-г улам ихээр хэрэглэж буйг харуулж байгаа бөгөөд энэ хэрээрээ цагдан хоригдох явцад хүний эрх ямар нэгэн хэлбэрээр зөрчигдөхөд хүрэх аюултай билээ. Дээрх тохиолдол нь илтгэгчийн нягтлан шалгасан ил байгаа зөвхөн нэг л жишээ бөгөөд хэрэг, бүртгэлт мөрдөн байцаалтын ажиллагаанд өөр олон тохиолдол далд гарч болох магадлал өндөр байгаа юм. Учир нь:

А. Мөрдөн байцаагч өөр дээр нь байгаа хэргийг хангалттай мөрдөж чадахгүй байгаа (бүр мөрдөхийг хүсэхгүй, зөвхөн байцаах сонирхолтой. М.М) болохоор сэжигтэн яллагдагчийг цагдан хорьж, улмаар хэргийн яллах нотлох баримтаа хангалттай бүрдүүлэх хүртлээ тухайн этгээдийн цагдан хорих ТСАХ-г өөрчлөх, хүчингүй болгох сонирхолгүй байдаг;

Б. Өнөөгийн манай улсын ЭБША-нд ирүүлсэн хэргийнх нь тоогоор мөрдөн байцаагч нарын цалин хөлс, суурьшууллыг олгож байгаа явдал²⁸ нь хүнийг яллахад улайруулж, цээрлүүлэх хөшүүрэг болж байна. Хэрэв хэн нэгэн хэрэгт холбогдох л юм бол баривчлал, цагдан хорьж, уг арга хэмжээг өөрчилж, хүчингүй болголгүйгээр цагдан хорих хугацааг сунгаж, дарамт шахалт үзүүлэн, улмаар сэтгэл санаагаар унасан, хантарсан үед нь зохиомлоор хэрэг хүлээлгэж байгаа нь нууц биш билээ. Энэ нь өөрөө эрүүдэн шүүх хөрс, суурийг бэлдэж байгаа юм.

Ийнхүү цагдан хорих ТСАХ-г

²¹ ЭБША-д өмгөөлөгчийн оролцоо чанартай сайн байх тусам эрүүдэн шүүх, хэргийг хүнлэг бус харьцаа гаргах магадлал бага байдаг ба хүний эрх тэр хэрээрээ хамгаалагддаг.

²² ЭБШХ-ийн 70.1, 70.2 дахь заалтууд нь өмгөөлөгчийн эрхийг хумисан, прокурорт илүү эрх мэдлийг олгосон шинжтэй байна.

²³ Үүнийг МӨХ-ны өмгөөлөгч Д.Пүрэвбаатартай хийсэн ярилцлагаар тодруулж авсан болно.

²⁴ "Ерөнхий шүүгч, прокурор хоёрын хамтарсан тушаал хуулийг завхруулж байна" ярилцлага. Өдрийн сонин, 2009 оны 5 дугаар сарын 5-ны өдөр №108 (3185).

²⁵ Уг case-ийг МӨХ-ны өмгөөлөгч Д.Пүрэвбаатараас тодруулан авсан болно.

²⁶ МУ-ын шүүхийн 2008 оны жилийн тайлан. УБ, 2009 он. 97 дахь тал.

²⁷ http://www.mongolnews.mn/index.php?option=com_news&task=news_detail&tab=200909&ne=98

²⁸ "Монголд шинэ цагийн "есөн эрүү" дэлгэрчээ" Нийтлэл. Эх сурвалж: <http://www.mongolnews.mn/unuud.php?n=8913>

өөрчлөх, хүчингүй болгох асуудалд прокурор санал гаргаагүй тохиолдолд шүүхээс өмгөөлөгчийн хүсэлтийг харгалзан үзэхгүйгээр хамтарсан захирамж гаргаж, энэ нь ЭБША-д хэрэглэгдэж, улмаар хүний эрх зөрчигдөж байгаа нь судалгаагаар тогтоогдлоо. Энэ нь:

А. Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 7 дугаар зүйлд заасан "Хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд ямар ч алагчилалгүйгээр хуулиар адилхан хамгаалуулах эрх", 10 дугаар зүйлд заасан "Хүн бүр ...эрх үүргээ тодорхойлуулахдаа хараат бус, тал хардаггүй шүүхээр бүрэн адил тэгш үндсэн дээр нээлттэй, шударгаар шүүлэх эрх"-ийг тус тус зөрчиж байна;

Б. МУ-ын Үндсэн хуулийн 14.1-д заасан "Хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх" зарчмыг, 16.3-д "халдашгүй чөлөөтэй байх эрхтэй ...хуульд заасан үндэслэл журмаас гадуур дур мэдэн хэнийг ч ...хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно..." гэж заасныг тус тус зөрчиж байна.

Дүгнэлт, санал

Шүүх эрх мэдлийн гол байгууллагууд болох шүүх, прокурорын зүгээс ЭБША-ны явцад хүний эрхийг хангах, хамгаалах баталгааг дээд зэргээр бүрдүүлж, хүний эрх зөрчигдөх явдлаас тууштай сэргийлэх нь өнөөгийн эрх зүйт ёсыг дээдэлсэн, ардчилсан нийгмийн зүй ёсны шаардлага билээ.

Гэтэл Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын Ерөнхий Прокурор нар хамтарсан захирамж гаргаж, хуулийн заалтыг нарийвчлан журамлаж байгаа нэрийдлээр цагдан хорих ТСАХ-г өөрчлөх, хүчингүй болгох асуудлаарх өмгөөлөгчийн хүсэлтийг шүүх бус

прокурор шийдэж байхаар зохицуулсан нь Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлд заасан "хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх", ЭБША-ийн 17 дугаар зүйлд заасан "Мэтгэлцэх" зарчмыг тус тус алдагдуулж, ЭБША-д бүрдүүлэх ёстой хүний эрхийн баталгааг үгүй хийжээ. Үүнээс үүдэн ЭБША-ны практикт Үндсэн хуулиар тодорхойлон томьёолсон иргэний үндсэн эрх, эрх чөлөө болон олон улсын гэрээнд тусгагдсан хүний эрх зөрчигдөж байгаа нь судалгааны үр дүнд тогтоогдлоо.

Дээрх хамтарсан захирамжаар цагдан хоригдсон сэжигтэн, яллагдагчийн таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх, хүчингүй болгох эрхийг прокурорын санал бүртэйгээр хаагдуулснаараа сэжигтэн яллагдагчийг эрүүдэн шүүх, хэргийг хүчээр хүлээлгэх нөхцөлийг мөрдөн байцаалтын ажиллагаанд бүрдүүлж байна. Мөн энэ байдлаас болж үйлчлүүлэгчийнхээ эрхийг хамгаалах үүднээс цагдан хорих ТСАХ-г өөрчлүүлэхээр өмгөөлөгч нь прокурор, шүүгчид авлига өгөх ноцтой үр дагаврыг үүсгэж байгаа нь судалгаанаас ажиглагдсан болно. Иймд цагдан хорих ТСАХ-г өөрчлөх, хүчингүй болгох хүрээнд шүүх эрх мэдлийн зүгээс хүний эрхийг бодитойгоор хангах, хүний эрхийг хамгаалах Үндсэн хуулийн үзэл баримтлалтай уялдуулан илтгэгчийн зүгээс дараах саналуудыг дэвшүүлж байна.

Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын Ерөнхий прокурорын хамтарсан 2008 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн 07, 26 тоот захирамж, тушаалаар батлагдсан "Баривчлах, цагдан хорихтой холбогдсон зарим ажиллагааг зохицуулах тухай журам"-ын 5.5 дахь заалтыг дараах байдлаар өөрчлөх. Ингэхдээ:

"Сэжигтэн, яллагдагчийн цагдан хорих ТСАХ-г өөрчлөх, хүчингүй болгох асуудлыг тухайн хэрэгт хяналт тавьж байгаа прокурорын санал, сэжигтэн, яллагдагчийн өмгөөлөгчийн хүсэлтийг үндэслэж шүүгч шийдвэрлэнэ" гэж өөрчлөх.

Өнөөгийн түвшинд ЭБШХ-ийн 70.2 дахь заалтад хамааруулан сэжигтэн, яллагдагчийн цагдан хорих ТСАХ-г өөрчлөх, хүчингүй болгох тухай өмгөөлөгчийн хүсэлтийг, прокурорын саналтай адил тэгш байдлаар шүүх авч хэлэлцэх, ингэж хэлэлцэхдээ өмгөөлөгч болон прокурорыг заавал байлцуулан, хөндлөнгийн байр суурьнаас шүүгч шийдвэрлэж байхаар журамласан тайлбарыг, Дээд шүүхийн Үндсэн хуульд заасан "хууль тайлбарлах" эрхийн хүрээнд гаргах. Цаашдаа ЭБШХ-ийн 70.2 дахь заалтыг дээрх байдлаар өөрчлөн найруулах.

Цагдан хоригдож буй сэжигтэн, яллагдагч нь тодорхой хаягтай, эд хөрөнгөтэй, мөн нарийн мэргэжлийн эмчид үзүүлэх, клиник эмчилгээ хийлгэх зайлшгүй шаардлагатай болж, эрүүл мэнд нь доройтсон нөхцөлд цагдан хорих ТСАХ-г нэн даруй өөрчилж байдаг практикийг ЭБША-д бий болгох. Үүнийг хүний эрхийн болоод шүүх, прокурорын байгууллагын хамтарсан сургалт, хяналт, шалгалтаар хэрэгжүүлэх.

Эцэст нь дүгнэхэд хууль, шүүхийн өмнө тэгш эрх эдлэх зарчмын дагуу, хүний эрхийг хамгаалах Үндсэн хуулийн үзэл баримтлалын үүднээс цагдан хорих ТСАХ-г өөрчлөх, хүчингүй болгох асуудлыг эрх зүйн зохицуулалтын болоод ЭБША-ны практикийн хүрээнд боловсронгуй болгох нь хүний эрхэд тулгуурлаж, хуулийн байгууллагуудыг шинэчлэх ажлын нэгэн чухал хэсэг байх болно.



*Монгол Улсын хөдөлмөрийн баатар, ардын багш, гавьяат хуульч,
доктор, профессор Б.Чимидийн нэрэмжит илтэлийн
уралдаанд III байрт шалгарсан онутны илтэл*

ҮНДСЭН ХУУЛЬТ ЁСНЫ ТӨЛӨВШИЛТӨД ЕРДИЙН БОЛОН ДАГНАСАН ШҮҮХИЙН ОРОЛЦОО

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн оюутан Н.Баттулга

Удиртгал

Монгол Улс Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих эрх бүхий Үндсэн хуулийн Цэц (цаашид ҮХЦ гэх) хэмээх оноосон нэртэй Үндсэн хуулийн шүүхийг байгуулан үйл ажиллагаагаа нь эхлүүлснээс хойш багагүй хугацааг өнгөрөөжээ. Хэдий тийм боловч ҮХЦ-ийн талаар хөндөж, хэлэлцэх ёстой асуудлууд шил шилээ даран хүлээгдсээр байна. Үндсэн хуулийн цэц байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж эхэлснээс хойш эдүгээ 17 жилийн хугацаанд 112 дүгнэлт, Улсын Их Хурал Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөөгүй гэсэн үндэслэлээр маргааныг эцэслэн шийдвэрлэж 37 тогтоол гаргаад байна.¹ ҮХЦ нь шүүх болохынхоо хувьд аливаа маргаантай асуудлыг өөрийн санаачилгаар авч шийдвэрлэх эрх байдаггүй. Цэцэд эрх бүхий этгээд хуульд заасан журмаар хандаагүй л бол Үндсэн хуулийг илт зөрчсөн тухайн хэм хэмжээ хүчин төгөлдөр үйчилсээр байна гэсэн үг. Иймээс Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагаа бусдын зүгээс түүнд хандахаас ихээхэн хамааралтай. Иймээс юуны түрүүнд ҮХЦ-ийн үйл ажиллагааг боловсронгуй болгох, үр нөлөөг нь дээшлүүлэхийн тулд эрх бүхий этгээдүүдээс түүнд хандах процесс нь эрх зүйн оновчтой зохицуулалттай байх нь зүй мэт санагдана.

Учир юу гэвэл Монгол Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар ҮХЦ-д иргэд

өргөдөл мэдээлэл, Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх (цаашид УДШ гэх), Улсын ерөнхий прокурор хүсэлт гаргах эрхтэй байдаг. Үндсэн хуулийн цэцээс гаргасан дээрх 112 дүгнэлтээс шүүж үзэхэд өнгөрсөн хугацаанд ҮХЦ өөрийн харьяаллын маргааныг Улсын дээд шүүх² (2006 онд), Монгол Улсын Ерөнхийлөгч (1993, 1994 онуудад)-ийн тус тус гаргасан 2 хүсэлтийн дагуу, үлдсэн 108 маргааныг иргэд өргөдөл, мэдээлэл гаргаснаар өөрийн санаачилгаар маргаан үүсгэж дүгнэлт гаргасан байна. Хүний эрх, эрх чөлөө, шударга ёсны баталгаа хэмээгддэг шүүх маань Үндсэн хууль ёсыг бэхжүүлэхэд идэвх зүтгэл гаргаагүй байгаа, түүнчлэн ҮХЦ, бусад шүүхүүдийн хоорондын харилцааг цаашид хэрхэн нэмэгдүүлэх зэрэг нь улмаар энэ талаар бие даасан судалгааны ажил хийхэд хүргэлээ.

Илтэлийн үндсэн зорилго нь манай өнөөгийн практикт Үндсэн хууль ёсыг бэхжүүлэх, Үндсэн



хуулийн зарчмыг нэвтрүүлэхэд ердийн болон дагнасан шүүхүүд хэрхэн оролцож байгааг хууль зүйн шинжлэх ухаан өндөр хөгжсөн улсууд дахь онолын болон практикийн үзэл баримтлалтай харьцуулах замаар хуульчдын гол зүйл болох хэм хэмжээ болон харилцаа байдгийг удирдлага болгон судалгаагаа явууллаа.

НЭГ. СУДАЛГААНЫ ҮЗЭЛ БАРИМТАЛ

Өнөө үед Үндсэн хууль ёс нь эрх зүйт төрийн үзэл санааг хэрэгжүүлэх хамгийн шилдэг, зохистой арга хэмээгдэж байна. Тиймээс Үндсэн хууль ёсыг хууль бол эцсийн бөгөөд дээд хүчинтэй, төр засгийн эрх мэдэл эрд түмнээс үүдэлтэй, засгийн үйл ажиллагаа хууль эрхээс хязгаарлагдмал, хууль нь хүний эрх (Үндсэн хуульд П.Б-д үндэслэгдсэн байхыг хэлнэ.³ Орчин үеийн шаардлага хангасан Үндсэн хууль

¹ Энэхүү судалгааг www.legalinfo.mn сайтад дээр тавигдсан Үндсэн хуулийн цэцийн шийдвэрүүдээс шүүж гаргасан болно. Үндсэн хуулийн цэцэд хүсэлт мэдүүлэх тухай "Иргэний хууль" (2006 оны 2 дугаар сарын 20), "ЭБШХ, ИХШХШХ, ЗХХуулийн зарим зүйл, хэсэг, заалт МУ-ын Үндсэн хуульд нийцэхгүй байгаа талаар" (2006 оны 3 дугаар сарын 20), Энэхүү судалгааг мөн Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдааны тогтоолуудаас дөхөж шүүж гаргасан болно.

² Өнөрбаяр. "Монгол Улсад Үндсэн хууль ёсны үзэл санаа нэвтэрсэн нь (1911-1924он). УБ, 2005 он, 21 дэх тал. (дам шиллэл)

терийг тодорхойлдог хэм хэмжээний тогтолцоонд Үндсэн хууль нь төрийн дээд хүчин чадал бүхий хэм хэмжээ байж, хууль, эрх зүйн бусад акт, дүрэм журмууд түүнд нийцсэн байх учиртай. Ийм ч үзрээс шүүх шударга байхын нэг гол шалгуур нь шүүх Үндсэн хуульд нийцсэн хуулийг хэрэглэж аливаа хэрэг маргааныг шийдвэрлэсэн байдлаар тодорхойлогдох ёстой.

Шүүгч хараат бус байж гагцхүү хуульд захирагдаж хариуцлагатай байх шударга ёсны хүрээ хязгаар нь Үндсэн хууль бөгөөд уг хуулиас гадуур түүнд харшилсан ёс журмыг шударга ёс гэж хүлээн зөвшөөрөх аргагүй.² Өөрөөр хэлбэл, шүүх маргаан шийдвэрлэх ажиллагааны явцад гагцхүү Үндсэн хуулийнхаа суурь зарчмаар хязгаарлагдах ёстой байдаг бөгөөд Үндсэн хуульд нийцээгүй хуулийг хэрэглэхгүй байх Үндсэн хуулийн суурь зохицуулалт энд үйлчилнэ. Иймээс шүүх бол зөвхөн хууль хамгаалах үүрэгтэй биш Үндсэн хуулийн ардчиллыг хамгаалагч тул Монгол Улсын Үндсэн хуулийн 50 дугаар зүйлийн 3-т "Улсын Дээд шүүх, дээд шүүх Үндсэн хуульд нийцээгүй, албан ёсоор нийтлээгүй хуулийг хэрэглэх эрхгүй" хэмээн заажээ.³ Бүх шүүх хүний үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалах үүрэг хүлээдэг бөгөөд түүнийг төрийн засаглалын бусад салбарын халдлагаас хамгаалах, шүүх шүүх эрх мэдлийн байгууллага, шүүгчдэд оногддог. Учир нь шүүх нь өдөр тутам хууль хэрэглэж, аливаа хэрэг маргааныг шийдвэрлэдэг онцгой эрхтэй субъект юм. Энэ ч үүднээс шүүх нь аливаа эрх зүйн тодорхой маргааныг хянан шийдвэрлэхдээ Үндсэн хуулийг дээдлэн анхаарч тухайн маргаанд хэрэглэгдэх хуулийг Үндсэн хуулийн дагуу байгаа эсэхийг яасан ч гэсэн эргэн харж байх ёстой. Ийнхүү шүүх эрх зүйн тодорхой маргааныг хянан шийдвэрлэхдээ хэрэглэгдэх хууль нь Үндсэн хуульд нийцээгүй гэж үзвэл шийдвэр гаргуулахаар Үндсэн хуулийн шүүх (Цэц)-д хандах нь ч эрх зүйн зөв оновчтой зохицуулалттай байх ёстой.

1.1. Хэм хэмжээний тодорхой хяналт

Шүүх нь Үндсэн хуульд нийцсэн, хүчин төгөлдөр хуулийг хэрэглэх үүрэгтэй тул Үндсэн хуульд нийцээгүй гэж үзсэн хуулиа хэрхэн хэрэглэх өөрөөр хэлбэл, парламентын хуульд үг дуугүй захирагдах уу? эсвэл тухайн хэрэглэх хуулийг Үндсэн хуульд нийцээгүй гэж үзсэний улмаас шүүх нь хүчингүй болгох, бүр байхгүй гэж үзэж болох уу? гэсэн асуудал тавигдана. Үндсэн хуулийн шүүхээс эрх зүйн актыг Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг хянахад зориулсан янз бүрийн арга зам байдаг бөгөөд эдгээрээс чухал байр суурийг эзэлдэг нь хэм хэмжээний тодорхой хяналтын хэлбэр юм.

Хэм хэмжээний тодорхой хяналтын хэлбэр ёсоор ердийн болон дагнасан шүүх өөрийн харьяаллын хэрэг, маргааныг шийдвэрлэхэд ач холбогдол бүхий буюу хэрэглэх гэж буй хуулиа Үндсэн хуульд нийцэхгүй байна гэж үзвэл тухайн шүүх бүрэлдэхүүн (шүүгч) хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж Үндсэн хуулийн шүүхэд хандаж шийдвэр гаргуулахыг хэлнэ. Өөрөөр хэлбэл, энэхүү хяналтын хэлбэр нь шүүхийн мэргэжлийн хянан шийдвэрлэх тодорхой ажиллагаанд үндэслэгдэж байдаг. Тодорхой хяналт гэж нэрлэсэн нь ч ийм учиртай. Энэхүү хяналт нь нэг талаас шүүхүүдэд хяналт тавих эрхийг олгосон боловч парламентаас баталсан хууль Үндсэн хууль зөрчөн эсэхийг шийдвэрлэх монополь эрхийг гагцхүү Үндсэн хуулийн шүүх эзэлнэ гэсэн үг юм.

ХОЁР. ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ СУДАЛГАА

Хэм хэмжээний тодорхой хяналтын хэлбэрийг ардчилсан тогтолцоонд шилжсэн улсуудын тал орчим хувь нь хэрэгжүүлдэг байна.⁴ Тухайлбал: ХБНГУ-ын Үндсэн хуулийн 100 дугаар зүйлд "Хэрвээ тухайн хэргийг шийдэхдээ үйлчлэх хуулийг Үндсэн хуультай нийцэхгүй гэж үзвэл хэрэг хянан шийдвэрлэх

ажиллагааг түдгэлзүүлж ... Холбооны Үндсэн хуулийн шүүхээр шийдвэр гаргуулна".⁵ Мөн ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 101 дүгээр зүйлд "Шүүх хэрэг хянан шийдвэрлэж байгаа аль ч үе шатандаа тухайн хэрэгт хэрэглэгдсэн, эсхүл хэрэглэгдэх хууль нь ОХУ-ын Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг шалгах талаар асуулга тавина"⁶ гэж тус тус заажээ. Өөрөөр хэлбэл, Холбооны Үндсэн хуулийн шүүхэд хандах эрхийг ердийн болон дагнасан бүх шүүх эдлэх бөгөөд энэ нь Холбооны дээд шатны шүүхээр дамжих шаардлагагүй гэсэн үг юм.

Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар УДШ Үндсэн хуулийн цэцэд хандах субъектүүдийн тоонд ордогийг өмнө дурьдсан. Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 3-д "Улсын дээд шүүх хүсэлтээ хуралдаанд оролцсон нийт гишүүдийн олонхийн саналд үндэслэн гаргана" гэж заасан байдаг. Мөн Шүүхийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 3-д "Тодорхой хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхдээ хэрэглэх хууль нь Үндсэн хуульд нийцэхгүй байна гэж үзвэл шүүх тухайн хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж, саналаа Улсын дээд шүүхэд оруулна" мөн хуулийн 12 дугаар зүйлийн 4-т "Улсын дээд шүүх энэ хуулийн 12.3-т заасан саналыг хэлэлцэл үндэслэлтэй гэж үзвэл Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргана" гэж зааснаас харахад ҮХЦ-д бусад шүүхээс эрх зүйн тодорхой маргааныг шийдвэрлэхдээ хэрэглэх гэж буй хуулийг хянах боломж байгаа юм. Гэсэн хэдий ч манай улс дахь эрх зүйн зохицуулалт хэм хэмжээний тодорхой хяналтаас дарах байдлаар ялгаатай байна.

1. Анхан болон давж заалдах шатны шүүх тодорхой маргааныг хянан шийдвэрлэхдээ хэрэглэх хууль нь Үндсэн хуульд нийцээгүй байна гэж үзвэл энэ тухай саналаа шууд Үндсэн хуулийн цэцэд биш эхлээд Улсын дээд шүүхэд оруулдаг. Улсын дээд шүүх уг саналыг хэлэлцэж

² Б.Чимид. "Хууль дээдлэх ёсыг хангахад шударга шүүхийн үүрэг". Хууль дээдлэх ёс сэтгүүл. УБ., 2009 он. №3. 30 дахь тал.

³ Г.Совд. "Монгол Улсын Үндсэн хууль, хүний эрх". УБ., 1999 он. 203 дахь тал.

⁴ Ц.Сарантуяа. "Үндсэн хуулийн процессын эрх зүй" суурь ойлголт, тулгамдсан асуудал. УБ., 2005 он. 118 дахь тал.

⁵ Ю.Харбиш. "ХБНГУ-ын Үндсэн хуулийн шүүхээс хэм хэмжээний хяналтыг хэрэгжүүлэх нь". Монгол Улсын Үндсэн хуулийн цэц өгүүлэл, илтгэлийн эмхтгэл. УБ., 2009 он. 461 дахь тал.

⁶ Ж.Амарсанаа. "Хүний эрх. Олон улсын ба үндэсний эрх зүйн асуудал". УБ. 2000 он. 126 дахь тал.

үндэслэлтэй гэж үзвэл Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргана.

2. Улсын дээд шүүхийн хувьд тухайн маргааныг шийдвэрлэж буй шүүх бүрэлдэхүүн хэрэглэх гэж буй хууль Үндсэн хуульд нийцэхгүй гэж үзэн санал гаргах боловч Үндсэн хуулийн цэцэд шууд хандах боломж байхгүй байна (Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 3 дахь заалтаас харахад).

3. Улсын Дээд шүүх нийт гишүүдийн хуралдаанаар Үндсэн хуулийн цэцэд хандахдаа зайлшгүй өөрийн харьяалан шийдвэрлэх эрх зүйн тодорхой маргааныг үед хэрэглэх гэж буй хуулиар гэсэн хязгаарлалт байхгүй буюу эрх зүйн маргаанаас ангид байдлаар Цэцэд хандаж болно. Үүнээс үзвэл, манай улсад хэм хэмжээний тодорхой хяналт хэрэгждэггүй гэж үзэж болохоор байна.

ГУРАВ. ХЭМ ХЭМЖЭЭНИЙ ТОДОРХОЙ ХЯНАЛТЫН ПРАКТИК АЧ ХОЛБОГДОЛ

Хэм хэмжээний тодорхой хяналт шүүхийн практикт өндөр ач холбогдолтой. Учир нь энэхүү хяналтын гол агуулга нь иргэний болон хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, сахин биелүүлэх Үндсэн хуулийн зарчмыг нэвтрүүлэх, мөн шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлэхэд Үндсэн хуульд ёсыг бэхжүүлэх (хуулийг боловсронгуй болгоход П.Б), үүгээрээ шүүхийн ажиллагсааны бүх оролцогчдод нөлөөлдөг гэж үздэг байна.⁸

ХБНГУ-ын Үндсэн хуулийн шүүхийн статистик зааснаар хэм хэмжээний тодорхой хяналт нь Үндсэн хуулийн гомдлын дараагаар буюу хянан шийдвэрлэх бусад төрлийн ажиллагаанаас хол газартай байдалтай байна гэжээ. Энэ нь Герман дахь шүүх бүрт Холбооны Үндсэн хуулийн шүүхэд шууд хандах боломжтой байдагтай холбоотой байдаг болов уу.¹⁰ Онцолбол: 1980 оны статистик үзүүлэлтээс харахад тэр ондоо шүүгчдээс 80 удаа хандсан байхад 57 нь доод шатны шүүхээс

ханджээ.¹¹

Манай улсын хувьд шүүх тодорхой хэрэг маргааныг хянан шийдвэрлэхэд хэрэглэгдэх хууль нь Үндсэн хуультай нийцэхгүй байна гэж үзвэл энэ тухай саналаа эхлээд Улсын дээд шүүхэд шүүхийн хараат бус байдлад халдаж буй хэрэг юм. Монгол Улсын хөдөлмөрийн баатар, ардын багш, гавьяат хуульч, доктор, профессор Б.Чимид шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдах зарчмыг авч үзэхдээ "Улсын дээд шүүх, бусад шүүх нь Үндсэн хуульд нийцээгүй, албан ёсоор нийтлэгий хуулийг хэрэглэх эрхгүй" (Үндсэн хуулийн 50 дугаар зүйлийн 3) гэсэн үндэслэлийг багтаасан байна. Үүнээс үзвэл шүүгчийн хараат бус байх үзэл баримтлалын салшгүй нэг хэсэг нь шүүгч зөвхөн Үндсэн хуульд нийцсэн гэж үзсэн, хүчин төгөлдөр хуульд захирагдах явдал юм.

Шүүгч эрх зүйн тодорхой маргааныг үед хэрэглэгдэх хууль нь Үндсэн хуульд нийцээгүй хэмээн эргэлзэж байвал ийнхүү эргэлзээгээ арилгахын тулд Үндсэн хуулийн шүүхэд хандах (хэм хэмжээний тодорхой хяналтын хэбэр хэрэгжиж байгаа тохиолдолд) үүрэгтэй. Гэтэл манай улсад хэн нэгэн субъектын тухайн хэргийг эцэслэн шийдвэрлэх эрх бүхий шүүхэд хандан гаргасан хүсэлтийг түүнийг нь эцэслэн шийдвэрлэх бүрэн эрх нь байхгүй өөр нэгэн байгууллага нийцсэнгүй, үндэслэлгүй гэдгийг нь хянах нь ардчилсан эрх зүйт төрийн зарчимтай хэр нийцэх, УДШ саналыг үндэслэлгүй гэж үзвэл тухайн шүүгчийн эргэлзээ арилах, мөн УДШ хэрэглэх тухайн хууль нь Үндсэн хуульд нийцээгүй гэж үзэн ирсэн ямар саналыг үндэслэлтэй, ямар саналыг нь үндэслэлгүй (хэрвэ УДШ саналыг үндэслэлгүй гэж үзэн буцаавал тухайн саналыг оруулсан шүүх маргааныг үргэлжлүүлэн шийдвэрлэх дуусгаж байна. Энэ тохиолдолд шүүгч Үндсэн хуульд нийцээгүй гэж үзсэн хуулиа хэрэглэн тухайн маргаанаа шийдвэрлэх болж байна) гэж үзэх, ийнхүү үзэхдээ ямар хуулийг

хэмжүүр болгох зэрэг нь онолын болон практикын хувьд эргэлзээ төрүүлж байна. Ийм учраас, хэм хэмжээний тодорхой хяналт нь шүүгчийн хараат бус, бие даасан байдлын нэг баталгаа болж байдаг гэж үзэж болно.

Бүх шүүхэд Үндсэн хуулийн шүүхэд шууд хандах эрхийг олгосноор тэднийг ийнхүү хандах сонирхол, шаардлагыг ихэсгэж байгаа нь дээрх судалгаанаас харагдаж байна.

ДӨРӨВ. ХЭМ ХЭМЖЭЭНИЙ ТОДОРХОЙ ХЯНАЛТЫН ХЭЛБЭРИЙГ ХУУЛЬЧЛАХ ШААРДЛАГА

Илтгэгчийн зүгээс энэхүү судлааг хийх явцад хэм хэмжээний тодорхой хяналтыг Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар хуульчилж өгөх шаардлагайг байгаа нь дараах байдлуудаас харагдсан юм.

1) ҮХЦ үйл ажиллагаагаа явуулж эхэлснээс хойш энэ цаг үе хүртэл УДШ 2 удаа хүсэлт гаргасан байгаагийн нэг гол шалтгаан нь Шүүхийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан хэрэглэгдэх тухайн хууль нь Үндсэн хуульд нийцэхгүй байгаа талаараа УДШ-д санал оруулах хуулийн заалт хэрэгжижгүй байгаагийн илрэл гэж судлаачийн зүгээс үзэж байна.¹² Иймд бүх шүүхэд ҮХЦ-д шууд хандах боломжийг бий болгох хэрэгтэй.

2) Манай Улсад эрх зүйн бүх салбарт шинэчлэл хийгдэж энэ үед тодорхой хяналтын хэлбэрийг хуульчилбал шүүхээс Үндсэн хуулийн цэцэд хандах сонирхлыг нэмэгдүүлж улмаар хуулийг боловсронгуй болгох Үндсэн хуулийн үзэл баримтлалтай нийцүүлэх, Үндсэн хуулийн зарчмыг нэвтрүүлэхэд чухал ач холбогдолтой.

3) Засаг захиргааны хууль бус үйлдлээс иргэдийг хамгаалах үүрэгтэй захиргааны дагнасан шүүх байгуулагдаад удаагүй байгаа энэ үед тодорхой хяналтын хэлбэрийг

⁸ Ж.Амарсанаа. "Хүний эрх: олон улсын ба үндэсний эрх зүйн асуудал", УБ. 2000 он. 126 дахь тал (дам ишлэл).

¹⁰ Ю.Харбиш "ХБНГУ-ын Үндсэн хуулийн шүүхээс хэм хэмжээний хяналтыг хэрэгжүүлэх нь." Монгол Улсын Үндсэн хуулийн цэц өгүүлэл, илтгэлийн эмхтгэл УБ. 2009 он. 464 дэх тал

¹¹ Мөн тэнд

¹² Хэрвэ УДШ-д ийм санал орж ирсэн байвал түүнийг нийт шүүгчдийн хуралдаанаар авч үзэн тогтоол гаргадаг. Гэтэл нийт шүүгчдийн хуралдааны тогтоолтой танилцахад уг асуудлыг авч үзсэн практик байхгүй байгаа нь УДШ-д санал ирж байгаагүй гэсэн үг.

хуульчилбал хүний эрхийг хамгаалах чухал үчин зүйл болно гэж үзэж байна. Учир нь захиргааны хэргийн шүүхийн гол үүрэг нь захиргааны байгууллагын үйл ажиллагаа ялангуяа **үндсэн эрх хөндөгдөх** явц Үндсэн хуультай нийцэж байгаа эсэхийг хянахад оршино.¹³

4) Үндсэн хуулийн шүүхийн үйл ажиллагаа өнөө үед төрийн гурван эрх мэдлийг хянах, тэдгээр байгууллагын шийдвэр, үйл ажиллагаагаар үндсэн хуулинд заасан иргэн хүний зөрчигдсөн үндсэн эрхийг сэргээн тогтооход чиглэгдэж байна. Манай Улсын хувьд иргэн хүн Үндсэн хуулинд заасан үндсэн эрхээ зөрчигдөө хэмээн үзвэл хувийн гомдол гаргах замаар Үндсэн хуулийн шүүх (цэц)-ийн түвшинд зөрчигдсөн эрхээ сэргээлгэх боломж байдаггүй буюу одоогоор байхгүй энэ үед ердийн болон дагнасан шүүхийн оролцоог нэмэгдүүлэх үүднээс хэм хэмжээний тодорхой хяналтын хэлбэрийг хэрэгжүүлэх боломжийг бий болгох шаардлагатай байна.

5) Үндсэн хуулийн цэцийн практикаас харахад сүүлийн жилүүдэд иргэд ҮХЦ-д хандах нь эрс ихэссэн бөгөөд 2005 онд 81, 2006 онд 98, 2007 онд 143, 2008 оны 12 дугаар сарын байдлаар 147 өргөдөл, мэдээлэл гаргаад байна.¹⁴ Гэтэл Үндсэн хуулийн цэц 2005 онд 9, 2006 онд 11, 2007 онд 13, 2008 онд 10 **дүгнэлт** гаргасан байна. Өөрөөр хэлбэл, Үндсэн хуулийн цэцэд хандан иргэд өргөдөл, мэдээлэл гаргах нь ихэссэн байтал Цэц маргаан үүсгэж шийдвэрлэсэн байдал нь хэвэндээ буюу бүр буурсан байна. Өнгөрсөн хугацаанд **тооны өөрчлөлт гарсан болохоос биш чанарын өөрчлөлт** гараагүй байна. Энэ байдал нь Үндсэн хуулийн цэцэд хандаж буй этгээд тэр бүр хуульч мэргэжлийн хүмүүс байдаггүйтэй холбоотой. Мөн Үндсэн хуулийн цэцэд ихэвчлэн мэдээлэл гаргах замаар буюу маргаанаас ангид байдлаар хандадаг. Харин Үндсэн хуулийн шүүхэд эрх зүйн тодорхой маргааны үед, мэргэжлийн шүүх бүрэлдэхүүн хандсанаар тухайн хэм хэмжээ

Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг хянах боломжтой болгодог.

ТАВ. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Судалгааны үйл явцаас үзэхэд судалгааны үр дүнг дараах байдлаар тодорхойлж болохоор байна.

Манай улсын шүүхүүд аливаа хэрэг, маргааныг шийдвэрлэхдээ тухайн маргаанд хэрэглэгдэх хууль нь Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхэд хяналт тавихгүй байгаа нь тогтоогдлоо.

- Улсын дээд шүүхэд бусад шүүхээс тодорхой маргаанд хэрэглэх гэж буй хуулиа Үндсэн хуульд нийцэхгүй байгаа талаар санал ирээгүй байгаа нь манай шүүгч нарт аливаа эрх зүйн тодорхой маргааныг хянан шийдвэрлэхдээ хэрэглэгдэх хуулиа эхлээд Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг хянах эрх зүйн ухамсар төлөвшөөгүй байгаатай, нөгөө талаас Үндсэн хуулийн цэцэд шууд хандах боломж байдаггүйтэй холбоотой гэж үзэж байна;

- УДШ-ээс өнгөрсөн хугацаанд Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргасан байдал хангалтгүй байгаа нь Дээд шүүхэд тодорхой маргааныг хянан шийдвэрлэхдээ хэрэглэгдэх хууль нь Үндсэн хуульд нийцээгүй хэмээн үзсэн санал ирдэггүйтэй, нөгөө талаас дээд шүүх Үндсэн хуулийн цэцийн эрх хэмжээний аль нэг асуудлаар буюу өөрт хамааралгүй байхад маргаанаас ангид байдлаар хандах сонирхол байхгүй байгаатай холбоотой гэж үзэж байна;

- Шүүхүүдэд эрх зүйн тодорхой маргааны үед хэрэглэх гэж буй хуулиа Үндсэн хуульд нийцээгүй гэж үзвэл Үндсэн хуулийн шүүхэд ямар нэгэн шат дамжлагагүйгээр шууд хандах боломжтой байдаг нь гэдний ийнхүү хандах сонирхол, шаардлагыг ч ихэсгээдэг байдаг байна;

- Манай улсад шүүхээс эрх зүйн тодорхой маргааны үед хэрэглэгдэх хууль нь Үндсэн хуулийг зөрчсөн гэж үзэж байвал энэ тухай саналаа шууд ҮХЦ-д биш, эхлээд УДШ-д оруулж, түүнийг УДШ үндэслэлтэй, үндэслэлгүй гэдгийг хянахаар

хуулийн зохицуулалт байгаа нь шүүгчийн аливаа хэрэг, маргааныг хөндлөнгийн хэнээс ч хараат бус байдлаар хууль, эрх зүйг удирдлага болгон шийдвэрлэхдээ сөрөг нөлөө үзүүлж болзошгүй байна.

ДҮГНЭЛТ

Илтгэлийг бичих явцад хэм хэмжээний тодорхой хяналтыг хэрэгжүүлэх асуудлаар манай судлаачид тэр бүр ултай, нухацтай судлаагүй байгаа нь тодорхой болсон юм. Дэлхий нийтэд нэгэнт тогтсон түгээмэл хандлагыг өөрийн оронд нэвтрүүлэх нь манай улсад эрх зүйт ёс хөгжих, Үндсэн хуульд ёсны төлөвшилтөд чухал нөлөө үзүүлэх нь дамжиггүй.

Дээрх судалгаанаас үүдэн дараах саналыг судлаачийн зүгээс дэвшүүлж байна.

- Монгол Улсын шүүхээс маргаан шийдвэрлэж буй үйл ажиллагааг Үндсэн хуульд ёсны төлөвшилтөд бодитойгоор ашиглах. Ингэхдээ хэм хэмжээний тодорхой хяналтын хэлбэрийг хуульчлах замаар энэхүү боломжийг бий болгох;

- Шүүгч нарт эрх зүйн тодорхой маргааныг шийдвэрлэхдээ хэрэглэгдэх хууль нь Үндсэн хуульд нийцэж эсэхийг хянах эрх зүйн ухамсарыг төлөвшүүлэх. Ингэхдээ шүүхийн практикт тогтмол судалгаа явуулж, шүүгч нарт аливаа хэрэг маргааныг шийдвэрлэхдээ Үндсэн хуулийг дээдлэн анхаарч үзэх үзлийг төлөвшүүлэх. Үүний тулд тогтмол сургалт, семинар зохион байгуулах.

Төгсгөлд нь хэлэхэд хэм хэмжээний тодорхой хяналт нь ердийн болон дагнасан шүүхээс Үндсэн хуулийн шүүхэд хандах тохиолдолд хэрэгждэг. Ийм учраас энэхүү хяналт хэрэгжих нь шүүгч нарын эрх зүйн ухамсар, Үндсэн хуулийг дээдлэх үзлээс ихээхэн хамааралтай. Шүүгч ганцхан даргатай тэр нь хууль гэж нэгэн мэргэн үг байдаг. Тэгвэл орчин үеийн Үндсэн хуульд төрд хуулиуд ганцхан даргатай байх ёстой. Тэр нь Үндсэн хууль. Үүнийг шүүгч нар маань ямагт санаж байвал зохилтой.

¹³ Е.П. Мюлер "Үндсэн хуультай төрөөс хүний эрхийг хамгаалах тухай" Хүний эрх ба Үндэсний аюулгүй байдал ОУ-ын симпозиум УБ, 1996 он, 106 дахь тал.

¹⁴ Т.Мөнхсүлд, М.Мөнхжаргал. "Үндсэн хуулийн цэцийн шийдвэр жишиг болох нь" Хууль дээдлэх ёс сэтгүүл УБ, 2009 он №1(24), 27 дахь тал.

Иргэний хэрэг зүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль 2002 ондлагдан мөрдөгдөж 2007 оны 8-аар сарын 3-ны өдөр уг хуульон нэмэлт өөрчлөлт нь ИХШШЗ-ийн хуулийн ихэнх бүлэг, зүйлийгмаагч эрх зүйн харилцаанд шилцэгчдын эрх, эрх чөлөө, хууль эрх шалгийг хамгаалах, тэдний эрх зүйн байдлыг баталгаатай болгох, талуудын мэтгэлзэх эрхийг хянахад ач холбогдолтой болсон учир хуулийн зарим бүлэг, зүйлс проorroдоог логик уялдаа холбоотой, ИХШШЗ эрх зүйн тулгуур ба тухай зарчимууд бүрэн хэмжээгээр хамгааж чадаагүй, зарим зүйлийг хуульд өөрт нь тодруулан зааж өгөхгүйгээс хэрэгслэхэд хүндрэл учир хуулийн шийдвэр шийдвэрлөгчдөг, хүчингүй болоход өөрөөр буй тал байгаа учир хуулийг хуулид боловсронгуй болгох нь тухайн гэж үзэж байна. Үүнд:



МУИС-ийн Хууль зүйн
сургуулийн ахлах багш,
докторант Д.Хуяг

нь" гэдэг нэр томъёог бүрдүүлэгч
хоёр бүрэлдэхүүн хэсэг юм.
Шүүхийн шийдвэр хууль ёсны

байх гэдэг нь шийдвэр эрх зүйн үндэслэлтэй байх гэсэн шинжийг агуулна. (Схем-1)

Шүүхийн шийдвэр үндэслэл бүхий байх гэдэг нь шүүхийн шийдвэр хэргийн үйл баримтын (факт) талаас үндэслэлтэй байх гухай ойлголт юм. (Схем-2)

Ийнхүү схем-2-оос үзвэл хэргийг "бүхэлд нь" хянах гэдэг ойлголт нь шүүхийн шийдвэрт тавигдах шаардлагуудыг илэрхийлж, давж заалдах шатны шүүхээс иргэний хэргийг хянах хэмжээ хязгаарыг тогтоосон нийлмэл ойлголт байх учир энэ ойлголтыг шүүхийн шийдвэр ба хэргийг давж заалдах шатаар хянах ажиллагааны бүлэгт тусгаж өгөх нь зүйтэй гэж үзэнэ.

1. ИХШХШ тухай хуулийн 116 дугаар зүйлийг дараах байдлаар өөрчлөн найруулах


116.3.Шүүхийн шийдвэр хууль ёсны байх гэдэгт :

116.3.1. Шүүх хэрэглэвэл зохих хуулийг хэрэглэсэн байх;

НЭГ. ИХШХШ тухай хуулийн 166 дугаар зүйлийн 4-т "Давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэж буй шүүх зөвхөн гомдолд дурдсан үндэслэлээр хязгаралгүйг хэргийг бүхэлд нь хянан" тухай заалтыг тодруулах нь зүйтэй байна. Дээрх "хэргийг бүхэлд нь хянан" тухай ойлголт ба дараах хоёр бүрэлдэхүүн хэсэгтэй байх тухай судлаач, эрдэмтэд зохиол бүтээлдээ авч үзсэн байна.

Тухайлбал: ИХШХШ тухай хуулийн 116 дугаар зүйлийн 2-г заасан "шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байна" гэж заасан ба энэ нь "бүхэлд

(Схем-1)




¹ Судебное решение М.Г.Авдюков М.1959

Гражданский процесс. Под ред. В.А.Мусина и др. М.2001 с.403-406

Гражданский процесс Под ред. М.К.Треушников. М 2008 гл.29. В.М.Шерстюк.с 541-544

Апелляция в гражданском / арбитражном/ процессе Е А Борисова. М.2000 с 153-163

(Схем-2)



116.3.2. Шүүх хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглээгүй байх;

116.3.3. Шүүх хуулийг буруу тайлбарлаж хэрэглээгүй байх;

116.3.4. Шүүх төсөөтэй харилцааг зохицуулсан хуулийг зөв хэрэглэсэн байх;

116.3.5. Шүүх хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зөрчөөгүй байх;

116.4. Шүүхийн шийдвэр үндэслэл бүхий байх гэдэгт:

116.4.1. Хавтаст хэрэгт цугларсан нотлох баримт нь агуулгын ба хэлбэрийн хувьд хуулийн шаардлага хангасан байх;

116.4.2. Шүүхээс хэрэгт хууль зүйн ач холбогдол бүхий нөхцөл байдлыг зөв тогтоосон байх;

116.4.3. Шүүх хэрэгт хууль зүйн ач холбогдол бүхий нөхцөл байдлыг тогтоогдсон гэж үзэж байгаа бол уг нөхцөл байдал хавтаст хэрэгт цугларсан нотлох баримтаар тогтоогдсон байх;

116.4.4. Шүүхийн шийдвэрт хэргийн талаар хийсэн дүгнэлт нь хэргийн жинхэнэ (бодит) нөхцөл байдалтай тохирч байх;

116.4.5. Хавтаст хэрэгт онцгой ач холбогдол бүхий нотлох баримт харилцан зөрүүтэй байхад шүүх

шийдвэрлэх хэмжээ, хязгаар

165¹. 1. Давж заалдах шатны шүүх хэргийг хэлэлцэхдээ шүүхийн шийдвэр хууль ёсны ба үндэслэлтэй болсон эсэхийг хэрэгт байгаа материалыг үндэслэн хянана;

165¹. 2. Давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэж буй шүүх зөвхөн гомдолд дурдсан үндэслэлээр хязгаарлахгүй хэргийг бүхэлд нь хянана.

3. ИХШХШ тухай хуулийн 168 дугаар зүйлийг дараах байдлаар өөрчлөн найруулах.

168 дугаар зүйл. Анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох:

168.1. Давж заалдах журмаар хэрэг хянан хэлэлцсэн шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг дараах үндэслэлээр хүчингүй болгоно.

168.1.1. Анхан шатны шүүхийн шийдвэр үйл баримтын (факт) талаас үндэслэлтэй болоогүй;

168.1.2. Материаллаг эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн буюу эсвэл буруу хэрэглэсэн;

168.1.3. ИХШХШ тухай хуулийг ноцтой зөрчсөн.

4. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд 168¹ дугаар зүйл гэсэн шинэ зүйлийг нэмэх.

алийг нь үнэн зөв гэж үзэж шүүхийн шийдвэрийн үндэслэл болгосон, бусдыг нь үгүйсгэсэн тухай үндэслэлийг шийдвэрт заасан байх.

2. ИХШХШ тухай хуульд дор дурдсан агуулгатай 165¹ дугаар зүйл гэсэн шинэ зүйл нэмэх.

165¹ дугаар зүйл. Давж заалдах шатны шүүхэд хэргийг хянаан

168¹ дугаар зүйл. Анхан шатны шүүхийн шийдвэр хэргийн үйл баримтын талаас үндэслэлтэй болоогүй.

168¹. 1. Дор дурдсан нөхцөл байдлын аль нэг нь байвал анхан шатны шүүхийн шийдвэр хэргийн үйл баримтын талаас үндэслэлтэй болоогүй гэж үзнэ.

168¹. 1.1. Анхан шатны шүүхээс хэрэгт хууль зүйн ач холбогдол бүхий нөхцөл байдлыг буруу тогтоосон;

168¹. 1.2. Анхан шатны шүүх хэрэгт хууль зүйн ач холбогдол бүхий нөхцөл байдлыг тогтоогдсон гэж үзэж байгаа боловч уг нөхцөл байдал хавтаст хэрэгт цугларсан нотлох баримтаар тогтоогдоогүй байгаа;

168¹. 1.3. Анхан шатны шүүхийн шийдвэрт хэргийн талаар хийсэн дүгнэлт нь хэргийн жинхэнэ (бодит) нөхцөл байдалтай тохирохгүй байгаа;

168¹. 1.4. Хавтаст хэрэгт онцгой ач холбогдол бүхий нотлох баримт харилцан зөрүүтэй байхад анхан шатны шүүх алийг нь үнэн зөв гэж үзэж шүүхийн шийдвэрийн үндэслэл болгосон, бусдыг нь үгүйсгэсэн тухай үндэслэлийг шийдвэрт заагаагүй.

5. ИХШХШ тухай хуульд 168² дугаар зүйл гэсэн шинэ зүйлийг нэмэх.

168² дугаар зүйл. Материаллаг эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн буюу эсвэл буруу хэрэглэсэн.

168². 1. Материаллаг эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн буюу эсвэл буруу хэрэглэсэн гэдэгт:

168². 1.1. Шүүх хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй;

168². 1.2. Шүүх хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн;

168². 1.3. Шүүх хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн;

168². 1.4. Шүүх төсөөтэй харилцааг зохицуулсан хуулийг буруу хэрэглэсэн.

6. ИХШХШ тухай хуульд 168³ дугаар зүйл гэсэн шинэ зүйлийг нэмэх.

168³.1 дугаар зүйл. Шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтойгоор зөрчих;

168³.1. Хэрэг хэлэлцэхэд оролцогчийн хуулиар хамгаалагдсан эрхийг хаах буюу хязгаарлах замаар эсхүл, бусад хэлбэрээр шүүхээс хэргийг бүх талаар хэлэлцэх явдалд саад болж, хууль ёсны ба үндэслэл бүхий шийдвэр гаргахад сөргөөр нөлөөлсөн буюу нөлөөлж болохуйцаар энэ хуулийн шаардлагыг зөрчсөн бол Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтойгоор зөрчсөн гэж үзнэ.

Дор дурдсан тохиолдолд шийдвэрийг заавал хүчингүй болгоно:

168³.1.1. Зохигч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгчийн шүүх хуралдаанд биечлэн оролцох эрхийг хангалгүй хэргийг хянан шийдвэрлэсэн;

168³.1.2. Хэргийн болон шүүх хуралдаанд оролцогчийн хуулиар олгогдсон эрх ноцтой зөрчигдсөн;

168³.1.3. Хууль бус бүрэлдэхүүнээр хэргийг хянан шийдвэрлэсэн;

168³.1.4. Шүүхийн шийдвэрт шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч гарын үсэг зураагүй, эсхүл шүүх бүрэлдэхүүнд ороогүй шүүгч гарын үсэг зурсан;

168³.1.5. Хуурамч нотлох баримтын үндсэн дээр хэргийг хянан шийдвэрлэсэн нь давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэхэд илэрсэн;

168³.1.6. Энэ хуулийн 38.6-д заасан тохиолдолд нотлох баримтыг шүүх дутуу бүрдүүлж хэргийг хянан шийдвэрлэсэн;

168³.1.7. Хэрэгт шүүх хуралдааны тэмдэглэл байхгүй;

168³.1.8. Шүүгч шийдвэрээ зөвлөлдөх тасалгаанд гаргахдаа шүүгчийн саналыг нууцаар гаргах тухай журмыг зөрчсөн.

ХОЁР. Давж заалдах шатаар шүүхийн шийдвэрийг "бүхэлд нь" хянаха гэдэг нь уг шатаар хэргийг хянаж байгаа шүүх зөвхөн гомдол дурдсан үндэслэлээр хязгаарлалгүй хэргийг бүхэлд нь хянах, тухайлбал, гомдлын хүрэнзээс хэтэрч хэргийг хянах, гомдол гаргаагүй хэргийн оролцогчийн хувьд хэргийг хянах, шүүх гомдол, тайлбарт дурдсан үндэслэлээс өөр үндэслэлээр хэргийг хянах гэсэн ойлголтыг агуулна. Гэвч хэргийг хянах тухай энэ үзэл баримтлал нь ИХШХШ эрх зүйн мэтгэлзэх ба диспозитив зарчим ба шүүгч хэрэг маргаанд төвч, хөндлөнгийн байр сууринаас хандах явдалтай зөрчилдөж байгааг цаашид анхааран үзэх нь зүйтэй.

ГУРАВ. ИХШХШ тухай хуульд дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулах нь зүйтэй гэж үзнэ. Үүнд:

1. ИХШХШ тухай хуулийн 25.1.2-т хэргийн материалыг хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тухай захирамж гарсаны дараа зохигчид танилцуулахаар заасан байгааг өөрчилж хариуцагчид нэхэмжлэлийн хувийг гардуулан өгмөгц хэргийн материалыг танилцуулах тухай заах;

2. Давж заалдах гомдлыг гомдол гаргаагүй хэргийн оролцогчдын тоогоор хувилж шүүхэд өгөх;

3. Давж заалдах гомдол хуулийн шаардлага хангаагүй бол шүүх гомдлыг хянан үзэхгүй орхиж, хуулийн шаардлага хангах хугацааг давж заалдах гомдол гаргах хугацааны дотор зааж өгөх;

4. Мөн хуулийн 170 дугаар зүйлийг одоогийн байгаа давж заалдах шатаар хэрэг хянах ажиллагааны 15 дугаар бүлгээс авч шийдвэр, түүний гаргах гэсэн 11 дүгээр бүлэгт оруулах;

5. Анхан шатны шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, шийтгээрт гомдол гарсан тохиолдолд уг

гомдлыг бусад оролцогчдод танилцуулах, гомдлыг хэлэлцэх шүүх хуралдааны талаар хэргийн оролцогчдод мэдэгдэх талаар тусгах;

6. Хэргийн оролцогчид Дээд шүүхийн Ерөнхий шүүгчид хэргийн талаар гомдол гаргасан тохиолдолд Улсын тэмдэгтийн хураамж төлөх тухай заалт нэмэх.

7. Мөн хуулийн 176 дүгээр зүйлийн 1-д заасан "хууль зөрчсөн" үндэслэл гэдэгт юу хамаарахыг тодруулан заах.

Шүүхийн шийдвэр дээр дурдсан хууль ёсны ба үндэслэлтэй байх шаардлагуудыг хангаагүй тохиолдолд давж заалдах ба хяналтын шатны шүүхээс шийдвэр, магадлал, шүүхийн тогтоол өөрчлөгдөх, хүчингүй болох нөхцөл болох ба давж заалдах шатаар 2003-2009 онд (7 жилд) хянасан хэргийн судалгаанаас үзэхэд хянасан хэрэг буюу шийдвэрийн 43% нь хэвээр үлдэж, 28% нь өөрчлөгдөж, 29% нь хүчингүй болжээ. (Өөрчлөгдөж, хүчингүй болсон хэрэг 57%). Дээд шүүхийн хяналтын шатаар 2003-2009 онд долоон жилд хянасан хэргийн судалгаанаас үзэхэд нийт хянагдсан хэргийн 47.9% нь хэвээр үлдэж, 28.5% нь өөрчлөгдөж, 23.4% нь хүчингүй болж (өөрчлөгдөж, хүчингүй болсон хэрэг 51.9%) байгаа нь шүүхийн шийдвэр хууль ёсны ба үндэслэлтэй байх хуулийн заалт нь бүрхэг, тодорхой бус байгаатай зарим талаар холбоотой гэж үзнэ.

Давж заалдах шатны шүүхээр 2003-2009 онд хянасан хэргийн судалгаа (Хавсралт-1)

Монгол Улсын Дээд шүүх хяналтын шатаар 2003-2009 онд хянасан хэргийн судалгаа (Хавсралт-2)



(Хавсралт-1)

Он	Нийт шийдсэн хэргийн тоо	Давж заалдсан хэргийн		Хэвээр үлдэсэн хэргийн		Өөрчлөлт оруулсан хэргийн		Хүчингүй болсон хэргийн	
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
2003	23407	1539	6.5%	732	47.6%	400	26%	407	26.4%
2004	23290	1324	5.7%	562	47.6%	315	23.8%	447	33.8%
2005	24492	1299	5.3%	562	43.0%	331	25.4%	406	31.2%
2006	27469	1364	4.9%	573	42.0%	368	27.0%	423	31.0%
2007	30699	1350	4.3%	446	33.0%	406	30.1%	498	36.9%
2008	28480	1518	5.3%	600	40.0%	515	34.0%	401	26.0%
2009	35822	2006	5.5%	965	48.1%	597	29.8%	444	22.1%
Дундаж хувь			5.3%		43.0%		28.0%		29.0%

(Хавсралт-2)

он	Нийт шийдсэн хэргийн тоо	Бүгд Хянагдсан хэрэг		Хянаад хүргүүлсэн хэрэг		Хурлаар хэлэлцсэн хэрэг		Үүнээс								Үлдэгдэл
		тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	Хэвээр үлдсэн		Өөрчилсөн		Хүчингүй болсон				
2003	23407	1152	4.9	343	29.7	809	70.2	364	44.9	225	27.8	220	27.1	36		
2004	23290	915	3.9	238	26.0	677	73.9	321	47.4	204	30.1	152	22.4	38		
2005	24492	842	3.4	207	24.5	635	75.4	271	42.6	183	28.8	181	28.5	33		
2006	27469	1079	3.9	251	23.2	781	72.3	326	41.7	183	23.4	272	34.8	47		
2007	30699	931	3.0	228	24.4	675	72.5	285	42.2	244	36.1	146	21.6	28		
2008	28480	809	2.8	171	21.1	620	76.6	362	58.3	164	26.4	94	15.1	18		
2009	35822	1060	2.9	192	18.1	803	75.7	467	58.2	221	27.5	115	14.3	65		
%			3.5		23.8		73.8		47.9		28.5		23.4			



Монгол Улсын Прокурорын байгууллагын 80 жилийн ойд*

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ПРОКУРОРЫН ГАЗРЫН ТҮҮХЭН ТОВЧООН

БНМАУ-ын VI Их Хурлын шийдвэрийг үндэслэн Улсын ерөнхий прокурорын газрыг Шүүх явдлын яаманд харъяалуулан байгуулж, дагаж мөрдөх эрх үүргийн дүрмийг Улсын Бага Хурлын тэргүүлэгчдийн 1930 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 25 дугаар тогтоолоор баталж Прокурорын байгууллага улсын нэрийн өмнөөс хяналт тавих үүрэг хүлээснээр Прокурорын байгууллага анх байгуулагдсан түүхтэй билээ.

1992 оны шинэ Үндсэн хуулиар Монгол Улсын прокурорын байгууллага нь "Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх үйл ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох" үндсэн чиг үүрэг хүлээсэн юм.

Ийнхүү Үндсэн хуулиар олгосон чиг үүргийн дагуу прокурорын байгууллагын бүтэц зохион байгуулалтад өөрчлөлт хийж тус дүүргийн прокурорын газар нь Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дагуу Сонгинохайрхан дүүрэг байгуулагдах үед зохион байгуулалтын өөрчлөлтөөр Октябры дүүргийн (хуучнаар) Прокурорын газраас өрх тусгаарлан Монгол Улсын Их Хурлын 1993 оны 15/59 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын 1993 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн тушаалаар "Сонгинохайрхан-Жаргалант" дүүргийн Прокурорын газар нэртэйгээр байгуулагдаж, ахлах прокурор 1, хяналтын прокурор 8, үйлчилгээний ажилтан 4 бүгд 13 орон тоотой ажиллаж эхэлсэн. Дүүргийн прокурор анх байгуулагдахад ахлах прокуророор

Ж.Ганхуяг, хяналтын прокуророор Ц.Бурмаа, Л.Долгор, С.Нансалмаа, Гийзэв нар ажиллаж байлаа. Үүнээс хойш тус дүүргийн прокурорын газарт, дүүргийн прокурор 5, хяналтын прокурор 85, үйлчилгээний ажилтан ажиллагсад 44 хүн, нийт 134 хүн анх үүсгэн байгуулагдахаас эхлээд ээлж дараалан өдийг хүртэл гар, сэтгэл нийлэн амжилт бүтээл дүүрэн ажиллаж үүнээс 16 прокурор Улс, нийслэлийн прокурорын газарт дэвшиж, 7 прокурор гавъяаныхаа амралтыг эдэлж, 11 прокурор өөр бусад аймаг, дүүргийн прокурорын газарт шилжин ажиллаж байгаа бөгөөд ажиллаж байсан үе үеийн прокурор, ажилтнуудыг дурсан санахад таатай байна.

Одоо Сонгинохайрхан дүүрэг нь 120 га газартай, 232,3 хүн амтай, 25 хороотой Нийслэлийн хамгийн том дүүргийн нэг болсон бөгөөд тус дүүргийн прокурорын газарт дүүргийн прокуророор Т.Баярсайхан, дүүргийн прокурорын орлогчоор Б.Мөнхбаяр, Дүүргийн прокурорын туслахаар Ш.Одонсүрэн, Мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих ажил хариуцсан хяналтын прокуророор Д.Туяа, С.Энхбат, Г.Магнайжав, С.Батсүрэн, Д.Мөнгөнцэцэг, Н.Алтантүлхүүр, Б.Уранчимэг, Ж.Айжуу, Б.Наранграв, Ц.Дэлгэрням, Б.Батжаргал,



Н.Эрдэмбилэгт нар, Хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих ажил хариуцсан хяналтын прокуророор Ц.Оюунэрдэнэ, О.Пүрэвсүрэн, Д.Туяана, Г.Ганчимэг нар, Шүүхэд төрийг төлөөлөх ажил хариуцсан хяналтын прокуророор Б.Отгончимэг, Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих ажил хариуцсан хяналтын прокуророор Т.Жаргалсайхан, Прокурорын туслах ажилтан Б.Ганбат, Б.Бямбадагва, нарийн бичгийн дарга Д.Мөнхтоогоо, ня-бо Ч.Мядагмаа нар болон үйлчилгээний 9 ажилтан нийт 32 орон тоотой болон өргөжин ажиллаж байна.

Манай прокурорууд бүгд дээд мэргэжлийн хуульчид бөгөөд мэргэжлээрээ 2-25 жил ажилласан хууль цаазын зөвлөхөөс хууль цаазын итгэмжит зөвлөх хүртэл зэрэг дэвтэй туршлага хуримтлуулсан хамт олон юм. Манай хамт олон дотроос ажиллаж байсан болон одоо ажиллаж байгаа ажиллагсдаас ажил бүтээлээр амжилт гарган системийн болоод төрийн дээд одон, медалиар шагнагдсан

гавьяатнууд олон бий. Үүнийг дурьдеал, Алтан гадас одонгоор дүүргийн прокурор Т.Баярсайхан, Г.Бадамханд, ахмад прокурор Ц.Дамдин, Л.Долгор, Н.Батначин, Ч.Баасанжав нар, Прокурорын тэргүүний ажилтнаар хяналтын прокурор Б.Отгончимэг нарын хүмүүс, мөн прокурорын хүндэт ажилтнаар бичээч Н.Сарантуяа, Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойн одон, медалиар хяналтын прокурор Д.Мөнгөнцэцэг, О.Пүрэвсүрэн, бичээч Н.Сарантуяа гэх мэт ажил үйлсээрээ манлайлагчид бий.

Манай хамт олон 2009 онд

Байцаан шийтгэх ажиллагаанд 2008 онд 263 удаа оролцсон нь хангалтгүй гэж дүгнэн, тодорхой ажил зохион ажилласнаар 2009 онд байцаан шийтгэх ажиллагаанд 333 удаа оролцож 22%-иар өссөн, ялангуяа хэргийн газраас бусад ажиллагаанд оролцсон тоо 53 буюу 50%-иар өссөн.

Мөн мөрдөнгийн хэргийн хугацаа сунгалт 2008 онд жилийн эцсийн мэдээгээр 118 хэрэг гэж гарсан бол одоо үлдэгдэл хугацаа сунгасан хэрэг 33 байна. Хэрэг бүртгэлтийн чиглэлээр 2008 онд 134 хэрэгт буюу

нийт хэргийн 14.2%-д хугацаа сунгаж байсан бол 2009 онд 93 хэрэгт, 10.7%-д нь хугацаа сунгаж 3.5%-иар буурсан.

Түдгэлзүүлсэн хэрэг тус дүүрэгт харьцангуй их байгаад дүгнэлт хийн мөрдөнгийн чиглэлээр жилийн төлөвлөгөөнд уялдаа бүхий 4 асуудал төлөвлөн, Цагдаагийн хэлтэстэй хамтарсан "аян" зохиож, мөн Улс, нийслэлийн прокурорын газрын "аян"-ны хүрээнд санаачлага гарган ажилласнаар түдгэлзүүлсэн хэргээс нийт 894 хэрэг сэргээн шийдвэрлэсэн. Хэрэг бүртгэлтийн хяналтаар өмнөх онд 52 хэрэг байсан бол энэ онд 38 болж 19.8%-иар буурсан.

2008 онд эсэргүүцлийн биелэлт 70% -тай байсан бол 2009 онд 84.6%-тай болж өссөн гэсэн дүнтэй гарлаа. Түүнлэн 72 хэрэг шүүхээс буцаж, 28 нь прокурорын алдаанд тооцогдсон бол энэ онд 47 хэрэг буцаж, 23 хэрэг алдаанд тооцсон байна.

Байгууллагын техник, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх, сайжруулах үүднээс гадны байгууллагын хандив туслалцааг ашиглан сейф, ширээ, сандал, зурagt зэргийг шинээр авч, иж бүрэн тохижуулан, гаднаа склад бариад

байна.

Түүнчлэн Сонгино-хайрхан, Хан-уул дүүргийн Засаг Даргын Тамгын газарт прокурор, ажилтны зуслангийн газрын талаар санал тавьж, Дүүргийн эрүүл мэндийн нэгдэлтэй гэрээ хийн, жилд 2 удаа үзлэгт хамруулж, жил бүр 1 сургуультай гэрээ байгуулан заал авч, 7 хоногт 1 удаа тоглож хэвшээд байна.

Дүүргийн прокурорын дэргэд 5 хүний бүрэлдэхүүнтэй зөвлөл ажиллаж дүүргийн прокурорын жил, улирлын ажлыг төлөвлөх, хяналтын ажлын үр дүнгийн талаар, прокуроруудын ажлын хариуцлага, шалгалтын дүн зэрэг шаардлагатай бусад асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж ажиллаж байна.

2009 онд Прокурорын байгууллагуудын дунд зохион байгуулагдсан спортын уралдаан тэмцээнд хамт олноороо 2 дугаар байр эзлэж шалгарсан.

Тус прокурорын байгууллагын хамт олны ажил сүүлийн жилүүдэд улам тогтмолжин, ажилд чанарын ахиц гарч байгаа бөгөөд амжилт бүтээл арвин дүүрэн прокурорын байгууллагын түүхт 80 жилийн ойг угтаж байна.



Эрхэм хүндэт уншигчид аа!

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн сонин,
СЭТГҮҮЛЭЭ ЗАХИАЛАН УНШИНА УУ.

№	Нэр	Тоо		Үнэ	Шуудангийн нэр, захиалгын индекс		
		Сард	Улиралд		Монгол шуудан	Улаан-баатар	Скай
1.	"Хууль дээдлэх ёс" сэтгүүл	-	1	2500	14278	2001086	14278
2.	"Хууль зүйн мэдээлэл" сэтгүүл	2	6	1000	14286	20011088	14286
3.	"Хууль зүйн мэдээ" сонин	2	6	500	11187	1022001	11187

ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙ ДЭХ ЭД ХӨРӨНГИЙН ХЯЗГААРЛАГДМАЛ ЭРХ ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН ЗРХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ

Иргэний эрх зүй дэх эд юмсын ойлголт, зохицуулалт нь хэдийгээр эртний институт болох боловч хууль зүйн хувьд онолын болоод практик талаасаа маргаантай асуудлын нэг байсаар байгааг Иргэний эрх зүй судлаачид хүлээн зөвшөөрдөг билээ. Иргэний эрх зүй дэх эд юмсын эрх зүйн ойлголт нь Эртний Ромын эрх зүйгээс үүсэлтэй¹ гэж үздэг.

Эд юмсын эрх зүйн зохицуулалт нь өөрийн гэсэн онцлогийг илэрхийлж байдаг. Энэ нь түүний зохицуулалтын хүрээгээр тодорхойлогдоно. Зах зээлийн шинэ нөхцөлд хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчлөгчид олноороо бий болж тэдгээрийн өмчийн эрхийг эрх зүйн бүхий л салбарын хууль тогтоомжоор хамгаалан бэхжүүлсээр байгаа билээ.²

Өнөө үед зах зээлийн эдийн засгийн харилцааг зохицуулж буй аливаа эрх зүйн зохицуулалт нь өргөн хүрээг хамрах болж дан ганц нэг эрх зүйн салбарт бус олон салбар эрх зүйг агуулсан өргөн ойлголтыг бүрдүүлж байгаа юм. Энэ нь ч материаллаг болон процессын эрх зүйн ойлголтыг өөртөө агуулж байна.

Ялангуяа үл хөдлөх хөрөнгийн эрх зүйн зохицуулалт нь иргэний эрх зүйн хөдлөх хөрөнгийн зохицуулалтаас өөрийн онцлог шинжээрээ ялгагдаж байдагтай шууд холбоотой. Тухайлбал: уг харилцаанд Иргэний хуулийг удирдлага болгон хэрэглэхээс гадна:

- Газрын харилцааны зохицуулалт;



*ОТПС-ийн Хууль зүйн сургуулийн
Иргэн, бизнесийн эрх зүйн
тэнхизийн багш Г.Жаргал*

- Үл хөдлөх хөрөнгө, бүртгэлийн зохицуулалт;
- Нотариатын чиг үүрэг зэргийг тусгайлсан хуулиудаар зохицуулж байна.

Уг сэдвийн хүрээнд иргэний эрх зүй судлаачид өөрийн бүтээл, нийтлэлдээ онолын болоод практикт хэрэгжүүлэх, боловсронгуй болгох саналуудыг гаргаж ирсэн. Миний бие уг үндсэн сэдвийн хүрээнд "Иргэний эрх зүй дэх эд хөрөнгийн хязгаарлагдмал эрхийн зарим асуудал"-ыг ялангуяа бусдын газар дээр барилга байгууламж барих эрхийн зохицуулалтыг онолын талаас нь хөндөхийг үнчээж, боловсронгуй болгох зарим саналыг өөрийн зүгээс дэвшүүлэх зорилт тавьсан болно.

Иргэний эрх зүйн эд юмсын эрх зүйл:

1. Эд юмсын бүрэн эрх;

2. Эд юмсын хязгаарлагдмал эрх гэсэн ойлголтууд байдаг. Иргэний эрх зүй дэх эд юмсын бүрэн эрх гэдэг нь өмчлөх эрх юм.

Өмчлөгч нь өөрийн өмчлөлийн зүйлийг зарчмын хувьд бүрэн эрхтэйгээр ямар нэгэн хязгаарлалтгүйгээр хэрэгжүүлж болдог бөгөөд үүнийг эд юмсын бүрэн эрх хэмээн тодорхойлдог. Гэтэл үүнээс гадна эд юмсын хязгаарлагдмал эрх гэж байдаг. Энэхүү хязгаарлагдмал эрхийн хуульзүйн үндэслэлийг Монгол Улсын Иргэний хуулийн 87 дугаар зүйлд "Өөр эрхтэй салшгүй холбоотой, түүнгүйгээр бие даан хэрэгжиж үл чадах эрхийг салгаж үл болох эрх гэнэ. Илүү өргөн хүрээтэй эрхээс уламжлагдсан тухайн эрхээр хязгаарлагдсан эрхийг хязгаарлагдмал эрх гэнэ" гэж заасан.

Эд юмсын эрх зүй дэх хязгаарлагдмал эрх нь өмчлөгч өмчлөлийн бүрэн эрхийн тодорхой хэсгийг өөр этгээдэд шилжүүлж байгаа нь уг эрхийн онцлог юм. Эд юмсын эрх зүй дэх хязгаарлагдмал эрхийн талаар зарим эрдэмтэн судлаач дараах байдлаар тодорхойлжээ.

Иргэний эрх зүй дэх эд юмсын хязгаарлагдмал эрх нь хэдийгээр өмчлөгч этгээд нь өмчлөлийн зүйлийн хувьд бүрэн эрхтэй байдаг боловч энэ эрхээ хязгаарлагдмал хүрээнд хэрэгжүүлэх явдал юм.³

"Иргэний эрх зүй дэх эд юмсын хязгаарлагдмал эрхийн гол онцлог нь тодорхой хүрээ, хязгаарын дотор өмчлөлийг зүйлийг эзэмших, ашиглах явдалаар тодорхойлогдоно" гэжээ.⁴ Эд юмсын хязгаарлагдмал

¹ А.Г.Резе. "К вопросу об определении принципов вещного права" //Актуальные проблемы гражданского права// год ред О.У. Шилохова. М.2005, с.248

² Хууль зүйн үндэсний төв, Дэлхийн банкны "Шүүх эрх зүйн шинэчлэлт" төсөл, "Монгол Улс дахь эрх зүйн шинэчлэл ба харьцуулсан судаллын хөгжил", УБ., 2004 он, 129 дэх тал

³ Capelle K. H. Bürgerliches Recht. Sachenrecht. Wiesbaden. 1999, S-15.

⁴ Скловский К.И. "Собственность в гражданском праве" Учеб-практ. пособие. М.1999, стр.175.

"Хрунь доводух ёс", 2010 он, №1

хуулийн 150.1 дүгээр зүйлд "Бусдын өмчийн газар дээр барилга байгууламж барих эрх олж авсан этгээд уг эрхээ гуравдагч этгээдэд өвлүүлэх, барьцаалах, худалдах болон бусад хэлбэрээр захиран зарцуулах эрхтэйгээр тухайн газрыг өөрийн эзэмшилд шилжүүлэн авна" гэж заасан байдаг. Дээрх хуулийн зохицуулалтаас авч үзвэл барилга байгууламж барих эрх нь нэг этгээдээс нөгөө этгээдийн эзэмшилд шилжүүлж болохоор тусгагджээ. Гэтэл хуулийн бусад хэлбэрээр гэдэгт түрээслэх эрх байж болох уу гэдгийг тодруулах нь зүйтэй болов уу.

2. Монгол Улсын Иргэний хуулийн 150.5 дугаар зүйлд "Барилга байгууламж барих эрхийн үндсэн дээр баригдсан барилга, байгууламж нь тухайн эрхийн гол бүрэлдэхүүн хэсэг байх бөгөөд ..." гэж заасан. Дээрх байдлаар тусгагдсаныг үзвэл дан ганц дууссан барилга байгууламжийн хувьд бус мөн дуусаагүй барилга байгууламжийн эрхийг ч мөн агуулж байгаа юм. Тэгэхлээр дуусаагүй барилга байгууламжийн хувьд Иргэний хуулийн 150 дугаар зүйлд заасан зохицуулалтууд бүгд нэгэн адил хамаарагдах уу? гэсэн асуулт гарч ирж байна. Энэ талаар Монголын зарим хуульч, судлаач нийтлэлдээ дурдсан байдаг. Харин уг асуудлын талаар Оросын эрдэмтэн, хуульч, судлаач "Дуусаагүй барилга байгууламжийг үл хөдлөх хөрөнгө гэж үзэн бүртгэж байгаа тохиолдолд дараах асуудалд анхаарлаа хандуулах нь зүйтэй" гэж бичсэн байсан. Тухайлбал:

• Дуусаагүй барилга байгууламж гэж юу ойлгох вэ?;

• Ямар цаг үед барилгын материал зохион бүтээлт нь үл хөдлөх хөрөнгийн объект болж байгааг тогтоох;

• Улсын бүртгэлд орсон үеэс эсвэл ашиглалтанд хүлээж авсан гарын үсэг зурсанаар уг барилгын объектыг хэзээ дууссаныг тооцон тогтоох;

• Баригдаж байгаа объектын зураг, төслийн бичиг баримттай нийцэж байгааг тогтоох;

• Хэрвээ барилга байгууламж барих эрхийг хэд хэдэн этгээд эзэмшиж байгаа бол энэхүү эрхийг хэний хэний нэрдээр бүртгэх вэ зэрэг асуудлыг тогтоосон байх ёстой гэжээ.

3. Барилга байгууламж барих эрх бүхий этгээд нь яах аргагүй "хөршийн эрхийн нөлөөлөл"-ийг харгалзан үзэх шаардлагатай юм. Иймээс уг эрхийг олж авсан этгээд нь Иргэний хуульд тусгагдсан "хөршийн эрх" -ийн зохицуулалтыг ч мөн зөрчихгүй байх ёстой юм. Иймээс эд юмсын хязгаарлагдмал эрхийн зохицуулалтанд Иргэний хуулинд тусгагдсан "Хөршийн эрхийн зохицуулалт удирдлага болгоно" гэж нэмж оруулах нь зүйтэй болов уу.

4. Бусдын газар дээр барилга байгууламж барих эрх бүхий этгээд болон газар өмчлөгч этгээдийн хооронд байгуулагдах гэрээний нөхцөл чухал юм. Тиймээс гэрээнд тусгагдал зохих гол нөхцөлүүдийг тодорхой болгох шаардлагатай гэж үзэж байна. Иргэний хуулиар эдийн болон эдийн бус баялагтай холбоотой харилцааг зохицуулж байгаа билээ. Гэхдээ хуулийн зохицуулалтын үед иргэний эрх зүйн харилцаанд хамаарагдах бүхий л асуудлыг нэг бүрчлэн шийдвэрлэн, зохицуулах боломж байхгүй ялангуяа гэрээний харилцаанд оролцогчдын эдлэх эрх, үүргийн тухайд. Энэ тохиолдолд оролцогч нэг бүрийн онцлогийг харгалзан зохицуулсан зохицуулалт шаардагдана. Иймд хуульд зөвшөөрсөний дагуу гэрээ байгуулах явдлаар хэрэгжинэ.

Эд юмсын хязгаарлагдмал эрхийн харилцаанд гэрээ байгуулах нь:

• Хуульд зөвшөөрсөн үндэслэл журмын дагуу Иргэний эрх зүйн харилцаанд оролцогчид өөрсдийн бололцоо нөхцөлийг харгалзан зохицуулах;

• Гэрээнд тусгагдах нөхцөлөө

нэгэнт өөрсдөө тохиролцон тогтоосон тул биелэгдэх боломжоор хангагдсан байдаг;

• Иргэний эрх зүйн харилцаанд оролцогч талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг нь тодорхой болсноор гэрээний талууд хэрэгжилтэнд хяналт тавих боломж бий болдог зэрэг ач холбогдолтой юм.

Практикт иргэний харилцаанд хэрэглэгдэж байгаа гэрээнүүдийг үзвэл уламжлал болгон хэрэглэгддэг гэрээнүүдийг талууд хэрэглэж байна. Тухайлбал (худалдах, худалдан авах гэрээ, эзэлийн гэрээ, барьцааны гэрээ гэх мэт). Гэтэл нэгэнт эд юмсын хязгаарлагдмал эрхийн талаархи харилцаа үүсэн хөгжиж байгаа өнөө үед тухайн харилцааг зохицуулсан гэрээний зохицуулалт байгаа хэдий ч практикт иргэд гэрээнд тусгагдах нөхцөлийг тодорхой бус байдлаар авч үзэх, уг гэрээг хуульд заасан зохицуулалтын хүрээнд байгуулах нь төдийлөн түгээмэл бус нийтлэг байдал ажиглагдах болов. Тус гэрээг байгуулахдаа дараах агуулгаар буюу бусад иргэний эрх зүйн гэрээний агуулгатай адилаар:

• Гэрээний зорилго, нийтлэг үндэслэл;

• Хязгаарлалтын хүрээ;

• Хугацаа;

• Гэрээний үнэ (төлбөр, шагнал);

• Талуудын эрх, үүрэг;

• Хүлээх хариуцлага;

• Давагдашгүй хүчин зүйл;

• Маргаан шийдвэрлэх журам;

• Нэмэлт нөхцөл;

• Хүчин төгөлдөр болох үндэслэл зэрэг байдлаар тусгаж өгөх нь зүйтэй болов уу. Гэхдээ талуудын эдлэх эрх, үүргийг оруулахдаа анхаарах хэрэгтэй гэж үзэж байна. Ингээд эд юмсын хязгаарлагдмал эрхийн талаархи зөвхөн үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой (бусдын газар дээр барилга байгууламж барих эрх, сервитут) гэрээний үлгэрчилсэн загварыг санал болгох байдлаар боловсруулахыг хичээсэн болно. (Хавсралаас үзнэ үү)

Ред М И Пискунов и др. "Государственная регистрация прав на недвижимость" "проблемы регистрационного права" М 2003, стр.346

5. Мөн ИХ-н 151.2 дугаар зүйлд зааснаар өмчлөх эрхээ хэрэгжүүлэхдээ өөрийнх нь эрх, хууль ёсны ашиг сонирхолд харшилсан үйл ажиллагаа явуулахгүй байхыг бусдад даалгах" гэж заасан. Тэгвэл үүнийг зүгээр л даалгаад орхих уу эсвэл дээрх нөхцөлийг тодруулсан гэрээ байгуулах уу гэдгийг анхаарах зүйтэй болов уу.

ХАВСРАЛТ

БУСДЫН ГАЗАР ДЭЭР БАРИЛГА БАЙГУУЛАМЖ БАРИХ ЭРХИЙН ГЭРЭЭ
(ҮЛГЭРЧИЛСЭН ЗАГВАР)

200 ____ оны ____ дугаар
сарын ____-ны өдөр

____ хот, сум

Нэг талаас газар өмчлөгч _____

(Иргэн, хуулийн этгээдийн нэр)

____ оршин байгаа газрын хаягт
суух, _____ бүхий

(регистрийн дугаар, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар)

____ ийн, _____ би цаашид (эрх шилжүүлэгч гэх), нөгөө
талаас эрх бүхий этгээд болох _____ оршин байгаа газрын хаягт суух,

(регистрийн дугаар, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар)

бүхий _____ ийн, _____ би (цаашид эрх эзэмшигч гэх) бид
дараах нөхцөлтэйгээр харилцан тохиролцсоны дагуу гэрээ байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Эрх шилжүүлэгч нь _____ газарт байгаа _____ газрын гэрчилгээ бүхий,
_____ кв,м _____ ыг, _____ объект хугацаатайгаар ашиглуулахаар
шилжүүлэн өгнө.

1.2. Гэрээ нь ____ оны ____ сарын ____ нээс ____ оны ____ сарын ____ ны өдөр хүртэл хүчин төгөлдөр
үйлчилнэ.

1.3. Гэрээний хугацаанд талууд хэн алиныхаа эрх, ашгийг зөрчихгүй байна.

1.4. Гэрээний зориулалтын дагуу _____
(зориулалтыг бичнэ) ашиглана.

1.5. Барилга, байгууламж барих эрхийг тухайн газарт нь талууд _____
тогтоож болно. (бүхэлд, хэсэгчлэн аль нэгийг нь сонгож болно).

1.6. Барилга, байгууламж барих эрхийн хүрээнд талууд дараах зүйлийг тохиролцож болно.

1.7. Гэрээний 5.1.3-д заасан тохиолдолд барилга, байгууламжийн ашиглалтын ердийн элэгдэл, хорогдлыг
харгалзан үзэхээр талууд тохиролцно.

1.8. Гэрээний 4.1.1-д заасан ноцтой зөрчил гэдгийг талууд дараах байдлаар тохиролцон тогтооно.

1.9. Талууд уг эрхээ хэрэгжүүлэхдээ Иргэний хуульд заасан хөршийн эрхийн зохицуулалтыг удирдлага болгоно.

Хоёр. Гэрээний үнэ

2.1. Эрх эзэмшигч нь барилга, байгууламж барих эрхийг олж авсаны үндсэн дээр эрх шилжүүлэгчид
_____ хугацаанд төлнө.

2.2. Эрх эзэмшсэний төлбөрийг 2 жилийн хугацаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр төлөөгүй тохиолдолд
гэрээг эрх шилжүүлэгч тал өөрийн санаачлагаар шууд цуцлана.

2.3. Эрх эзэмшсэний төлбөрийг хугацаандаа төлөх боломжгүй болсон тохиолдолд боломжгүй болсон тухайгаа
нэн даруй бичгээр нөгөө талдаа мэдэгдэнэ.

2.4. Эрх эзэмшсэний төлбөрийг хүндэтгэн үзэх зайлшгүй шаардлагын улмаас хугацааг _____ хоногоор
сунгаж болно.

2.5. Эрх эзэмшсэний төлбөрийн хэмжээг талууд _____ жил тутамд шинэчлэн тогтоож болно.

2.6. Гэрээний 2.5-д заасан нөхцөл үүссэн тохиолдолд шинэчлэн тогтоох үндэслэл бүхий тооцоог бичгээр нөгөө
талдаа хүргүүлнэ.

Гурав. Төлбөрийн нөхцөл

3.1. Төлбөрийг _____ хийнэ. (жил бүрийн)

3.2. Төлбөрийг _____ тоот дансаар шилжүүлнэ.

Цөрөв. Эрх шилжүүлэгчийн эрх, үүрэг

4.1. Эрх шилжүүлэгчийн эрх

4.1.1. Гэрээний төлбөрийг хугацаандаа төлөхийг шаардах эрхтэй.

4.1.2. Гэрээнд заасан хязгаарлалтын хүрээнд эрхээ хэрэгжүүлэхийг шаардах эрхтэй.

4.1.3. Гэрээний хугацаа дуусгавар болоход барилга, байгууламжийг авч үлдэх эрхтэй.

4.1.4. Барилга, байгууламж барих эрхийг эрх эзэмшигч нь эрхээ бусдад худалдах, барьцаалах болон _____ бусад хэлбэрээр захиран зарцуулахад өөрийн эрх, ашиг сонирхлыг ноцтой зөрчихөөр байвал зөвшөөрөл өгөхөөс татгалзах эрхтэй.

4.1.5. Бусад эрх _____

4.2. Эрх шилжүүлэгчийн үүрэг

4.2.1. Гэрээний дагуу эрх эзэмшигчийн шаардлагыг хангахуйц хүрээнд эрхийг нь эдлэх боломжоор хангах үүрэгтэй.

4.2.2. Барилга, байгууламж барихад зайлшгүй шаардлагатай бус боловч тэдгээрийг илүү зохистой ашиглах боломж олгож байгаа газрыг шаардсаны дагуу шилжүүлэн өгөх үүрэгтэй.

4.2.3. Барилга, байгууламж барих эрх гэрээний хугацаа дуусгавар болоход барилга, байгууламжийн үнийг төлөх үүрэгтэй.

4.2.4. Бусад үүрэг _____

Тав. Эрх эзэмшигчийн эрх, үүрэг

5.1. Эрх эзэмшигчийн эрх

5.1.1. Барилга, байгууламж барих эрхийг бусдад _____ худалдах, барьцаалах болон _____ (бусад) хэлбэрээр захиран зарцуулах эрхтэй.

5.1.2. Барилга, байгууламж барихад зайлшгүй шаардлагатай бус боловч тэдгээрийг илүү зохистой ашиглах боломж олгож байгаа газрыг шаардах эрхтэй.

5.1.3. Барилга, байгууламж барих эрх гэрээний хугацаа дуусгавар болоход газар өмчлөгчөөс барилга, байгууламжийн үнийг шаардан авах эрхтэй.

5.1.4. Бусад эрх _____

5.2. Эрх эзэмшигчийн үүрэг

5.2.1. Барилга, байгууламж барих эрхийг бусдад худалдах, барьцаалах болон _____ бусад хэлбэрээр захиран зарцуулах тохиолдолд эрх шилжүүлэгчид мэдэгдэх үүрэгтэй.

5.2.2. Гэрээний хугацаанд барилга, байгууламж нурсан, зөдэрсэн бол барилга, байгууламжийг өөрийн зардлаар засварлах үүрэгтэй.

5.2.3. Гэрээний хугацаанд ердийн ашиглалтын засан сайжруулалттай холбоотой зардлыг хариуцах үүрэгтэй.

5.2.4. Бусад үүрэг _____

Зургаа. Талуудын хүлээх хариуцлага

6.1. Эрх шилжүүлэгчийн хүлээх хариуцлага

6.1.1. Гэрээний хугацаа дуусгавар болоход барилга байгууламжийн үнийг төлөөгүй тохиолдолд _____ хоногийн дотор эрх эзэмшигчид нөхөн төлнө.

6.1.2. Бусад хариуцлага _____

6.2. Эрх эзэмшигчийн хүлээх хариуцлага

6.2.2. Гэрээнд заасан төлбөрийг хугацаандаа төлөөгүй бол хугацаа хожимдуулсан тохиолдолд _____ хоногийн дотор нөгөө талдаа төлнө

6.2. Бусад хариуцлага _____

Долоо. Давагдашгүй хүчин зүйл

7.1. Гэрээний талуудаас шалтгаалзахгүйгээр давагдашгүй хүчин зүйл (байгалийн гамшиг, гоц халдварт өвчин, г.м) илэрвэл гэрээний төлбөрийн хэмжээг талууд тухайн үед тохиролцон хугацаа, төлбөрийн хэмжээг өөрчилнө.

7.2. Давагдашгүй хүчин зүйлийн улмаас гэрээний зүйл гэмтсэн тохиолдолд талууд хэн аль нь хариуцлага хүлээхийг.

7.3. Бусад _____

Найм. Маргаан шийдвэрлэх журам

8.1. Талууд гэрээгээс үүссэн маргааныг шийдвэрлэхэд гэрээний нөхцөлийг удирлага болгоно.

8.2. Талууд гэрээнээс үүссэн маргааныг шийдвэрлэхэд _____ шүүх, арбитр, бусад аль нэгийг сонгоно.

Ес. Нэмэлт нөхцөл

9.1. _____

Арав. Бусад заалт

10.1. Гэрээний тал тус бүр гэрээний хувийг хадгална.

10.2. Гэрээ нь хавсралтын хамт хүчинтэй.

10.3. Гэрээг бүртгүүлсэнээр хүчин төгөлдөр болно.

Арван нэг. Хавсралт

11. _____

Арван хоёр. Талуудын хаяг

Эрх шилжүүлэгч:

Хаяг: _____

Утас: _____

Бусад: _____

Эрх эзэмшигч:

Хаяг: _____

Утас: _____

Бусад: _____

**СЕРВИТУТЫН ГЭРЭЭ
(ҮЛГЭРЧИЛСЭН ЗАГВАР)**

сарын ____-ны өдөр

Нэг талаас үл хөдлөх эд хөрөнгийг өмчлөгч _____

(Иргэн, хуулийн этгээдийн нэр)

_____ оршин байгаа газрын хаягт
суух, _____ бүхий

(регистрийн дугаар, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар)

ийн, _____ би цаашид (эрх шилжүүлэгч гэх), нөгөө

талаас үл хөдлөх эд хөрөнгийг шилжүүлэн авагч _____ оршин байгаа
газрын хаягт суух, _____

(регистрийн дугаар, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар)

бүхий _____ ийн, _____ би (цаашид эрх эзэмшигч гэх) бид
дараахь нөхцөлтэйгээр харилцан тохиролцсоны дагуу гэрээ байгуулав.

Нэг: Нийтлэг үндэслэл

1.1. Эрх шилжүүлэгч нь эрх эзэмшигчид хязгаартайгаар ашиглуулахаар _____ ,
_____ газарт байрлах (үл хөдлөх хөрөнгийг тодорхой зааж өгөх) _____ кв,м _____ объектын
_____ зориулалтын дагуу шилжүүлэн өгнө.

1.2. Үл хөдлөх хөрөнгийг хязгаартайгаар ашиглана. (тодорхой зааж өгнө)

а. _____

б. _____

в. _____

г. _____

1.3. Гэрээний төлбөрийг _____ (жил, сар бүрийн) _____ ний өдөр төлнө.

1.4. Гэрээний зүйлийг шилжүүлсэний шагналыг талууд _____ хэмжээгээр нөгөө талдаа өгөхөөр

тохиролцоно.

1.5. Гэрээний зүйлийн шагналыг талууд _____ удаа нөгөө талдаа өгнө.

1.5. Гэрээнд заасан төлбөрийн хэмжээг өөрчлөхөөр бол талууд нэн даруй бичгээр мэдэгдэнэ.

Хоёр: Эрх шилжүүлэгчийн эрх, үүрэг

2.1. Эрх шилжүүлэгчийн эрх

2.1.1. Сервитутын гэрээгээр шилжүүлсэнээс бусад эрхээ үл хөдлөх хөрөнгийн өмчлөгчийн хувьд бие даан эдлэх эрхтэй.

2.1.2. Гэрээнд заасан хугацаанд үл хөдлөх эд хөрөнгийг ашиглуусаны төлөө төлбөр, шагналаа шаардан авах эрхтэй.

2.1.3. Сервитутын гэрээний хугацаанд гэрээгээр шилжүүлсэн эрхийн хүрээнд үйл ажиллагаа явуулахыг шаардаж

эрхтэй.

2.1.4. Сервитутийг өөрийн эзэмшил газрын өөр хэсэгт шилжүүлэх эрхтэй.

2.1.5. Гэрээний хугацаанд сервитут бүхий талд шилжүүлэн өгсөн _____ үл хөдлөх хөрөнгийн хэвийн ашиглалтыг хангахыг даалгах эрхтэй.

2.1.6. Бусад _____

2.2. Эрх шилжүүлэгчийн үүрэг

2.2.1. Гэрээнд заасны дагуу эрх эзэмшигчийн шаардлагыг хангасан үл хөдлөх хөрөнгийг шилжүүлэх үүрэгтэй.

2.2.2. Сервитутыг өөрийн эзэмшил газрын өөр хэсэгт шилжүүлэх тохиолдолд энэ тухайгаа эрх эзэмшигчид мэдэгдэх үүрэгтэй.

2.2.3. Сервитутыг өөрийн эзэмшил газрын өөр хэсэгт шилжүүлэх тохиолдолд холбогдох зардлыг хариуцах үүрэгтэй.

2.2.4. Сервитутын объект болох барилга, байгууламжийн хувьд бүрэн бүтэн байлгах, зохих ёсоор ашиглахтай холбоотой зардлыг _____ (дангаар, хэсэгчлэн) хариуцна.

2.2.5. Бусад _____

Гурав: Эрх эзэмшигчийн эрх, үүрэг

3.1. Эрх эзэмшигчийн эрх

3.1.1. Гэрээний шаардлагыг хангах үл хөдлөх эд хөрөнгийг хүлээн авах эрхтэй.

3.1.2. Сервитутыг хэрэгжүүлэхэд бусад этгээд саад учруулж байвал эрх эзэмшигч этгээд нь уг саадыг арилгахыг шаардах эрхтэй.

3.1.3. Эрх эзэмшигч нь сервитутаар өөрт олгогдсон эрхээ хэрэгжүүлэхэд _____ бусад үйлдлийг хийх эрхтэй.

3.1.4. Бусад эрх _____

3.2. Эрх эзэмшигчийн үүрэг

3.2.1. Гэрээгээр шилжүүлсэн _____ хөрөнгийг гэрээнд заасан нөхцөл, зориулалтын дагуу ашиглах үүрэгтэй.

3.2.2. Гэрээний төлбөрийг хугацаанд төлөх үүрэгтэй.

3.2.3. Гэрээний хугацаанд гэрээгээр шилжүүлсэн эрхийн хүрээнд үйл ажиллагаа явуулах үүрэгтэй.

3.2.4. Бусад газар эзэмшигч болох _____ эрхийг зөрчихгүй байх үүрэгтэй.

3.2.5. Бусад үүрэг _____

Дөрөв: Нэмэлт нөхцөл

Тав: Хавсралт

Зургаа: Бусад

6.1. Талууд гэрээний хувийг тус бүр хадгална.

6.2. Давагдашгүй хүчин зүйлийн улмаас гэрээний нөхцөлийг биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд нөгөө талдаа бичгээр нэн даруй мэдэгдэнэ.

6.3. Гэрээнээс үүссэн маргааныг талууд шүүх, арбитраар шийдвэрлүүлнэ.

6.4. Гэрээ нь хавсралтын хамт хүчин төгөлдөр болно.

6.5. Гэрээг бүртгүүлсэнээр хүчин төгөлдөр болно.

Гэрээ байгуулсан.

Эрх шилжүүлэгч:

Хаяг:

Регистрийн дугаар

Бусад:

Гарын үсэг:

Эрх эзэмшигч:

Хаяг:

Регистрийн дугаар:

Бусад:

Гарын үсэг:



ЭРХ ЗҮЙ БА АЖ АХУЙН НЭГЖИЙН ҮҮСЭЛ, ХӨГЖИЛ

"Harvard Law Review" сэтгүүлээс орчуулсан Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Иргэн, эдийн засгийн эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ажилтан Ц.Одмаа

Компанийн эрх зүй бусад эрх зүйн салбартай харьцуулахад залуу бөгөөд нэр томъёо, хэллэг бүрэн төлөвшөөгүй байгаа энэ үед уг салбар эрх зүйн цаашдын хөгжилд бага боловч нэмэр болох үүднээс Харвардын Их сургуулийн нэр бүхий судлаачдын эрдэм шинжилгээний бүтээлээс хэсэгчлэн хүргэж байна. Бүрэн гүйцэд ойлгогдохгүй, буруу үг хэллэг хэрэглэгдсэн байх аваас чадан ядан анхны орчуулгын материалаа хэвлүүлж байгаа намайг өршөөж болгооно уу. Орчуулга болон энэхүү нийтлэлтэй холбоотой аливаа санал, асуулт, шүүмжлэлийг талархан хүлээн авах болно.

"Эрх зүй ба аж ахуйн нэгжийн үүсэл хөгжил" гэх энэхүү эрдэм шинжилгээний үнэтэй бүтээлийг олж орчуулах санаа, эсдэл төрүүлсэн Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хууль зүйн сургалтын төвийн эрхлэгч, доктор, дэд профессор С.Сүхбаатар багшид талархан илэрхийлэе.

**Henry Hansmann
Reinier Kraakman
Richard Squire
Harvard Law Review, March, 2006**

Аж ахуйн нэгж нь хууль зүйн хувьд хувь нийлүүлэгч болон гүйцэтгэх удирдлагаасаа тусгаарлагдсан, өөрийн гэсэн хөрөнгөтэй, гэрээ байгуулах бүрэн эрхтэй байх боломжийг хуулийн этгээдийн эрх зүй олгоно. Аж ахуйн нэгж ба хувь нийлүүлэгчийн энэхүү тусгаарлалт буюу нэршиж занснаар аж ахуйн нэгжийн өр зээлээс хувь нийлүүлэгчийг хамгаалдаг

"хязгаарлагдмал хариуцлага"-ын талаар хуульч судлаачид болон эдийн засагчид ихээхэн анхаарч, санал бодлоо илэрхийлсээр иржээ. Гэвч хууль зүйн тусгаарлалтын нэг болох бидний нэрлэснээр "хуулийн этгээдийн халхавч"-ийн асуудал анхаарал бага татсаар ирсэн боловч түүхэн болон эдийн засгийн ач холбогдлын хувьд "хязгаарлагдмал хариуцлага"-аас илүү байсаар ирсэн юм. "Хязгаарлагдмал хариуцлага" хувь нийлүүлэгчийн хувийн хөрөнгийг аж ахуйн нэгжийн харилцагчдаас хамгаалдаг бол "хуулийн этгээдийн халхавч" аж ахуйн нэгжийн хөрөнгийг хувь нийлүүлэгчийн харилцагчаас (мөн бусад бизнесийн эрсдэлээс) хамгаалах бөгөөд ингэснээрээ тэрхүү хамгаалагдсан хөрөнгийг аж ахуйн нэгжийн өөрийнх нь харилцагчдад зориулан нөөцөлөнө. Хуулийн этгээдийн халхавч нь хувь нийлүүлэгчийн хувьд зээлдэлтийн зардлыг багасгах, дампуурлын гүйцэтгэлийн зардлыг бууруулах, тогтвортой байдлыг бэхжүүлэх, үнэт цаасны зах зээлд боломж бүрдүүлэх гэх мэт эдийн засгийн чухал үр өгөөжийг бий болгож байдаг. Үүний хажуугаар хууль зүй, бизнесийн төрөлжсөн институц бий болгохыг шаардах, хувийн болон бизнесийн харилцагч аль алинтай нь уялдаатай оппортунизимийн¹ нөхцөлийг бүрдүүлэх гэх мэт сул талын тэнцвэрт байдлын хэлбэлзэл нь өөр өөр цаг хугацаа, нийгэм дэх хуулийн этгээдийн хувьсал хөгжлийг тайлбарлан харуулдаг билээ.

Удиртгал

Орчин үеийн нийгэмд дэх эдийн

засгийн үйл ажиллагаанд хувь хүмүүсээс илүүтэйгээр өөрийн өмчлөлдөө хөрөнгөтэй, гэрээ байгуулах чадвартай, хувь нийлүүлэгч болон гүйцэтгэх удирдлагаасаа хууль зүйн хувьд бие даасан байдлаар хариуцлага хүлээдэг аж ахуйн нэгжүүд давамгайлж байна. Орчин үеийн эдгээр бизнесийн нэгжүүдийн нийтлэг шинж нь харилцагчтай байгуулсан гэрээний баталгаа болох өөрийн хөрөнгөтэй байх эрхийг эдлэхийн зэрэгцээ тухайн хөрөнгийг хувь нийлүүлэгчдийнхээ хувийн харилцагчдын нэхэмжлэлээс хамгаалах боломжтойд оршино. Бидний өмнө нэрлэснээр хөрөнгийг тусгаарлан бататгах буюу "хуулийн этгээдийн халхавч" гэх энэхүү хууль зүйн шинж нь барууны худалдааны эрх зүйн түүхэнд гүн үл мөр үлдээсэн боловч тэр хэрээрээ бүрэн судлагдаагүй байна.

Хөрөнгийн тусгаарлалт ба хуулийн этгээдийн халхавч

Өртэй хүнийг хорих, боол болгох гэх мэт гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангах олон төрлийн санкцийг түүхийн явцад хэрэглэж байв. Эдгээр санкцийн хууль зарчим орчин үеийн эрх зүйн системд оршоор байгаа бөгөөд үүний жишээ нь өрөө буцааж төлөөгүй үүрэг гүйцэтгэгчийн хувийн хөрөнгийг хураан авах эрхийг харилцагчид олгох явдал мөн. Хувь хүн гэрээ байгуулсан тохиолдолд түүнийхээ үүргийн гүйцэтгэлийг өөрийн бүх хөрөнгөөрөө хариуцаж жижүүрийн² нөхцөлийг орчин үеийн хуульд тусгаж өгсөн. Үүнтэй төстэй эрх зүйн хэм хэмжээ компанийн хувьд ч хэрэгждэг. Өөрөөр хэлбэл, гэрээнд өөрөөр заагаагүй бол компанийн өмчлөлийн бүх хөрөнгө түүний үүргийн гүйцэтгэлийн баталгаа болно. Хувь хүн (эсвэл

¹Шударга бус замаар ашиг хонжоо олж гэсэн санаа (орч).
²Default-жижүүрийн буюу нөхвөрийн

түүний хувийн хөрөнгө), компани хоёр хоёулаа хуулийн этгээдийн шинжийг агуулдаг. Хуулийн этгээд гэх энэхүү нэр томъёогоор бид хэлбэлзэл бүхий бүлэг харилцагчдын баталгааг хангах хөрөнгийн төвлөрлийг илэрхийлж байгаа бөгөөд ингэснээр хувь хүн болон аж ахуйн нэгжийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг эрх зүйн хувьд тусгаарлагдсан уг хөрөнгийн төвлөрлөөр хангах юм. Тусгайлсан хууль зүйн зарчим буюу бидний нэрлэснээр хөрөнгийн тусгаарлалтын зарчим нь аль хуулийн этгээд ямар гэрээний үүргийг гүйцэтгэх, аль хөрөнгө нь аль этгээдэд хамаарахыг тодорхойлсон байх ёстой. Харилцагч зээлийн төлбөрийг зээл өгсөн этгээдээсээ өөр этгээдийн өмчлөлийн хөрөнгөөс гаргуулж болохгүй буюу этгээдүүдийн хоорондох хөрөнгө ихэвчлэн бүрэн тусгаарлагдсан байдаг. Харин орчин үеийн нийтлэг нөхөрлөлийн хувьд хөрөнгийн тусгаарлалт бүрэн биш байж болно. Жишээ нь: нөхөрлөлийн харилцагчдад төлөх өрийг бүрэн төлсөний дараа үлдсэн хөрөнгөөс түүний гишүүдийн харилцагчид авлагаа гаргуулж болдог. Энэ жишээндээ харахад аж ахуйн нэгжийн хөрөнгө болон түүний хувь нийлүүлэгчдийн хөрөнгийн тусгаарлалт нь хөрөнгийг харилцагчдын аль бүлгээс халхавчилж байгаагаас шалтгаалан 2 хуваагдана. Бид тэрхүү 2 хэлбэрийг "хуулийн этгээдийн халхавч" болон "хувь нийлүүлэгчийн халхавч" гэж нэрлэж байна.

Хуулийн этгээдийн халхавч хуулийн этгээдийн үндэс болох нь "Хуулийн этгээдийн халхавч" гэсэн томъёоллоор аж ахуйн нэгжийн хөрөнгийг хувь нийлүүлэгчийнх нь хувийн харилцагчаас хамгаалах нөхцөлийг тодорхойлж байгаа юм. Орчин үед 3 хэлбэрийн хуулийн этгээдийн халхавч байна. Үүнд:

Хуулийн этгээдийн сул

халхавч-аж ахуйн нэгжийн хөрөнгийг хуваах явцад хувь нийлүүлэгчийн харилцагчаас аж ахуйн нэгжийн харилцагчдыг тэргүүн ээлжинд тавина. Энэ нь аж ахуйн нэгжийн харилцагчийн өрийг эхний ээлжинд бүрэн төлсний дараа хувь нийлүүлэгчийн хувийн харилцагч үлдсэн хөрөнгөөс өрөө төлүүлэх боломжтой гэсэн үг. Орчин үеийн нөхөрлөлийн онцлог шинжийг энэ зарчим бүрдүүлж байна.

Хуулийн этгээдийн хүчтэй халхавч- хуулийн этгээдийн сул халхавч дээр хуулийн этгээдийн хөрөнгийг мөнгөн хэлбэрээр татан авахын эсрэг хамгаалалтыг (цаашид "хөрөнгийн хамгаалалт" гэх. орч)³ нэмсэн байна. Хөрөнгийн хамгаалалт нь хувь нийлүүлэгч, түүний харилцагч аж ахуйн нэгжийн нийт хөрөнгө дэх тухайн хувь нийлүүлэгчийн эзэмших хувийг хүчээр гаргуулан авах нөхцөлийг хязгаарлана. Аж ахуйн нэгжийн хувь нийлүүлэгчийн хувьд тогтоосон хязгаарлалт тэдгээрийн хувийн харилцагчдад тогтоосон хязгаарлалтаас зарчмын хувьд ялгаатай байх боловч бид энэхүү 2 хязгаарлалтыг ихэвчлэн хослуулан тогтоосон байгааг тайлбарлан харуулах болно. Компанийн харилцагчид түүний хөрөнгөөс өрөө төлүүлэхээр тэргүүн ээлжинд шаардлага гаргах эрх эдлэхээс гадна тэрхүү хөрөнгийг аж ахуйн нэгжийн хувь нийлүүлэгчид болон тэдгээрийн хувийн харилцагчид мөнгөн хэлбэрээр татан авах оролдлогоос давхар хамгаалагдадаг хуулийн этгээдийн хүчтэй халхавчийн шинжийг орчин үеийн компаниуд агуулж байна.

Хуулийн этгээдийн бүрэн халхавч- хувь нийлүүлэгчийн хувийн харилцагч гэх мэт аж ахуйн нэгжийн харилцагч биш аливаа харилцагч аж ахуйн нэгжийн хөрөнгөд шаардлага гаргах боломжийг үгүйсгэдэг. Энэ шинжийг агуулсан орчин үеийн жишээнд ашгийн бүс байгууллага, буяны итгэлийн сан (Charitable trust) багтана. Эдгээр байгууллагуудын

хувьд гүйцэтгэх удирдлагынх нь хувийн харилцагчид эсвэл ашиг тусыг нь хүртэгчид (beneficiaries) байгууллагын хөрөнгөд ямар нэгэн шаардлага гаргах эрхгүй байдаг бөгөөд түүнийг зөвхөн байгууллагын нэрийн өмнөөс хийсэн гэрээний үүргийг гүйцэтгэхэд л зарцуулна.

Орчин үеийн аж ахуйн нэгжийн ямар ч хэлбэр хуулийн этгээдийн халхавч бүхий байдаг. Хуулийн этгээдийн халхавч нь хуулийн этгээдийн эрх зүй дэх өмчийн тусгайлсан зарчмын хүрээнд л биелэгдэх боломжтой байдгаараа хувь нийлүүлэгчийн халхавчаас ялгаатай ба үүнийг бид дараагийн хэсэгт тайлбарлах болно. Ийм ч учраас бид хуулийн этгээдийн халхавч нь хуулийн этгээдийн хувьд sine qua non (зайлшгүй шаардлагатай) гэдэгт итгэлтэй байгаа бөгөөд хуулийн этгээдийг түүний халхавчийн зэргээс нь шалтгаалан сул хуулийн этгээд, хүчтэй хуулийн этгээд, төгс хуулийн этгээд гэж 3 ангилж байна.

Хувь нийлүүлэгчийн халхавчийн хэлбэрүүд

Хуулийн этгээдийн халхавчаас эсрэгээр хувь нийлүүлэгчийн халхавч гэдэгт хувь нийлүүлэгчийн хувийн хөрөнгийг аж ахуйн нэгжийн харилцагчаас хамгаалах зарчмыг хэлнэ. Хувь нийлүүлэгчийн халхавч нь хуулийн этгээдийн халхавчтай адил хуулийн этгээдийн зорилгод голчлон үйлчилдэггүй. Хувь нийлүүлэгчийн халхавч орчин үеийн хуулийн этгээдийн бүх хэлбэрт илрэн гардаггүй байна. Үүний нэг жишээ нь нөхөрлөл юм. Мөн хувь нийлүүлэгчийн халхавчийг гэрээгээр бий болгоход тийм ч төвөгтэй биш. Гэхдээ хувь нийлүүлэгчийн халхавч хуулийн этгээдийн хувьд тулгуур чухал үүргийг гүйцэтгэдэг учраас бид түүний цөөн хэлбэрийн талаар дурьдъя.

Хувь нийлүүлэгчийн сул халхавч нь хуулийн этгээдийн сул халхавчийн толинд буусан дүртэй адил юм. Энэ нь хувь нийлүүлэгчийн хөрөнгийг

³ Liquidation protection-хуулийн этгээдийн хөрөнгийг мөнгөн хэлбэрээр татан авахын эсрэг хамгаалалт гэж орчуулах нь утгыг зөв гаргаж байна гэж үзэв. (орч).

хуваахад хувийн харилцагчдад нь аж ахуйн нэгжийн харилцагчаас тэргүүн ээлжинд¹ шаардлага гаргах боломжийг олгодог. Хувь нийлүүлэгчийн сул халхавч нь 1978 оноос өмнө 2 зууны туршид Америкийн ердийн нөхөрлөлийн шинжийг бүрдүүлж байсан бол одоогийн Англи дахь нөхөрлөлийн хувьд ч хэвээр байсаар байна.

Хувь нийлүүлэгчийн бүрэн халхавч нь аж ахуйн нэгжийн харилцагчид хувь нийлүүлэгчийн хувийн хөрөнгөд шаардлага гаргах боломжийг бүрэн хаадаг бөгөөд ингэснээрээ тэдгээр харилцагчдын эрхийг аж ахуйн нэгжийн хөрөнгийн хэмжээгээр хязгаарлаж байдаг. Үүнтэй төстэй жишээ бол орчин үеийн компанийн хувьцаа эзэмшигчийн хязгаарлагдмал хариуцлага мөн. Бид энэхүү өгүүлэлд "хувь нийлүүлэгчийн халхавч", "хязгаарлагдмал хариуцлага" гэсэн 2 нэр томъёог хоёуланг нь нэг утгаар хэрэглэх болно.

Хуулийн этгээдийн халхавчийг бий болгоход хууль зайлшгүй шаардлагатай бол хувь нийлүүлэгчийн халхавчийн хувьд шаардлагагүй.

Хэдийгээр орчин үеийн бизнесийн байгууллагын зээлдүүлэгчийн эрхийн байдлыг ойлгоход хуулийн этгээдийн халхавч болон хувь нийлүүлэгчийн халхавчийн аль альных нь үндсэн зарчмууд чухал боловч зөвхөн хуулийн этгээдийн халхавчийг бий болгоход хуулийн тусгай зохицуулалт зайлшгүй хэрэгтэй. Харин хувь нийлүүлэгчийн халхавчийг ихэнх тохиолдолд гэрээний үндсэн дээр бий болгох боломжтой.

Ихэнх төрлийн аж ахуйн нэгжийн хувьд хуулийн этгээдийн үр нөлөөтэй халхавчийг тусгайлан хуулийн зохицуулалтыгээр бий болгох бодит боломж байхгүй. Ерөнхийдөө хуулийн этгээдийн халхавч гэдэг нь хувь нийлүүлэгчийн хувийн

зээлдүүлэгчийн аж ахуйн нэгжийн эд хөрөнгөд гаргах шаардлагыг дараагийн ээлжинд тавих замаар эрхийг нь хязгаарлах ба үүн дээр нэмээд аж ахуйн нэгжийн хөрөнгөөс татан авах чадварыг нь хүчтэй хуулийн этгээдийн халхавч сулруулдаг. Онолын хувьд дээрх хоёр үр дүнд хүрэхийн тулд аж ахуйн нэгжийн хувь нийлүүлэгчид зээлдүүлэгч тус бүртэйгээ байгуулах гэрээндээ шаардах эрхээс татгалзах талаар тохиролцоонд хүрч болох юм. Гэхдээ тийнхүү шаардах эрхээс татгалзах нь шилжүүлгийн өндөр зардлаас гадна ёс суртахууны, эрсдэлт байдалд өртөх магадлалтай. Эрхээс татгалзах тохиолдол бүр нь аж ахуйн нэгжийн зээлдүүлэгчийн нөхцөл байдлыг илүү сайжруулж, аж ахуйн нэгжийн зээл авах зардлыг бууруулах замаар хувь нийлүүлэгчдэд ашигтай байдлыг үүсгэдэг. Гэсэн хэдий ч эрхээс татгалзах тохиолдол бүр нь хувь хүний зээл авах зардлыг нэмэгдүүлэх ба тухайн зардал нь бүхэлдээ эрх хязгаарлах тохиролцоо хийж буй хувь нийлүүлэгчээр төлөгдөх болно. Ингэснээр хувь нийлүүлэгч бүрт эрх хязгаарлах хэлцэл хийхгүй байх замаар ашиг хонжоо хайх сэдэл төрдөг. Цаашилбал, өөрийн үйл хэргээ удирдан явуулах эрх чөлөөгөө эдлэж байгаа тэрхүү эс үйлдлийг цагдан журамлах шаардлага үүсэн бий болж бусад хувь нийлүүлэгчид болон аж ахуйн нэгжийн харилцагчаас гарах зардал нэмэгдэх талтай. Хувь нийлүүлэгчдийн тоо нэмэгдэх хэрээр тэдгээрийн хяналтыг илүү төвөгтэй болгох, хувийн болон нийтийн ашиг сонирхлыг зөрчилдүүлэх гэх мэтээр асуудлыг улам дордуулан. Хувь нийлүүлэгчийн эзэмших хувийг нөлөөтэй шилжүүлэх боломжтой бол цагдан журамлах асуулал улам ч ярвигтай. Гэрээгээр тохиролцсон эсэхээс үл хамааран эдгээр асуудлыг (ихэвчлэн энэ тухай үр дүнчилэн мэдэгдэхгүйгээр) зөвхөн хувь нийлүүлэгчийн хувийн зээлдүүлэгчдийн эрхийг хязгаарлах замаар л шийдвэрлэх боломжтой.

Ингэхийн тулд байгууллагын хөрөнгөд зориулсан өмчийн эрх зүйн тусгайлан хэм хэмжээг хэрэгтэй. Энэ хэм хэмжээг хуулийн этгээдийн тухай хуулиар тогтооно.

Нөгөө талаасаа тодорхой хэмжээний хувь нийлүүлэгчийн халхавч буюу ялангуяа хязгаарлагдмал хариуцлагыг гэрээгээр бий болгох боломжтой. Ингэхийн тулд харилцагчтай байгуулах гэрээнд хувийн хөрөнгөөс шаардах эрхийн татгалзал эсвэл хязгаарлалтыг тусгахыг аж ахуйн нэгжийн ажилтнуудад (аж ахуйн нэгжийг төлөөлж байгаа хувь нийлүүлэгчийг оролцуулаад) хувь нийлүүлэгч даалгаж болно. Хэдийгээр ийм тогтолцоо нь зарим нэгэн ёс суртахууны эрсдэлд өртөх магадлалтай боловч сөрөг нөлөө багатай. "Эрхээс татгалзах" шаардлагыг хэрэгжүүлэхгүй орхисноор гарах зардал хувь нийлүүлэгч нэг бүрийн хувийн хөрөнгийг эрсдэлд оруулах боловч аж ахуйн нэгжийн зээл авах зардлыг бууруулж, ингэснээрээ хувь нийлүүлэгчдэд ч ашигтай байдлыг бүрдүүлэх, бусдын өртөгөөр ашиг олох нөхцөлийг багасгах давуу талтай. Түүнчлэн, хэрвээ агентийн эрх зүйн² үндсэн зарчим үйлчилвэл хувь нийлүүлэгчийн хүлээх хариуцлагыг хувийн биш байгууллагын эд хөрөнгийн хэмжээгээр хязгаарлахыг аж ахуйн нэгжийн ажилтанд үүрэг болгох замаар хувь нийлүүлэгч эрхээ хамгаалж болно. "Хязгаарлагдмал" гэдэг үгийг аж ахуйн нэгжийн нэрийн ард оруулах буюу гуравдагч этгээдэд агентийн бүрэн эрх хязгаарлагдмал гэдгийг мэдэгдэх замаар дээрх аргын үр нөлөөг нэмэгдүүлэх боломж ч бий. Английн хувьцаат компаниуд нийтийн эрх зүй болон хуулиар "хязгаарлагдмал хариуцлага"-ыг аж ахуйн нэгжийн үндсэн зарчим болгон тогтоохоос өмнө түүнийг бодит байдал дээр ашиглаж байжээ.

Корпораци гэх мэт хүчирхэг хуулийн этгээдийн үндсэн шинжийг бүрдүүлэгч хөрөнгийн хамгаалалтыг

¹ Agency law-аж ахуйн нэгжийн тодорхой албан тушаалтанд эрх олгохтой холбоотой харилцааны эрх зүй (орч).

бий болгоход хуулийн этгээдийн тухай хууль зайлшгүй шаардлагатай гэх саналын хүрээнд түүнийг ангилж авч үзэх хэрэгтэй байна. Бид хөрөнгийн хамгаалалт өөртөө 2 хэлбэрийг агуулдаг гэж тодорхойлсон. Үүнд:

- хувь нийлүүлэгч аж ахуйн нэгжийн хөрөнгөөс эзэмших хувиа дангаараа татан авах эрхийг хасах хувь нийлүүлэгчийн эсрэг хөрөнгийн хамгаалалт;

- хувь нийлүүлэгчийн зээлдүүлэгч өрөө төлүүлэхийн тулд аж ахуйн нэгжийн хөрөнгөөс гаргуулан авах боломжийг хаасан хувийн зээлдүүлэгчийн эсрэг хөрөнгийн хамгаалалт.

Хэдийгээр хуулийн этгээдийн тухай хуулиар дээрх 2 шинжийг аль алийг нь баталгаажуулах ёстой боловч юуны түрүүнд аж ахуйн нэгжийн хөрөнгийг хувийн зээлдүүлэгчдээс хамгаалах нь хамгийн чухал юм. Өнгөрсөн үеэ эргэн харахад аж ахуйн нэгжийн хөрөнгийг урьдчилан тодорхойлсон нөхцөл байдал үүсэхээс өмнө эсвэл нийтээр хүлээн зөвшөөрөөгүй байгаа үед татан авахгүй байх нөхцөл бүхий гэрээг бизнесийн талууд байгуулдаг байсан байна. Зарим тохиолдолд өмчийг чөлөөтэй шилжүүлэхийн эсрэг байнгын хязгаарлалтыг хэрэгжүүлэх асуудал дээр шүүх хойрго ханддаг байжээ. Түүнчлэн, зөрчил гаргагчид ногдуулах санкц нь ихэвчлэн нотлогдсон хохирлын нөхөн төлбөрөөр л хязгаарлагддаг байсан ба энэ нь үр ашгийг хөрөнгө татан авалтыг зогсоход хангалтгүй байв.

Хувь нийлүүлэгч аж ахуйн нэгжийн хөрөнгөөс хувиа татан авах боломжийг хаасан байнгын хамгаалалт бүхий корпораци гэх мэт хүчирхэг хуулийн этгээдийн үүрэг хүлээх чадвар нөхөрлөлтэй харьцуулахад илүү байдаг. Хувь нийлүүлэгчийн эсрэг хөрөнгийн хамгаалалт бүхий хуулийн гүйцэтгэх үүрэг нь "төрөл"-ийн гэхээсээ илүү "зэрэглэл"-ийн асуудал юм. Нөгөө талаасаа, хөрөнгө татан авах эрхээсээ татгалзсан цөөн тооны хувь нийлүүлэгчдийн дунд байгуулсан гэрээнд тэдгээрийн зээлдүүлэгчид бүрэн хамрагдаж чаддаггүй учраас зээлдүүлэгчдийн эсрэг хөрөнгийн хамгаалалтыг тогтоосон хуулийн тусгайлсан хэм хэмжээ маш чухал байна. Түүнчлэн, гэрээний үндсэн дээр эрхээсээ татгалзагчдыг харилцагчдаас хамгаалах оролдлого нь дээр тайлбарласан ёс суртахууны эрсдэлд өртөх магадлалтай. Үүнтэй адил шалтгаанаар хувь нийлүүлэгчийн өв залгамжлагч гэх мэт өөрийн хүсэл зоригоос гадуур хөрөнгө шилжүүлэн авсан этгээдийн хөрөнгө татан авах эрхийг хязгаарлах тусгай хэм хэмжээг хуулийн этгээдийн тухай хуульд тусгах нь ч зөв юм.

Компанийн түүхэн ач холбогдол нь нөхөрлөлийнхөөс ялгаатай буюу хувь нийлүүлэгчийн эсрэг хөрөнгийн хамгаалалтыг бий болгосонд орших ба энэ нь хувь нийлүүлэгч өөрийн оруулсан хөрөнгө оруулалтдаа үнэнч байх нөхцөлийг бүрдүүлдэг гэсэн санааг судлаачид дэвшүүлээд удаагүй байна. Бид ч гэсэн хувь нийлүүлэгч хөрөнгө оруулалтдаа

үнэнч байх нь компанийн эрх зүйн үндсэн чиг үүрэг гэх энэ үзэлтэй санал нийлж байна. Гэхдээ дээр өгүүлсэнчлэн компани ч бай хуулийн этгээдийн бусад ямар ч хэлбэрийн хувьд хувь нийлүүлэгчийн эсрэг хөрөнгийн хамгаалалт угтвар нөхцөл нь болдоггүй. Үүнтэй харьцуулахад, зээлдүүлэгчийн эсрэг хөрөнгийн хамгаалалт нь хуулийн этгээдийн шинж чанарыг тодорхойлсон өмчийн эрх зүй дэх тусгай хэм хэмжээсээс хамааралтай байна. Зээлдүүлэгчийн эсрэг хөрөнгийн хамгаалалтгүйгээр өмчлөгчийн эсрэг хөрөнгийн хамгаалалтын эдийн засгийн үр өгөөж хязгаарлагдмал болно. Дурьдсан шалтгаануудын улмаас корпораци гэх мэт хүчирхэг хуулийн этгээдүүдэд хийсэн бидний түүхэн болон онолын судалгаанд аж ахуйн нэгжийн хөрөнгийг хувь нийлүүлэгчдийн хувийн зээлдүүлэгчдээс хамгаалдаг шинж чанар бүхий хуулийн этгээдийн чухал үүрэг онцгой байр суурь эзэлж байна.

Дүгнэж хэлбэл, хуулийн этгээдийн халхавчгыг гэрээгээр тогтооход учрах саад бэрхшээлийг даван туулж чадсан өмчийн эрх зүйн хэм хэмжээг бий болгодог нь хуулийн этгээдийн анхдагч давуу тал мөн. Гэхдээ энэхүү давуу тал нь зээлдүүлэгчийн эрхийг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр хязгаарлах боломжийг хувь хүнд олгодог хууль зүйн хэргэсэл болохынхоо хувьд хүчирхийллийн шинж чанарыг агуулсан сул талтай.



ГЭР БҮЛ БА ХӨРӨНГӨ

Илтгэлийн зорилго, сонголт

Нийгмийн аль ч үед гэр бүлийн асуудал нь зөвхөн нэг улсын бус дэлхийн шинжтэй асуудал байсаар ирсэн билээ.

Монгол Улсад 1990 оноос өмнө төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засаг бүхий нийгмийн үед өмчийн олон хэвшлийг хүлээн зөвшөөрдөггүй зөвхөн социалист өмч ноёрхож байх үзэл санаа оршиж байсан билээ.

Монгол Улсын эрх зүйн тогтолцооны үндсэн шалгуурын нэг нь Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлд заасан **хууль дээдлэх** ёс бөгөөд Ром-Германы үзэл баримтлалыг баримжаалан хөгжих нь гарцаагүй болж байгаа юм.

Монгол Улсын Үндсэн хууль-ийн 16 дугаар зүйлийн 16.11-д "Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн эрх, ашиг сонирхлыг төр хамгаална" гэж гэр бүлийн харилцаан дахь суурь зарчмыг нийгмийн амьдралын тодорхой хүрээнд улам нарийсган тодорхойлж, холбогдох хуулиар гэр бүлийн гишүүдийн эрх, ашиг сонирхлыг ханган хамгаалахаар зохицуулсан билээ.

Гэр бүл нь хүний анхдагч бичил орчин байдаг учраас хүний хөгжил нь энэ орон зайнаас эхлэлтэй гэж үзэж болох юм.

2006 онд улсын хэмжээнд Иргэний бүртгэлийн байгууллагад нийт 50.502² хос гэрлэлтээ бүртгүүлж амьдралын хатуу бэрхийг туулахаар сэтгэл зүрхээ нэгтгэн өрх тусгаарласан нь өмнөх оныхоос 31 дахин өссөн байна. Харин 2008 онд гэрлэлтээ бүртгүүлсэн хосын тоо 33.754³ байгаа нь өмнөх оныхтой харьцуулбал 6689 хосоор буурсан байна.

Амьдралын аливаа саад, бэрхшээлээс үүдэн 2008 онд 1955 гэр бүл гэр бүл цуцалсан бүртгэл



Цагдаагийн Академийн
Иргэний эрх зүйн тэнхимийн
багш О.Олтонтуяа

хийлгэсэн нь өмнөх оныхоос 221 хосоор их байгаа боловч цаана нь хэдэн гэр бүл гэр бүл цуцлуулсаны бүртгэл хийлгээгүй байгаа, хэдэн гэр бүл гал голомтоо бадраасан амьдралаас тусдаа амьдарч байгааг хэн ч таашгүй.

Гэр бүлийн дундын эд хөрөнгийн асуудлыг зохицуулсан Иргэний хууль болон Гэр бүлийн тухай хуульд гэр бүлийн дундын эд хөрөнгийн харилцааны зохицуулалт хэрхэн тусгагдсан, гэр бүлийн дундын эд хөрөнгийн шүүхээр хэрхэн шийдвэрлэж байгаад дүн шинжилгээ хийх, тухайн харилцааг гэрээгээр зохицуулах үндэс шаардлага, ач холбогдол, улмаар энэ талаархи заалтыг хэрхэн ойлгож, практикт хэрэглэх дүгнэлт санал гарах зорилгоор уг сэдвийг сонгон энэхүү илтгэлийг бичлээ.

Үндсэн хэсэг

• Гэр бүлийн дундын эд хөрөнгийн талаархи зарим орны эрх зүйн зохицуулалт

Гэрлэгчид дундын өмчийн

асуудлаа гэрээгээр зохицуулж болохоор шинэчилсэн найруулсан 2002 оны Иргэний хуульд тусгасан нь практикийн ач холбогдолтой зүйл болсон гэж илтгэгчийн зүгээс дүгнэж байна.

Гэрлэлтийн гэрээ нь анх Франц, Англи зэрэг улсад үүсэлтэй гэж судлаачид үздэг ба эмэгтэйчүүдийн болон түүний садангийнханд гэрлэлтээс өмнөх хөрөнгийг захиран зарцуулах, өмчлөх эсхүл ашиг, орлогын хувь хуртэх эрхийг нөхрийн талтай тохиролцон баталгаажуулах нь энэхүү гэрээ бий болох шаардлага болжээ.⁴

Англи Улсад 1882 он хүртэл "нийтлэг эрх зүйгээр" ("common law") гэр бүлийн өмч нь цэвэр нөхрийн мэдэлд байсан ба нөхөрт гарсан эмэгтэй хүн бие дааж өмчлөх, эзэмших, захиран зарцуулах эрхгүй байжээ.

1882 онд парламент Гэр бүл болсон эмэгтэйчүүдийн өмчийн тухай хуулийг баталсан. Уг хуулиар эмэгтэй хүний өмч нь гэр бүл болсноор болон түүнээс хойших хөрөнгө нь гэрлэлтийн гэрээний дэглэмд захирагдана гэжээ. Өөрөөр хэлбэл, гэрлэгчид тус тусын өмчтэй байх, эсхүл гэрлэлт цуцалсаны дараа олж авах асуудлыг тус гэрээгээр зохицуулахаар тохирч мөн эмэгтэйчүүд нь эд хөрөнгө өвлөж болохоор уг хуульд зааж байв.

Иймд гэрлэлтийн гэрээний үүслийн анхдагч үндэслэл нь тухайн нийгмийн чинээлэг иргэд өөрийн өмч хөрөнгөө бусдаас хамгаалах хэрэгцээ байж гэж дүгнэж болох байх.

Гэрлэгчид нь эд хөрөнгийн харилцааг гэрээгээр зохицуулах бүрэн боломжтой юм. Ийнхүү гэрээгээр зохицуулах асуудал нь шинэ тутам гарсан шинэлэг ойлголт мөн эсэхийг тодруулах зорилгоор түүхэн сурвалжийг сөхөв. **Монгол**

¹ Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл сэтгүүл. 1992 он. №1.
² Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвөөс авсан статистик. 2007 он.
³ Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвөөс авсан статистик. 2008 он.
⁴ МУИС-ийн Хууль зүйн сургууль. Олон улсын эрх зүйн тэнхим. "Судалгааны илтгэлийн зэмтгэл". 2006 он. 41-44 дэх тал.

Улсын 1926 оны анхны Иргэний хуульд "Эр эм хоёр аливаа хогшлын тухай завсарт хууль ёсоор гэрээ хэлэлцээр байгуулж болмой" гэжээ. Үүнийг судлаачид хэрхэн тайлбарласныг үзвэл: дээрхи зүйлүүд ёсоор байгуулсан гэрээ, хэлэлцээний дотор хоёр этгээдийн хэн нь ч атугай хөрөнгө хогшлыг эзэрхэн эдлэх тухай эрхийг үндсээр нь хасагдуулан муудуулах зэрэг зүйл байх ахуй түүнийг байгуулсан эр, эм хоёр бус бусад этгээдээс тэдгээрийн ашиг тусыг хамгаалахын тулд уг байгуулсан гэрээг устгуулахыг хүсэж зохих шүүх таслах газраа мэдүүлж болмой.³

Франц Улсад гэрлэлтийн гэрээг нотариатаар гэрчлүүлж байж уг гэрээ хүчин төгөлдөр болдог бол **Италид** гэрээг орон нутгийн төрийн байгууллагад бүртгүүлэхийн зэрэгцээ уг гэрээ нь үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой эрхийн харилцааг хөндсөн бол үл хөдлөх хөрөнгө бүртгэх бүртгэлийн газар давхар бүртгүүлсэн тохиолдолд хүчин төгөлдөр болдог байна.⁴

ОХУ-ын гэрлэлтийн гэрээний талаархи эрх зүйн зохицуулалтыг Монгол Улсын гэрлэлтийн гэрээний эрх зүйн зохицуулалттай харьцуулан авч үзэх нь

ОХУ-д гэрлэлтийн гэрээний эрх зүйн зохицуулалтыг 1995 онд батлагдсан Гэр бүлийн тухай хуульдаа суулгаж өгсөн.⁵

Гэрлэлтийн гэрээг бичгээр байгуулах бөгөөд нотариатаар гэрчлүүлнэ. Харин гэрлэлтийн гэрээний агуулгын хувьд гэрлэлтийн гэрээ байгуулсан гэрлэгчид нь хуулиар тогтоосон хамтын өмчийн дэглэмээ өөрчлөх, дундын өмчийн хэлбэрээ тогтоох, хуваарьт эд хөрөнгөө тогтоох зэрэг эрх эдэлнэ.

Мөн гэрлэгчид гэрлэлтийн гэрээндээ харилцан бие биенээ гэжээн тэтгэх, гэр бүлийн зардлыг хариуцах журам, гэрлэлтээ цуцалсан

тохиолдолд гэрлэгчдэд ногдох эд хөрөнгийг тодорхойлох журам зэргийг тусгаж болно. ОХУ-ын дээд шүүхийн дэргэд ажилладаг судалгааны төвөөс 2005 онд явуулсан судалгаагаар тус улсад нийт 1.5 мянган гэрлэгч гэрлэлтийн гэрээ байгуулсан байх бөгөөд тэдний 86.04 хувь нь тус улсын иргэн гадаадын иргэнтэй гэр бүл болохдоо гэрлэлтийн гэрээ байгуулсан байна.⁶

Гэрлэлтийн гэрээнд заасан гэрлэгчдийн хүлээх эрх, үүргийг тодорхой хугацаагаар хязгаарлаж болдог. Мөн гэрлэлтийн гэрээ нь гэрлэгчдийн эрхийн чадамжийг хязгаарласан байж болохгүй ба тэд өөрийн хууль ёсны эрхээ хамгаалуулахаар шүүхэд хандах, эдийн бус амины харилцаагаа зохицуулах, үр хүүхдээ асран хүмүүжүүлэхэд хүлээх эрх, үүргээ тодорхойлох зэрэг эрх эдэлнэ.

Гэрлэлтийн гэрээг гэрлэгчдийн зөвшилцсөнөөр ямар ч үед цуцлах буюу түүнд өөрчлөлт оруулж болно. Гэрлэлтийн гэрээг биелүүлэхээс нэг тал нь татгалзсанаар уг гэрээг цуцлаж болохгүй.

Гэрлэлтийн гэрээг хуульд заасан шаардлагын дагуу байгуулаагүй бол уг гэрээг хүчин төгөлдөр бусад тооцно.

Энэ бүх хууль зүйн зохицуулалтаас харахад ерөнхийдөө манай улстай зарчмын ялгаагүй байгаа хэдий ч гэрлэлтийн гэрээг Гэр бүлийн тухай хуульдаа бүлэг болгон оруулж өгч, түүнийг байгуулах журам, гэрлэгчдийн гэрлэлтийн гэрээ байгуулсан тохиолдолд эдлэх эрх үүргийг тусгайлан тодорхойлсон зэрэг уг асуудлыг хуулийн хүрээнд системчилж өгсөн нь ихээхэн ач холбогдолтой болсон байна гэж үзлээ.

Япон Улсын гэр бүлийн эрх зүйн зарим зохицуулалтыг Монгол Улсын гэр бүлийн эрх зүйн зарим зохицуулалттай харьцуулан авч

үзэх нь

Япон Улсын Гэр бүлийн тухай хууль нь манай улсынхаас нэлээд онцлогтой байх бөгөөд түүнийг товч үзвэл:⁷ (71 дүгээр хуудасны Хүснэгт-1)

Дээрх шаардлагыг хангасан гэр бүл болохыг хүсэгчид гарын үсэг бүхий өргөдлийг орон нутгийн эрх бүхий байгууллагад гаргаж түүнийг нь 2-3 гэрч гэрчилсэн тохиолдолд хүчин төгөлдөрт тооцдог.

Мөн Япон Улсын Гэр бүлийн тухай хуулийн нэгэн өвөрмөц зохицуулалт нь сүйлэх журам тогтоосон явдал юм. Сүй тавихдаа гэрээ байгуулдаг. Сүйлэх нь харилцан бэлэг солилцох замаар явагдах бөгөөд сүйг сүмд үйлдэхгүй байж болно. Сүйн гэрээг зөрчсөн тохиолдолд гэрээний нэг тал нөгөө талаасаа гэрээг албадан биелүүлэхийг шаардаж болохгүй. Гэхдээ ийнхүү зөрчсөн нь нөгөө талд бодитой хохирол учруулсан тохиолдолд гэм буруутай тал нь нөгөө талд учирсан хохирлыг нөхөн төлөх үүрэг хүлээнэ.

Гэрлэлтийн гэрээний нөхцөлийг талууд өөрсдөө бие даан тодорхойлох эрхтэй боловч уг гэрээ нь хатуу тогтсон хэлбэртэй байх бөгөөд талууд гэр бүл болох тухай өргөдлөө гаргахаасаа өмнө гэрээг байгуулах ёстой. Гэр бүл болсны дараа байгуулсан гэрээг хүчингүйд тооцох ба энэ үед гэрлэгчдийн дунд үүсэх эд хөрөнгийн харилцааг Японы Иргэний хуулийн дагуу зохицуулна.

Гэрлэлтийн гэрээг заавал бүртгүүлэх ёстой. Гэр бүл болох тухай өргөдлөө эрх бүхий орон нутгийн байгууллагад гаргасны дараа гэрлэлтийн гэрээнд өөрчлөлт оруулахыг хатуу хориглодог.

Гэрлэлт дуусгавар болох талаар хуульд заахдаа гэрлэлт дуусгавар болох хоёр үндсэн нөхцөл байна.

- Гэрлэгчид нас барах;
- Гэрлэлт цуцлах.

³ З.Сүхбаатар, П.Оюундэлгэр, "Монгол Улсын Иргэний хуулиуд, нэмэлт өөрчлөлтүүд (1926, 1952, 1963, 1994, 2002)" УБ, 2002 он, 15 дахь тал.

⁴ С.Н.Бондов "Брачный договор", М., 2001г., стр.58.

⁵ Семейный кодекс РФ, Москва, 2005г., Глава 8.

⁶ www.majk.ru

⁷ В.В. Пилияев "Гражданское и торговое право Японии", М., 2005г., стр.107-110

Хүснэгт-1

Шалгуур	Зохицуулалт
Эд хөрөнгийн хэлцэл хийх эрх зүйн чадамж	Энэ төрлийн хэлцлийг 20 нас хүрсэн этгээд хийж болно. Хэрэв тухайн этгээд нь эрх зүйн бүрэн чадамжгүй бол төлөөлөгчөөрөө дамжуулан уг хэлцлийг хийж болно.
Гэр бүл болох эрх зүйн чадамж Гэр бүл болоход харгалзан үзэх нөхцлүүд	Эрэлтэй 18, эмэгтэй нь 16 наснаас үүснэ. Гэрлэх гэж буй этгээдүүдийн хүсэл зориг Гэрлэлт, гэр бүлийн хэлцэл нь хуульд заасан зан суртахууны хэм хэмжээ нийтээр дагаж мөрдөж байгаа заншлын хэм хэмжээ зөрчөөгүй байх ёстой. Эрх бүхий байгууллагад бүртгүүлснээр гэрлэлтийг албан ёсоор тооцно. Хамтран амьдрах Хамтран хөдөлмөрлөх Харилцан бие биедээ туслалцаа үзүүлэх Гэр бүлийн үнэнч байдлыг хадгалах Нэг овогтой байх Эхнэр, нөхөр олсон орлого, эд хөрөнгөөрөө гэр бүлд гарсан зардалыг тэнцүү зарцуулах
Гэрлэгчдийн үндсэн эрх, үүрэг	Хамтран амьдрах Хамтран хөдөлмөрлөх Харилцан бие биедээ туслалцаа үзүүлэх Гэр бүлийн үнэнч байдлыг хадгалах Нэг овогтой байх Эхнэр, нөхөр олсон орлого, эд хөрөнгөөрөө гэр бүлд гарсан зардалыг тэнцүү зарцуулах
Гэр бүл болоход саад болох нецлөл	Гэр бүлийн тухай ердөөл гаргах хэлбэр, нөхцлийн биелүүлэлгүй Гэрлэх насанд хүрээгүй Өмнөх гэрлэлтээ албан ёсоор цуцлуулаагүй (Эмэгтэйчүүдийн хувьд өмнөх гэрлэлтээ цуцлуулаад 6 сарын дотор дахин гэрлэхийг хориглодог) Гэр бүл болохыг хүсч буй этгээдүүд нь ойрын хамаатан бол Насанд хүрээгүй хүмүүс Хууран мэхлэх замаар эсхүл албадан гэр бүл болж байгаа
Гэрлэлтийг хүчин төгөлдөр бусад тооцох үндсэн нөхцөл	Гэрлэх гэж буй этгээдүүд гэр бүл болох хүсэл сонирхолгүй Гэр бүл болох тухай ердөөл гаргаагүй Гэрлэлтийг хүчин төгөлдөр бусад тооцох тухай нэхэмжлэлийг шүүхэд гаргасан
Гэр бүлийн маргааныг шийдвэрлэх	Гэр бүлийн шүүх (Тэгжэн тэтгэхтэйн холбоотой харилцаа, гэрлэлтийн гэрээтэй холбоотой маргаан, гэрлэгчдийн дундын эд хөрөнгөтэй холбоотой маргаан зэрэг)

Эрх зүйт төрийн хувьд Үндсэн хуулийн хамгийн дээд зарчим буюу хэм хэмжээ болдог бөгөөд Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т "Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална" гэж заасан.

Монгол Улсад одоогоор хүчин төгөлдөр үйлчилж байгаа 390-ээд хууль байгаа бөгөөд үүний 159 хууль нь өмчийн эрх зүйн харилцааг хэсэгчилэн болон бүхэлд нь зохицуулж байна. Эдгээр хуулийн 29 нь шинээр батлагдсан, 23 хууль нь шинэчлэн найруулагдаж, 119 хуульд 316 удаа нэмэлт, өөрчлөлт орсон байна.

Манай улс одоогийн байдлаар 196 олон талт гэрээнд нэгдэж ороод байгаа бөгөөд Үндсэн хуульд заасан эрх үүргээ бага ч гэсэн хэмжээгээр хэрэгжүүлж байгаа билээ. Уг олон талт гэрээнд гэр бүлийн харилцаанд ач холбогдол бүхий Хүний эрхийн

түгээмэл тунхаглал, Хүүхдийн эрхийн тухай конвенц, Сайн дурын үндсэн дээр гэрлэх болон гэрлэх нас, гэрлэлтийг бүртгэх тухай конвенц зэрэгт нэгдэн орж үндэсний хууль тогтоомжийг нийцүүлэх ажлыг гүйцэтгэж байгаа нь ач холбогдолтой юм.

Гэвч шүүхийн практикийг судлахдаа нийт иргэний 5610¹⁰ шийдвэр, магадлал, тогтоолыг уншсан ба үүний 480 шийдвэр, магадлал, тогтоол нь гэр бүлийн харилцаатай холбоотой маргаан байсан бөгөөд гэр бүлийн маргааныг шийдвэрлэсэн хэрэгт олон улсын гэрээ, конвенцийг хэрэглэсэн тохиолдол нэг ч байхгүй байна. Харин гэм хорын хохирыг шийдвэрлэсэн 2 хэрэгт хэрэглэсэн нь практикийн ач холбогдолтой зүйл болж байна.

Монгол Улс, гадаадын 9 улстай иргэн, гэр бүлийн талаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээ

байгуулсан байгаа бөгөөд энэхүү гэрээ нь зарим талаар учир дутагдалтай байна. (72 дугаар хуудасны Хүснэгт-2)

• Гэр бүлийн дундын эд хөрөнгийн маргааныг шийдвэрлэж буй шүүхийн практик

Улсын хэмжээнд 1993 оноос хойш шүүхээр шийдвэрлэсэн хэргийн тоон үзүүлэлт¹¹: (72 дугаар хуудасны Хүснэгт-3)

Гэрлэлтээ цуцлуулахдаа хамтран өмчлөх дундын эд хөрөнгө болон хуваарьт эд хөрөнгийн маргааныг шийдвэрлэсэн нь тодорхой бус байна.

2006 онд шийдвэрлэсэн гэр бүлийн маргааны 74 хувийг гэрлэлт цуцлалттай холбоотой маргаан эзэлж байгаа нь 2002 оны тоон үзүүлэлттэй харьцуулахад 6 хувиар буюу нэг жилд 1.2 хувиар өсөж байгаа нь хүн бүрд гэр бүлийн баталгаа юунд оршиж байна вэ гэсэн бодол өөрийн эрхгүй төрүүлэх буй.

Гэвч гэр бүлийн эд хөрөнгийн харилцааг "Иргэний хуулиар зохицуулна гэж" Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д заасан бөгөөд 2002 оны Монгол Улсын Иргэний хуулиар бүхэлдээ буюу есөн зүйлд гэр бүлийн хөрөнгийн харилцааг зохицуулсан байна.

2006 оны 12 дугаар сарын 22-ны өдрөөс 2007 оны 3 дугаар сарын 30-ны өдөр хүртэл шийдвэрлэсэн 5610 иргэний хэргийн 480 буюу 8.5 хувь нь гэрлэлт цуцлалттай холбоотой маргаан байна.

Гэрлэлт цуцлалттай холбоотой маргааны 9 буюу 1.9 хувийг хяналтын шатны шүүхийн тогтоол, 17 буюу 3.6 хувийг давж заалдах шатны шүүхийн магадлал, 400 буюу 83.3 хувийг анхан шатны шүүхийн шийдвэр, 53 буюу 11.02 хувийг шүүгчийн захирамж тус тус эзэлж байна.

Гэрлэлт цуцлуулахыг хүссэн 480 нэхэмжлэлийн 53 маргааныг гэрлэгчид хялбаршуулсан журмаар шийдвэрлүүлсэн байна.

¹⁰ Монгол Улсын шүүхийн шийдвэрийн эмхтгэл (Иргэний хэрэг 6)-д оруулахаар 21 аймаг, 9 дүүргээс ирүүлсэн шийдвэрүүд
¹¹ УДШ-ийн судалгааны төвийн судалгаа УДШ-ийн 2003-2006 оны тайлан

Хүснэгт-2

Бүгд Найрамдах Хятад Ард Улс	Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс
Шинэ Үндэсний хууль батлагдсантай холбоотойгоор манай улсын иргэд, иилийн чандад суурь боловсрох, аригдгаа, гүйцээж хийх суурь тавигдсантай холбоотойгоор бусад улсын иргэнтэй гэр бүл болох асуудал нэмэгдсэн. Тиймээс хөрш зэрэгдэлт улс болох БНХАУ-тай байгуулсан эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээнд гэр бүлийн асуудлыг хэрхэн тусгасан талаар Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын гэрээний нөхцөлтэй харьцуулан үзвэл	Иргэн, гэр бүлийн хэргийн талаарх эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээ Гэр бүлийн хэрэгт
✓ шүүхийн зэдрэлээс хөнгөлөх, чөлөөлөх	✓ гэрлэх
✓ бичиг баримтыг хүргүүлэх болон шалгах нотлох	✓ гэрлэгчдийн хувийн болон эд хөрөнгийн эрхийн харилцаа
✓ дэлгэвэр биелүүлэх	✓ гэрлэлтийг цуцлах
✓ биелэлтийг мэдэгдэх, дипломат төлөөлөгчийн буюу консулын газрын эрх мэдэл	✓ гэрлэснийг хүчингүйд тооцох
✓ шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх хэмжээ	✓ эцэг, эх хүүхдийн эрхийн харилцаа
✓ хязгаар	✓ хүүхэд үрчлэх
✓ шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх татгалзах	✓ асран хамгаалах, харгалзан дэмжих
✓ шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай хүсэлт гаргах	
✓ хүсэлтэд хэсэгдэх бичиг баримт	
Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улстай байгуулсан эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээ нь харьцангуй тодорхой, өөрөөр хэлбэл иргэний хэргээс гэр бүлийн эрх зүйн харилцааг тусад нь хэсэг болгон зохицуулсан байна. БНХАУ-тай байгуулсан эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээ нь гэр бүлийн эрх зүйн харилцааг нэриэмчлэн зохицуулаагүй гэж хэлж болохоор байна. Тиймээс уг гэрээнд гэр бүлийн эрх зүйн харилцааг нэриэмчлэн зохицуулах шаардлагатай байна.	

Хүснэгт-3

№	Он	Нийт шийдвэрлэсэн иргэний хэрэг	Нийт шийдвэрлэсэн гэр бүлийн маргаан	Гэрлэлт цуцлалт	Эцэг, эх байх эрх хасах	Хүүхдийн тэтгэлэг гаргуулах	Тэтгэлэг тогтоосон хүүхдийн тоо
1	1993	14864	2782				
2	1994	15734	2101				
3	1995	18939	1996				
4	1996	26437	2504				
5	1997	26936	2410				
6	1998	28107	2485	1637	1		1427
7	1999	28039	2191	1425	9		709
8	2000	21717	2192	1517	8		899
9	2001	23252	2412	1657	7		1371
10	2002	24100	2630	1799	2		1089
11	2003	23407	2777	1890	3	423	1556
12	2004	23290	2939	2004	3	442	1270
13	2005	24492	2955	2094	3	397	1437
14	2006	27469	2989	2237	12	342	1308
15	2007	30659	3544	1323	4	189	736
				III улирал	III улирал	III улирал	III улирал
Нийт		357482	38907	17583	56	1793	11802

Үүний 8 маргаан нь гэрлэлт цуцлуулахтай холбоотой маргаантай хамтатган хамтран өмчлөх дундын эд хөрөнгийн өөрт оногдох хэсгийг гаргуулахаар нэхэмжлэлийн шаардлага гаргасан байна.

Шүүхээс гэр бүлийн холбогдолтой хэрэг маргааныг шийдвэрлэхдээ зохигчийг эвлэрэх талаар хугацаа заах урьдчилсан арга хэмжээг дийлэнх тохиолдолд авсан байх боловч гэрлэгчдийн хамтран өмчлөх дундын эд

хөрөнгийг өмчлөх эрхийг шилжүүлэх, худалдах, бэлэглэх, захиран зарцуулахыг хориглосон арга хэмжээ авсан тохиолдолд байхгүй байгаа нь талууд, талуудын эрх, ашиг сонирхлыг ханган оролцож байгаа өмчлөгч, төлөөлөгч хүсэлт гаргахгүй байгаатай холбоотой байна гэж дүгнэж болох юм.

Анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн 400 шийдвэр байгаа бөгөөд үүний 215 буюу 53.75 хувь нь хүүхдийн тэтгэлэг тогтоогдсон, 47 буюу 11.75 хувь нь хүүхдийг эцгийнх

нь асрамжид үлдээсэн, 355 буюу 88.75 хувь нь хүүхдийг эхийнх нь асрамжид үлдээсэн, 31 буюу 7.75 хувь нь гэрлэлт цуцлуулахтай хамт хамтран өмчлөх дундын эд хөрөнгийн маргааныг шийдвэрлэсэн шийдвэр байна.

Гэр бүлийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д заасны дагуу "Хүүхэд гэр бүлийн дотор тэгш эрх эдэлнэ" гэж заасны дагуу анхан шатны шүүхээр гэрлэлт цуцлуулахад хамтад нь гэр бүлийн хамтран өмчлөх эд хөрөнгийг цугт нь шийдвэрлэсэн байгаа бөгөөд үүний 25 шийдвэрээр маргаантай эд хөрөнгийг эцэг, эх, хүүхдэд тэнцүү хуваасан энэ заалт бодитой хэрэгжиг байгаагийн илрэл юм.

Нийт гэрлэлт цуцлалтай холбоотой маргааны хүүхдийн насны байдлыг харгалзан үзвэл 305 буюу 36.5 хувь нь 1-3 насны буюу бага насны хүүхдэдтэй байна.

2007 онд зарим дүүргийн шүүхээр шийдвэрлэсэн гэр бүлийн маргаанд гэрлэгчид эд хөрөнгийн гэрээ байгуулсан байгаа нь гэрлэгчдийн дунд эд хөрөнгийн гэрээ ямар ач холбогдолтой болохыг анхаарч буй нэгэн илрэл юм.

Давж заалдах шатны шүүхийн 17 магадлалын 9 магадлал буюу 53 хувь нь гэрлэлт цуцлуулахтай хамт хамтран өмчлөх дундын эд хөрөнгө хуваахыг хүүссэн маргаантай асуудал байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль батлагдан гарснаас хойш хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах арга хэмжээ нийт 30 хүнд авсан бөгөөд үүний 5 буюу 16.6 хувьд нь хамтран өмчлөх дундын эд хөрөнгө эзэмших, ашиглах, захиран зарцуулахыг хориглосон байна.

Иргэний хуулийн 129 дүгээр зүйлийн 129.3-д "Гэрлэлт цуцлуулсан буюу гэрлэлтийг хүчингүйд тооцсоноос гэр бүлийн гишүүнд ногдох эд хөрөнгийн хэсгийг тодорхойлохдоо гэрлэгчдийн эрүүл мэндийн байдал, хүүхдийн ашиг сонирхлыг харгалзан шүүх өөрөөр тогтоож болно", мөн тус хуулийн 129.4-д "... гэр бүлийн гишүүнд

ногдох эд хөрөнгийн хэсгийг тодорхойлохдоо" гэр бүлийн хамтран өмчлөх эд хөрөнгө бий болгоход оруулсан хөдөлмөрийн оролцоог харгалзан багасгах, эсхүл олгохгүй байхаар шүүх тогтоож болно" гэж заасан ч хуваарилалтын ямар үндэслэлээр шийдвэрлэж байгаа нь тодорхой бус байна.

Дүгнэлт

1. Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.11-д "Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална" гэж заасан. 2003 онд Улсын Их Хурлын 16 дугаар тогтоолоор Монгол Улсын төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлогыг баталсан. Уг бодлого нь гэр бүлийн хөгжлийн 10-15 жилийн хэтийн чиглэлийг тодорхойлох үндсэн баримт бичиг юм. Уг баримт бичгийн гол зорилго нь гэр бүлийн амьдралын түвшинг тасралтгүй дээшлүүлж, гэр бүлийн харилцаа, ёс зүйн эрүүл орчин, түүний нийгмийн өмнө хүлээсэн үүрэгз биелүүлэх таатай нөхцөлийг бүрдүүлэх замаар монгол хүний хөгжлийг дэмжихэд чиглэснээр ач холбогдолтой.

Гэр бүлийн маргааныг гэр бүлийн асуудлаар мэргэшсэн шүүгч шийдвэрлэдэг болох, гэр бүлийн гишүүдийн эрхийг зөрчих, дарамт шахалт үзүүлэх, хүчирхийлэх явдалтай тэмцэх эрх зүйн орчинг боловсронгуй болгох арга хэмжээнүүдийг шат дараалан чанартай гүйцэтгэснээр уг бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд гэр бүлийн эрх зүйн орчинг боловсронгуй болгоно. Эрх зүйн орчин боловсронгуй болсноор шүүхээр шийдвэрлүүлж буй Гэр бүлийн тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар шийдвэрлүүлэх маргааны тоо буурах давуу талтай юм. Мөн гэр бүлийн асуудлаар мэргэшсэн шүүгч гэр бүлийн маргааныг шийдвэрлэдэг болох нь бие даасан гэр бүлийн маргааныг шийдвэрлэх дагнасан шүүх байгуулах урьдач нөхцөлийг бүрдүүлж байгаагаараа практик ач холбогдолтой юм.

2. Нийслэлийн 7 дүүргийн шүүгч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нартай Гэр бүлийн хуулийн хэрэглэхэд гарч буй бэрхшээл, зөрчил хийдлийн талаар уулзаж ярилцахад "гэр бүлийн дагнасан шүүх"-ийг байгуулах нь зүйтэй гэсэн саналууд их гарч байсан. Дэвшүүлж буй санал энэ зүйлд чиглэгдэж байгаа юм. Учир нь 2007 онд шийдвэрлэсэн нийт хэргийн 11.6 хувь нь гэр бүлийн харилцаатай холбоотой маргаан эзэлж байгаа нь өмнөх оноос 18.6 хувиар өссөн байгаа нь жил бүр гэр бүлийн харилцаатай холбоотой маргаан өсөн нэмэгдэж байгааг харуулж байна. Үндсэн хуулийн 48 дугаар зүйлийн 48.1-т "... эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр шүүхийг дагнан байгуулж болно" гэж заасны дагуу гэр бүлийн дагнасан шүүхийг байгуулах хэрэгцээ, шаардлага аль хэдийнээ бий болсон байна.

3. ХЗДХЯ-ны дэргэд эсвэл төрийн бус байгууллагын статустай "Гэр бүлийн маргааныг эвлэрүүлэн зуучлах байгууллага"-ыг байгуулж "Төрөөс гэр бүлийн хөгжлийг талаар баримтлах бодлого"-д заасан арга хэмжээ, сургалт, таниулах ажлыг цогцоор нь хэрэгжүүлэх чиглэлтэй байхаар зохион байгуулах.

4. Иргэний хуулийн 125 дугаар зүйлийн 125.1 дэх хэсэгт "Гэр бүлийн хөрөнгө нь гэрлэгчдийн, гэр бүлийн бусад гишүүдийн хөрөнгөөс бүрдэнэ" гэж заасан. Гэтэл энд гэр бүлийн бусад гишүүн гэдэгт хэн орох ёстой вэ? гэсэн асуулт гарч байна. Өөрөөр хэлбэл, гэр бүлийн бусад гишүүн гэдэгт ийм этгээдүүд орно гэж Иргэний хууль хийгээд Гэр бүлийн тухай хуульд заагаагүй. Гэр бүлийн

тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтад гэр бүлийн гишүүн гэдгийг тодорхойлж өгснөөс бус гэр бүлийн бусад гишүүн гэсэн томъёоллыг оруулаагүй. Иймд гэр бүлийн гишүүн, гэр бүлийн бусад гишүүн гэдэг ойлголтууд нь ижил ойлголт мөн эсэх, хэрэв тийм бол тэдгээрийг хууль тогтоомжид нэг нэр томъёогоор оруулж жигдрүүлэх нь зүйтэй. Хэрэв ялгаатай бол тэд гэр бүлийн эрх зүйн эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус харилцаанд чухам ямар эрх эдэлж, үүрэг хүлээх талаар нарийвчлан заах нь чухал.

5. Монгол Улс гадаадын 9 улстай иргэн, гэр бүлийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулсан боловч ихэнх гэрээ нь иргэний ерөнхий заалтыг тусгасан нь учир дутагдалтай байна. Тиймээс Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улстай байгуулсан эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээний дагуу бусад улстай байгуулсан иргэний болон гэр бүлийн хэргийн талаархи гэрээг нарийвчлан зохицуулах.

6. Япон Улсын Иргэний хуульд заасны дагуу эмэгтэйчүүдийн хувьд өмнөх гэрлэлтээ цуцлуулснаас хойш 6 сарын дотор дахин гэрлэхгүй байх нөхцөлийг Гэр бүлийн тухай хуульд оруулж өгөх. Тухайн заалтын ач холбогдол нь өмнөх нөхрөөсөө гэрлэлтээ цуцлуулахдаа тухайн эмэгтэй жирэмсэн байгаад түүнийгээ мэдээгүй тохиолдолд түүний эд хөрөнгийн ба эд хөрөнгийн бус эрх, ашиг сонирхлыг хамгаалах юм.

Үүнтэй уялдуулж гэрлэлтийн гэрээг гэрлэлт цуцласнаас хойш 6 сарын дотор цуцлахгүй байх гэсэн заалтыг нарийн тусгаж өгөх.



ХАМТРАН АМЬДРАГЧИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН АСУУДАЛ

Манай улс 1990 оноос хойш нийгмийн тогтолцооны шинэчлэл хийж, Үндсэн хуулиараа улс орныхоо тусгаар тогнол, бүрэн эрхэт байдлыг бататган бэхжүүлж, хүний эрх, эрх чөлөө, үндэсний эв нэгдлийг эрхэмлэн дээдлэж, хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж, эх орондоо хүмүүнлэг иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх эрхэм зорилго дэвшүүлсэнтэй холбоотойгоор нийгмийн бүх салбарын харилцааг зохицуулах эрх зүйн хэм хэмжээг шинэчлэн батлах хэрэгцээ, шаардлага зайлшгүй тулгарсан билээ.


Тиймээс 1973 онд Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн 159 тоот зарлигаар батлагдсан БНМАУ-ын гэр бүлийн тухай хуулийг 1999 онд буюу 25 жилийн дараа шинэчлэн баталсан. Энэ хуулийг өмнөх хуулиудтай харьцуулахад гэр бүлийн харилцааг харьцангуй өргөн хүрээнд, нарийвчлан зохицуулсан нь онцлогтой хэдий ч орчин үеийн хүмүүсийн амьдралын хэв маяг, гэр бүлд хандах хандлага зэрэг олон зүйлээс шалтгаалан зарим нэг зохицуулалтыг эргэн харах цаг болсон гэдэг нь бодит амьдралаас ажиглагдах боллоо.

1999 оны гэр бүлийн тухай хуулийн 3 дугаар зүйлд гэр бүлийн эрх зүйн гол нэр томёонуудыг тайлбарласан байна. Тухайлбал:

3 дугаар зүйлийн 3.1.2-т "гэр бүл" гэж гэрлэлтийн үр дүнд бий болсон, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус үүргээр холбогдсон хамтын амьдрал бүхий гэр бүлийн гишүүдийг ойлгоно гэж тодорхойлсон байна. Энэ тодорхойлолтоос:

1. Гэр бүлд гэрлэлтийн үр дүнд бий болсон гишүүд байх,

2. Гэр бүлийн гишүүд эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус



МУБИС-ийн Туух, нийгмийн ухааны сургуулийн Философи, дидактикийн тэнхимийн эрх зүйн тэнхимийн багш Э.Чулуунцэцэг

эрх үүргээр холбогдсон байх;

3. Гэр бүлийн гишүүд нь хамт амьдрах гэсэн зайлшгүй онцлог шинжүүдийг тодруулж болох юм.

Хуулийн тус зүйлд:

"гэрлэлт" гэж энэ хуулиар тогтоосон насанд хүрсэн эмэгтэй, эрэгтэй хоёр сайн дурын, чөлөөтэй, тэгш эрхийн үндсэн дээр гэр бүл болох зорилгоор хуульд заасны дагуу төрийн эрх бүхий байгууллагад бүртхүүлэхийг;

"Гэр бүлийн гишүүн" гэж гэрлэгчид, тэдэнтэй хамт амьдарч байгаа төрсөн, дагавар, үрчлэн авсан хүүхэд, болон төрөл, садангийн хүнийг" гэж тодорхойлсон¹.

Эндээс гэрлэлтийг заавал төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлснээр хүлээн зөвшөөрөгдөнө, гэр бүл бол заавал гэрлэлтийн үр дүнд бий болно, гэр бүлийн гишүүд гэдэг нь заавал гэрлэгчид буюу хамтын амьдралаа эрх бүхий байгууллагад мэдээлсэн субъектуудтай хамт амьдарч байгаа хүүхэд, садан, төрөлийн хүн байна гэж дүгнэж болно.

Гэтэл "амьдрал дээр хэн нэгэнтэй гэрлэж байгаагүй ганц бие хүмүүс, өрх толгойлсон эцэг эхтэйгээ амьдарч байгаа хүүхэд, гэрлэж

байгаагүй хүмүүст үрчлэгдсэн, төрүүлсэн хүүхдүүд хамт амьдарч, хамтын аж ахуйгаа хөтөлж бие биенээ тэжээн тэтгэх явдал цөөнгүй байдаг.²

Манай гэр бүлийн эрх зүйн зохицуулалтаар бол эдгээр хүмүүсийг гэр бүл гэж үзэх үндэслэлгүй, эрх зүйн зохицуулалтын гадна үлдэх болж байна

Мөн сүүлийн үед хүмүүс гэрлэлтээ бүртгүүлэхгүйгээр хамтран амьдрах нь цөөнгүй болсон байна. Эдгээр хүмүүс нь хувийн янз бүрийн шалтгааны улмаас гэрлэлтээ бүртгүүлдэггүй. Тухайлбал, бие биеэ таньж мэдэх, гэр бүл болоход бэлэн бус, хариуцлагаас зайлсхийх, эсвэл гэрлэлтийн талаар буруу ойлголтой гэсэн олон шалтгаан дурьдаж болох юм. Хэдийгээр хамтын амьдралаа эрх бүхий байгууллагад мэдэгдээгүй боловч тэдгээр хүмүүс нэг гэрт амьдарч, бие биеэ дэмжин туслаж, хүүхэд төрүүлж, харилцан бие биенээ тэжээн тэтгэж, эдийн засгийн хувьд хоорондоо холбоотой, гэр бүлийн нэгэн адил хамтын амьдрал бүхий хүмүүсийн нэгдэл гэж ойлгож болно.

Гэтэл эдгээр хүмүүсийг хамтын амьдралаа төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлээгүй гэсэн үндэслэлээр хуульд заасны дагуу гэр бүл гэж үзэх үндэслэлгүй, гэр бүлийн эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдахгүй, түүний гадна орших нийгмийн нэг төрлийн харилцаа болдог. Энэ тохиолдолд тухайн хүмүүсийн эрх, ашиг сонирхолд нөлөөлөх олон сөрөг үр дагавар үүсэх боломжтой. Тухайлбал:

- Гэр бүлийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1-д заасан гэрлэгчид бие биенээ тэжээн тэтгэх үүрэг нь хамтран амьдрагчдын хувьд үүсэхгүй;

- Гэр бүлийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1-д заасан

¹ "Гэр бүлийн тухай хууль" "Төрийн мэдээлэл" сэтгүүл УБ, 1999 он №30, 3.1.1, 3.1.3

² А.Дугармаа "Монгол Улсын гэр бүлийн эрх зүй" УБ, 2004 он, 33 дахь тал.

гэрлэлтийн харилцаа дуусгавар болсон ч шаардлагатай тохиолдолд хэн нэгээрээ тэжээн тэтгүүлэх эрхийг хамтран амьдрагч эдлэхгүй;

- Хамтран амьдрагчид хамтын амьдралаа дуусгавар болгох тохиолдолд гэр бүлийн тухай хуульд заасан гэрлэлт дуусгавар болгох журмын дагуу эрх бүхий байгууллагад хандаж, өгөгдөл, нэхэмжлэл гаргах үндэслэлгүй;

- Хамтран амьдрагчдын хэн нэг нь нас барахад иргэний хуульд зааснаар өвлөх эрхээ алдах зэрэг хамтын амьдралын явцад бий болсон эд хөрөнгийг гэр бүлийн эд хөрөнгийн адил үзэж, зохицуулах боломжгүй юм.

Манайд өнөөдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн хүрээнд энэ асуудлыг хэрхэн зохицуулах боломжтой эсэх талаар авч үзвэл хамтран амьдрагчдын эд хөрөнгийн харилцааг иргэний хуулийн 108 дугаар зүйлд зааснаар дундын өмчийн зохицуулалтаар зохицуулах боломжтой, мөн тухайн субъектүүд өөрсдөө харилцан тохиролцож гэрээ байгуулах боломжтой.

Хамтран амьдрагчид хүүхэдтэй болсон тохиолдолд гэр бүлийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5-д зааснаар "Гэрлэлтээ бүртгүүлээгүй хүмүүсийн дундаас төрсөн хүүхэд гэрлэлтээ бүртгүүлсэн гэр бүлээс төрсөн хүүхдийн нэгэн адил эрх эдэлж, үүрэг хүлээнэ" гэсний дагуу хүүхдээ тэжээн тэтгэх үүрэг, хүүхдээрээ тэжээн тэтгүүлэх эрх нь гэр бүлийн гишүүдийн нэгэн адил байна.

- Харин гэр бүлийн эрх зүйн нэг чухал эх сурвалж болох 2004 оны 05 дугаар сарын 13-ны өдөр батлагдсан, 2005 оны 01 дүгээр сарын 01-ний өдөрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа "Гэр бүлийн хүчирхийллийн тухай" хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д зааснаар "энэ хуулийн зохицуулалтад гэрлэлтээ төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлээгүй боловч хамтын амьдралтай байгаа

хүмүүс, түүнчлэн гэр бүлийн тухай хуульд заасны дагуу хүүхдийг гэр бүлдээ авч асран хүмүүжүүлсний, эсхүл, асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоосны үр дүнд тухайн иргэний асрамжинд байгаа этгээд нэгэн адил хамаарна"³ гэснээс хамтран амьдрагчид бие биенээ хүчирхийлсэн тохиолдолд хариуцлага хүлээлгэх эрх зүйн үндэслэлийг тогтоож өгсөн нь хамтран амьдрагчдын эрх ашгийг хамгаалсан ихээхэн ач холбогдолтой эрх зүйн зохицуулалт болсон байна.

Гадаадын зарим улс орны гэр бүлийн эрх зүйн хэм хэмжээг судалж үзвэл "гэр бүл" гэсэн ойлголтыг тодорхойлдог хамгийн гол шалгуур нь хуульд заасан насанд хүрсэн гэрлэхийг хүсэгчид тэгш эрх, сайн дурын үндсэн дээр гэрлэлтээ албан ёсоор зохих байгууллагад бүртгүүлсэн байх явдал юм. Зохих байгууллага гэдэгт шашны болон төрийн эрх бүхий байгууллагууд хамаарна. Монгол Улсын Иргэний бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д зааснаар "гэрлэхийг хүсэгчид хэн нэгнийхээ эсвэл хамтран оршин суугаа газрынхаа сум, дүүргийн засаг даргын тамхы газарт гэрлэлтээ бүртгүүлнэ" гэсний дагуу төрийн байгууллагад бүртгүүлэх эрх зүйн зохицуулалттай.

Франц, Швейцарь, Бельги зэрэг оронд мөн адил төрийн байгууллага нь гэрлэлтийг бүртгэдэг бол Андорра, Израли, Лихтенштейнд зөвхөн шашны дэг, жаягийн дагуу сумийн гэрлэлтийг хүлээн зөвшөөрдөг байна, харин Англи, Австрали, Скандиновын орнуудад сум, төрийн байгууллагын аль алинд нь бүртгүүлсэн гэрлэлт хүлээн зөвшөөрөгддөг байна.⁴

Зарим нэг улс орон тухайн асуудалд хууль зүйн үүднээс хэрхэн хандаж байгааг авч үзвэл 1995 онд батлагдсан ОХУ-ын гэр бүлийн тухай хуульд зааснаар иргэний гэр бүлийн бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн гэрлэлтийг хүлээн зөвшөөрнө гэж тусгасан байдаг. Мөн адил хамтран

амьдрагчдын асуудлыг гэр бүлийн эрх зүйн гадна үлдээсэн нь энэ томоёоноос зайлсхийсэн гэж дүгнэж болохоор байна.

"ОХУ-ын зарим эрдэмтэн судлаач үзэж байгаагаар бол гэрлэлтээ бүртгүүлээгүй, хамтран амьдрагчдын харилцаанд эрх зүйн зохицуулалт хийх нь эдгээр этгээдийн хувийн амьдралд бүдүүлгээр оролцож байгаа хэрэг бөгөөд тэд өөрийн эрх ашгийг хамгаалах эрмэлзэлгүй байна. Тиймээс эрх зүйн зохицуулалт шаардлаггүй гэж тайлбарласан байна. Харин зарим судлаач, жишээлбэл, С.И.Ретов "Гэр бүлээ бүртгүүлэх нь мэдээж нийгмийн байр суурины үүднээс чухал асуудал, гэхдээ хууль ёсоор бүртгүүлээгүй гэрлэлт нь эрх зүйн зохицуулалтын гадна оршихгүй", М.В.Антокольская "бүртгүүлээгүй гэрлэлт нь ямарч муу үр дагаваргүй, тиймээс хамтран амьдрагчдын харилцааг гэр бүлийн эрх зүйн нэг институт байдлаар тусад нь зохицуулах шаардлагатай"⁵ гэх зэргээр энэ асуудалд хоёр өөр байр сууринаас хандаж тайлбарлаж байна.

"ХБНГУ-ын хувьд хамтран амьдрагчдын хоорондын харилцааг иргэний хууль, иргэний процессийн хууль, даатгалын хуулиар зохицуулах боломжтой бөгөөд зохицуулдаг боловч хамтран амьдрах гэрээгээр зохицуулах нь хуульчдын анхаарлыг зүй ёсоор татаж байгаа асуудлын нэг юм. Энэ гэрээнд тавигдах шаардлага нь нийтийн ёс суртахууны болоод зан суртахууны хэм хэмжээнд харшлахгүй байх, гэрээний хэлбэрийн хувьд амаар, бичгээр, бодит үйлдлээр аль ч хэлбэртэй байж болно. ХБНГУ-д хамтран амьдрагчид харилцан тохиролцож гэрээ байгуулах нь хүлээн зөвшөөрөгдсөн асуудал болсон байна. Гэрээний нөхцөл нь орон сууц, тэжээн тэтгэх, ахуй хөтлөх, эд хөрөнгийн талаар тусгаж болно гэсэн эрх зүйн зохицуулалттай.⁶

Өнөөдрийн байдлаар хамтран амьдрах хэв маяг өндөр хөгжсөн улсад Америк, Солонгос тооцогдох болсон. Тэдгээр улсуудын гэр бүлийн тухай хуульд үр асуудлыг

¹ Гэр бүлийн хүчирхийллийн тухай" хууль "Төрийн мэдээлэл" сэтгүүл, УБ, 2004 он

² Рос Газета 2008 ноябрь, с.4

³ Начаева А.М. "Семейное право" 1998, с.95.

⁴ МУИС-ийн ХЗС-ийн "Судалгааны илтгэлийн эмхтгэл", УБ, 2006 он. Б.Тэмүүлэн

"Хамтран амьдрагчдын эрх зүйн зохицуулалт", (ХБНГУ-ын жишээ), 38 дахь тал.

тусгасан байдаг, мөн хамтран амьдрагчид нь хэн хэнийгээ эрх, ашиг сонирхолд нийцүүлэн харилцан тохиролцож гэрээ байгуулах замаар тухайн харилцааг зохицуулдаг байна.

Эрт дээр үеэс Монголчууд төдийгүй дэлхий нийтээрээ гэр бүлийн тухай асуудалд ихээхэн ач холбогдол өгч судалж ирсэн түүхтэй. Гэсэн хэдий ч "гэр бүл, гэрлэлтийн талаар нийтлэг нэг тодорхойлолт байдаггүй"⁷. Тиймээс гэр бүлийг тодорхойлохын тулд түүний олон тодорхойлолтыг авч үзэх нь зүйтэй бөгөөд өөрийн улс орны соёл, уламжлалыг анхаарч үзвэл зохилтой. Өөрөөр хэлбэл, энэ асуудалд хандах хандлага нь улс орон бүрийн соёлын байдлаас шалтгаалан харилцан адилгүй байдаг.

Хэдийгээр улс орон соёлын нөхцөл байдлаа дагаад гэрлэлтийг хүмүүс харилцан адилгүй ойлгож байгаа ч аливаа зүйл цаг үеэ дагаад тодорхой хэмжээгээр хувьсан өөрчлөгдөж байдгийг анхаарах нь зүйтэй юм.

"Гэр бүл хэмээх нэр томъёоны тухайд авч үзвэл Монголчуудын хувьд нэлээд эртнээс уламжилж нэрлэгдсэн "гэрийн өрх" хэмээх үгнээс гаралтай бөгөөд "Өрүх гэр" гэж нэрлэж, тухайн нийгмийн ёс заншил, хууль зүйтэй уялдан өрх толгойлох, өрхийн данс, өрх тусгаарлах зэрэг өв өвлөх, өмч хөрөнгөтөй холбоотой ухагдахуун юм.⁸ 17-19 дүгээр зууны үеийн архивын данс, данс хэрэглэгдэхүүнийг судалсан эрдэмтдийн бүтээлээс үзвэл "өрх гэр" бус "өрх ам" "өрх" "өрх хүн" гэсэн байна.⁹ Манайд 20 дугаар зуунаас эхлэн гэр бүл хэмээх нэр томъёог хэрэглэх болсон байна. Оросоор "семья", англиар "family", латинаар "familia" гэдгийг шууд "гэр бүл" гээд орчуулахад Монгол айлын онцлогт тэр бүр тохирохгүй байна гэж дүгнэмээр байна. Харин өрх юм уу

ам бүл гэвэл илүү дөхөмтөй.

Дорно дахины тэр дундаа монголчуудын ойлголтоор их гэр, бага гэр гэсэн хоёр ойлголт байдаг.

"Их гэр гэдгийг өвөг эцэг, эмэг эх, эцэг, эхтэйгээ үр хөвгүүд ач, жич, гуч нь нэгэн гэрт амьдрахыг ойлгодог байна. Харин их гэрээс салбарлан гарсан өрхийг бага гэр гэдэг"¹⁰. Эндээс үзвэл энэ уламжлалын дагуу манай хуулийн тодорхойлолтыг ойлгож, тодорхойлсон ч байж болох талтай.

Тэгэхээр юуны өмнө бид гэр бүл гэсэн тодорхойлолтыг гэр бүлийн тухай хуулиараа оновчтой зөв тодорхойлох хэрэгтэй байна. "Гэр бүл" хэмээх ойлголтыг судлаачид хууль зүйн болоод социологийн талаас нь их олон янзаар тодорхойлодог.

"Орчин үед хууль зүйн талаас нь гэрлэлтийг тодорхойлохдоо "насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй нийгэм, эдийн засаг болон хүйсийн хувьд харилцан хоорондоо холбогдож, нийгэм, хууль зүй, сэтгэл санааны хувьд харилцан бие биенийхээ өмнө хариуцлага хүлээхийг хэлнэ"¹¹ гэсэн тодорхойлолтыг чухалчлан авч үзэж байна.

Гэрлэгчид бүртгүүлсэн тохилдолд гэр бүл болно гэсэн шалгуурыг үгүйсгэх нь зүйтэй гэсэн санааг дэвшүүлж байна.

Мөн хамтын амьдрал ба гэрлэлт нь хүмүүс хоорондын харилцаа болон гүйцэтгэх үүрэг хариуцлагынхаа хувьд харилцан адил төстөй боловч тухайн улс орныхоо соёл, уламжлалаа дагаад хууль ёсны ба хуулиас гадур ойлголт болдог байна. Гэрлэлт, хамтын амьдралын аль нэгийг хувь хүн өөрөө чөлөөтөй сонгох боломжтой байх ёстой.

"Хамтран амьдрагчид" гэдэг нь нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн, гэр бүлээс гадна хүмүүсийн тогтвортой амьдрах нэгдэл, эрх эдлэж, үүрэг хүлээж, гарах үр дагаварыг хариуцах чадвартай гэр бүлийн

байгууламжийн нэг хэлбэр юм гэж тодорхойлж болно.

Иймээс эдгээр хүмүүсийн эрх, ашиг сонирхолыг хамгаалах болон тухайн харилцааг боловсронгуй болгох үүднээс тусгайлан зохицуулсан эрх зүйн зохицуулалт зайлшгүй шаардлагатай байна.

ОХУ-ын эрдэмтэн М. В. Антокольскаягийн бүртгүүлээгүй гэрлэлт нь ямар ч муу үр дагаваргүй, тиймээс хамтран амьдрагчдын харилцааг гэр бүлийн эрх зүйн нэг институт байдлаар тусад нь зохицуулах шаардлагатай гэсэн санааг дэмжиж байна.

Эрэгтэй, эмэгтэй хүмүүс хамтран амьдрахыг гэр бүлийн байгууламжийн нэг хэлбэр гэж үзээд гэр бүлийн эрх зүйн нэг институт байдлаар тодорхойлох боломжтой.

Мөн гэр бүлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д зааснаар гэр бүлийн эд хөрөнгийн харилцааг иргэний хуулиар зохицуулдаг. Үүнтэй адилаар гэр бүлийн эрх зүйн нэг институт болох хамтран амьдрагчдын эд хөрөнгийн харилцааг иргэний хуулиар зохицуулаж болохоос гадна тус хуульд хамтран амьдрах гэрээний нарийвчилсан зохицуулалт хийх нь зүйтэй болов уу.

Хамтран амьдрагчид нь харилцан бие биенийхээ өмнө эрх эдлэж, үүрэг хүлээж, түүнээс үүдэн гарах үр дагаварыг хариуцвал зохистой. Тэдгээр хүмүүс амьдралын энэ хэв маягийг сонгосноор амьдралдаа алдаа гаргахгүйг эрмэлзэж байгаа хэдий ч гэрлэсний дараах хариуцлагаас зайлшгүй боломжийг эрэлхийлж байгааг үгүйсгэх аргагүй юм. Тиймээс энэ тал дээр анхаарч үзэх хэрэгтэй байна.

Ингэснээр бодит амьдрал дээр болоод, иргэдийн эрх зүйн байдал мөн хууль тогтоомжийн хэрэгжилтийн хувьд ч ихээхэн ач холбогдолтой гэдгийг давхар тэмдэглэмээр байна.



⁷ Т. Намжил. "Монгол гэр бүлийн сурган хүмүүжүүлэх зүй". УБ., 2007 он. 145 дахь тал.

⁸ "Монголын соёлын түүх" тэргүүн боть. УБ., 1999 он. 239 дэх тал.

⁹ "Гэр бүлийн хүчийг илэрлээс урьдчилан сэргийлэх арга зам". УБ., 2003 он. 10 дахь тал.

¹⁰ Т. Намжил. "Монгол гэр бүлийн сурган хүмүүжүүлэх зүй". УБ., 2007 он. 38 дахь тал.

¹¹ Т. Намжил. "Монгол гэр бүлийн сурган хүмүүжүүлэх зүй". УБ., 2007 он. 38 дахь тал.

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ

Хүн оюун ухаантай, сэтгэг боддог, аливаа нийгэмд болж буй үйл явдлыг өөрийнхөөрөө тунгааж түүнд үнэлэлт дүгнэлт өгч, үзэл бодлоо илэрхийлдэгээрээ адгуус амьтнаас ялгаатай билээ. Тэгвэл хүнийг амьтнаас ялгаж өгч байгаа энэхүү гол чанараа илэрхийлэх нэг хэлбэр нь хэвлэл мэдээллийн эрх чөлөө юм. Германы сэтгэгч Г.В. Герель "Эрх чөлөө бол дур зорго бус, хүн эрх чөлөөтэй байна гэдэг нь хийж байгаа зүйлийнхээ хүрээ хязгаар, зайлшгүй шинжийг ухамсарлах явдал" гэсэн байна.

Calamus fortior gladio буюу Үзэг бол илднээс хүчтэй гэдэг үгийг хүн бүр дээд зэргээр ухамсарлаж, аливаа мэдээ, мэдээлэл, нийтлэл бичихдээ байнга санаж явах хэрэгтэй. Учир нь хэвлэл мэдээллийн эрх чөлөө гэдэг бол хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, мэдээлэл хайх, хүлээн авах эрх гэх мэт хоорондоо нягт холбоотой бүлэг (хэсэг) эрх, эрх чөлөө юм. Тэгэхээр хэвлэл мэдээллийн эрх чөлөө гэдэг бол зөвхөн сэтгүүлчдэд хамаарах эрх, эрх чөлөө биш хүн бүрт олгогдсон боломж. Үг хэлэх эрх чөлөө нь төр засгаас хориглоно, яллана буруутгана гэх айдасгүйгээр хүн өөрийнхөө үзэл бодлыг чөлөөтэй илэрхийлэх эрхтэй байна гэсэн үг болохос бусад хүмүүс түүнд танхим, индэр, телевиз болон радио станци, хэвлэх машин тавьж өгнө гэсэн үг биш. Эрх чөлөө гэдэг бол зөвхөн хариуцлага хүлээх чадвартай хүмүүсийн эрүүл саруул зорилго¹ юм.

Францын хүний ба иргэний эрхийн тунхагийн 11 дүгээр зүйлд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг түүхэнд анх тунхагласан



Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Иргэн, эдийн засгийн эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ажилтан Б.Солонго

байдаг.² Түүнээс хойш Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 19 дүгээр зүйлд: "Хүн бүр өөрийн үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй, энэхүү эрхэд үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрх чөлөө, үзэл санаа, мэдээллийг улсын хилээр үл хязгаарлан аливаа арга замаар эрж сурвалжлах, хүлээж авах, түгээн дэлгэрүүлэх эрх чөлөө багтана" хэмээн баталгаажуулсан бол Иргэний ба улс төрийн эрхийн тухай Олон улсын пактын 19 дүгээр зүйлд: "1. Хүн бүр үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрхтэй; 2. Хүн бүр санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй, энэ эрхэд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар эсхүл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана; 3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт дурдсан эрхийг эдлэх нь онцгой үүрэг, хариуцлага оногдуулна. Тийм учраас түүнийг зарим талаар

хязгаарлаж болох боловч тэр нь заавал хуулиар тогтоогдсон байх ёстой бөгөөд дараахь шаардлагаас үүдэн гарсан байх ёстой:

а) бусдын эрх, нэр төрийг хүндэтгэх;

б) үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах.

НҮБ-аас 1946 оны хамгийн анхны чуулганаар баталсан 59 (I) тогтоолдоо: "Мэдээллийн эрх чөлөө бол хүний үндсэн эрх... бөгөөд НҮБ-ын эрхэм зорилго болсон бүх эрх чөлөөнүүдийн тулгын чулуу болдог" гэж энэ эрх чөлөөний ач холбогдлыг үнэлсэн бол Хүний эрхийн Европын шүүх танхим: "Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө нь (ардчилсан) нийгмийн амин чухал үндэс суурь бөгөөд түүний дэвшил хүн бүрийн хөгжлийн үндсэн нөхцөл болдог. Энэ нь зөвхөн зэрэгээр хүлээж авдаг буюу аядуу төлөв агуулгатай төдийгүй төр засаг болон хүн амын аль нэг хэсэг рүү давшилсан, чоцоосон, төвөг учруулсан "мэдээлэл" ба "үзэл санаа"-нд ч бас хамаатай. Ийм олон ургальч үзэл, бусдыг тэвчих чадвар, өргөн цар хүрээтэй сэтгэлгээ үгүйгээр ардчилсан нийгэм гэж байдаггүй" хэмээн заасан байна.

Иймд ардчилсан улс орнууд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх болон хэвлэл мэдээллийн эрх чөлөөг Үндсэн хууль хийгээд ердийн хуулиар хамгаалсан байдаг. Жишээ нь: Австрийн Үндсэн хуулийн 13 дугаар зүйлд "Хүн бүр өөрийн сонирхолоо дагах эрхтэй. Хэвлэл бол хяналтын юм уу зөвшөөрөл олгох алба биш, Финландын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлд "Финландын иргэн бүр үгээ

¹ Г.В. Герель. Философия права. М.1990. с.44-48.

² Милтон Фридман. "Хувь заяагаа сонгох нь". УБ., 2001 он.

³ Заулу судлаачдын үндэсний андугаар форумын Эрх зүйн салбарын судалгааны тайлан. 50 дахь тал.

⁴ Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх болон мэдээллийн эрх чөлөөнд нөлөөлж буй Монгол Улсын хуулиудад хийсэн эзлэн шинжилгээ. УБ., 2003 он. 14 дэх тал.

чөлөөтэй илэрхийлэх эрхтэй, мөн хэний ч урьдчилсан шалгалт хяналтгүйгээр бичгээр болон зургаар илэрхийлсэн материалыг хэвлүүлэн нийтлүүлэх эрхтэй. Францын 1958 оны Үндсэн хуульд "Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх нь хүний хамгийн үнэт эрх чөлөө мөн. Иймээс хүн бүр чөлөөтэй ярих, бичих, хэвлэх эрхтэй бөгөөд чингэхдээ энэхүү эрх чөлөөгөө буруугаар ашигласан бол тус хуульд заасан тохиолдлуудад хариуцлага хүлээх болно. Герман Улсын Үндсэн хуулийн 5(1) зүйлд: "Хүн бүр өөрийн үзэл бодлоо амаар, бичгийн болон дүрсийн хэлбэрээр илэрхийлэх, түгээх эрхтэй бөгөөд олон нийтийн хүртээл болгосон мэдээллийг ямар ч саадгүйгээр олж авах эрхтэй" гэж тус тус заажээ.

Манай улс "Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал"-ын үзэл санааг хүлээн зөвшөөрдөг бөгөөд 1974 онд "Иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон улсын Пакт", "Хүний эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай Олон улсын Пакт"-д нэгдэн орсон юм. Үүгээрээ Монгол Улс дээрх баримт бичгийн хүний эрх, мэдээллийн эрх чөлөөтэй холбоотой заалтыг дагаж мөрднө гэдгээ хүлээн зөвшөөрсөн байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн арванзургаадугаар зүйлийн 17-д "иргэд төр түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй" гэж зааснаас гадна иргэдийнхээ "Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал цуглаан хийх эрх чөлөөг" баталгаажуулсан.

Үндсэн хуульд заасан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрхийг баталгаажуулах зорилгоор 1998 онд "Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль" батлан гаргасан.

2000 онд УИХ-аас Хүний эрхийн үндэсний комиссийн тухай хууль

баталсан нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хангах хууль эвч баталгааг сайжруулахад чухал ач холбогдолтой болсон юм.

Монгол Улс Үндсэн хуулийнхаа арвядугаар зүйлийн 2-т "Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ", мөн зүйлийн "Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хвчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ" гэсэн нь Монгол Улсын хуулиудад тусгагдаагүй байгаа хэвлэл мэдээллийн эрх чөлөөний талаархи олон улсын гэрээний заалтууд нь манай улсын хуулийн хийдлийг нөхөх боломж болж байгаа хэдий ч шүүхийн практикт олон улсын гэрээний заалтыг үндэслэл болгон хэрэг шийдвэрлэх асуудал учир дутагдалтай байгаа юм.

Энэ мэтээр хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хууль зүйн хувьд баталгаажуулсан байдаг хэдий ч итгэл үнэмшилтэй байж, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх, хамгаалах гэдэг бол хүнд өөрт нь заяагдсан эрх болохоос хэн нэг өгөөмөр сэтгэлтний өглөг, тэр дундаа засаг төрийн олговор биш. Харин улс төрийн ардчилсан дэглэмийн нөхцөлд засаг төр нь уул эрхийг хүлээн зөвшөөрч хамгаалах, үүний тул элдэв хориг хязгаарлалтаас татгалзах үүрэг хүлээдэг нь ардчиллын алтан хууль мөн.⁶

Ардчилсан улс орнуудад төр, засгийн байгууллагын үйл ажиллагааны тухай мэдээлэл хуучмвт нээлттэй байх ёстой гэсэн зарчим баримталдаг хэдий ч өнөөдөр манай улсад төр засгийн байгууллагын үйл ажиллагааны мэдээлэл "Байгууллагын нууц" гэсэн нэрийн дор хаалттай хэвээрээ байна.

Мэдээллийг чөлөөтэй олж авах, хязгаарлалттай хүртэх гэсэн ардчиллын эрхний хоёр зарчмын үндэс үзэхд өнөөдөр манай улсад жирийн иргэд байтугай ард түмэнд

үнэн зөв мэдээлэл түгээх үүрэгтэй сэтгүүлчид ч хуссан мэдээллээ олж авах боломж хомс байна. Сэтгүүлчид хамгийн энгийн мэдээллийг хүртэл байгууллагын "хэвлэл мэдээлэл хариуцсан ажилтан"-ны өгсөн мэдээллээр, мэдээллийн хүрээнд хязгаарлалттай хүртэж байна.

Ийм учраас олон улсын туршлагад байдагчлан сэтгүүлчдийн хардах эрхийг хуулиар баталгаажуулж өгөх шаардлагатай байна. Төр засгийн байгууллага болон түүнд ажиллаж байгаа төсвийн мөнгөөр чалинждаг хэн боловч төр, байгууллага, хувь хүний нууц-тай нь холбоогүй аливаа мэдээллийг нууцлах ёсгүй бөгөөд тэр тусмаа байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг нууцлах ёсгүй юм. Гэтэл өнөөдөр "төрөх эмнэлэгт ямар өвчин, юунаас болж гарав, хэдэн хүүхэд өвдсөн? гэж мэт энгийн мэдээллийг хүртэл иргэд үнэн зөвөөр нь олж мэдэх эрхгүй болчихоод байна. Хэвлэл мэдээллийн эрх чөлөө "Байгууллагын нууц" нэрийн дор хэрхэн зөрчигдөж байгаагийн нэг илрэл нь энэ юм. "Байгууллагын нууцын тухай хууль" байгууллагын албан үйл ажиллагааны онцлогтой холбоотой... нууцыг" байгууллага өөрөө тогтооно" гэжээ.⁷ Энэ нь дарга захирал бүрт нууцлахгүй юмыг нууцлах боломж олгож, энэ чанараараа хэвлэл мэдээллийн ажилтан сэтгүүлчдээ мэдээлэлд нэвтрэх, олж авах түгээх эрхийг нь үндэслэл муутай хязгаарлаж буй хэрэг гэсэн дүгнэлтэд хүргэж байна. Мөн хуулийн 5 дугаар зүйлийн 2-т "Байгууллагын нууцыг мэргэжлийн үйл ажиллагааны дагуу... олж мэдсэн этгээд уул нууцыг чанд хадгалах үүрэгтэй". Хэрэв тэр энэ үүргээ зөрчиж, нууцыг нь "... задруулбал 20 000-50 000 төгрөгөөр торгоно". (9 дүгээр зүйл) гэжээ. Энэ заалтаас үзвэл сэтгүүлч аль нэг даргын тогтоосон нууцыг мэдчихээд

⁶ "Эрх зүйт төр". Залуу судлаачдын үндэсний анхдугаар Форум эрх зүйн салбарын судалгааны тайлан. УБ, 2005 он.

⁷ Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө. УБ, 2001 он. 8 дахь тал.

⁸ Байгууллагын нууцын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2, 4 дүгээр зүйлийн 2.

нийтэлчихвэл торгуулийг хүлээх болж байна.⁸

Төрийн албан хаагч ба улс төрийн намыг гүтгэх. Аль ч ардчилсан гэгдэх нийгэмд төрд алба хашигч шүүмжлэлээс ангид байх ёсгүй. Иймээс тэд эмзэг арьстай байх боломжгүй. Ихэнхи тохиолдолд тэдний үйл ажиллагааны талаархи мэдээлэл нь шүүмжилсэн эсвэл гүтгэсэн мэт харагдах боловч үнэн хэрэгтээ бага ч атугай үнэний хувьтай байдаг. Харамсалтай нь мэдээлэл бүрийг тодорхой фактаар нотлох боломж хомс. Ард түмэнд үнэнийг хүргэх гэсэн оролдлого эцэстээ гүтгэлэг нэр зүүх нь олонтаа. Энэ үүднээс АНУ, Англи, Өмнөд Африк, Энэтхэг зэрэг оронд төрийн байгууллага, нутгийн удирдах байгууллага, бусад төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллага өөрсдийнх нь үйл ажиллагааг гүтгэсэн хэмээн шүүхэд заргалдах эрхгүй байдаг байна.⁹

Манай орны хувьд хэдийгээр мэдээлэл хайх, олж авах, түгээх эрх нь Үндсэн хуулиараа баталгаажсан хэдий ч түүнийг хэрэгжүүлэх талаар хуульд тодорхой тусгагдаагүй, хэвлэл мэдээллийн эрх чөлөөг зөвхөн хуулиар хязгаарлах ёстой атал ямар нэг байгууллагын дарга "байгууллагын нууц"-ын жагсаалт гаргаж тушаалаараа баталгаажуулаад иргэдийн мэдээлэл авах эрхийг дүр мэдэн хязгаарлаж байна. Ингэж тушаал гаргаж "байгууллагын нууцын жагсаалт"-ыг батлах нь зөв хэдий ч байгууллагын нууцыг хуульд зааснаас илүү өргөтгөж, дарга өөрийн хийж буй үйлдэл бүрээ байгууллагын нууц гэж нууцлах нь буруу юм.

Энэ нь ялангуяа сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллага олон нийтийн өмнө "тэдний ашиг сонирхолд нийцсэн, үнэн зөв мэдээлэл түгээх"-ээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд хамгийн их саад бэрхшээл учруулж байгаа юм. Хүний

эрхийн тухай Олон улсын Пактуудад заасан шалгуураар нууцлах зүйлс улс орнуудад бий боловч түүнийг өргөсгөх нь албан ёсны бүх мэдээллийг нууц гэж үзэхэд хүргэдэг. Энэ нь эрх зүйн сөрөг үр дагавартай байх нь тодорхой. Сэтгүүлчид бусад иргэдийн адил мэдээлэлд нэвтрэх (олж авах) эрхтэй бөгөөд мэдээллийн эх сурвалжаа нууцлах нь сэтгүүлчийн онцгой бөгөөд цорын ганц эрх юм. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь олон нийтийн мэдээлэлд нэвтрэх (олж авах) эрхийг хангах, тэдний ашиг сонирхлыг дээдлэх талаар шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг билээ. Тиймээс мэдээллийн эх сурвалжийг нууцлах тал дээр: тухайн нийтэлж нэвтрүүлсэн мэдээлэл үнэн бодитой нь баталгдвал эх сурвалжийг илчлэх ёсгүй, нууцлах нь зөв. Харин мэдээлэл худал хуурмаг буюу ташаа гэж нотлогдвол сэтгүүлчид мэдээлэл өгсөн этгээд, сэтгүүлч хоёр хоёулаа хариуцлага хүлээх ёстой. Харин тухайн мэдээллийг нэхэмжлэгч этгээд өөрөө нотлох үүргтэй гэж хуульчилж өгөх нь зүйтэй.

Өнөөдөр манай улсад 139 сонин, сэтгүүл, 24 телевиз, 20 гаруй радио болон олон зуун вэб сайт ажиллаж байна.¹⁰ Хэвлэлийн эрх чөлөөний үр дүнд мэдээллийн орон зай ийнхүү тэлсэн нь зөрөг, сөрөг олон үр дагаварыг дагуулах болж хэвлэл мэдээллийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлагыг бий болгож байна.

Хэвлэл мэдээллийн байгууллага олон байсны ач холбогдол нь ард түмэн улс орныхоо үйл ажиллагааны тухай мэдээлэлтэй байвал төр засагтаа итгэх итгэл нь нэмэгдэнэ, нөгөө талаар төсвийн хөрөнгөөр санхүүждэг бүх албан тушаалтныг хянаж байх нь эргээд бид өөрсдийн халааснаас гарсан мөнгөө ямар зүйлд, хэрхэн зарцуулагдаж байгааг мэдэх ач холбогдолтой. Хэвлэл мэдээллийн хэрэгсэлийн тоо ийнхүү өссөөнөөр "мэдээлэл бол таваар мөн", "хэвлэл

бол бизнес мөн" гэдэг зах зээлийн жам ёсны болон өрсөлдөөний хууль үйлчлэх болов. Иймээс иргэд энэ олон хэвлэл мэдээллийн хэрэгслээс үнэн бодит мэдээлэл олж аван, мэдээлэлдээ хэр итгэл үнэмшилтэй хандаж байна өз гэдгийг судлахаар Монголын хэвлэлийн хүрээлэнгээс 2009 онд "Монголын хэвлэл мэдээллийн талаархи олон нийтийн үнэлэмж" нэртэй судалгаа хийсэн ба судалгааны үр дүнд иргэдийн хэвлэлийн эрх чөлөөний талаархи ойлголт сайжирсан байгаа хэдий ч "хэвлэлийн эрх чөлөө бүрэн хэрэгжиж байна" гэсэн үзүүлэлт 2 дахин буурч, "хэрэгжихгүй байна" гэсэн үзүүлэлт 5 дахин өсжээ.¹¹ 2004 онд явуулсан судалгаагаар иргэдийн дийлэнх нь иргэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж, сэтгүүлчид чөлөөтэй бичих, нийтлэх эрх чөлөөтэй байвал хэвлэлийн эрх чөлөө хэрэгжиж байна гэж үзэж байв. Харин 2009 онд судалгаанд оролцогчдын дийлэнх нь хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр үнэн зөв, тэнцвэртэй мэдээлэл түгээж байвал, засаг төр, нам, эрх мэдэлтнээс хэвлэл мэдээлэл хараат бус, ангид байж чадвал хэвлэлийн эрх чөлөө жинхэнэ утгаараа хэрэгжинэ хэмээн үзсэн байна. 2004 оны судалгаагаар хэвлэл мэдээллийн хэрэгсэлийн тоо нэмэгдэж байгааг иргэд талархан хүлээн авч, энэ нь хэвлэлийн эрх чөлөөнд зөргөөр нөлөөлнө хэмээн гурван иргэн тутмын нэг нь тайлбарлаж байв. Гэтэл энэ үнэлэмж жил ирэх тусам багасаж, харин сэтгүүлчид бүх сэдвээр нээлттэй бичих бололцоо бүрдсэн нь хэвлэлийн эрх чөлөөнд сайнаар нөлөөлж байна хэмээн үзэх болжээ. 2008 онд судалгаанд оролцогчдоос хэвлэл мэдээллийн итгэл үнэмшил, хэвлэлийн эрх чөлөөний талаархи үнэлэмжийг асуухад "мэдэггүй, энэ талаар бодож байгаагүй юм байна" гэх иргэдийн тоо өмнөх жилүүдээс 3 дахин нэмэгдсэн байна. Энэ нь

⁸ Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө. УБ. 2001 он 17 дахь тал.

⁹ Магистрант П.Өнөрмаа "Гүтгэлэг тойрсон маргаантай асуудлууд", "Хууль дээдлэх ёс" сэтгүүл, 2008 он, 73 дахь тал.

¹⁰ Өдрийн сонин, 2010 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн Лхагва гариг, №009 (3399).

¹¹ Өдрийн сонин, 2010 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн Лхагва гариг, №009 (3399).

¹² Хэвлэлийн хүрээлэн "Монголын хэвлэл мэдээллийн талаархи олон нийтийн үнэлэмж" Судалгааны тайлангаас, 2009 он.

олон нийтээс хэвлэл мэдээллийн эрх чөлөө бидэнд хамаагүй гэж үзэх, хэвлэл мэдээллийн салбарыг сонирхохгүй байх, үл тоох, хандлага өсөх магадлалтай бөгөөд улмаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээж буй мэдээ, мэдээлэлд итгэх итгэл үнэмшил буурахад нөлөөлж болох талтай. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөнд мугаар нөлөөлж буй хүчин зүйлийг хэвлэл мэдээллийн салбарын дотоод орчин буюу сэтгүүлчдийн мэдлэг, ур чадвар, ёс зүйтэй илүү холбож тайлбарладаг байсан бол 2009 онд гадаад орчин буюу улс төр, эдийн засаг, эрх зүйн орчин түүнчлэн улс төрчид хэвлэл мэдээллийн хэрэгсэл эзэмших болсон, тодорхой бүлэглэлүүд хэвлэл мэдээллийн агуулгад нөлөөлж байгаа, эрх зүйн зохицуулалт дутмаг, хэвлэл мэдээллийн эздийн салбарын мэдлэг, чадвар сул байдаг зэрэгтэй холбон тайлбарлажээ.

Улс төрчид болон төрийн албан хаагчдын үйлдэл нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр ил тод бичигдэхгүй, олон түмний шахалтад өртөх аюул байхгүй гэдэгт итгэлтэй байх тусам тэд өөрийн албан тушаалын байдлыг хувийн ашиг сонирхолд ашиглах сонирхолтой бөгөөд боломжтой болдог. Улс төрчид дээрх байдлыг зорилго болгохдоо хэвлэл мэдээллийн хэрэгслийн амыг боох оролдлого ямагт хийсээр байдаг нь нууц биш юм.¹²

Эрх чөлөө, хариуцлага хоёр нэг зоосны хоёр тал юм. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөг эдлэхтэй зэрэгцэж нийгмийн өмнө хэвлэл мэдээллийн хэрэгслийн удирдлага

болон сэтгүүлчдийн хүлээх хариуцлага, мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг мөрдөх шаардлага бий болдог. Хэрэв хэвлэл мэдээллийн хэрэгсэл хариуцлага алдвал олон түмний дэмжлэгийг алдаж улмаар дөрөв дэх эрх мэдэл гэж хичнээн чанга хашгираад ч үр дүн нь хоосон галд цуурай мэт үлдэнэ. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл үнэн зөв бодитой, тэнцвэртэй олон эх сурвалжаар баталгаажуулсан, сонирхолтой мэдээллийг ард түмэнд түгээх үүрэгтэй. Үүнийг дагаад ёс зүйн асуудал дагалдана. Ёс зүйтэй байж л олон түмний итгэлийг хүлээнэ. Иймээс хэвлэлийн мэдээллийн ёс зүйтэй холбогдолтой маргааныг урьдчилан хянан шийдвэрлэдэг (хөндлөнгийн) механизм хэрэгтэй бөгөөд тэр нь хэвлэлийн ёс зүйн хороо буюу консул байж болох юм. Хэвлэл мэдээллийн эсрэг дэгдсэн маргааныг хэвлэлийн ёс зүйн хороо анхлан шийдвэрлээд түүний шийдвэрийг нэхэмжлэгч эс зөвшөөрвөл шүүхэд хандаж болно гэж хуульд тусгаж өгөх нь зүйтэй болов уу.

Энэ бүхэнд дүгнэлт хийж үзвэл: Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа Монгол Улсын Үндсэн хууль болон Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль нь хэвлэлийн эрх чөлөөг хууль эрх зүйн хувьд баталгаажуулсан нь сайшаалтай юм. Ардчилсан нийгэмд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй, мэдээлэл хмвуст нээлттэй байх ёстой гэсэн зарчим баримталдаг хэдий ч өнөөдөр манай улсад төр засгийн байгууллагын үйл ажиллагааны

мэдээлэл "Байгууллагын нууц" гэсэн нэрийн дор хаалттай хэвээрээ байна. Иймээс байгууллагын нууцыг албан тушаалтнуудын, дур зоргоор биш хуулиар тогтоодог болгох, (одоо хуульд заасан байгаа боловч хэрэгжилт сул байгаа).

Сэтгүүлчдийн хардах эрхийг хууль зүйн хувьд баталгаажуулах, сэтгүүлчдийн мэдээллийн эх сурвалжийг нууцлах тал дээр тухайн нийтэлж нэвтрүүлсэн мэдээлэл үнэн бодитой нь батлагдвал эх сурвалжийг илчлэх ёсгүй, нууцлах нь зөв. Харин мэдээлэл худал хуурмаг буюу ташаа гэж нотлогдвол сэтгүүлчид мэдээлэл өгсөн этгээд, сэтгүүлч хоёр хоёулаа хариуцлага хүлээх ёстой. Харин тухайн мэдээллийг нэхэмжлэгч этгээд өөрөө нотлох үүрэгтэй гэж хуульчилж өгөх нь зүйтэй. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл үнэн зөв бодитой, тэнцвэртэй олон эх сурвалжаар баталгаажуулсан, сонирхолтой мэдээллийг ард түмэнд түгээх үүрэгтэй. Үүнийг дагаад ёс зүйн асуудал дагалдана. Ёс зүйтэй байж л олон түмний итгэлийг хүлээнэ. Иймээс хэвлэлийн мэдээллийн ёс зүйтэй холбогдолтой маргааныг урьдчилан хянан шийдвэрлэдэг (хөндлөнгийн) механизм хэрэгтэй бөгөөд тэр нь хэвлэлийн ёс зүйн хороо буюу консул байж болох юм. Хэвлэл мэдээллийн эсрэг дэгдсэн маргааныг хэвлэлийн ёс зүйн хороо анхлан шийдвэрлээд түүний шийдвэрийг нэхэмжлэгч эс зөвшөөрвөл шүүхэд хандаж болно гэж хуульд тусгаж өгөх нь зүйтэй болов уу.



¹² Докторант Д.Золжаргал. "Хэвлэл мэдээллийн эрх чөлөө" "Хууль дээдлэх ёс" сэтгүүл. 2008 он. №4. 6 дахь тал.

Монгол Улсын хөдөлмөрийн баатар, ардын багш, гавьяат хуульч,
доктор, профессор Б.Чимидийн нэрэмжит илтгэлийн
урлаанд багш, судлаачдаас II байрт шалгарсан илтгэл

ЦЭВЭР АБСТРАКТ ХЯНАЛТ БА МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ХЯНАЛТЫН СИСТЕМ: ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Японы хүүхдийг ивээх сангийн ажилтан, судлаач Н.Энхцэцэг



нөхцөлгүйгээр³ шилжсэн нь барууныхныг ямагт "гайхшруулж бас бишрүүлж" байсны адилаар Үндсэн хуулийн хяналтын систем бий болсон нь ч мөн өндрөөр үнэлэгдсэн.⁴ Өмнөх 70 жилийн тогтолцоонд байгаагүй шинэ систем байснаар шинэ Үндсэн хуулийн төслийг хэлэлцүүлж байх үед хяналтын ямар хэлбрийг сонгох талаар нэлээдгүй хугацаанд хэлэлцсний эцэст цэвэр абстракт хяналт хийдэг, Ханнс Келзений систем бүрэлдэн бий болсон.

2. Цэвэр абстракт хяналт

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц нь цэвэр абстракт буюу хийсвэр хяналт хийдэг шүүх юм. Коммунизмын дараахь Зүүн Европын орнуудад шинээр байгуулагдсан Үндсэн хуулийн шүүхийн үйл ажиллагаа нь мөн адил абстракт хяналт хийх замаар "идэвхжиж" ирсэн. Гэхдээ институтын хувьд тэднээс нэлээд ялгаа бий.

(i) Манайд өргөдөл, мэдээлэл гаргагч нь хэн ч байж болдог бол парламентийн цөөнх⁵ нь абстракт хяналтыг санаачилдаг. Ийнхүү парламентын цөөнхийн гаргасан гомдлыг шийдвэрлэн Үндсэн хууль зөрчсөн, зөрчөөгүй эсэх талаар

Монгол Улсад Үндсэн хуулийн хяналтын систем бүрэлдэн тогтоод 20 орчим жил болж байна. Цэвэр абстракт хяналт хэрэгжүүлдэгээрээ нэгэн үед байгуулагдсан бусад орны шүүхээс ялгагдах Монгол Улсын Үндсэн хуулийн цэц байгуулагдсан цагаасаа Монгол оронд ардчиллыг бэхжүүлэн хөгжүүлэх, хууль дээдлэх ёс, тэр дундаа Үндсэн хуулийг дээдлэх ёсыг сахин биелүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж ирсэн. Энэхүү өгүүлэлд Монгол Улсын Үндсэн хуулийн

хяналтын онцлог хэв шинж, түүний нөлөөллийг институтынх талаас нь Германы болон Зүүн Европын зарим орны ижил төрлийн системтэй харьцуулан толилуулж байна.

1. 1992 оны шинэ Үндсэн хууль батлагдснаар Монгол Улс анх удаа Үндсэн хуулийн хяналтын систем бий болсон. Ардчиллын "дөрөв дэх давалгаа"² хэмээн нэрлэгддэг Зүүн Европт коммунист систем нуран унахтай зэрэгцэн Азийн цээжинд орших Монгол Улс ардчилсан тогтолцоонд аливаа "урьдач

¹ Б.Чимид, Үндсэн хуулийн үзэл баримтлал нийтлэг асуудал, 2004 он, 167 дэх тал.

² Michael A. McFaul, *The Fourth Wave of Democracy and Dictatorship: Noncooperative Transitions in the Postcommunist World*, World Politics, Vol. 54 no. 2 at 212.

³ Ардчилалд шилжихэд хамгийн чухалд тооцогддог эдийн засгийн чадавхи сул байсан. Steven Fish, *Mongolia: Democracy without Prerequisites*, 9 J. DEM. 127 (1998).

⁴ Some pro-democracy experts have also taken the Mongolian case as an example of confrontation of concept "Asian value". Tomas Ginsburg, *Democracy in Unlikely Places: Mongolia's Quite Transformation*, <http://mira.go.jp/publ/review/98winter/gin.html>

⁵ Францад 60 депутат эсхүл сенатч Үндсэн хуулийн зөвлөлд хандаж болдог. Коммунизмын дараахь Зүүн Европын орны Үндсэн хуулийн шүүхүүд ч мөн адил парламентийн цөөнхөд Үндсэн хуулийн шүүхэд хандах эрхийг олгосон юм. Тухайлбал, ОХУ-д депутатууд эсхүл Холбооны зөвлөлийн гишүүдийн тавны нэг нь, Польш-д 50 Латви-д доод тал нь 20 депутат, Украйнд 45-аас доошгүй депутат г.м. GIBERT H FLANZ, RETT LUDWIKOWSKI, *COMPARATIVE HUMAN RIGHTS AND FUNDAMENTAL FREEDOM*, 2, 13, 2141 (Oceana, 2002) [hereinafter R.Ludwиковski].

дүгнэлт гаргаж зөрчсөн гэж үзсэн тохиолдолд тухайн хуулийн зүйл, заалтыг хүчингүй болгодог утгаар нь тэдгээр шүүхийг "парламентын хоёр дахь танхим", эсхүл "цөөнхийн эрхийг хамгаалагч" хэмээн нэрийддэг. Өөрөөр хэлбэл, энэ тохиолдолд Үндсэн хуулийн хяналтын байгууллага шүүхийн хэв шинжтэй гэхээсээ илүү "хууль тогтоогч мэт" хэв шинжийг агуулна.⁶ Монгол Улсын Үндсэн хуулийн хяналтын систем маргаан үүсгэгч субъектынхаа хувьд дараахь онцлог шинжүүдтэй. Үүнд:

"Парламентийн цөөнхийг хамгаалагч" гэсэн шинж Монгол Улсын ҮХЦ-ийн хувьд үгүйсгэгдэнэ. Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу Улсын Их Хурал (УИХ) Цэцэд хүсэлт гаргах эрх бүхий субъект. Гэвч өнөөг хүртэл УИХ энэхүү эрхээ хэрэгжүүлээгүй бөгөөд⁷ ийнхүү хэрэгжүүлэх боломжгүй юм. Учир нь олонхийн саналаар шийдвэр гаргадаг УИХ өөрийн баталсан хуулийн эсрэг маргаан үүсгэх нь наад зах нь логикгүй зүйл юм.

Германд Бундестагийн гишүүдийн гуравны нэг нь цөөнхөө төлөөлөн шүүхэд гомдол гаргаж болдог ба олон арван чухал шийдвэр⁸ Холбооны парламентын бүлэг гишүүдийн санаачилгаар үүсгэсэн хэргийг шийдвэрлэх явцад гарч байсан хэмээн Германы Үндсэн хуулийн нэрт эрдэмтэн К.Беймэ⁹ тэмдэглэсэн байдаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн анхны төсөлд УИХ-ын гишүүн Цэцэд хүсэлт гаргаж болохоор оруулсан байсан нь харагддаг.¹⁰ Гэвч хэлэлцүүлгийн явцад гишүүд эхлээд хуралдаанд хүсэлтээ уламжлах, улмаар УИХ ҮХЦ-д асуудлаа "оруулж" байхаар хуульчлагдсан юм. Өөрөөр хэлбэл, УИХ-ийн гишүүн дангаар УИХ-ийг төлөөлөн асуудал тавих боломжгүй, харин *actio popularis* аргаар иргэнийхээ хувьд өргөдөл, гомдол гаргах боломж хориглогдоогүй юм.

Энэ арга замаар хэд хэдэн маргаан 1990-ээд оны дунд үед шийдвэрлэгдэн үлдсэн. Тухайлбал, УИХ-ын гишүүн агсан С.Зориг шүүхийн тухай хуулийн холбогдох заалтыг¹¹, УИХ-ын гишүүн асан, одоогийн УИХ-ын гишүүн Р.Гончигдорж Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн хэд хэдэн заалтыг¹², гишүүн асан Д.Бямбадорж Нийгмийн даатгалын тухайн хуулийн зарим заалтууд¹³ Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн хэмээн хүсэлт гаргаж ҮХЦ-ээс дэмжсэн шийдвэр гаргаж байсан байна. Дээрх гурван маргааныг үүсгэсэн гишүүдийн улс төрийн намын харьяаллыг авч үзвэл бүгд тухайн үедээ улс төрийн нам нь парламентын цөөнх болж байсан байна.¹⁴ Үүнээс үзэхэд парламентад цөөнх болж байгаа улс төрийн хүчний дуу хоолой чухал байр суурьтай, анхааралдаа авч үзэхүй асуудал болох нь харагдана.

Институтын хувьд, нэгэнт бүлгээр хүсэлт гаргах боломжгүй тохиолдолд парламентын цөөнхийн санаа бодол нэг болон хэсэг гишүүдийн санаачилгаар илэрхийлэгдэх боломжтой болж харагдана. Р.Гончигдорж, Д.Бямбадорж нарын маргаан бүрэн, С.Зоригийн гомдол хэсэгчлэн дэмжигдсэнээс үзэхэд парламентын цөөнхийн санаа бодол хүний эрхийг хамгаалахад чухал үүрэгтэй хэмээн үзэх бүрэн боломжтой. Нөгөөтэйгүүр, энд дурдсан жишээнээс өөр УИХ-ийн гишүүн байхдаа цөөнх болсон үедээ маргаан үүсгэсэн тохиолдолгүй байгаа нь УИХ-ийн гишүүдийн "идэвхгүй" хандлага ажиглагдана.

Парламентийн цөөнхийн Үндсэн хуулийн шүүхэд хандан олонхийн дэмжлэг авч чадаагүй хууль, тогтоомжийн тодорхой зүйл заалтыг Үндсэн хууль зөрчсөн хэмээн аргумент дэвшүүлж буй нь сайн талтай ч түүнийг нөгөө талаас нь буюу "каунтер мажоритар хүндрэл" ("counter-majoritarian difficulty")¹⁵-ийн талаар хяналтын систем анзаарах нь зүйтэй юм.

(ii) Монгол Улсын Үндсэн хуулийн хяналтын систем нь Европ маягийн конкрет¹⁶ буюу тодорхой хяналтыг хэрэгжүүлдэггүй гэж үзэж болно. Ердийн шүүхээс хэрэг маргаан шийдвэрлэх явцад нь хэрэглэж буй хуулийн зүйл заалт Үндсэн хууль зөрчсөн байх болох эргэлзээ төрсөн үед бух шатны шүүх

⁶ Wojciech Sadurski, *RIGHTS BEFORE COURT: A STUDY OF CONSTITUTIONAL COURTS IN POST COMMUNIST STATES OF CENTRAL AND EASTERN EUROPE*, 67 (Springer, 2005) [hereinafter Sadurski].

⁷ 1992-2006 онд Үндсэн хуулийн цэцээс гаргасан шийдвэрүүдийн хоёрыг Ерөнхийлөгч, хоёрыг УДШ хүсэлт гаргаж шийдвэрлүүлсэн байна.

⁸ Abortion I case had filed 193 members of Parliament challenged the Abortion Reform Act 1974 which abolished criminal penalties for abortions carried out in the first 12 weeks of pregnancy. The Act was annulled pending in the interim pending the Court's final decision.

⁹ Klaus von Beyme, *supra* note 101, at 106.

¹⁰ Ардын Их Хурлын хуралдааны тэмдэглэл, 1991 оны 12 дугаар сарын 20-ны өдөр, №37.

¹¹ Үндсэн хуулийн цэцийн шийдвэр (цаашид "ҮХЦШ"). 1994.01-1.01, Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн эмхтгэл (цаашид "эмхтгэл" гэх) №1, 2005 он, 63-67 дахь тал.

¹² ҮХЦШ-ийд 1994 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр, №02, *Эмхтгэл* №1, 2005 он, 74-80 дахь тал.

¹³ ҮХЦШ-ийд 1994 оны 1 дүгээр сарын 04-ний өдөр, №02, *Эмхтгэл* №1, 2005 он, 286-291 дахь тал.

¹⁴ While R. Gonchigdorj was a member of Social Democrat Party which was the minority in the 1992-1996 Parliament. D. Byambadorj, who was a member of Mongolian People's Revolutionary Party that was the minority party between 1996-2000.

¹⁵ Alexander M. Bickel, *THE LEAST DANGEROUS BRANCH: THE SUPREME COURT AT THE BAR OF POLITICS*, 16 (1962).

¹⁶ Европ маягийн конкрет хяналт нь Америкийн конкрет хяналтаас зарчмын ялгаатай. Америк загварын хяналт нь цэвэр конкрет бөгөөд бодит хэрэг дээр тулгуурлан хяналт хийдэг. Маргааны нэг тал нь Үндсэн хуулийн зүйл заалттай харшилсан хуулийн үйлчилгэйн хүрээнд эрх нь зөрчилдсөн байх нь хэрэг, маргааны үндэслэл болно. Жишээ нь: *Roe v. Wade*, 410 U.S. 113 (1973). Илүү дэлгэрэнгүй: Brief of petitioner in *Norman Dorsen, Michel Rosenfield, ANDRÁS SAJÓ, SUSANNE BIERER, COMPARATIVE CONSTITUTIONALISM: CASES AND MATERIALS*, at 84 (Thomson West, 2003).

Үндсэн хуулийн цэцэд хандаж тухайн зүйл, заалтыг хянаж шийдвэрлэхийг хүсдэг.¹⁷ Үндсэн хуулийн цэц түүнийг хянан шийдвэрлэхэд ямар нэг маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа явагддаггүй тул "үнэн хэрэгтээ абстракт"¹⁸ байдаг. Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу Улсын Дээд Шүүх (УДШ) хүсэлт гаргах эрх бүхий субъект (Үндсэн хууль, 66.1) мөн ч хянан шийдвэрлэж буй хэрэг маргаантай нь холбоотой байхыг шаарддаггүйгээрээ бусад ижил төстэй шүүхээс ялгагдана. 1992-2006 он хүртэлх хугацаанд ҮХЦ-ийн шийдвэрлэсэн хэрэг, маргааны дунд УДШ-ээс 2 удаа хүсэлт гаргаж маргаан шийдвэрлүүлсэн бөгөөд тэдгээр нь конкрет хяналт бус, цэвэр абстракт хяналт юм. Бодит хэрэг дээр тулгуурлан хууль тогтоомжийн Үндсэн хуульд нийцсэн эсэхэд хяналт тавих систем хувь хүний эрхийг хамгаалахад онцгой ач холбогдолтой тул үүнийг Үндсэн хуулийн хяналтын системд нэвтрүүлэх зайлшгүй шаардлагатай хэлбэр гэж зохиогч үздэг.

(iii) Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд иргэн өргөдөл, гомдол чөлөөтэй гаргах өргөн эрхтэй бөгөөд (66.1) хувь хүний Үндсэн хуулийн шүүхэд ханддаг хоёр арга замын нэг болох *actio popularis*¹⁹ аргаар хандана. Өөрийнх нь эрх зөрчигдсөн эсэхээс үл хамааран

ямарваа нэг хуулийн зүйл, заалт Үндсэн хуулийн тодорхой зүйл заалтыг зөрчиж байна" хэмээн өргөдөл гаргадаг энэ системийг хэрэглэдэг шүүх төдийлэн байдаггүй бөгөөд Зүүн Европын орнуудын Үндсэн хуулийн шүүхүүдээс Унгар²⁰ улсад хэрэглэгдэг нь судлаачдын зүгээс шүүмжлэлтэй тулгарч байсан. Тухайлбал,

Б.Акерман (B. Ackerman)–Унгар улс үнийхүү абстракт хяналт хийхээ больж зөвхөн конкрет буюу тодорхой хяналтаар хязгаарлагдах нь зүйтэй хэмээн зөвлөж байлаа. Шалтгааныг нь тэрээр "зөвхөн улс төрийн маргаан шүүхийг оршин тогтноход хүргэж байна" хэмээсэн юм.²¹

Унгарын Үндсэн хуулийн шүүхэд иргэд *actio popularis* замаар "цаазаар авах ял, хувь хүний бүртгэлийн дугаар, төрийн байгууллага, албан тушаалтныг шүүмжилсний төлөө хариуцлага хүлээлгэж байсан зэрэг олон арван хувь хүний эрхийг зөрчсөн хуулийн заалтыг хүчингүй болгосон" хэмээн Садуурски²² судалгааны дүндээ онцолсон. Яагаад *actio popularis*-ийг хэрэглэж байгаа талаар Унгарын Үндсэн хуулийн судлаач Г.Халмай (Gabor Halmay) хэлэхдээ "эрх зүйн хуучин системийн элементүүдийг системчлэн хянах зорилгоор хэрэглэж байгаа" гэсэн юм.²³

Монгол Улсын Үндсэн хуулийн

цэцээс 1992-2006 онд шийдвэрлэсэн маргааны 95 хувийг иргэний гаргасан өргөдөл, мэдээлэл эзэлж байна.²⁴ Өмнө дурдсанчлан, иргэд хүний эрхтэй холбоотой, холбоогүй бүхий л асуудлаар өргөдөл, мэдээллийг хязгааргүй гаргаж болно. Иргэдээс эвлэлдэн нэгдэх эрхийг зөрчсөн²⁵, энгийн хувьцаа эзэмшигчдийн хуулийн өмнө тэгш байх эрхийг хангах,²⁶ эрх мэдлийг хуваарилах зарчмыг зөрчсөн,²⁷ төрийн өндөр албан тушаалтан Үндсэн хууль зөрчсөн²⁸ гээд хандсан асуудлын цар хүрээ нэлээдгүй өргөн, бүр цаашилдаг УИХ-ын дарга Үндсэн хууль зөрчсөн хэмээн "дуулиант" маргаан үүсгэж, түүнийг огцроход хүргэж байлаа.²⁹

Ийнхүү *actio popularis* гомдлын хэлбэр Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн ажиллах үндсэн хөшүүрэг нь болж өгч байна. Үүний гол сөрөг тал нь юу байдаг вэ гэдэгт энэхүү өгүүллийн утга санаа оршино. Хууль тогтоомжийг абстракт байдлаар хянан үзэж буй Үндсэн хуулийн шүүх ямагт шүүхийн гэхээсээ илүү "хууль тогтоогч мэт" (*quasi-legislator*) байж, шүүхийн байгууллага өөрөө улс төрийн шинж чанартай болж гаргасан шийдвэр нь улс төрийн маргааны төв болдог нь түүний мөн чанар юм.³⁰

(iv) Нөгөө нэг арга зам болох Үндсэн хуулийн гомдлын систем нь

¹⁷ Basic Law, ch. IX, art. 100.

¹⁸ Alec Stone, *Judging Judicial Review: Marbury in the Modern Era. Why Europe Rejected American Judicial Review: And Why It Not Matter*, 101 Mich L Rev at 2744, 2771 (2005).

¹⁹ MAURO CAPPELLETTI, *JUDICIAL REVIEW IN THE CONTEMPORARY WORLD*, 39 (1971) [hereinafter Cappelletti].

²⁰ SADURSKI, *supra* note 6, at 5-6.

²¹ Bruce Ackerman, *The Future of Liberal Revolution* (Yale University Press: New Haven, 1992) at 108.

²² SADURSKI, *supra* note 6, at 6.

²³ Gabor Halmay, *The Hungarian Approach to Constitutional Review: The End of Activism? The First Decade on the Hungarian Constitutional Court*, in *CONSTITUTIONAL JUSTICE, EAST AND WEST: DEMOCRATIC LEGITIMACY AND CONSTITUTIONAL COURTS IN POST-SOVIET EUROPE IN A COMPARATIVE PERSPECTIVE*, 193 (Wojciech Sadurski ed., 2002).

²⁴ 1992-2007 он хүртэлх хугацаанд ҮХЦ-ийн дунд суудлын хуралдаанаас нийт 90 шийдвэр гарсан бөгөөд, тэдгээрийн 86 нь иргэдийн өргөдөл, мэдээлэлд үндэслэгдсэн байв.

²⁵ Иргэн Сэлэнгэ Улс төрийн намуудын тухай хуулийн татан буугдсан намын нэрийг шинээр байгуулагдах намд өгөхийг хориглосон зүйл, заалт Үндсэн хууль зөрчсөн буюу эвлэлдэн нэгдэх эрхийг зөрчсөн хэмээн үзэж маргаан үүсгэсэн ба Цэц дэмжсэн шийдвэр гаргасан. ҮХЦШ, 2005-09-10, ҮХЦ-ийн website: www.constcourt.gov.mn.

²⁶ Нэр бүхий гурван иргэн Компанийн тухай хуулийн энгийн хувьцаа эзэмшигчдийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцохыг хязгаарласан заалтыг ялгаварлан гадуурхсан, хуулийн өмнө тэгш байх зарчим, өмчлөх эрхийг зөрчсөн хэмээн үүсгэсэн маргаан. ҮХЦШ, 2002-06-10, *эмхгэл* No 2, 163-174 (2005).

²⁷ Энэ зарчмыг зөрчсөн хэмээн нэлээд хэдэн маргаан үүсгэгдсэн байдаг.

²⁸ 1992-2007 оны хооронд УИХ-ын гишүүн, Ерөнхий прокурор, Ерөнхий шүүгч хууль зөрчсөн гэсэн 7 маргаан шийдэгдсэн байна.

²⁹ ҮХЦШ-ийдөөр 2007 оны 1 дүгээр сарын 03-ны өдөр ҮХЦ website: www.constcourt.gov.mn.

³⁰ SADURSKI, *supra* note 6, at 6; TOM GINSBURG, *JUDICIAL REVIEW IN NEW DEMOCRACIES: CONSTITUTIONAL COURT IN ASIAN CASES*, 36 (2003).

хувь хүний эрхийг хамгаалах Үндсэн хуулийн үндсэн арга хэрэгсэл байдаг бөгөөд энэхүү системийг 1951 онд Герман Улсын Үндсэн хуулийн хяналтын системд нэвтрүүлсэн³¹ нь тус орныг энэ системийн анхдагч болгосон ба Коммерс энэ системийг "хууль тогтоомжоос өгсөн бэлэг" хэмээн нэрийдсэн байдаг.³² Улмаар 1969 онд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр түүнийг оруулсан байна. Тэрээр Германы Үндсэн хуульд зааснаар Үндсэн хуулиар хамгаалагдсан эрхийг нь төрийн аливаа байгууллагаас зөрчсөн тохиолдолд тухайн этгээд маргаан үүсгэх³³ нь энэ системийн онцлог бөгөөд Үндсэн хуулийн шүүхэд хандаж буй нийт тохиолдлын 95 хувийг³⁴ Үндсэн хуулийн гомдол эзэлдэг байна.

Манай Үндсэн хуулийн хяналтын системд Улсын Дээд шүүхийн шийдвэр эцсийн шийдвэр байдаг (50.2) тул иргэд Үндсэн хуулиар хамгаалагдсан эрх нь зөрчигдсөн тохиолдолд "Үндсэн хуулийн гомдлын систем"-ээр Үндсэн хуулийн гомдол гаргах боломжгүй.

Харин тухайн хэрэг, маргааныг нь шийдвэрлэхэд хэрэглэсэн, үндэслэл болгосон хуулийн зүйл, заалтын эсрэг өргөдөл гаргаж болох юм.

Үндсэн хуулийн гомдол, *actio popularis* хоёрын ялгаа нь: (i) хяналтын объектын хувьд нэг нь Үндсэн хуулийн эрхийг зөрчсөн үйлдэл, эс үйлдэл (omission), нөгөө нь Үндсэн хуультай харшилсан хуулийн зүйл, заалт; (ii) үүсгэж буй хэрэг маргаан нь гомдол гаргаж буй этгээдэд хамаатай, хамааралгүй байх явдал. ҮХЦ-ийн шийдвэрлэсэн маргаан дунд тухайн үүсгэгсэн маргаан өөрт нь хамаатай байсан хэд хэдэн тохиолдол бий. Ерөнхий сайд асан Д.Бямбасүрэн иргэнийгээ хувьд Ерөнхий Прокурор Ганбаярын эсрэг үүсгэгсэн гомдол,³⁵ иргэн Нармандах, Баянмөнх нарыг УИХ-ын сонгуульд нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзсан Сонгуулийн Ерөнхий хорооны шийдвэрийн эсрэг гаргасан гомдол (1996.06, №5) юм.

Ийнхүү цэвэр абстракт хяналт хэрэгжүүлж буй Монгол Улсын Үндсэн хуулийн цэц өнгөрсөн хугацаанд улс төрийн халуун цөм

болсоор ирсэн. Түүний гаргасан шийдвэрүүд Монгол Улсад ардчилсан нийгмийг төлөвшин хөгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулсаар ирсэн нь мэдээж юм. Мөн 2007 он хүртэлх ҮХЦ-ийн шийдвэрт тойм шинжилгээ хийж үзвэл нийт маргаан үүсгэгсэн хуулийн зүйл заалтын 37 хувь нь Үндсэн хуулийг бүрэн зөрчсөн, 17 (зохиогчийн өөрийн хийсэн судалгаанд үндэслэсэн) хувь нь хэсэглэн зөрчсөн хэмээн дүгнэлт гаргаж хүчингүй болгох шийдвэр гаргасан байна. Энэ нь бусад улс оронтой харьцуулахад өндөр үзүүлэлт бөгөөд Цэц "каунтер мажоритар хүндрэл" хэрхэн учруулж буй эсэхэд шинжилгээ судалгаа хийх шаардлагатай болохыг харуулна.

Эцэст нь зохиогч Монгол Улсын Үндсэн хуулийн хяналтын систем цэвэр абстракт хяналтаас алхам алхамаар татгалзан, хувь хүний Үндсэн хуулиар хамгаалагдсан эрхийг хамгаалах конкрет хяналт, Үндсэн хуулийн гомдлын механизмыг нэвтрүүлэх нь зүйтэй хэмээн үзэж байгаа болно.

ХУУЛЬ ЗҮЙН

19-82

ЛАВЛАХ

³¹ Constitutional Court Act, ch. 15, art. 90-96.

³² DONALD KOMMERS, THE CONSTITUTIONAL JURISPRUDENCE OF THE FEDERAL REPUBLIC OF GERMANY, at 14 (2nd ed., 1994).

³³ BASIC LAW, ch. IX, art. 93, § 1, [4a].

³⁴ VICKI C. JACKSON & MARK TUSHNET, COMPARATIVE CONSTITUTIONAL LAW 529 (second ed. 2006).

³⁵ ҮХЦШийдвэр: 1994 оны 1 дүгээр сарын 07-ны өдөр, Эмхтгэл, №1, 2005 он: 107-114 дэх тал.

ТӨР, ТҮҮНИЙ ӨМЧИЙН ДАРХАН ЭРХИЙН ОНОЛ: АЛБАДЛАГЫН АРГА ХЭМЖЭЭ АВАГДАХААС АНГИД БАЙХ УЛСЫН ДАРХАН ЭРХ

Удиртгал

Төрийн шүүхийн болон түүний өмчийн дархан эрх нь олон улсын эдийн засгийн харилцааны чухал асуудал болж байгаа бөгөөд бүрэн эрхт улсууд уг асуудалд анхаарлаа ихээхэн хандуулж байна.¹

Төрийн туйлын ба хязгаарлагдмал дархан эрхийн онол гэсэн хоёр онол олон улсын эрх зүйд байдаг бөгөөд бүрэн эрхт бие даасан улсууд нь төрийн хязгаарлагдмал дархан эрхийн онолыг баримтлан төрийн дээд эрх мэдлээ хэрэгжүүлж байгаа үед бус харин худалдааны харилцаанд оролцсон үед дархан эрхээсээ татгалзах болсон. Гэвч улсууд нь эд хөрөнгөд албадлагын арга хэмжээ авах нь тусгаар тогтнолд халдаж байгаа явдал хэмээн үзэж дархан эрхээсээ татгалзах хүсэлгүй байдаг.² Тиймээс албадлагын арга хэмжээ авахаас ангид байх улсын дархан эрх нь маргаантай асуудал болоод байгаа бөгөөд уг эрх нь шүүхийн дархан эрхтэй харилцан хамааралтай гэж үзэхэд бэрхшээлтэй болж байна.

Энэ илтгэлээр төрийн ба түүний өмчийн дархан эрх, төрийн өмчийн ямар төрөлд албадлагын арга хэмжээ тогтоож болох эс болох талаар дурьдах болно. Уг асуудлыг Төрийн шүүхийн болон түүний өмчийн дархан эрхийн тухай НҮБ-ын конвенцийн зохицуулалтын хүрээнд авч үзнэ.

1. Төрийн дархан эрх

1.1. Төрийн туйлын дархан эрхийн онол

Төрийн тусгаар тогтнол, тэгш эрхт байдал нь философи болон практик



МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Олон улсын эрх зүйн тэнхимийн багш Б.Тамир

талаасаа нэг улсын шүүх нөгөө гадаад улсыг түүний зөвшөөрөлгүйгээр шүүхэд дуудахад хүндрэлтэй болгож байсан.³

Нутаг дэвсгэрийн хэрэг шүүн шийдэх эрхийн харъяалал болон төрийн дархан эрхийн хоорондын харилцан хамаарлын талаар анх АНУ-ын Дээд Шүүхийн тэргүүн шүүгч Маршалл *The Schooner Exchange v. McFaddon* (1812)-ны хэрэг дээр хөнджээ. *The Schooner Exchange* хэмээх хөлгийн эсрэг Францын Засгийн газар болон франц үндэстэн хэсэг иргэд нэхэмжлэл гаргажээ. Тэргүүн шүүгч Маршалл: "Эргийн харъяалал нь тухайн улсын нутаг дэвсгэр дээр халдашгүй ба туйлын бөгөөд энэ нь гадаад улсын бүрэн эрхт байдлыг хөндөхгүй" гэж дурьджээ.⁴ *The Schooner Exchange* хэмээх хөлөг нь цэргийн хөлөг онгоц байсан. Цэргийн хөлөг онгоц нутаг

дэвсгэрийн далайн хилээс гадагш байхдаа гадаадын ямар нэгэн улсын албадлагын арга хэмжээ, шүүн таслах ажиллагаанд үл захирагдан, бүрэн дархлагдсан байна гэсэн үндэслэлээр дээрх шийдвэрийг гаргажээ.⁵

18-19 дүгээр зууны үед бүрэн эрхт бие даасан улсууд нь хэргийн нөхцөл байдлаас үл хамааран үндсэндээ төрийн туйлын дархан эрхийн онолыг баримталдаг байсан. Төрийн туйлын дархан эрхийн онолыг тууштайгаар баримталдаг байсан орнуудын тэргүүлэх улс нь Англи байсан бөгөөд хэд хэдэн чухал хэргийг бий болгожээ. Тухайлбал, төрийн туйлын дархан эрхийн онолыг хамгийн хурц байдлаар хөндсөн нь *Porto Alexandre*-ийн (1920, UK) хэрэг юм. Португалийн төрийн өмчийн усан онгоц худалдааны үйл ажиллагаанд оролцсон байсан бөгөөд Ливерпүүлийн ойролцоох зогсоолд зогсож татлагын үйлчилгээний хөлсөө төлөөгүйн улмаас төлөхийг шаардсан тухай шүүхийн шийдвэр Английн шүүхэд гарчээ. Гэвч Португал Улсын Засгийн газар туйлын дархан эрхийн онолыг баримтлан сөрөг нэхэмжлэл гаргасан бөгөөд Английн шүүх хэргийг Португал Улсын Засгийн газрын ашиг сонирхолын дагуу шийдвэрлэсэн.⁶

Төрийн дархан эрх хэмээх ойлголт анх улсуудын тогтсон заншлын хэм хэмжээний хувиар байсан ба дараа нь улсуудын дотоодын хууль тогтоомж, олон улсын гэрээгээр тодорхойлогдсон.

1.2. Төрийн хязгаарлагдмал дархан эрхийн онол

19 дүгээр зууны дүнд үеэс аж үйлдвэрлэл хөгжиж эхлэх үед төр нь худалдаа, эдийн засгийн харилцаанд ихээхэн оролцох

¹ КНЕУСЧИН О.В. STATE IMMUNITY IN INTERNATIONAL ECONOMIC RELATIONS. 308 (2002).

² Mag. Eva Wiesinger. State Immunity from enforcement measures. p. 3.

³ MALCOLM N. SHAW, INTERNATIONAL LAW, 622 (2003).

⁴ Id. at 622.

⁵ Id. at 580.

⁶ Id. at 626.

болсон. Худалдааны харилцаанд төр идэвхитэйгээр оролцох болсноор хувийн эрх зүйн шинжтэй харилцаанаас үүссэн маргааныг шийдвэрлэхэд бэрхшээлтэй болсон. Учир нь төр туйлын дархан эрхийн онолыг баримтлан аливаа хариуцлагаас ангид байсан нь хувийн эрх зүйн харилцаанд тэгш бус байдал үүсгэсэн. Тиймээс засгийн газрын агентлаг, төрийн өмчит үйлдвэр, бусад төрийн байгууллагууд, томоохон корпорациуд төрийн туйлын дархан эрхийн онолыг эсэргүүцжээ төрийн хязгаарлагдмал дархан эрхийн онол бий болгоход хүргэсэн юм. Үүнээс улбаалан төрийн дархан эрхийн хүрээг улс орнуудын шүүх нийтийн эрх зүйн харилцаа (засаглалын шинжтэй харилцаа) буюу *jure imperii*, хувийн буюу худалдааны үйл ажиллагаатай холбоотой харилцаа *jure gestionis* гэж ангилан үздэг болсон.⁷

1950 онд Австрийн Дээд Шүүх судалгаа хийж үүний дүнд төр нь худалдааны харилцаанд идэвхитэйгээр оролцох болсноор төрийн туйлын дархан эрхийн сонгодог онол нь ач холбогдолгүй болж байна гэж дүгнэжээ. Мөн түүнчлэн 1952 онд АНУ-ын Төрийн Департамент: "Төр худалдааны үйл ажиллагаанд оролцож байгаа нь төрийн туйлын дархан эрхийн онолыг баримтлахыг татгалзахад хүргэж байна" хэмээжээ. Тиймээс Департамент нь төрийн хязгаарлагдмал дархан эрхийн онолыг баримтлах болно гэж тунхагласан. Энэхүү хандлага нь шүүхийн шийдвэрүүдэд тусгалаа

олж эхэлсэн байна. Тухайлбал, *Victory Transport Inc. v. Cornisaria General de Abastecimientos y transporte*-ийн хэрэг дээр улаан буудай тээвэрлэхээр АНУ-аас усан онгоц түүрээслэн Испанийн Худалдааны яамны үйлдэл нь улс төрийн шинжтэй биш тул хэргийг шүүн шийдэх эрхтэй гэж үзэж байжээ.⁸

Англи улс нь төрийн туйлын дархан эрхийн онолыг тууштай баримталдаг байсан тухай өмнө дурдсан. Гэвч хязгаарлагдмал дархан эрхийн онол үүссэнээр аажимдаа уг онолыг баримтлах болсон бөгөөд үүний илэрхийлэл нь 1978 онд Төрийн дархан эрхийн тухай хууль батлагдсан явдал юм.⁹

Мөн 1970-аад оноос тодорхой тооны улсууд төрийн хязгаарлагдмал дархан эрхийн онолыг баримтлах болсон ба эдгээр улсуудын хэлэлцээний үр дүнд Европын Зөвлөл 1972 онд Төрийн дархан эрхийн тухай Европын конвенцийг баталсан.¹⁰ Уг конвенци нь төрийн дархан эрхийн асуудлаарх анхны олон талт гэрээ болсон юм.¹¹ Мөн түүнчлэн зарим улсад төрийн дархан эрхийн тухай хууль батлаж байсан юм. Тухайлбал, АНУ-д Гадаад улсын дархан эрхийн тухай хууль, Англи, Канад, Өмнөд Африк, Пакистан, Сингапур, Австрали зэрэг оронд Төрийн дархан эрхийн тухай хууль тус тус батлагдсан байна.¹²

Өнөөдрийн байдлаар төрийн туйлын дархан эрхийн онолыг БНХАУ болон цөөн хэдэн гуравдагч ертөнцийн орнууд баримталж байна.¹³

2. Төрийн өмчийн дархан эрх

Төрийн өмчийн дархан эрхийн хүрээнд төрийн өмчид албадлагын арга хэмжээ авахаас ангид байх улсын дархан эрхийн тухай хөндөгдөнө.

Төрийн хязгаарлагдмал дархан эрхийн онолын хүрээнд аливаа төрийн эд хөрөнгөд өөр улсын зүгээс албадлагын арга хэмжээ оноож болохгүй, хэрэв албадлагын арга хэмжээ хэрэглэх бол түүний зөвшөөрөлгүйгээр халдахыг хориглоно гэсэн ойлголт байдаг. Гадаадын төрийн өмчийн хувьд төр нь зөвхөн төрийн удирдах дээд эрх мэдлээ буюу *jure imperii* хэрэгжүүлж байгаа тохиолдолд л дархан эрх нь хэрэгжинэ. Хэрэв төр гадаад худалдааны хэлцлийн шижтэй харилцаанд (*iure gestionis*) оролцож байгаа үед дархан эрх нь хэрэгжихгүй юм. Энэ тохиолдолд тухайн төрийн эд хөрөнгөд албадлагын арга хэмжээ хэрэглэж болно.¹⁴ Өөрөөр хэлбэл, төрийн өмчид албадлагын арга хэмжээ тогтоож болох эсэх нь хязгаарлагдмал дархан эрхийн онолын хүрээнд яригдана. Төрийн туйлын дархан эрхийн онолын хүрээнд дээрх асуудал хөндөгдөхгүй юм.

Дархан эрхийг хүлээн зөвшөөрөх нь төрийн хүлээсэн үүргээс чөлөөлөхгүй, мөн үүргээ биелүүлээгүйн төлөө хүлээх хариуцлагаас чөлөөлөхгүй. Аливаа төр болон түүний орон нутгийн байгууллага нь өөрийн хүлээсэн үүргээ өөрсдийн өмчлөх эрхэд байгаа эд хөрөнгөөрөө хариуцдаг. Гэвч тодорхой төрийн эд хөрөнгө

⁷ Lauterpacht H. *The problem of Jurisdictional Immunities of foreign States*, British Yearbook of International Law. – 1951, -Vol. XXVIII

⁸ MALCOLM N SHAW, INTERNATIONAL LAW, 628 (2003).

⁹ Дээр дурдсан *Porto Alexandre*-ийн хэрэгтэй төстэй *Pillipine Admiral*-ын хэрэг мөн Английн шүүхэд шийдэгдэх болжээ. Филиппин улсын төрийн өмчид байдаг усан онгоцны эсрэг Хонг Конгийн усан онгоцны хоёр компани нэхэмжлэл гаргажээ. Уг хэргийг Английн шүүх шийдэхдээ: "Энэ хэргийг шийдэхэд *Porto Alexandre* хэргийн шийдвэрийг харгалзан үзэхгүй бөгөөд төрийн өмчлөлийн худалдааны онгоцтой холбоотойгоор худалдааны хэлцлээс үүссэн аливаа маргааныг шийдэхэд туйлын дархан эрхийн онолыг баримтлан аливаа төр шүүхэд хариуцагчаар татагдахгүй гэсэн тэгш бус харилцаа байх өсгүй" гэжээ. Энэ хэргийн шийдвэр нь Англи улс худалдааны харилцаанд төрийн хязгаарлагдмал дархан эрхийн онолыг баримтлах болсны нэг нотолгоо юм. MALCOLM N SHAW, INTERNATIONAL LAW, 629 (2003).

¹⁰ Европын Конвенцид Австрали, Бельги, Кипр, ХБНГУ, Люксембург, Нидерланд, Швейцарь, Их Британи зэрэг 8 улс нэгдэн орсон.

¹¹ International Law Programme, ILP BP 05/01, May 2005.

¹² Kneychuk O.B. *State Immunity in international economic relations*. 2002 p 309.

¹³ *Id.* at 310.

¹⁴ М.М. Богуславский, Олон Улсын Хувийн Эрх Зүй, 144-дэх тл, 2008 (Монгол орчуулга)

нь албадлагын арга хэмжээ авахаас ангид байдаг. Үүнийг Төрийн шүүхийн болон түүний өмчийн дархан эрхийн тухай НҮБ-ын конвенцид тусгайлан зохицуулсан. Уг зохицуулалтыг доор дэлгэрүүлэн авч үзье.

2.1. Төрийн шүүхийн болон түүний өмчийн дархан эрхийн тухай НҮБ-ын конвенцийн зохицуулалт

Тодорхой асуудлаар аль нэг тусгаар тогтносон улсын бүрэн эрхэд халдаж түүнийг буюу эсвэл эрх бүхий албан тушаалтныг шүүхэд татаж болох юм гэсэн үзэл санаа дэлгэрэх мөн үеэс бүрэн эрхт улс нь гадаад улсын шүүхэд дуудагдах явдлыг зохицуулах хэм хэмжээ хөгжиж ирсэн. Хэм хэмжээг боловсруулах явцад улсыг шүүхэд татаж болох эсвэл татагдахгүй байх үндэслэлүүдийг тогтоож өгсөн. Тухайлбал, хараахан хүчин төгөлдөр болоогүй байгаа¹⁵ Төрийн шүүхийн болон түүний өмчийн дархан эрхийн тухай НҮБ-ын конвенци (цаашид НҮБ-ын конвенци гэх) нь дээрх санааг агуулдаг. НҮБ-ын шинэ конвенци нь Олон Улсын эрх зүйн комиссийн нийт 27 жилийн ажлын үр дүн юм.

Уг конвенцоор эрүүгийн шүүн таслах ажиллагаа болон аль нэг улсын албан тушаалтан хүний эрхийг зөрчсөн бөгөөд зөрчил нь тухайн улсын нутаг дэвсгэрт гарсан тохиолдолд үүнтэй холбогдуулан иргэний нэхэмжлэл гаргах зэрэг харилцааг зохицуулахгүй.¹⁶

Уг конвенци нь албадлагын арга хэмжээ авахаас ангид байх төрийн өмчийн шинэ ангиллыг бий болгосон бөгөөд доорх хязгаарлалтуудыг тогтоосон байна. Үүнд:

2.1.1. Төрийн өмчийн эсрэг албадлагын арга хэмжээ авах

нөхцөлүүд:

1(а) Албадлагын арга хэмжээ авах шийдвэрийг биелүүлэх нөхцөл Албадлагын арга хэмжээ авахаас өмнө нэгдүгээрт, хэрэг шүүн шийдэх харьяалалыг буюу *acta jure imperii* эсхүл *acta jure gestionis* аль нь болохыг тогтоох, хоёрдугаарт, тухайн объектын ашиглалтын зориулалтыг тодорхойлох ёстой;

1(в) Улсын зөвшөөрлийн үндсэн дээр албадлагын арга хэмжээ авах *альтернатив нөхцөл*

Дараах хоёр нөхцөл нь төрийн өмчийн зориулалтаас үл хамааран албадлагын арга хэмжээ тогтоож болох нөхцөл юм. Хэрэв төрийн өмч нь улсын бүрэн эрхт бие даасан үйл ажиллагаатай холбоотойгоор ашиглагдах боловч тухайн төр нь албадлагын арга хэмжээ авахаас ангид байх дархан эрхээсээ татгалзсан, мөн өмч нь тусгайлан хуваарьлагдсан бол уг арга хэмжээг авч болно;¹⁷

• Албадлагын арга хэмжээ авахаас ангид байх дархан эрхээсээ татгалзах

Хариуцагч улс нь албадлагын арга хэмжээ авахаас ангид байх дархан эрхээсээ НҮБ-ын конвенцийн 19 (а)-д заасны дагуу татгалзах болно. Мөн зарим улсын дотоодын хуульд шүүхийн дархан эрхээсээ татгалзаж болох тухай тусгасан байдаг. Албадан арга хэмжээ авах эрхээс дархан байх эрхээсээ татгалзах илэрхийлэлээ талуудын хооронд маргаан үүссэний дараа олон улсын гэрээ, арбитрайн хэлэлцээр, бичгэн гэрээ, шүүхийн өмнө мэдэгдэл хийх, албан бичгийн харилцааны журмаар илэрхийлнэ. Гэхдээ олон улсын гэрээ, арбитрайн хэлэлцээрийн дагуу тодорхой нөхцөлийн үндсэн дээр эрхээсээ татгалзах тухай илэрхийлсэн илэрхийлэлээ буцаан татаж болно. Харин шүүхийн өмнө

мэдэгдэл хийх маягаар илэрхийлсэн бол уг мэдэгдлийг эргүүлэн татах боломжгүй юм. Өөрөөр хэлбэл, энэ нь нэгэнт шүүх ажиллагаа эхэлсэн бол зөвшөөрлөө буцаах нь ямар ч боломжгүй гэсэн үг юм.¹⁸ Үндэсний хуульд уг эрхээсээ татгалзах тухай гадаад улсад байгаа дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн томилогч улсынхаа нэрийн өмнөөс илэрхийлэх эрхтэй гэсэн зохицуулалт байдаг.¹⁹

• Хуваарьлагдсан өмч

Хувиарлагдсан өмч гэдэгт төрөөс нэхэмжлэлийн шаардлагыг хангах зорилгоор хуваарилсан өмчийг ойлгох бөгөөд энэ нь хохирлыг барагдуулахад хүрэлцэхүйц байх ёстой.²⁰

1(с) Улсын зөвшөөрлийг шаардахгүйгээр албадлагын арга хэмжээ авах *альтернатив нөхцөл* НҮБ-ын конвенцийн 19(с) дүгээр зүйлд хариуцагч улсын худалдааны бус зорилгоор хэрэглэж буй эсхүл хэрэглэгдэх өмчөөс бусад өмч нь нэхэмжлэгч улсын нутаг дэвсгэр дээр оршиж байвал уг эд хөрөнгийг нэхэмжлэгч улс битүүмжилж болно гэж заажээ.

• Төрийн худалдааны бус зорилгоор хэрэглэж буй эсхүл хэрэглэгдэх өмч

НҮБ-ын конвенцийн дагуу уг ойлголт 3 үндсэн хязгаарлалтыг тогтоосон байдаг. Нэгдүгээрт, битүүмжлэгдэх гэж байгаа эд хөрөнгө нь "төрийн худалдааны бус зорилгоор" хэрэглэгдэх эд хөрөнгө байх, хоёрдугаарт, тухайн эд хөрөнгө нь нэхэмжлэгч улсын нутаг дэвсгэр дээр байх, гуравдугаарт тухайн эд хөрөнгө нь хэрэгт холбогдож буй этгээдтэй холбоотой байх гэсэн хязгаарлалт юм.

а. Өмчийн зориулалт

Хариуцагч улсын зөвшөөрлийг шаардахгүйгээр худалдааны зориулалттай эд хөрөнгийг

¹⁵ Уг конвенци нь соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан эсхүл нэгдэн орсон тухай 30 дахь баримт бичгийг НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргад хадагнуулахаар хүргүүлснээс хойш 30 дахь хоног дээр хүчин төгөлдөр болно.

¹⁶ UN Convention on Jurisdictional Immunities of States and Their Property, 2004, Annex, UN-Doc.

¹⁷ Art. 21. UN Convention on Jurisdictional Immunities of States and Their Property, 2004, Annex, UN-Doc.

¹⁸ Mag. Eva Wiesinger, *State Immunity from enforcement measures*, p. 7.

¹⁹ Английн Төрийн дархан эрхийн тухай 1978 оны хууль 13 (5) дахь заалт. Австралийн гадаад улсын төрийн дархан эрхийн тухай 1985 оны хууль 31 (5) дахь заалт.

²⁰ Art. 18(b), 19(b) UN Convention on Jurisdictional Immunities of States and Their Property, 2004, Annex, UN-Doc.

нэхэмжлэгч улс битүүмжилж болох боловч тодорхой төрлийн эд хөрөнгөд халдаж болохгүй юм. Үг халдаж болохгүй өмчийн талаар НҮБ-ын конвенцийн 21 дүгээр зүйлд зохицуулсан. Үүнд дараах худалдааны бус зорилгоор хэрэглэх төрийн өмч хамаарна:

- *Дипломат төлөөлөгчийн газар, олон улсын байгууллага дахь тусгай төлөөлөгч, эсвэл олон улсын хуралд оролцож буй төлөөлөгчдийн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор ашиглаж буй эд хөрөнгө болон банкны данс* – Дипломат төлөөлөгчийн газрын эд хөрөнгийг зарцуулах талаар Дипломат харилцааны конвенци болон үндэсний хууль тогтоомжид тусгайлан зохицуулалт байдгаас гадна үүнийг Төрийн шүүхийн болон түүний өмчийн дархан эрхийн тухай НҮБ-ын конвенцид бататган зохицуулсан юм. Элчингийн байр, бусад эд хөрөнгийг битүүмжилж болохгүй тухай үндэсний шүүхүүдийн практик байдаг. Энэхүү практикийг төрийн нэрийн өмнөөс худалдааны бус үйл ажиллагаа явуулдаг соёлын төв, мэдээллийн оффист хамааруулан хамгаалалтад оруулдаг. Дипломат төлөөлөгчийн газрын эд хөрөнгөтэй холбоотой хэргүүд ихэвчлэн элчингийн банкны данстай холбоотой байдаг. Тухайлбал, 1977 онд Филиппинийн Элчин сайдын яамны банкны данстай холбоотой хэрэг Германы Холбооны Үндсэн хуулийн шүүхэд гарчээ. Нэхэмжлэгч нь Филиппинийн Элчин сайдын яамны байрыг эзэмшдэг. Түрээс болон засварын нийт төлбөр болох 95.000 DM-ийг хариуцагч буюу Филиппиний гал төлөх тухай шүүхийн шийдвэр гарсан. Тиймээс нэхэмжлэгч тал хариуцагчийн Бонн хотод байрлах Дойче банкин дахь дансанд албадан арга хэмжээ тогтоохыг хүссэн. Гэвч Холбооны Үндсэн хуулийн шүүх гэрээний практик, үндэсний шүүхийн шийдвэрийг судлаж үзсэний үндсэн дээр элчингийн данс нь төрийн бүрэн эрхт

байдлын хүрээнд худалдааны бус зорилгоор үйл ажиллагаагаа эрхлэн явуулахтай холбоотой мөнгөн хөрөнгийг агуулдаг тул түүнд албадан арга хэмжээ тогтоох үндэслэлгүй юм гэж шийдвэрлэжээ.

- *Цэргийн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор ашиглаж буй цэргийн эд хөрөнгө* – Цэргийн усан онгоц удаан хугацааны туршид албадан арга хэмжээ авахаас ангид байх дархан эрхтэй байсан бөгөөд үүнийг олон тооны олон талт гэрээгээр зохицуулсан. 1926 оны Төрийн өмчийн усан онгоцны дархан эрхтэй холбоотой дүрэм журмыг нэгтгэсэн Брюсселийн конвенци нь энгийн төрийн өмчтэй усан онгоц болон худалдааны бус үйл ажиллагаанд ашиглах төрийн өмчтэй усан онгоц хоёрыг хооронд нь ялгаж авч үздэг бөгөөд сүүлдээ эдгээр нь албадан арга хэмжээ авахаас ангид байх дархан эрхтэй болсон. Төрийн бүрэн эрхт байдлын үйл ажиллагааны хүрээнд хэрэглэгдэж буй зөвхөн цэргийн болон төрийн өмчид усан онгоцыг албадан арга хэмжээ авахаас ангид байх дархан эрх нь өргөжсөн. 1991 оны Олон улсын эрх зүйн комиссын төслийн тайлбарт дурдсанаар цэргийн зориулалтын эд хөрөнгөд усан цэрэг, агаарын хүчний эд хөрөнгийг багтаан олгоно. Мөн зэвсэг, сум, харилцаа холбооны тоног төхөөрөмж, цэргийн онгоц, танк, цэргийн бусад тээврийн хэрэгсэл зэрэг багтана. Эдгээрийг зарж борлуулж болохгүй бөгөөд албадан арга хэмжээ авч болохгүй юм. НҮБ-ын конвенцийн 21(в) дүгээр зүйлийн дагуу цэргийн зориулалттай боловч худалдааны шинжтэй энгийн эд зүйлс буюу хоол, хувцас зэргийг албадан авч болохгүй гэж заасан байна;

- *Улсын төв банкны данс* – Төв банкууд ихэвчлэн гадаад улсын банкинд албаны зорилгоор гадаад валютын нөөцийг бий болгох үүднээс данстай байдаг. Зарим тохиолдолд энэ дансаа төр нь худалдааны үйл ажиллагаанд хэрэглэдэг. Төв банк нь улсын

мөнгөний бодлогыг зохицуулах, хянах, үндэсний мөнгөн хөрөнгийн нөөцийг бүрдүүлдэг. Мөн түүнчлэн гадаад улсын болон олон улсын байгууллагын мөнгөн хөрөнгийг хадгалдаг. Тиймээс улсын төв банкны дансанд албадлагын арга хэмжээ тогтоож болохгүй юм. Албадан арга хэмжээ авахтай холбоотойгоор гарч байгаа нэгэн бэрхшээлтэй асуудал бол банкны дансны зарим мөнгөн хөрөнгийг төрийн бүрэн эрхт байдлын хүрээнд хэрэглэдэг, нөгөө үлдсэн хэсгийг худалдааны зорилгоор хэрэглэдэг төрийн банкны холимог данс юм. Дээр дурьдсан Филиппиний Элчин сайдын яамны банкны данстай холбоотой хэрэг дээр Германы Холбооны Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрт "шүүхийн улсын нутаг дэвсгэрт байгаа гадаад улсын элчин сайдын яамны үйл ажиллагаагаа явуулахад гарах зардалд зарцуулах хөрөнгийг агуулсан энгийн банкны дансыг шүүхийн улс нь битүүмжилж болохгүй" гэж тусгажээ²¹. НҮБ-ын конвенци нь дипломат төлөөлөгчийн газрын банкны дансыг битүүмжлэхийг хориглоно гэж заасан ч уг конвенцид банкны холимог дансыг битүүмжилж болох эсэх талаар тодруулаагүй юм;

- *Худалдаалагдах зорилгогүй улсын соёлын өв болон үзэсгэлэнд тавьсан шинжлэх ухаан, түүхийн холбогдолтой бусад эд хөрөнгө* – Үг эд хөрөнгийн төрөл нь НҮБ-ын конвенцид шинээр тусгагдан ангилал юм. Тус конвенцийн 21 дүгээр зүйлийн (с)-д зааснаар улсын соёлын өв, архив, үзэсгэлэнгийн шинжлэх ухаан, соёл, түүхийн эд зүйлсийг бүрдүүлж буй эд хөрөнгө нь худалдааны зорилгоор ашиглагдах ёсгүй гэжээ. Үйлвэрлэлийн зорилгоор ашиглагдах төрийн өмчийн үзэсгэлэнгийн эд хөрөнгө нь албадлагын арга хэмжээ авахаас дархан байна.

а.а. Өмчийн зориулалтыг батлах
Дээрх ангилалд багтах төрийн эд хөрөнгөнд албадлагын арга хэмжээ

²¹ Philippine Embassy Bank Account Case, Federal Republic of Germany, Federal Constitutional Court, 13 December 1977, 65 ILR 146, 187

авахгүй байх үндэслэл нь тухайн эд хөрөнгө нь төрийн бүрэн эрхт байдлыг хангах зорилгоор ашиглагдана гэдгийг батлах нотолгоо юм. Английн Төрийн дархан эрхийн тухай хуульд Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн тухайн эд хөрөнгө нь худалдааны зориулалтаар хэрэглэгдэх ёсгүй юм гэдгийг гэрчлэх эрхтэй гэж заасан байдаг.²² Гэвч энэхүү зохицуулалт нь "дипломат төлөөлөгч нь гэрчийн хувьд мэдүүлэг өгөх үүрэггүй" гэж заасан Дипломат харилцааны тухай конвенцитай зөрчилдөж байгаа юм.²³

в. Нутаг дэвсгэрийн хязгаарлалт
НҮБ-ын конвенцийн 19(с)-д заасан өөр нэг хязгаарлалт бол тухайн эд хөрөнгө нь шүүхийн улсын нутаг дэвсгэр дээр байх ёстой гэсэн зохицуулалт юм. Уг зохицуулалтад тухайн улсын эд хөрөнгө гуравдагч улсын нутаг дэвсгэр дээр байгаа тохиолдлыг хамааруулахгүй юм. НҮБ-ын конвенци болон Европын төрийн дархан эрхийн тухай конвенци нь нутаг дэвсгэрийн хязгаарлалтыг өөр өөр зохицуулсан. НҮБ-ын конвенци нь албадан арга хэмжээ тогтоож болох эд хөрөнгийг ангилан авч үздэг бол Европын конвенци нь албадан арга хэмжээ авах тухай гадаад улсын шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх эсэх асуудлыг зохицуулдаг.²⁴

с. Эд хөрөнгө нь хэрэгт холбогдож буй этгээдтэй холбоотой байх

НҮБ-ын конвенцийн дагуу нэхэмжлэлийн агууллагаас үл хамааран шүүх ажиллагаанд оролцогч этгээдийн бүх эд хөрөнгийг битүүмжилж болно гэсэн зохицуулалт байдаг. Тус конвенцийн хавсралтад "хэрэгт холбогдож буй этгээд" гэдэгт төр буюу засаглалын бусад байгууллагууд, холбооны улсын үүсмэл этгээд, эсвэл олгогдсон эрхийнхээ хүрээнд бүрэн эрхээ хэрэгжүүлэх улс төрийн нэгдлүүд, олгогдсон эрхийнхээ хүрээнд бүрэн эрхээ хэрэгжүүлэгч агентлагийг ойлгоно гэж тодорхойлсон. Энэхүү тодорхойлолт нь битүүмжлэгдэх эд хөрөнгийн агуулгыг явцуу хүрээнд болгож байгаа юм. Тиймээс албадлагын арга хэмжээ авах эсэх нь зөвхөн "хэрэгт холбогдож буй этгээд"-ийн эд хөрөнгөд хамаатай.

Дүгнэлт

Төрийн хязгаарлагдмал дархан эрхийн онолыг зарим улс хүлээн зөвшөөрөхгүй байгаагийн нэг шалтгаан нь төрийн өмчид албадлагын арга хэмжээ авч төрийн бүрэн эрхт, бие даасан байдалд нь халдаж, улмаар дипломат харилцаанд сөргөөр нөлөөлнө гэсэн үзэлтэй холбоотой юм. Гэхдээ төрийн худалдааны зорилгоор хэрэглэж буй эсхүл хэрэглэгдэх эд хөрөнгөд тухайн төрийн зөвшөөрлийг шаардахгүйгээр албадлагын арга хэмжээ авч болох тухай олон улсын эрх зүйн зохицуулалт байна. НҮБ-ын конвенцид заасан албадлагын арга хэмжээ авч болохгүй хэд хэдэн

тодорхой төрлийн эд хөрөнгийн категори нь төрийн туйлын дархан эрхийн онолыг баримталахыг тодорхой хэмжээгээр хумиж байна. Гэхдээ аливаа төрийн банкны холимог дансны талаарх асуудал тодорхойгүй байгаа юм. Ямар нэгэн улс нь энэхүү банкны холимог дансыг төрийн бүрэн эрхт бие даасан байдлын зорилгоор ашиглаж байна хэмээн худалдааны үйл ажиллагаатай холбоотой мөнгөн хөрөнгийг халхавчлах зорилгоор ашиглаж болзошгүй юм. Улсын банкны дансанд халдах нь олон улсын эрх зүйгээр хориглосон аливаа улсын дотоод хэрэгт оролцсон явдал болно. Элчингийн холимог банкны дансыг битүүмжлэх явдал нь хүлээгч авагч улс нь дипломат төлөөлөгчийн газар үйл ажиллагаагаа явуулахад нь бүх боломжийг олгоно гэсэн Дипломат харилцааны Венийн конвенцийг заалтыг зөрчсөн болно.

НҮБ-ын конвенцийн дээр дурдсан 19, 21 дүгээр зүйл нь эд хөрөнгөд албадлагын арга хэмжээ тогтоож болох эсэх талаар зохицуулснаараа ихээхэн ач холбогдолтой зохицуулалт болсон.

Гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх бодлогыг баримталж буй улсуудын хувьд төрийн дархан эрхийн асуудал ихээхэн ач холбогдолтой болоод байна. Манай Монгол Улс гадаадын хөрөнгө оруулагчдын анхаарлыг ихээхэн татаж байгаа өнөө үед НҮБ-ын конвенцийн ач холбогдлыг авч үзэх нь зүйтэй болов уу.



²² Mag. Eva Wiesinger, *State Immunity from enforcement measures*, p. 15


²³ Дипломат харилцааны тухай Венийн конвенци, 31 дүгээр зүйлийн 2 дахь заалт, 1961 он.

²⁴ Art. 19 UN Convention on Jurisdictional Immunities of States and Their Property, 2004. Annex, UN-Doc. Art. 71 European Convention on State Immunity (ETS No 74), 1972.

МОНГОЛ УЛСАД ЦААЗААР АВАХ ЯЛЫГ ХАЛАХ УУ АЛЬ ЭСВЭЛ...



*Хууль зүйн үндэсний
хүрээлэнгийн Эрүүгийн эрх зүй,
криминологийн секторын эрдэм
шинжилгээний ажилтан,
докторант Г.Оюунболд*



*Хууль зүйн үндэсний
хүрээлэнгийн Захиргаа,
хүмүүнлэгийн эрх зүйн секторын
эрдэм шинжилгээний ажилтан,
магистр А.Түвшинтулга*

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн 2010 оны 1 дүгээр сард хийсэн мэдэгдэлтэй¹ холбогдуулаад цаазаар авах ялыг халах уу үгүй юу гэдэгт эрүүгийн эрх зүйн салбарын болон хүний эрхийн чиглэлээр судалгаа, шинжилгээ хийдэг эрдэмтэн судлаачид өөр өөрийн байр суурийг илэрхийлсээр байна. Энэхүү мэдэглэлийг хийснээс хойш Монгол Улсын хил дээр гарсан дуулиант хэрэгт 3 хүн цаазаар авах ялаар шийтгүүлээд байна. Эдгээр хүмүүсийг Ерөнхийлөгч уучлах болов уу, яах бол?

Энэхүү өгүүлэлээрээ бид цаазаар авах ялыг халах эсвэл хэвээр байлгах талаар 2 өөр байр суурийн үндэслэлийг тайлбарлахыг оролдлоо. Урьд нийтлэгдсэн эрдэм шинжилгээний өгүүлэл болон судлаачдын нийтлэлийг дахин

дурдахаас зайлсхийсэн болно.

Ялын онцгой хэлбэр цаазаар авах ял нь хүн төрөлхтөний түүхэнд байсаар ирсэн төдийгүй Монгол Улсын түүхэнд тодорхой байр суурь эзэлж, эрүүгийн хариуцлагын уламжлалт шинж чанарыг тодотгосоор иржээ. Түүхэн баримтыг судлаж үзэхэд Монгол Улс нь төрт улс болсон үеэс цаазаар авах ялыг хэрэглэж ирсэн бөгөөд "амийг нь авах", "огтчин алах" гэж нэрлэж ирсэнийг тэмдэглэвэл зохино. "Амийг нь авах" гэсэн нэр нь хүнд аюултай гэмт хэрэг үйлдсэн хүний амь насыг төр хүчээр авна гэсэн арай зөөлрүүлсэн утгыг илэрхийлж байгаагаараа өмнөх томъёоллоос ялгаатай аж.

"Цаазаар авах ял"-ыг "цазлах" гэсэн нэр томъёогоор илэрхийлж иржээ. Цаазлах гэсэн үг нь өөрөө хоёрдмол утгатайгаас болж холхь хутган ойлгох, дүгнэх явдал гарч байсан байж магадгүй аж. Энэ үгийн нэг утга нь хүнд гэмт хэрэг үйлдсэн хүний амийг авах, нөгөө утга нь гэмт үйлдэл хийхийг хориглох утга санааг илэрхийлдэг байна.²

Монгол Улсын төр хууль цаазын түүхэн уламжлалаас харахад цаазаар авах ял нь хэрэг заалхайг газар дээр нь түргэн шуурхай шийдвэрлэх сэтгэхүй, цааз бичигтэй холбоотой байсан бөгөөд энэ нь монголчуудын эрт дээр үеэс уламжлагдан ирсэн "амийг амиар" гэсэн менталитеттэй³ шууд холбоотой байжээ. Түүнээс хойш манжийн дарлалын үе болон үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний үеүүдэд ч дээрх уламжлал байсаар ирсэн бөгөөд 9 эрүү шүүлтийг тулгасны

дараагаар цаазалдаг байв. Тэр ч байтугай энэхүү 9 эрүү шүүлтийн хэлбэр эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны нэг хэлбэр төдийгүй алах ялын нэг хэлбэр ч хэмээн ойлгогдож байсан.

Шүүхээс цаазаар авах ял оногдуулах явдлын өсөлт, бууралтад дагаж мөрдөж буй эрүүгийн хууль, тус улсад үйлдэгдэж буй гэмт явдлын шинж буюу онц хүнд гэмт явдлын гаралт, улс орны нийгэм, эдийн засагт гарсан эрс өөрчлөлт, тухайн цаг үеийн ялын бодлого, хүмүүсийн амьдралын түвшин, нийгмийн сэтгэл зүйн байдал гэх зэрэг хүчин зүйл шууд нөлөөлдөг болох нь тодорхой байна. Тухайн цаг үеийн эрүүгийн ялын бодлого цаазаар авах ялд хэрхэн нөлөөлдгийг ганцхан жишээгээр харуулахад 1984 онд МАХН-ын Төв Хорооноос хуулийн байгууллагуудад

¹ 2010 оны 1 дүгээр сарын 14-ний өдөр УИХ-ын чуулганд мэдэгдэл хийхдээ өөрийн Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаанд цаазаар авах ялын гүйцэтгэлийг зөвшөөрөхгүй гэсэн мэдэгдэлийг хийсэн

² Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор И.Дашням "Монгол оронд цаазаар авах ялыг хэрэглэж ирсэн түүхэн уламжлал ба цаашдын чиг хандлагын зарим асуудал" эрдэм шинжилгээний өгүүлэл, "Эрдэм судлал" сэтгүүл, № 45 нэх тал

³ Монгол хүний менталитетыг нэлээд эртний үеэс улируулан философийн үүднээс судалсан нь доктор Н.Хавх болно. Тэр менталитет гэдэг үгийг "унаган төрх" гэсэн монгол нэр томъёогоор дүйлгэн нэлээд утгай тодорхойлсон байна.

хууль ёс ноцтой зөрчигдөж байгаа талаар авах зарим арга хэмжээний талаар тогтоол гаргаж, улмаар ялын бодлогыг чангатгах чиглэлийг хуулийн байгууллагын удирдлагад өгч байжээ. Үүнээс шууд шалтгаалан 1985 онд цаазаар авах ял шийтгүүлэгсдийн тоо 1965 онтой харьцуулахад 285,7 хувиар, өмнөх онтой харьцуулахад 58,8 хувиар гэнэт огцом өсөх хандлага ажиглагдаж байв.

1990-ээд оны үед Монгол Улс нийгмийн эрс өөр тогтолцоонд шилжилт хийсэн онцлог нөхцөл байдлын үед 1991-1995 онд шүүхээс цаазаар авах ялаар шийтгүүлэгсдийн тоо үлэмжхэн өссөн статистик анхаарлыг зүй өсөөр татсаар байна.

Цаазаар авах ялыг халах талаар гарч байсан оролдлогууд: БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1953 оны 8 дугаар сарын 5-ны өдрийн "Алах ялыг өөрчлөх тухай" 93 дугаар зарлигт "БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдээс энх тайван цаг үед алах ялыг хойшид хэрэглэхийн хэрэггүй гэж үзнэ" гэж заажээ. Эл зарлигаар БНМАУ-д дагаж шийтгүүлж байгаа хуулиудаар тогтоосон алах ялыг хэрэглэхгүй болгож, зөвхөн эх орноос урвагчид, тагнуулчид, хорлон сүйтгэгч нарт хэрэглэж байхаар тогтоосон билээ. Цаазаар авах ялыг хүчингүй болгосон энэ заалт дөнгөж 10 орчим сар хэрэгжиж, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1954 оны 67 дугаар зарлигаар хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар бусдыг санаатай алсан гэмт хэрэгт буудан алах ял хэрэглэж байхаар тогтоожээ. Үүний цаад учир шалтгаан нь тухайн үед нэг дор олон хүний амь насыг хөнөөсөн дуулиант хэрэг гарч, ард иргэдийн дургүйцлийг дарах үүднээс хэрэглэхээ больжээ.

1998 онд УИХ-ын гишүүн Д.Хувьсгөлдорж бүрэн эрхийнхээ дагуу Монгол Улсын Эрүүгийн хуульд

байгаа цаазаар авах ялыг халах тухай хуулийн төслийг санаачлан боловсруулж, УИХ-д өргөн барьсан боловч хууль сахиулах байгууллагууд болон хууль тогтоогчид дэмжээгүй тул төслөө парламентаар хэлэлцүүлэлгүй буцаан авч байжээ.⁴

Монгол Улс дахь дахь цаазаар авах ялын байдал:

Монгол Улсын Их Хурал 2002 онд шинэ Эрүүгийн хууль баталж, мөн оны 9 дүгээр сарын 1-нээс эхлэн дагаж мөрдүүлж байна. Тус Эрүүгийн хуулиар дараах төрийн гэмт хэрэгт цаазаар авах ял хэрэглэхээр тогтоосон байна: төр, нийгмийн зүтгэлтний амь биед халдах (81.2 дугаар зүйл); хорлон сүйтгэх (84 дүгээр зүйл); хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар бусдыг санаатай алах (91.2 дугаар зүйл); онц хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар хүчиндэх (126.3 дугаар зүйл); зандачлах (177.2 дугаар зүйл); төрлөөр устгах (302 дугаар зүйл) зэрэг хэрэгт цаазаар авах ял оногдуулж байсан бол Эрүүгийн хуульд (178 дүгээр зүйл) Терроризм гэсэн зүйлийг 2008 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн хуулиар нэмсэнээр нийтдээ 7 зүйлд цаазаар авах ял оногдуулахаар заасан. **Хууль тогтоогчид 2002 оны Эрүүгийн хуулийн ялын бодлогыг маш хатуу чанга болгосноор шүүхээс цаазаар авах ял хэрэглэх байдал өмнөх үетэй харьцуулахад үлэмж нэмэгдэж** 2003-2005 онд өмнөх онтой харьцуулахад энэхүү ялаар шийтгүүлэгсдийн тоо 20 гаруй хувиар тогтвортой өсөх хандлага ажиглагдаж байна. Сүүлийн 40 жилд цаазаар авах ял оногдуулсан шүүхийн шийдвэрт хийсэн судалгаа⁵ (1965-2005)-наас үзэхэд 806 хүнд цаазаар авах ял оногдуулсан байна.

2000 онд шүүх 13 хүнд цаазаар авах ял оногдуулснаас Улсын Дээд шүүхийн давж заалдах шатны шүүхээс тэдгээр шийтгэх

тогтоолуудаас 3-ыг өөрчилж, 2-ыг хүчингүй болгож байжээ.⁶ Энэ бол ихээхэн ноцтой баримт юм. Өөрөөр хэлбэл, нэг жилд шүүхээс цаазаар авах ял оногдуулсан тогтоолын 30 шахам хувь нь зөвхөн давж заалдах шатны шүүхээр өөрчлөгдснөөс 10 шахам хувь нь хүчингүй болсон буюу өөрөөр, хэлбэл цаазаар авах ялыг шүүх гэм буруугүй хүнд ногдуулж байсан гэсэн хэрэг юм.⁷

Цаазаар авах ялын талаархи уучлалт: "Цаазаар авах ял шийтгүүлсэн хүн бүр ял хэлтрүүлэх хүсэлт гаргах эрхтэй. Бүх тохиолдолд ял хэлтрүүлж, өршөөл уучлал үзүүлж, цаазаар авах ялыг өөрчилж болно." гэж Монгол Улсын нэгдэн орсон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 6 дугаар зүйлийн 4-т заасан билээ.

Монгол Улсын Үндсэн Хуулийн 33 дугаар зүйлийн 1.8-д зааснаар ялтанд уучлал үзүүлэх нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрх болохыг хуульчилсан бөгөөд уучлал үзүүлсэн тохиолдолд Ерөнхийлөгч зарлиг гаргана. Монгол Улсын Эрүүгийн хуулийн 53.3-т "Цаазаар авах ял шийтгүүлсэн этгээд Монгол Улсын Ерөнхийлөгчид хандаж уучлал хүсэх эрхтэй. Монгол Улсын Ерөнхийлөгч цаазаар авах ял шийтгүүлсэн этгээдийн амийг уучилсан тохиолдолд 30 жилийн хугацаагаар ганданд хорих ялаар солино" гэж заажээ.

Үүний дагуу Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж цаазаар авах ял шийтгүүлсэн этгээд нэг бүрийн амь насыг өөрийн бүрэн эрхийн хүрээнд уучилна хэмээн мэдэгдсэн. Харин үүнийг Эрүүгийн хууль болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх нь УИХ-ын бүрэн эрхийн асуудал юм. Харин энэ талаар Ерөнхийлөгч хууль санаачилж болно.

Цаазаар авах ял шийтгүүлсэн ялтанд уучлал үзүүлэх явдлыг

⁴ Хүний амьд явах эрх ба цаазаар авах ял судалгааны тайлангаас Монголын Эмнести Интернэшнл УБ, 2006 он

⁵ Хүний амьд явах эрх ба цаазаар авах ял судалгааны тайлангаас Монголын Эмнести Интернэшнл УБ, 2006 он

⁶ Монгол Улс дахь хүний эрхийн төлөө байдал УБ, 2001 он 76 дахь тал

⁷ Хүний амьд явах эрх ба цаазаар авах ял судалгааны тайлангаас УБ, 2005 он Монголын Эмнести Интернэшнл судалгааны

тайлангаас

"Ялтанг уучлал үзүүлэхийг хүссэн өргөдлийг хянан шийдвэрлэх журм"-аар зохицуулж байгаа бөгөөд эл журмыг Ерөнхийлөгчийн 2002 оны 156 дугаар зарлигаар баталсан.⁸ Зарим судлаач "Ерөнхийлөгчийн уучлал нь цаазаар авах ялыг 30 жил гянданд хорих ялаар сольж байгаа мэт боловч нөгөө талаас шүүх эрх мэдлийн байгууллагын ажилд оролцож байна, нэгэнт шүүхийн эцсийн шийдвэр гарсан нөхцөлд хэн ч өөрчлөх эрхгүй" гэж дүгнэжээ.

Цаазаар авах ялын талаарх дэлхий дахины нийтлэг чиг хандлага

Дараахи олон улсын гэрээгээр цаазаар авах ял ногдуулахыг хориглосон буюу хязгаарласан байна:

- Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт;
- Америкийн хүний эрхийн конвенцийн цаазаар авах ялыг халах тухай протокол;
- Европын хүний эрхийн конвенцийн 6 дугаар протокол;
- Европын хүний эрхийн конвенцийн 13 дугаар протокол.

Цаазаар авах ялын гүйцэтгэлийн байдл: Өнөөдөр 20,000 гаруй хүмүүс цаазаар авах ялаар шийтгүүлэн хэзээ гүйцэтгэхийг хүлээж байгаа нь Эмнести Интернэшнл байгууллагын судалгаагаар тогтоогдоод байна. Зөвхөн 2005 онд гэхэд л дэлхийн 53 оронд нийт 5,186 иргэнд цаазаар авах ял ногдуулж, түүнээс 22 улс нь хамгийн наад зах нь 2,148 иргэнд цаазаар авах ялыг гүйцэтгэжээ. Үүний 94 хувийг Хятад, Иран, Саудын Араб, АНУ эзэлж байна. Хятад зэрэг олон Засгийн газар цаазаар авах ялын гүйцэтгэлийн талаарх албан ёсны статистик тоо баримтыг хэвлэн нийтлэхээс татгалздаг. Вьетнам гэхэд л статистикийн тоо баримтаа ангилан цаазаар авах ял нь "төрийн нууц" хэмээн зарласан байдаг гэх мэтээр цаазаар авах ялын талаарх тоо

баримтыг нууцлах нь их байдаг болохоор дээрх тоо баримтыг ойлголцоогоор гаргасан гэж үзэж болно.

Цаазаар авах ялыг хязгаарласан болон халсан байдл: Өнөөдрийн байдлаар цаазаар авах ялыг бүхэлд нь халсан 95, жирийн гэмт хэргүүдэд халсан 9, практикт халсан 35, буюу нийтдээ 139 орон цаазаар авах ялыг хуульдаа болон практикт халчихаад байна.

Цаазаар авах ялыг халж байгаа улс орнуудын тоо жилээс жилд өсөн нэмэгдсээр байна. Сүүлийн 20 жилд олон улс гүрэн цаазаар авах ялыг гүйцэтгэхээ хоёр дахин багасгажээ. Дэлхийн улс орнуудын талаас илүү хувь нь цаазаар авах ялыг нэгэнт халсан байна. Үүнийг тоон үзүүлэлтээр гаргавал 95 улсад бүх төрлийн гэмт хэрэгт цаазаар авах ял оногдуулахыг цуцалсан байна. Мөн 11 улс дайны үеийн гэмт хэргээс бусад тохиолдолд цаазаар авах ял оногдуулахыг цуцалжээ. Түүнчлэн 25 улс цаазаар авах ялыг хуульдаа тусгасан ч хэрэглэхээ зогсоож, сүүлийн 10 гаруй жилд цаазаар авах ялын гүйцэтгэл нэг ч удаа хийгдээгүй байна. Үүнээс үзэхэд нийтдээ 139 улс цаазаар авах ял ногдуулах болон гүйцэтгэхээ зогсоосон байна. Харин дэлхийн 58 улс орон энэ ялыг хэрэглэж байна.

Цаазаар авах ялыг дахин хэрэглэсэн орнууд: Цаазаар авах ялыг цуцалсан улс орнуудаас зарим нэг тохиолдолд дахин хэрэглэсэн явдал гарсан байна. 1985 оноос хойш 50 гаруй улс цаазаар авах ялыг халж, ердийн болон бүх төрлийн хэрэгт ийм ял оногдуулахаа зогсоосон юм. Энэ хугацаанд ялын дээд хэмжээ оногдуулахыг хориглосон улс орнуудаас зөвхөн 4 улс л дахин хэрэглэжээ. Гэвч Непал, Филиппин улс дахин хэрэглэж байсан боловч Непал 1997 онд, Филиппин улс 2007 онд халжээ. Нөгөө 2 улс болох Гамби, Шинэ Гвинейн Папуа нь одоогоор ямар ч

гүйцэтгэл хийгээгүй байна.

ДҮГНЭЛТ:

Цаазаар авах ялыг халах тухай: (А.Түвшинтүлгэ)

Цаазаар авах ял нөхөн сэргээх боломжгүй ял шийтгэлийн хамгийн хүнд хэлбэр. Иймээс хэрэв хангалттай нотолгоогүйгээр цаазаар авах ял оногдуулсан бол энэ нөхөн сэргээх боломжгүй хүний эрхийн хамгийн том зөрчил болдог.

• Ял шийтгэлийн бодлогын хувьд цаазаар авах ял цээрлэл үзүүлэх, урьдчилан сэргийлэх нөлөөлөл хэрэгжиж байгаа гэсэн ямар ч үндэслэл, нотолгоо байхгүй. Ял шийтгэлийн бодлого хатуу байснаар хэргийн гаралт буурсан тухай готорхой баримт байхгүй. Нөгөөтэйгүүр, Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан 30 жилийн хугацаагаар гянданд хорих ял цээрлэлийн хувьд харьцангуй илүү шийтгэл болдог.

• Олон улсын хүний эрхийн хэм хэмжээний наад захын шаардлагад нийцүүлэн Монгол Улс нь цаазаар авах ялыг зөвхөн онц ноцтой хүнд гэмт хэргүүдэд (Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын Пакт 6-2) оноох-ыг шаардаж байна. "Онц ноцтой хүнд гэмт хэрэг"-ийн цар хүрээ нь урьдчилан төлөвлөсөн аллага, санаатайгаар болон урьдаас төлөвлөсөн хүн алахыг завдсан гэмт хэргүүдээр хязгаарлагддаг.

• Цаазаар авах ялаар шийтгүүлсэн байдлыг төрийн нууцад хамааруулж, олон нийтээс нууцалж байгаа одоогийн нөхцөл байдлыг өөрчлөх. Уг ялыг ямар байгууллага, хэрхэн яаж гүйцэтгэдэг, цогцсыг хэрхэн оршуулдаг, нас барсныг иргэний бүртгэлд хэрхэн тэмдэглэдэг, ЦАЯ-онгдуулсаны дараа цогцсыг ар гэрийнхэнд нь өгч болох эсэх заалт байхгүй байгаа нь тэднийг нэгэн адил залхаан цээрүүлж байгаа үйлдэл юм.

• Шүүхийн алдаа хэрэв анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр хангалттай үндэслэл

⁸ Энэ зарлиг нь төрийн нууцын зэрэглэлд хамаарах байна.

⁹ Далайбаатар "Эрүүгийн эрх зүй дэх хорих ялын асуудал" эрдэм шинжилгээний өгүүлэл. "Эрдэм судлал" сэтгүүл. 2002 он. УБ хот. 56 дахь тал.

"Хувьд бэлдэх ёс", 2010 он, №1

ХУУЛЬ БУСААР УЛСЫН ХИЛ НЭВТРЭХ ГЭМТ ХЭРГИЙН ШАЛТГААН, НӨХЦӨЛ

ТЭГ-ын Дорнод аймаг дахь газрын дарга, хурандаа, докторант Ц.Доржням

Хууль бусаар улсын хил нэвтрэх гэмт хэрэгт явуулах тэмцлийг боловсронгуй болгоход тухайн гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг судалж, тогтоох нь ач холбогдолтой билээ.

Ингэхдээ юуны өмнө Монгол Улсад гарч буй гэмт явдлын ерөнхий шалтгааныг авч үзэх шаардлагатай.

Монгол Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судалсан судалгааны тайлангаас үзвэл, хувь хүн гэр бүлтэй холбоотой шалтгаан 24,1 хувь, нийгмийн шалтгаан 18,6 хувь, хувь хүн, нийгмийн хавсарсан шалтгаан 57,5 хувь байгаа ба үүний дотор судлагаанд оролцогчдын 49,7 хувь нь ядууралтай холбоотой, 48,6 хувь нь ажилгүйдэлтэй холбоотой гэж үзжээ.¹

Энэхүү шалтгаан нь мөн 2007 онд бүртгэгдсэн гэмт хэргийн 23 хувь нь согтуугаар үйлдэгдсэн, гэмт хэрэгт холбогдогсдын 61 хувь нь эрхэлсэн тодорхой ажилгүй хүмүүс байгаа бөгөөд нийт хүн амын 32,2 хувь нь амьжиргааны баталгаажих доод түвшингээс доогуур байгаагаар² давхар батлагдаж байна.

Хууль бусаар улсын хил нэвтрэх гэмт хэргийн гаралтад дээр дурьдсан нийтлэг шалтгаан, нөхцөл нөлөөлөөхөөс гадна доорх гадаад хүчин зүйл нөлөөлж байна. Үүнд:

а) Манай улс дэлхийд нээлттэй гадаад бодлого баримтлах боловч гадаадаас хувийн хэргээр зорчин иргэдийн тоо өсөн нэмэгдэхийн хэрээр хууль бусаар улсын хил нэвтрэх гэмт хэрэг үйлдэх явдал дорвитой буурахгүй байгаа билээ;

б) БНХАУ-ын талаас Монгол Улсаар дамжин бусад улсад цагаачлах Хятадын иргэд болон Солонгосын

дүрвэгсэдэд тавих хяналт сул байгаагаас хууль бус цагаачлалын урсгал таслан зогсоогдохгүй байна.

в) Манай улстай хилэлсэн ОХУ-ын Тува улсын хилийн районд зохион байгуулалтай янз бүрийн бүлэг этгээдүүд хил дамнансан гэмт үйл ажиллагаа явуулж байна.

г) ОХУ-ын хууль хяналтын байгууллагаас манай улстай хилэлсэн хилийн хэсэгт үйлдэгдэж буй хил дамнансан гэмт хэрэгтэй шийдвэртэй тэмцэл явуулахгүй байгаа байдал.

д) ОХУ-ын Буриад улстай хиллэсэн ой тайгын хэсэгт Оросын талын хил хамгаалалт үндсэндээ байхгүй зөвхөн тагнуулын хүч хэрэгслээр зохион байгуулдаг зэрэг нь хууль бусаар улсын хил нэвтрэх гэмт хэргийн гаралтад сөргөөр нөлөөлдөг.

Хууль бусаар улсын хил нэвтрэх гэмт хэргийн гаралтад доорх шалтгаан, нөхцөл нөлөөлж байна гэж үзэж байна.

1. Ажилгүйдэл, ядуурал.

Хил хамгаалах болон хууль сахиулах байгууллагуудын 380 ажилтны дунд анкетын асуулга явуулсан дүнг нэгтгэн шинжилж үзэхэд³ ажилгүйдэл 69,0 хувь, ядуурал 29,7 хувь тус тус нөлөөлдөг гэж үзсэн нь тухайн гэмт хэргийн гаралтад нөлөөлдөг гол шалтгаан болж буйг баталж байгаа юм.

"Улсын хилийн аюулгүй байдал" сэдэвт арилцлагад оролцсон хүмүүсийн 37,4 хувь ажилгүйдэл, 22,7 хувь нь ядуурал хууль бусаар улсын хил нэвтрэх гэмт хэргийн шалтгаан болж байна гэж үзэж байв.⁴

Бидний хийсэн хэсэгчилсэн судалгаагаар хууль бусаар улсын хил нэвтрэх гэмт хэрэгт шийтгэгдэгсэдийн 88 хувь нь ажил, сургуульгүй хүмүүс, 52 хувь амьдралын түвшин доогуур

хүмүүс байгаа юм. Судалгаанд хамрагдсан ялтнуудын 60 хувь нь амьдралын нөхцөл, материаллаг байдлаа сайжруулахын (орон байртай болох) тулд мөнгөтэй болох зорилгоор хууль бусаар Монгол Улсын хил нэвтрэн гадаад улсад гарсан, дээрх зорилгоор хууль бусаар улсын хил нэвтрэн гарахыг завдсан хүмүүс байна.⁵

2. Хүмүүсийн зан төлөв, ёс суртахууны доголдол.

Манай ард түмэн олон зуун жилийн турш төрөө дээдэлж, хууль цаазаа хүндэтгэж ирсэн зан заншил, уламжлал, ёс зүйн хэм хэмжээ, үнэлэмжийн чиг баримжаа нь зах зээлийн нийгэмд алдагдах болсон нь ёс суртахууны доройтолд орж, улмаар гэмт хэрэг түүний дотор хууль бусаар улсын хил нэвтрэх гэмт хэрэг гарах нэг шалтгаан болж байна.

Бидний хийсэн судалгаагаар хууль бусаар улсын хил нэвтрэх гэмт хэрэг үйлдэхэд хувь хүний ёс суртахууны доройтол, зан төлөвийн гажуудал 16,6 хувь, боловсрол, мэргэжил 19,5 хувь, эрх зүйн ухамсар 41,8 хувь тус тус нөлөөлдөг болох нь харагдаж байгаа болно.⁶

Хил зөрчигчдийн материал, хууль бусаар улсын хил нэвтрэх гэмт хэрэгт шийтгэгдсэн хүмүүсийг судалж үзэхэд Монгол Улсын хилийн халдашгүй байдлыг хүндэтгэх, Улсын хилийн тухай хууль тогтоомж, хөрш улсуудтай хилийн асуудлаар байгуулсан гэрээ, хэлэлцээрийг сахин биелүүлэх ёс суртахуун төлөвшөөгүй, гэмт хэргийн замаар ашиг олох, өөрийн хэрэгцээ, явцуу сонирхлоо урьтал болгодог нь тэдний ёс суртахуун доройтсныг харуулж байна. ОХУ-ын Тува улсын талаас хууль бусаар улсын нэвтрэх

¹ Монгол Улсын хэмжээнд 1990-2004 онд бүртгэгдсэн гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг судалж, дүгнэлт гаргах ажлын хэсгийн судалгааны тайлан. УБ. 2005 он. 43 дахь тал.

² П.Измая. Монгол Улс дахь 2007 оны гэмт хэргийн нөхцөл байдал. "Хууль дээдлэх ёс" сэтгүүл. УБ., 2008 он. № 1.

³ Ц.Доржням. Хуульчдын дунд явуулсан санал асуулгын дүн. УБ., 2009 он.

⁴ Ц.Доржням. Улсын хилийн аюулгүй байдал сэдэвт арилцлагын нэгдсэн дүн. УБ., 2009 он.

⁵ Ц.Доржням. Ялтнуудын дунд явуулсан судалгааны нэгдсэн дүн. УБ., 2008 он.

⁶ Хуульчдын дунд явуулсан санал асуулгын дүн. УБ., 2009 он.

гэмт хэрэг үйлдэгсэдийн дийлэнх нь хил зөрчин мал хулгайлах нь амьдралын утга учир, итгэл үнэмшил нь болсон байдаг онцлогтой.

Хууль бусаар хил нэвтрэх гэмт хэрэг үйлдэж буй манай улсын иргэдийн хувьд гадаадад гарч ажиллахын тулд үндэсний хууль тогтоомжийг үл хүндэтгэн, залилан мэхлэх янз бүрийн арга хэрэглэн улсын хил зөрчиж өөрсдийн зорилгоо хэрэгжүүлж байдаг бөгөөд тухайлбал, урьд нь гэмт хэрэг үйлдэн 2 удаа ял шийтгэгдэж байсан, 2000 онд өөрийн бичиг баримтаар хил нэвтрэн Япон улсад зорчин хуурамч визтэй гэдэг үндэслэлээр албадан гаргуулж байсан Монгол Улсын иргэн "Г" нь бусдын нэрээр хуурамч иргэний үнэмлэх, гадаад паспорт 800 доллараар гаргуулан авч, 2004-2008 оны хооронд Замын-Үүд, Алтанбулаг, Буянт-Ухаа хилийн боомтуудаар нийт 10 удаа улсын хилийг хууль бусаар нэвтэрсэн гэмт хэрэг үйлдсэн⁹ баримтыс харж болно.

3. Хууль бус аргаар мөнгө олох гэсэн шунахайн сэдэлт шалтгаан.

Хилийн боомт бус газраар хууль бусаар Монгол Улсын хил нэвтрэх гэмт хэргийг үйлдэгсэдын хувьд ямар ч аргаар хамаагүй мөнгө олох, хуримтлуулах, ашиг орлогоо нэмэгдүүлэх гэсэн өөрийн сонирхол, хэрэгцээ нь уг гэмт хэргийг үйлдэх нэг шалтгаан болж байна. Эд зүйл, мал амьтан хууль бусаар улсын хил нэвтрүүлэх, хулгайн ан хийх зорилгоор улсын хил зөрчигсэдийн гэмт үйлийн шалтгаанд шунахайн сэдэлтэй шалтгаан голлох байдалтай байдаг. Жишээ нь. Дорнод аймгийн Халх гол суманд оршин суугч, эрхэлсэн тодорхой ажиггүй иргэн "Г. Т. Д. Бо Ба" нар бүлэглэн 1998-2000 онд Дорнод аймгийн хилийн хороодын (24.31) хариуцсан хилийн хэсгээр улсын хил зөрчин 4 удаагийн үйлдлээр нийт 147 адуу Хятадын талаас хулгайлан улсын

хилээр хууль бусаар нэвтрүүлэн оруулж ирсэн гэмт хэрэг үйлдсэн,⁸ Монгол Улсын иргэн "Д" нь 2007 оны 9 дүгээр сарын 18-ны шөнө Увс аймаг дахь хилийн хорооны хариуцсан хэсэг, улсын хилийн 115/1 дүгээр тэмдэгтээр иргэн Ц.О.Т нартай бүлэглэн улсын хил зөрчин 295 хонь улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэн гаргасан, хилийн хариуулын дарга "А"-д 200.0 мянган төгрөгийн хээл хахууль өгсөн, мөн 2007 оны 6 дугаар сарын 20-ны шөнө хилийн 116 дугаар тэмдэгтээр хил зөрчин, бусадтай бүлэглэн 120 хонь хууль бусаар улсын хилээр нэвтрүүлэн гаргасан гэмт хэрэг үйлдсэн⁹ зэрэг баримтаас тухайн гэмт хэргийн шунахайн сэдэлт шалтгаан хангалттай харагдана.

4. Улсын хил хамгаалалт, хилийн боомтын үйл ажиллагаанд оршиж буй сөрөг үзэгдэл.

Бидний явуулсан анкетын судалгаа¹⁰, "Монгол Улсын хилийн аюулгүй байдал" сэдэвт ярилцлагын¹¹ үр дүнг шинжлэхэд хууль бусаар улсын хил нэвтрэх гэмт хэргийн гаралтад улсын хилийн хамгаалалт, хилийн боомтын хяналт шалгалт сул байдал 15.2-18.2 хувь нөлөөлж байгаа нь харагдаж байна.

Мөндэрх ярилцлагад хамрагдсан хүмүүсийн 30 хувь нь улсын хилийн халдашгүй байдал хангагдаж чадахгүй байна. Монгол-Тувагийн хилийн зөрчил дорвитой буурахгүй, хуурамч бичиг баримтаар улсын хил нэвтрэх гэмт хэрэг өсч байгаад үргэлж сэтгэл зовниж явдаг (55%) тухайгаа илэрхийлж байсан юм¹².

Олон нийтээс улсын хил хамгаалалт, хил дээр үйлдэгдэж буй гэмт хэрэг, хилийн зөрчлийн асуудалд хэрхэн хандаж байгааг судлах зорилгоор 2008 он, 2009 оны нэгдүгээр улирын өдөр тутмын хэвлэл "Өдрийн сонин", Зууны мэдээ" сонинд нийтлэгдсэн материалыг түвээрлэн авч судлахад нийт 82 материал

нийтлэгдсэний 68.3 хувьд нь улсын хилийн зөрчил, улсын хил дээр үйлдэгдэж буй хууль бусаар улсын хил нэвтрэх болон бусад төрлийн гэмт хэрэг, тэдгээрийн шийдвэрлэлтийн талаар мэдээ нийтэлж, улсын хил хамгаалалтыг бэхжүүлэх, хилийн зөрчил, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх шаардлагатайг төр, олон нийтийн сонорт хандуулсан байв.

Хилийн боомтоор тодорхой этгээд хуурамч бичиг баримтаар удаа дараа нэвтрэж байхад хилийн шалган нэвтрүүлэх албаны шалгагчид шатм (хил нэвтрэх дардас) дарж хилээр нэвтрүүлж байсан баримт олон байгаа нь тэдний ажлын хариуцлагатай холбоотойгоос гадна өс суртахууны доголдолтой ч холбоотой гэж үзэх үндэстэй юм. Тухайлбал, иргэн Ц.Э нь хуурамч бичиг баримт ашиглан 2007-2008 онд улсын хилээр 35 удаа нэвтэрсэний эцэст хэрэг нь илэрч шүүхээр шийтгэгдэж байсан баримт байдаг.¹³

Хил хамгаалах байгууллагаас улсын хилийн зөрчилтэй холбоотой гэмт хэргийг гол төлөв захиргааны зөрчилд тооцож шийдвэрлэх,¹⁴ улсын хилийн дэглэм зөрчигсөдөд хүлээлгэх захиргааны хариуцлагын үр нөлөө муу, зарим тохиолдолд хил зөрчсөн үйлдэлд хариуцлага хүлээлгэхгүй байх, эсхүл тухайн үйлдлийг хууль сахиулах байгууллагад мэдэхгүйгээр нуун дарагдуулах зэрэг сөрөг үзэгдэл нь хууль бусаар улсын хил нэвтрэх гэмт хэргийн гаралтад зохих хэмжээгээр нөлөөлж байгаа юм.

Улсын хил хамгаалалтын нягтрал сул, ялангуяа ОХУ-тай хиллэсэн хуураах, ой, тайгын бүсийн хил хамгаалалтын нягтрал сул байдал нь ОХУ-ын Тува улстай хиллэсэн хэсгээр мал хулгайлах, эд зүйл улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх, хулгай хийх зорилгоор улсын хилийг хууль бусаар нэвтрэх гэмт хэргийн гаралтад нөлөөлж байна. Өнөөгийн байдлаар

⁸ Хан-Уул дүүргийн шүүхийн шийтгэх тогтоол 2008 оны 7 дугаар сарын 23-ны өдөр №132

⁹ Мөрдөн байцаалтын хавтаст хэрэг №20017172, Дорнод, 2001 он

¹⁰ Мөрдөн байцаалтын хавтаст хэрэг №20817063, Увс 2008 он, 535-536 дахь тал

¹¹ Дурдсан санал асуулгын дүн, 2009 он

¹² Дурдсан ярилцлагын дүн, 2009 он

¹³ Мөн тэнд

¹⁴ Нийслэлийн Хан-уул дүүргийн шүүхийн 2008 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 176 дугаар шийтгэх тогтоол.

¹⁵ Судалгаанд оролцогчдын 15.8 хувь

Хилийн отряд, заставт хүч хэрэгсэлийн нягтрал, хамгаалалтын боломж, зэвсэглэл, техникийн хангамж, хангалтыг сайжруулах шаардлага зүй ёсоор тавигдаж буй талаар хил судлалын чиглэлийн судлаачид төдийгүй "Улсын Хилийн аюулгүй байдал" сэдэвт ярилцлагад оролцогчид үзэж байгаа билээ.¹⁵

Мөн улсын хил хамгаалалтын байдалд тавих хяналт сулаас хилчид өөрсдөө улсын хилийг хууль бусаар нэвтрэх гэмт хэрэгт хамтран оролцох, гэмт хэрэгт үйлдэгсдээс хээл хахууль авах зэргээр уг гэмт хэрэг үйлдэх нь таслан зогсоогдохгүй байна. Хил хамгаалах байгууллагад ажиллаж байгаад улсын хилээр эд зүйл хууль бусаар нэвтрүүлэх болон хууль бусаар улсын хил нэвтрэх гэмт хэрэг зөрчилд 1992-2003 онд 179 офицер, алагч холбогдож албаанса халагджээ.¹⁶

5. Гадаад улсад найдвартай гаргана, зуучилна гэсэн санал тавьсан зар сурталчилгаа.

Олон нийтийн хэвлэл, мэдээлэлийн хэрэгслээр байнга явагдаж буй гадаадад гаргах, хил нэвтрэх эрхийн бичиг баримт гаргах, улсын хилийн боомтоор найдвартай гаргаж зорьсон улсад нь саадгүй хүргэж өгөх талаарх хэсэг бүлэг, зальхай хүмүүсийн зар сурталчилгаа нь гадаадад гарч ахиухан цалин хөлстэй ажил хийж амьдралын нөхцөлөө сайжруулахыг эрмэлзэж буй залуусыг гэмт хэрэг үйлдэхэд өдөөн турхирч байна.¹⁷ Хэвлэл мэдээлэлийн зар сурталчилгааны мөрөөр холбогдох "түнш"-ээ олж харилцан, гадаадад хууль бусаар гарч ажиллаж байгаад эх орондоо буцаж ирэх үедээ гэмт хэрэг нь илэрч шүүхээр шийтгэгдсэн хүн олон байна.

Сүүлийн жилүүдэд хууль бус зар сурталчилгаандаа интернетийг өргөн ашиглах болсон бөгөөд зөвхөн 2000-

2008 онд интернет зар ашиглан хуурамч бичиг баримт гаргуулан хууль бусаар улсын хил нэвтрэх гэмт хэрэг үйлдэх явдал 28 удаа гарчээ.¹⁸

6. Хууль бусаар улсын хил нэвтрэх гэмт хэргийг шалгаж шийдвэрлэх үүрэг бүхий мөрдөн байцаах, прокурор, шүүхийн үйл ажиллагаанд оршиж буй доголдол дутагдал нь уг гэмт хэргийн гаралтад нөлөөлж байна.

Бидний хийсэн анкетын судалгааны үр дүнгээс¹⁹ хууль бусаар улсын хил нэвтрэх гэмт хэрэгтэй тэмцэхэд эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байгаа нь шүүхээс гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ялыг оновчтой тохируулан хэрэглэхгүй байх (24.5 хувь), хэргийг түдгэлзүүлэх зэргээр хэргийн шийдвэрлэлтийг удаашруулж замхруулах (19.2 хувь), мөрдөн байцаах, прокурорын байгууллага улсын хил зөрчих гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг тухай бүр илрүүлэхгүй байх (17.9 хувь), мөрдөн байцаах байгууллагаас гэмт хэрэг зүйлчлэлийн алдаа гаргах (7.1 хувь) зэрэг зөрчил дутагдал нөлөөлж байна гэж үзэх үндэслэлтэй байгаа юм.

Хууль бусаар улсын хил нэвтрэх гэмт хэргийн гаралтад хууль, хяналтын байгууллага дахь хээл хахууль бага хэмжээгээр (2.3 хувь) нөлөөлдөг талаар практик ажилтнууд өөрсдөө үзсэн²⁰ нь харьцангуй ойголт гэж үзэж байна. Энэ нь хууль сахиулах байгууллага дахь хээл хахуулыг илрүүлэн баримтжуулах явдал хангалтгүй байгаатай ч холбоотой. Сүүлийн жилүүдэд гадаад паспорт хийх технологи боловсронгуй болсноос Иргэний Бүртгэл Мэдээлэлийн Улсын төвийн зарим удирдах ажилтан, байцаагч хил нэвтрэх эрхийн бичиг баримтыг хуурамчаар үйлдэх гэмт хэрэг үйлдэж байсан нь тухайн гэмт хэргийн

гаралтад нөлөөлж байна. ИБМУТ-ын мэдээлэлийн санд ТЕГ-аас хийсэн болон дотоодын хяналт шалгалтын дүнд 2004-2007 онд 200 орчим хүнд хуурамч гадаад паспорт олгосон гэмт хэрэг илэрч, эрүүгийн хэрэг үүсгэн шалгагдаж тодорхой хэсэг нь шүүхээр шийдвэрлэгджээ.²¹

Хилийн боомтоор хууль бусаар улсын хил нэвтрэх гэмт хэрэг үйлдэгсэд нь хуурамч гадаад паспорт бусдаар гаргуулахдаа их хэмжээний мөнгийг хээл хахуулын журмаар өгдөг нь мөрдөн байцаалт, шүүхийн шатанд тогтоогддог. Харин уг мөнгийг авсан зуучлагч гэж хүний нэр, хаяг тодорхой бус, түүнийг тогтоож чадаагүйгээс хээл хахуулийг ямар албан тушаалын хэнд өгөв гэдэг нь тогтоогдохгүй нууц хэвээр үлддэг. Тухайлбал, иргэн "Ц" нь эхнэр "Н"-ын хамт "Зар" сонины зарын дагуу "Н" гэх хүнтэй танилцан, тохиролцож 2004 оны 8 дугаар сарын 5-ны өдөр бусдын нэрээр БНСУ-ын визтэй өөрсдийн зурагтай хуурамч гадаад паспортыг тус бүрийг нь 5700 доллараар гаргуулан авч хууль бусаар улсын хил нэвтрэх гэмт хэрэг давтан үйлдсэн.²² иргэн "М" нь Тува гэгчээр зуучлуулан, 1500 доллар өгч хуурамч паспорт гаргуулан, ашиглаж, хууль бусаар улсын хилийг нэвтрэх гэмт хэргийг давтан үйлдсэн²³ зэрэг эрүүгийн хэргийг шүүхээр шийдвэрлэхдээ хээл хахууль зуучилсан авсан хүнийг тогтоож чадалгүй орхисон зэрэг олон баримтыг дурьдаж болно.

Иймээс төр, хууль хяналтын байгууллагаас хууль бусаар улсын хил нэвтрэх гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг арилгахад чиглэсэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг боловсронгуй болгох шаардлагатай байна.



¹⁵ Судалгаанд оролцогчдын 12 хувь.

¹⁶ Ц.Ганболд Монгол Улсын хилийн төлөөлөгч түүний үйл ажиллагааг боловсронгуй болгох нь УБ., 2004 он, 105 дахь тал.

¹⁷ Судалгаанд оролцогчдын 12.1 хувь.

¹⁸ ТЕГ-ын мөрдөн байцаах хэлтсийн эрүүгийн хэргийн бүртгэл мэдээ УБ., 2008 он.

¹⁹ Хуульчдын дунд явуулсан санал асуулгын дүн, 2009 он.

²⁰ Мөн тэнд.

²¹ Ц.Доржням "Хууль бусаар Монгол Улсын хил нэвтрэх гэмт хэрэг ба хууль сахиулах байгууллага", "Шүүх, прокурор, мөрдөн байцаах албадын хамтын ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх нь" сэдэвт олол, практикын бага хурлын ялтгэлийн эмтгэл УБ., 2009 он, 33 дахь тал.

²² Нийслэлийн Хан-уул дүүргийн шүүхийн шийтгэх тогтоол 98а, 2008 оны 8 дугаар сарын 27-ны өдөр.

²³ Нийслэлийн Хан-уул дүүргийн шүүхийн шийтгэх тогтоол №32, 2008 оны 2 дугаар сарын 19-ний өдөр.

ШШҮХ-ИЙН ШҮҮХ-ДНХ ШИНЖИЛГЭЭНИЙ ЗАРИМ ҮР ДҮН

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн

лабораторийн тасгийн дарга, биологийн ухааны доктор С.Ганболд, магистрант Р.Баярмаа

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны УИХ-ын нэгдсэн хуралдаанд цаазаар авах ялтай холбогдуулж хэлсэн үгэндээ "Цаазтай хэргийн нотлох баримтад ДНХ-ийн шинжилгээг заавал оруулахыг шаарддаг, зарим өндөр хөгжилтэй оронд уг хэрэгт холбогдон хоригдож байсан хүмүүс гэмт хэрэг үйлдээгүй нь нотлогдож хэдэн арваараа суллагдсан тохиолдол ч байдаг" -ийг дурдсан байна.¹

2000 оноос өндөр хөгжилтэй орнуудын хүний эрхийн хуульчид Гэм буруугүйн төсөл (Innocence project) гэгчийг санаачилж шийтгэгдсэн хүмүүсийн цөөхөн нь л гэмт хэрэгт үнэндээ буруугүй гэдгийг хүн бүр хүлээн зөвшөөрөх болсон. Гэвч уламжлалт судалгааны арга техникээр хааяа нэг шударга бусаар шийтгэгдсэн хүн цагаатгагддаг байсан ч тэр хүний гэм буруугүй нь үнэн үү үгүй юу гэдэг асуулт гарсаар байсан. Зарим тохиолдолд аллага үйлдсэн хэргээр яллагдаж гянданд байгаа эсвэл цаазлагдсан хүний "алагдсан хохирогч" ял шийтгэлийн дараа амьд гарч ирэх эсвэл хааяа нэг тохиолдолд андуурсан байсныг зарласан тохиолдол ч нэг биш удаа гарсан байдаг.

1980-аад онд хохирогч болон сэжигтний шингэн болон хүний биенийн материалаас гэмт хэрэгт холбогдсон хүнийг ялгах чадавтай шинжлэх ухааны нарийн арга болох ДНХ-ийн шинжилгээ нээгдэж улмаар 1980-аад оны сүүлчээр хүн амины

эсвэл хүчингийн хэргээр буруутгагдсан хүнийг өмгөөлөхдөө өмгөөлөгчид нь ДНХ шинжилгээний тусламжтайгаар гэмт хэрэгт холбогдолгүйг нь баталдаг болоод байна.

1990-ээд оны эхээр Barry Scheck, Peter Neufeld нарын хуульчид ДНХ-ийн шинжилгээнд тулгуурлаж "Гэм буруугүйн төсөл" боловсруулах нь ямар ч буруугүй олон хүмүүс шударга бусаар шийтгэгдсэнийг цагаатгах маш чухал сайхан боломж нээгдлээ гэж үзэх болсон. Тэд анх "Гэм буруугүйн төсөл" -ийг үндэслэж Нью Йорк дахь Кардосо хуулийн сургуультай хамтарч тэднийг үнэхээр буруугүй болохыг нотолсон судалгааны ажлыг эхлүүлсэн байдаг.

2005 оны 9 сарын 17нд "Гэм буруугүйн төсөл" нь 1989 оноос хойш цагаатгагдсан 162 гэм буруугүй хүмүүс ялагдан цаазаар ахуулсан эсвэл хийгээгүй хэргийн төлөө урт хугацаагаар шоронд хоригдсоныг баримтаар нотолсон байна. Шударга бус ял оноход нөлөөлөх олон хүчин зүйл байдгаас гэмт хэргийн эд мөрийн баримтыг шинжлэх шинжилгээний мэдрэг биш аргыг хэрэглэн шинжээчийн дүгнэлт гаргасан тохиолдол багагүй хувийг эзэлдэгийг дурдсан байдаг.²

Дээр дурдсан учир холбогдлыг иш үндэс болгон Монгол Улсын Шүүхийн шинжилгээний практикт шүүх-ДНХ-ийн шинжилгээг нэвтрүүлэх ажил хийгдэж байгаа бөгөөд сүүлийн 3 жилд манай

лабораторид хийгдсэн ДНХ-ийн шинжилгээний зарим тохиолдолд товч дүн шинжилгээ үр дүнг нийтэлж байна

2004 оны 11 дүгээр сараас Шүүх эмнэлгийн биологийн лабораторид шүүх-ДНХ-ийн шинжилгээг хүүхдийн эцэг тогтоох шинжилгээний практикт нэвтрүүлсэнээр эхэлсэн түүхтэй. Үүнээс хойш 2009 оны 5 дугаар сар хүртэл эцэг тогтоох болон гэмт хэргийн холбогдолтой шүүх-ДНХ-ийн шинжилгээг Промега фирмийн "GenePrint" ДНХ кит хэрэглэн тухайн генийн аллелийг полимеразийн гинжин урвал явуулан олшруулж, полиакриламидын гельд электрофорез явуулах гар аргаар 3-9 локусаар хийж шинжээчийн дүгнэлт гарган өгч байсан юм.

Мөн энэ хугацаанд ДНХ-ийн шинжилгээний үр дүнгийн магадлалыг тооцоолоход зайлшгүй хэрэглэгддэг микросателлитын локусуудын аллелийн генийн тархалтыг Монголын хүн амд тогтоох эрдэм шинжилгээ судалгааны ажил болон шинжилгээ хийх аргачилал, шинжилгээний горим тогтоох туршилт судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн болно.^{3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13}

Өнөөдрийн байдлаар ШШҮХ-д шүүх-ДНХ-ийн шинжилгээг AmpFISTR® Identifier® system кит буюу микросателлитын 16, AmpFISTR® Y-filer® system кит буюу эрэгтэй хүний У хромосомын 17 микросателлитын локусаар хийж

¹ Өдрийн сонин № 011 (340). 2010 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр.

² <http://www.innocenceproject.org>

³ С.Ганболд "Эмгэг судал шүүх эмнэлгийн биологийн лабораторийн шинжилгээний өнөөгийн байдал, хэтийн төлөв". Монголын анагаах ухаан сэтгүүл 2002он №2.

⁴ С.Ганболд "Микросателлитийн CSF1PO, TPOX, THO1, VWA, FESFPS, F13A01, D13S317, D7S820, D16S539 локусыг хүүхдийн эцэг тогтоох шүүх биологийн шинжилгээнд хэрэглэсэн үр дүн". Шүүх эмнэлэг-45 Эрдэм шинжилгээ, онол, практикийн бага хурлын илтгэлийн хураангуй. УБ. 2005 он.

⁵ С.Ганболд "ШШҮХ-ийн ШЭХ-ийн биологийн лабораторийн өнөөгийн байдал, тулгамдаж байгаа асуудал, цаашдын зорилт". Шүүх эмнэлэг-45 Эрдэм шинжилгээ, онол, практикийн бага хурлын илтгэлийн хураангуй. УБ. 2005 он.

⁶ Kyoung Don Kwak, Ganbold S., Tundewitwetsen S., Han Jun Jin., Seung Bun Hong, Myun Soo Han., Wook Kim., "Y-Chromosome STR haplotype profiling in the Mongolian population". Journal Legal Medicine 8 2005, p. 58-61.

⁷ С.Ганболд, М.Цэзэнбат. "Результат применения молекулярно-генетического исследования в судебно-биологическом

эхлээд байгаа ба Промега фирмийн PowerPlex16 System кит буюу аутосомын 16 микросателлитын локус. PowerPlex16 System кит буюу эрэгтэй хүний У хромосомын 11 локусаар шүүх ДНХ-ийн шинжилгээний туршилт судалгааны ажил хийж эхлээд байна.

ШШҮХ-ийн лабораторид хийгдсэн шүүх-ДНХ-ийн зарим шинжилгээний үр дүнд хийсэн дүн шинжилгээг авч үзвэл:

Судалгааны дүнгээс харахад тухайн хүүхдийн эцэг байх тохиолдол 2008 оны сүүлийн 6 сарын дүнгээс үзэхэд 25 тохиолдлын 80 % нь эцэг болох нь батлагдсан, 20 % нь хүүхдийн эцэг байх боломж

байсан бол 2009 оны 6 дугаар сараас микросателлитын 9-16 локусаар шүүх-ДНХ-ийн шинжилгээ хийж дүгнэлт гаргаж өгч байгаа юм.

2009 оноос хүүхдийн эцэг эх тогтоох Шүүх-ДНХ-ийн шинжилгээг 9-16 локусаар хийж шинжилгээний үр дүнг гарган өгч байгаа нь олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандартын хэмжээнд хүрсэн үзүүлэлт гэж хэлж болох бүрэн үндэслэлтэйг дурдаж байна. Гагцхүү ДНХ-ийн лабораторийн шинжилгээнд хэрэглэгддэг урвалж бодис, оношлуурын нөөцтэй байх явдал хамгийн чухал байгаа юм.

Сүүлийн 3 жилийн эцэг тогтоох

(Хүснэгт 1)

Он	2008 оны сүүлийн 6 сар	2009 он	2010 оны эхний 2 сар
Батлагдсан	20 (80%)	55 (74.3 %)	10 (90.9 %)
Үгүйсгэгдсэн	5 (20 %)	19 (25.7%)	1 (9.1%)
Нийт дүн	25	74	11

үгүйсгэгдэж гарсан нь харагдаж байна (Хүснэгт 1).

2009 онд хийгдсэн нийт дүнгээс үзэхэд 74 тохиолдлын 74.4 % нь эцэг болох нь батлагдсан, 25.7 % нь хүүхдийн эцэг байх боломж үгүйсгэгдэж гарсан нь харагдаж байна.

2010 оны эхний 2 сарын дүнгээс үзэхэд 11 тохиолдлын 90.9 % нь эцэг болох нь батлагдсан, 9.1 % нь хүүхдийн эцэг байх боломж үгүйсгэгдэж гарсан нь харагдаж байна.

Тус хүрээлэнгийн ДНХ-ийн лабораторид 2008 оноос 2009 оны 5 дугаар сар хүртэл эцэг тогтоох шинжилгээг микросателлитын 6-9 локусаар хийж дүгнэлт гаргаж

шинжилгээний дүгнэлт гарсан хугацааны динамикийг ажиглахад шинжилгээний хариу 5-14 хоногт гарсан ба хугацаа нь лабораторийн ажлын ачаалал, шинжилгээнд энгийн гар арга хэрэглэн үр дүнг гаргаж байгаа, эсвэл автомат генетик анализатараар үр дүнг уншиж байгаа юу гэдгээс хамаарч байгаа нь ажиглагдлаа.

Эцэг тогтоох шинжилгээний хариуг зохигчид хүлээн зөвшөөрөхгүй тохиолдол 4 удаа гарсан ба бүрэлдэхүүнтэй давтан шинжилгээгээр өмнө нь гарсан үр дүн батлагдсан нь шүүх-ДНХ-ийн шинжилгээ нь магадлалын маш өндөр хувьтайг (99.99% –хувийн) нотлон харуулж байна.

Сүүлийн 3 жилийн хугацаанд гэмт хэргийн холбогдолтой шүүх-ДНХ-ийн шинжилгээний үр дүнд дүн шинжилгээ хийж үзэхэд дараах дараах онцлог ажиглагдлаа.

Гэмт хэргээтэй холбоотой шүүх-ДНХ-ийн шинжилгээнд 50 жилийн өмнө сураггүй алга болсон хүмүүстэй холбоотой шинжлэгдэхүүн, олон жилийн өмнө нас барсан хүний яс, түүний эд эрхтэний хэсэг, нас барсан болон хүчирхийлэлд өртсөн хүнээс авсан шулуун гэдэс, үтрээний арчдас, ор хөнжлийн давуу, тухайн үед хэрэглэж байсан дотуур, гадуур хувцас, ариун цэврийн хэрэгсэл, ураг, ургийн эд, үрийн шингэн, цусны толбо, янз бүрийн эд юмсад наалдсан цус, шүлс, ялгадас, хөлсний толбо, үс, эд эсийн лабораторийн шинжилгээнд дээжлэн авсан эд, эрхтэний парафинжуулсан блок, эрхтэн, эдийн хэсэг, тамхины иш, шуудангийн марк, хумс зэрэг биологийн гаралтай эд мөрийн баримт шүүх-ДНХ-ийн шинжилгээ хийж дүгнэлт гаргаж өгсөн байна.

Дээрхи биологийн гаралтай эд мөрийн баримтад ДНХ-ийн шинжилгээ хийж гарсан үр дүнг хүснэгтээр үзүүлэв (Хүснэгт 2).

Шинжилгээний үр дүнгээс үзэхэд 2008 онд гэмт хэргт холбогдолтой ирсэн шинжилгээний 18.2 хувьд нь, 2009 онд 24.2 хувьд, 2010 онд 12.6 хувьд нь ДНХ-ийн шинжилгээний үр дүн гараагүй нь харагдаж байна. Үүний учир шалтгааныг үнэлж үзэхэд олон хил зориулалтын бус нөхцөлд гадны физик, химийн, байгалийн хүчин зүйлд ихээхэн өртсөн, хэргийн газрын үзлэгээр зохих горим баримтлагүй дээжлэн авсан, буруу хадалгадсан зэрэгтэй холбоотой

экспертизах" Пятая Монгольско-Российская научно-практическая конференция, Улаанбаатар 2005.

* С.Ганболд, Г.Таня, М.Цэрэнбат, Ш.Пүрэвдулам. "Генетическое разнообразие девяти STR локусов в Монгольской популяции". "Актуальные вопросы судебной медицины и экспертной практики на современном этапе" - Материалы Всероссийской научно-практической конференции с международным участием, посвященной 75-летию Российского центра судебно-медицинской экспертизы" стр. 196-197, 2006г. Москва.

* С.Ганболд. "Наблюдение успешного применения методов молекулярной генетики в случаях спорного отцовства" - Актуальные вопросы судебной медицины и экспертной практики на современном этапе" нэртэй "Сборник пленарных и стендовых докладов Всероссийской научно-практической конференции с международным участием, посвященной 75-летию Российского центра судебно-медицинской экспертизы" стр. 54-59, 2006г. Москва.

* С.Ганболд, М.Цэрэнбат, Т.Яамамото, Е.Кацумата, Р.Учики, Ш.Пүрэвдулам. Д.Баярлхагва. "Монголын хүн ам дахь шүүх биологийн шинжилгээнд хэрэглэх 15 STR локусын аллелийн тархалт". Монголын анагаах ухаан сэтгүүл. 2007 он. №3.

* С.Ганболд, Ш.Пүрэвдулам, М.Өнөржаргал, Х.Батбаяр, Д.Баярлхагва. "Биологийн зарим дээжнээс хүний геномын ДНХ ялгасан судалгааны үр дүн". Эрдмийн чуулган-49. Эрүүл мэндийн шинжлэх ухаан сэтгүүл. 2008он. №49.

* С.Ганболд. "Шүүх биологийн шинжилгээнд хэрэглэх 17 STR локусын аллелийн тархалтаар Монгол хүний генийн сан бий болгох нь". ШУТСангийн төслийн тайлан. 2007 он. Улсын бүртгэлийн дугаар № 200700039.

* М.Цэрэнбат, С.Ганболд. "Монголын хүн ам дахь аутосом микросателлитын локусын аллелийн тархалтын судалгаа". Анагаах ухааны докторын зэрэг горилж бичсэн нэг сэдэвт бүтээл. 2008 он.

байж болох боловч өөр хүчин зүйл бас байгаа нь ажиглагдаж байна. Тухайлбал, бохирлогдсон, зориулалтын бус нөхцөлд хадгалагдсан, маш өчүүхэн хэмжээтэй биологийн материалаас тухайн хүний ДНХ-ийг ялган авахад хэрэглэгддэг орчин үеийн зарим техник хэрэгслэл, өндөр мэдрэг, цэвэршүүлэлт бүхий урвалж бодис, ДНХ-ийн кит байхгүйн улмаас үр дүнд хүрээгүй цөөнгүй тохиолдол гарлаа. Нэн ялангуяа ясыг хэт нам хасах хэмд бутлах төхөөрөмж, маш өчүүхэн үлдэц бүхий биоматериалаас ДНХ ялгах тусгай зориулалтын PrepFiler™, Наборы выделения Qiagene DNA-Mini, Наборы очистки ДНК Qiagene Quick Pufication кит зэрэг

ийн шинжилгээний үр дүнгүйгээр дээрхи хэргийн эзэн холбогдогчдыг тогтоох боломжгүй байсныг зориуд дурдан хэлэх байна. Тухайлбал 50 жилийн өмнө сураггүй алга болсон хүнийг эцэг, төрсөн ах дүү нартай харьцуулан ДНХ-ийн шинжилгээ хийж байж ах дүү нарыг хооронд нь уулзуулж учруулсан нь Монголын шүүхийн шинжилгээний практикт шүүх-ДНХ-ийн шинжилгээний хүчирхэг, мэдрэг технологи нэвтэрсэний ач тус мөн болно.

Гэмт хэрэгтэй холбоотой хийгдсэн шүүх-ДНХ-ийн шинжилгээний үр дүнгээс харахад тухайн хэрэгт холбоотой ирсэн шинжилгээний хэд нь батлагдаж нотлогдож, хэд нь үгүйсгэгдэж байгаа нь судалгааны үр дүнгээс

эдийн засгийн хохирол учруулах, чирэгдүүлэх зэрэг сөрөг нөлөө үр дагаварыг дагуулж байгааг анхаарч үзэх шаардлагатай байгаа юм.

Гэмт хэргийн холбогдолтой шүүх-ДНХ-ийн шинжилгээний хугацааг богиносгох, үр өгөөжийг нь нэмэгдүүлэхийн тулд дараах зүйлийг анхаарч ажиллах шаардлагатай байгаа нь дээрхи судалгааны үр дүнгээс урган гарч байна.

Нэг, "Хэргийн газраас биологийн гаралтай ул мөр илрүүлж, лабораторид илгээх үндсэн зарчмууд"-ыг¹⁴ шинжилгээнд материал ирүүлдэг холбогдох бүх мэргэжлийн хүмүүст судалж мэдүүлэх ажлыг зохион байгуулах.

Хоёр, Янз бүрийн биологийн

материалаас ДНХ ялгах тусгай зориулалтын техник хэрэгслэл, ДНХ-ийн китийн цуглуулга, иж бүрдэл, ДНХ-ийн шинжилгээний эцсийн үр дүнг гарган авах оношлуурын нөөцтэй байлгах.

Гурав, Өөрийн лабораторийн нөхцөл байдалд тулгуурлан

шүүх-ДНХ-ийн шинжилгээний бусад нарийн арга нэвтрүүлэх туршилт судалгааны ажлыг хийх, молекул-генетикийн чиглэлийн нарийн мэргэжил эзэмшсэн боловсон хүчнийг авч ажиллуулах, эрдэм шинжилгээний судалгаа явуулах, түүнийг санхүүжүүлэх эх үүсвэрийг эрж хайх мэт ажлыг бодлогын төвшинд зохион байгуулах шаардлагатай нь харагдаж байна.



(Хүснэгт 2)

Гэмт хэргийн төрөл	2008 оны сүүлийн 6 сар				2009 он				2010 оны эхний 2 сар			
	Батлагдсан	Үгүйсгэгдсэн	Үрдүн гаргаж Нийт	Батлагдсан	Үгүйсгэгдсэн	Үрдүн гаргаж Нийт	Батлагдсан	Үгүйсгэгдсэн	Үрдүн гаргаж Нийт			
Хүчин	3	1	2	6	12	6	3	21	3	1	2	6
Хүний амь бүрэлгэсэн	-	4	-	4	3	5	4	12	2	6	-	8
Нас барсан олдсон	-	-	-	-	3	1	2	6	1	-	-	1
Хулгайлагдаж сураггүй алга болсон	-	-	-	-	1	-	2	3	1	-	-	1
Заналхийлсэн	-	-	-	-	-	2	-	2	-	-	-	-
Төрөхөд нарай хүүхэд солигдоон Зодуулсан	-	1	-	1	-	-	-	1	-	-	-	-
Нийт дүн	3	6	2	11	19	15	11	45	7	7	2	16
Хувь	27.3	54.5	18.2	100	42.3	33.3	24.4	100	43.8	43.8	12.4	100

юм бол цаашид ДНХ-ийн шинжилгээний үр дүнг өндөр магадлалтай, 9-13 локусаар гарган авах боломж бүрэн байгааг тэмдэглэх нь зүйтэй юм.

Дээр дурдсан хүчингийн, хүн амины ноцтой, илрүүлэхэд төвөгтэй гэмт хэрэгт холбоотой шүүх-ДНХ-ийн бусад шинжилгээний үр дүнг гарган авсан нь гэмт хэргийн жинхэнэ холбогдогчийг хөдөлгөөнгүй нотлох баримтаар тогтооход чухал үр дүнтэй ажил болсон ба шүүх-ДНХ-

тодорхой харагдаж байна (Хүснэгт 2).

Нөгөөтэйгүүр гэмт хэргийн холбогдолтой хэргийн шүүх-ДНХ-ийн шинжилгээний хариу сар түүнээс олон хоногийн хугацаанд гарсан хэд хэдэн тохиолдол байгаа нь нэг талаас, хэргийн мөрдөлт, прокуратурын хяналтын хугацааг хэрүүлэх нөгөө талаас сэжигтэн нь хэрэгт огт холбогдолгүй байсан бол хүний эрхийг нь зөрчих, улмаар ар гэр болон өөрт нь сэтгэл санаа,

¹⁴ Хэргийн газраас биологийн гаралтай ул мөр илрүүлж, лабораторид илгээх үндсэн зарчмууд, аргачилсан зөвлөмж. 2009 он. Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн аргачилсан зөвлөмж.

ОРОН НУТАГ ДАХЬ “ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦААНЫ ТӨВ”-ИЙН ОДОО БА ИРЭЭДҮЙ

Эрх зүйн тусалцааны төв байгуулагдсан нь:

Монгол Улсын Засгийн газрын 2006 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 263 дугаар тогтоолоор “Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн тусалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг баталсан нь улсын хэмжээнд “Эрх зүйн тусалцааны төв” байгуулагдах эрх зүйн үндэслэл болсон юм.

“Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн тусалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд “Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн тусалцаа үзүүлэх асуудлыг хариуцсан Үндэсний зөвлөлийг байгуулах”, “Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн тусалцаа үзүүлэх асуудлыг хэрэгт анхан шатны хууль зүйн зөвлөгөө өгөх, эрх зүйн албан бус сургалт, сурталчилгаа явуулахын зэрэгцээ иргэдэд хууль зүйн тусалцаа үзүүлэх үйлчилгээний хүртээмж, үр нөлөөг дээшлүүлэх зорилго бүхий нэгж юм.

Засгийн газрын тогтоол, төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2007 оны 155 дугаар тушаалаар “Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн тусалцаа үзүүлэх асуудлыг хариуцсан Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг баталж, улмаар бүх аймаг, дүүргүүдэд салбар зөвлөлүүд байгуулагдсанаар төвийн үйл ажиллагаа улсын хэмжээнд эхлэх үндсэн нөхцөл бүрдсэн билээ.

Төв нь анх Хууль зүй, дотоод хэргийн яам, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэгтэйгээр аймаг, дүүргүүдийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтсийн үйл ажиллагаанд түшиглэн нэг Эрх зүйн сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн, өмгөөлөгчтэйгээр үйл ажиллагаагаа эхлүүлж төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн тусалцаа үзүүлэх, эрх зүйн сургалт, сурталчилгаа явуулах, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх



*Сэлэнгэ аймгийн ЗДТГ-ын
Хууль зүйн хэлтсийн Эрх зүйн
сургалт, сурталчилгаа
хариуцсан ахлах мэргэжилтэн,
магистр Д.Ендонжамц*

ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Эрх зүйн тусалцааны төв нь эрүүгийн хэрэгт холбогдсон төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн тусалцааг үнэ төлбөргүй үзүүлэх, эрүү, иргэн, захиргааны хэрэгт анхан шатны хууль зүйн зөвлөгөө өгөх, эрх зүйн албан бус сургалт, сурталчилгаа явуулахын зэрэгцээ иргэдэд хууль зүйн тусалцаа үзүүлэх үйлчилгээний хүртээмж, үр нөлөөг дээшлүүлэх зорилго бүхий нэгж юм.

Төвийн үйл ажиллагаа ба өнөөгийн нөхцөл байдал:

Эрх зүйн тусалцааны төвүүд нь аймаг, дүүргийн ЗДТГ-ын Хууль зүйн хэлтсийн Эрх зүйн сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн, өмгөөлөгч гэсэн 2 орон тоотойгоор ажиллаж байна.

Эрх зүйн сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн нь Хууль зүйн хэлтсийн мэргэжилтэн, төрийн албан хаагч бөгөөд иргэдэд хууль зүйн анхан шатны зөвлөгөө өгөх, эрх зүйн албан бус сургалт, сурталчилгаа явуулах, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх чиг үүрэгтэй ажилладаг.

Өмгөөлөгч нь сонгон шалгаруулалтад тэнцсэн.

төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн тусалцаа үзүүлэх чин эрмэлзэлтэй иргэн байх бөгөөд тухайн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн эрүүгийн хэрэгт холбогдсон төлбөрийн чадваргүй иргэнд өөрийнх нь хүсэлтийн дагуу эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны бүхий л шатанд үнэ төлбөргүй хууль зүйн тусалцаа үзүүлэх, иргэний болон захиргааны хэрэгт хууль зүйн анхан шатны зөвлөгөө өгөх, үйлчлүүлэгчийн санал хүсэлтийг үндэслэн эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагаа явуулан. Захиргааны болон иргэний хэрэгт аль нэг талыг төлөөлөн оролцох боломж нь нээлттэй байдаг.

Төв нь компьютер, канон, проектор, номын шкаф, ажлын болон уулзалтын ширээ, сандал, ном, гарын авлага зэрэг материаллаг бааз суурьтайгаар аймгийн Засаг даргын Тамгын газрын байранд үйл ажиллагаагаа явуулж байна.

Төвийн өмгөөлөгч, эрх зүйн сургалт, сурталчилгаа хариуцсан ажилтанд олон төрлийн хэрэг, маргаанд оролцуулах хүсэлт, төрөл бүрийн хуулийн зөвлөгөө, лавлагаа авах асуудлаар иргэд их ханддаг тул дээрх хүмүүс мэргэжлийн болон ур чадварын хувьд чин бэлтгэгдэж, салбар бүрийн тодорхой мэдлэгтэй, хууль тогтоомжийн сан, мэдээллийн бааз суурьтай байх шаардлагатай байдаг.

Эрх зүйн тусалцааны төвүүдийн үйл ажиллагаа нь газар нутгийн хэмжээ, байршил, хил, гааль, хууль, хяналтын байгууллага, аж ахуйн нэгж, үйлдвэрлэл, үйлчилгээ, сум, баг, хорооны болон хүн амын тоо, эдийн засаг, дэд бүтцийн хөгжил, иргэдийнх нь эрхэлж буй ажил, амьжиргааны гүвшин, өмгөөлөгчдийн тоо зэргээс шалтгаалан харилцан адилгүй хэмжээнд явагдаж байна.

Сэлэнгэ аймгийн хувьд гэвэл Засаг захиргааны хувьд 17 сум, 6

тосгон, 50 багтай, 96 000 гаруй хүн ам, 26 000 гаруй өрхтэй, нийт хүн амын 21.3 хувь нь аймгийн төвд, 9.7 хувь нь хот тосгонд, 53.2 хувь нь сумын төвд 15.5 хувь нь хөдөө амьдарч байна.

Тус аймаг нь хөдөө аж ахуйн чиглэлтэй үйлдвэрлэл давамгайлсан, байгалийн нөөц баялагт тулгуурласан уул уурхайн үйлдвэрлэл хөгжих ирээдүйтэй, өрхийн аж ахуйгаар иргэд нь амьдралаа хангалуун авч явах хэв шинж бүрдсэн, зам тээвэр, холбоо, эрчим хүч зэрэг дэд бүтцийн салбар сайн хөгжсөн, гадаад харилцаа хөгжүүлэх өргөн боломжтой нийгэм, эдийн засгийн хөгжлийн чадавхи бүхий нутаг юм.

Аймгийн нутаг дэвсгэр дээр Дархан-Уул аймаг оршдог бөгөөд Сүхбаатар, Мандал (Зүүнхараа), Сайхан (Хөтөл) зэрэг орон нутгийн томоохон хот, хилийн байнгын ажиллагаатай Сүхбаатар, Алтанбулаг боомттой, улсын болон орон нутгийн чанартай төмөр болон авто замтай бөгөөд эдийн засгийн дотоод, гадаад харилцааны тээврийн гол үүрэг, үйлчилгээг гүйцэтгэдэг.

Аймгийн дээрх нөхцөл байдалтай уялдан иргэдийн шилжилт хөдөлгөөн их явагддаг, гадаад, дотоодын иргэд хил гаалиар их зорчдогтой холбогдон гэмт хэрэг, захиргааны зөрчил их гардаг учир аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон хууль хяналтын байгууллага, албан хаагчдын ажлын ачаалал их байдаг.

Дээрх нөхцөл байдал нь Эрх зүйн тусалцааны төвийн үйл ажиллагаанд ч мөн адил нөлөөлж байгаа нь өдөр тутмын үйл ажиллагаанаас тодорхой харагдаж байдаг.

2008 оны Статистик мэдээгээр аймгийн нийт хүн амын 11256 нь ядуу буюу нэн ядуу ангилалд багтдаг бөгөөд 4500 гаруй хөгжлийн бэрхшээлтэй иргэн, 3300 гаруй өрх толгойлсон эх, эцэг, 8000 орчим тэтгэвэр авдаг ахмад настантай гэсэн судалгаа байна.

Аймгийн хэмжээнд үйлдэгдсэн

гэмт хэргийн судалгааг 2005-2009 оны байдлаар буюу сүүлийн 5 жилээр авч үзвэл жилд дунджаар 875 гэмт хэрэг бүртгэгдэж, шүүхээс жилд дунджаар 350 гаруй эрүүгийн хэрэг шийдвэрлэдэг дүн мэдээтэй байна.

Үүнээс 2007-2009 онуудад төлбөрийн чадваргүй иргэдийн өмгөөлүүлсэн байдлыг авч үзвэл:

№	Үзүүлэлт					
	2007 он		2008 он		2009 он	
1	Хэрэг	Хүн	Хэрэг	Хүн	Хэрэг	Хүн
2	23	23	53	66	79	113

Дээрх хүснэгтээс харахад төв байгуулагдсанаас хойшхи сүүлийн 2 жилийн хугацаанд эрүүгийн хэрэгт холбогдож үнэ төлбөргүй өмгөөлүүлсэн төлбөрийн чадваргүй иргэдийн тоо өссөн үзүүлэлттэй байгаа нь харагдаж байна.

Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод тусгагдсан "Төлбөрийн чадваргүй иргэдэд үйлчилгээ үзүүлж буй шалгуур үзүүлэлт, тооцоо аргачлал"-аар аймгийн хэмжээнд 2009 оны байдлаар тооцож үзвэл нэг өмгөөлөгчид дунджаар 80 орчим төлбөрийн чадваргүй иргэн ногдож байна.

Төвөөс 2008, 2009 онд явуулсан хууль, эрх зүйн сургалт, сурталчилгааны ажил, анхан шатны зөвлөгөө өгсөн байдлыг үзвэл доорхи үзүүлэлттэй байна.

№	Үзүүлэлт/он	2008 он	2009 он
1	Хууль зүйн зөвлөгөө авсан	91	387
2	Хууль, эрх зүйн албан бус сургалтанд хамрагдсан	54	332
3	Эрх зүйн актын лавлагаа авсан	34	216
4	Эрх зүйн эх холбогдол бүхий анхан шатны баримт бичиг боловсруулсан	53	148
5	Хууль, эрх зүйн сурталчилгаа явуулсан байдлаар	4460 иргэн	17600 иргэн

Эрх зүйн тусалцааны төв нь аймгийн төвийн иргэд болон зорьж ирсэн зарим нэг сумдын иргэдэд үйлчилгээ үзүүлж байгаа нь учир дутагдалтай юм. Тиймээс Эрх зүйн тусалцааны төвийг хүн ам ихээр төвлөрч суурьшсан томоохон сум, суурин газар, бүсийн төвүүдэд байгуулах зайлшгүй шаардлагатай байгааг өнөөгийн нөхцөл байдал

харуулж байна.

Тус аймгийн хүн амын төвлөрөл ихтэй, сумын бүсийн төвүүд болох Мандал, Сайхан сумдад "Эрх зүйн тусалцааны төв"-ийн салбарыг ажиллуулах шаардлага тавигдаж байна.

Мандал сум нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх Ерөнхий газрын харьяа хоёр хорих анги, аймгийн

сум дундын 2 дугаар Шүүх, Прокурор, Цагдаагийн хэлтэс, Өмгөөлөл, Нотариатын салбартай бөгөөд Мандал, Баянгол сум, Хэрх, Түнхэл тосгодын 29,000 гаруй иргэдэд төрийн үйлчилгээг үзүүлж байдаг.

Сайхан сум нь сум дундын 3 дугаар Шүүх, Прокурор, Цагдаагийн тасаг, Өмгөөлөл, Нотариатын салбартай, Орхон, Орхонтуул, Баруунбүрэн, Сант сумдын нийт 18,000 гаруй иргэдэд төрийн үйлчилгээг үзүүлж байна.

Энэ нь аймгийн хэмжээнд хүн амын төвлөрөл ихтэй томоохон сум, суурин газар, бүсийн төвүүдэд "Эрх зүйн тусалцааны төв" байх шаардлагатайг харуулж байна.

Цаашдаа төвийн үйл ажиллагааг өргөжүүлэхийн зэрэгцээ хууль зүйн тусалцаа үзүүлэх ажилд

хуульч, хуулийн зөвлөх, өмгөөлөгч нараас гадна төрийн албан хаагчдыг тодорхой түвшинд энэ чиглэлээр тусгайлан бэлтгэж оролцуулах шаардлагатай байна.

Ялангуяа иргэд олноор үйлчилүүлж үйлчилгээ, мэдээлэл, тусалцаа авдаг сумын ЗДТГ-ын дарга, сумын хууль, эрх зүйн асуудал хариуцсан ажилтан, багийн Засаг

дарга нар, сургуулийн нийгмийн ажилтан, цагдаа, эмнэлэг, халамж, татвар, иргэний бүртгэлийн зарим ажилтан хууль зүйн туслалцаа үзүүлэх чиглэлээр сургалт, семинарт хамруулж паралегалуудыг¹ бэлтгэх шаардлагатайг харуулж байна.

Төвийн ирээдүйн нөхцөл байдал, анхаарах асуудлууд:

Цаашид "Эрх зүйн туслалцааны төв"-ийн үйл ажиллагааг өргөжүүлж, орон нутагт эрх зүйн мэдээлэл, лавлагаа, хууль зүйн анхан шатны зөвлөгөө өгөх, төлбөрийн чадваргүй болон иргэдийн хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах, хууль, эрх зүйн сургалт, сурталчилгаа, хүний эрхийг хангах ажил үйлчилгээнд ахиц гаргах, хууль зүйн үйлчилгээний хүртээмж, үр нөлөөг дээшлүүлэх шаардлага зүй ёсоор тавигдахын зэрэгцээ өнөөгийн нийгмийн эрэлт, хэрэгцээ

ч үүнийг шаардаж байна. Энэхүү эрэлт, хэрэгцээ шаардлагыг хангахын тулд дараах ажлуудыг хийж гүйцэтгэх хэрэгтэй гэж үзэж байна: Үүнд:


- Хууль, эрх зүйн сургалт, сурталчилгаа болон Эрх зүйн туслалцааны төвийн үйл ажиллагаа, хууль зүйн туслалцаа үзүүлэхтэй холбогдон үүсэж гарах харилцааг зохицуулсан хууль, эрх зүйн акт гаргах;
- Эрх зүйн туслалцааны төвийн статус, санхүүжилт, байрны асуудлыг шийдвэрлэх;
- Өмгөөлөгчийн хүрэлцээгүй байдлыг шийдвэрлэх;
- Эрх зүйн туслалцааны төвүүдийг олноор байгуулах;
- Паралегалуудыг олноор бэлтгэх;
- Төлбөрийн чадваргүй иргэн гэдгийг тогтоох шалгуур үзүүлэлт, тооцох аргачлалыг сайжруулах;

• Төвийн ажилтан, өмгөөлөгчийн цалин хөлс, урамшууллын асуудлыг нэгдсэн байдлаар шийдвэрлэх;

• Хуулийн их, дээд сургууль бүрийг клиник сургалтын төвтэй болгох;

• Хуулийн сургуулиудын төгсөх ангийн оюутнуудыг төвд ажиллуулах, төрийн бус байгууллага, төсөл, хөтөлбөр, тусламжийн байгууллагуудтай хамтран ажиллах, дэмжлэг, туслалцаа авах харилцааг зохицуулсан журам бий болгож, мөрдүүлэх;

• Цаашдаа орон нутаг дахь төвүүдийг бие даасан статустай болгож, сургалт, эрдэм, шинжилгээний байгууллагын хэмжээнд ажиллуулах шаардлагатай байна.



¹ Хууль зүйн анхан шатны зөвлөгөө өгдөг, өмгөөлөгч бус хүмүүсийг, өөрөөр хэлбэл хуулийн сургууль төгсч хуульч болоогүй ч хүмүүст хуулийн анхан шатны зөвлөгөө туслалцаа үзүүлдэг хүмүүсийг "Паралегал" гэж нэрлэдэг. Пара гэдэг үг нь "тэий адилхан-тэй төстэй" гэсэн утгатай. Товчоор хэлбэл, Паралегал гэдэг нь хуульч бус хуульч гэж орчуулагддаг.

Хуульчдын байнгын анхаарлын төвд байх ёстой нэг асуудал бол хууль зүйн нэр томьёог нэг мөр болгож цэгцлэх явдал билээ. Манай сэтгүүл энэ дугаараасаа эхлэн хууль зүйн нэр томьёоны булан нээж байна.

Манайд тогтсон уламжлал ёсоор ЭРХ ЗҮЙ-ХУУЛЬ хэмээх хоёр ойлголтыг ялгаж авч үздэг. Орос хэлээр ПРАВО-ЗАКОН гэдэг бол англиар LAW гэж ганц үгээр хэлдэг. ЭРХ ЗҮЙЧ, ХУУЛЬЧ гэсэн мэргэжлийн нэр байна. Үүнийг оросоор ПРАВОБЕД, ЮРИСТ хэмээн. Харин англиар юу гэх вэ? Англи хэлэнд JURIST, LAWYER гэж хоёр үг бий. Нэр цуутай шүүгч, эрдэмтнийг JURIST хэмээн хүндэтгэж нэрлэдэг бол LAWYER нь хуулийн практик ажиллах эрх бүхий этгээд. Одоо манайд хуульчийн сонгон шалгаруулалтад орж, тэнцсэн иргэнийг ХУУЛЬЧ гэж нэрлэж заншиж хандалгатай байна. Энэ нь ч зөв хандлага бөгөөд ХУУЛЬЧИЙГ англиар LAWYER гэхэд болохоор байна. Харин ЭРХ ЗҮЙЧИЙГ JURIST гэвэл зохимжгүй мэт. ЭРХ ЗҮЙЧ гэж хуулийн дээд боловсрол эзэмшсэн этгээд. Иймд англиар LAW GRADUATE гэвэл илүү оновчтой болов уу. Харин гавъяат хуульчийг JURIST гэж орчуулбал болохгүй гэх газаргүй юм.

ЭРХ ЗҮЙ, ХУУЛЬ ЗҮЙ хоёрыг хэрхэн ялгаж ойлгох вэ? "Эрх зүйн" бус гагцхүү "хууль зүйн" гэсэн тодотголтой хэрэглэдэг хууль зүйн сайд, байнгын хороо, магистр, доктор, сургууль, бодлого, алба, салбар гээд олон үг бий. Тэгэхээр, нэг талаас, хууль зүй гэдэг нь ямартай ч эрх зүйгээс өөр зүйл бололтой. Дашрамд дурьдахад, дээрх олон үгний "хууль зүйн" гэсэн тодотголлыг англи, орос хэлээр орчуулахад өөр, өөр үг хэллэг хэрэглэнэ. Жишээ нь: minister for justice-министр юстиции, legal standing committee-постоянный комитет по правовым вопросам, master of laws-магистр права, doctor of laws-доктор юридических наук, law school-юридический институт гэх мэт. Гэтэл нөгөө талаас, хууль зүйн эсвэл эрх зүйн шинжлэх ухаан гэж дээрх хоёр үгийн аль алиныг нь зэрэгцүүлэн

хэрэглэдэг явдал бий. Оросоор правовая эсвэл юридическая наука гэдэгтэй төстэй юм. Англиар legal science гэсэн хэллэг хаана нэг тааралдаж байдаг? ХУУЛЬ ЗҮЙ гэдэг нь Монголын хөрсөнд үүсч бий болсон хэллэг бөгөөд цаашид лавшруулан судлах шаардлагатай байна.

Харьцуулсан эрх зүйд хэрэглэгддэг зарим нэр томьёог орчуулан хэвшүүлэх асуудал мөн чухлаар тавигдаж байна. Тухайлбал, эрх зүйн бүл (legal family), эрх зүйн тогтолцоо (legal system)-ноос гадна эрх зүйн уламжлал (legal tradition) гэсэн ойлголт байна. Манайд Ром-Германы эсвэл эх газрын, Англи-Саксоны эсвэл Англи-Америкийн гэх үг хэллэг нэлээд хэвшмэл хэрэглэгдэж байгаа боловч CIVIL LAW иргэнлэг эрх зүй, COMMON LAW нийтлэг эрх зүй (нийтийн эрх зүй бол PUBLIC LAW) гэсэн товч хэллэг төдийлөн хэвшихгүй байна. AMERICAN LAW (аж ахуйн эрх зүй)-тэй нийлээд PRIVATE LAW (хувийн эрх зүй)-г бүрдүүлдэг иргэний эрх зүйг мөн CIVIL LAW гэж хэлдэг.

LEGAL TRANSPLANT хэмээх чухал ойлголт бий. Үүнийг ЭРХ ЗҮЙН СУУЛГАЦ гэмээр. Харин LEGAL TRANSPLANTATION гэдгийг ЭРХ ЗҮЙГ (хэсэгчлэн) ШИЛЖҮҮЛЭН СУУЛГАХ гэж болох мэт. ШИЛЖҮҮЛЭН НУТАГШУУЛАХ гэдэг бол ADAPTATION гэсэн ойлголттой илүү дүйх болов уу. RECEPTION бол ЭРХ ЗҮЙГ ШИЛЖҮҮЛЭН АВАХ гэсэн ойлголт.

Эрх зүйн онол (legal theory), эрх зүйн номлон (legal doctrine) бол манайд харьцангуй тогтсон ойлголтууд. Харин JURISPRUDENCE гэж юу вэ? Зарим толь бичигт тайлбарласныг үзвэл эрх зүйн онол, мөн гүн ухаан, зарим тохиолдолд, эрх зүйн номлолыг ч ингэж хэлдэг ажээ. Оросоор юриспруденция гэж бас бий. ЭРХ ЗҮЙН СУРГААЛЬ гэж тогтоол ямар вэ гэсэн санал дэвшүүлж байна.

Үндсэн хуулийн эрх зүйд холбогдох шинэлэг ойлголт болох CONSTITUTIONAL DESIGN гэдэг үгийг орчуулан нэвтрүүлэх явдал чухал шаардлагатай байна. Үүнийг Үндсэн

хуулийн ур хийг гэвэл ямар бол? Илүү оновчтой үг хэллэг санал болгоно уу.

Эрх зүйг эдийн засгийн үүднээс судлах явдал өндөр хөгжилтэй улс орнуудад нэлээд хүчтэй байр суурь эзлэх болжээ. Англиар the economic analysis of law (эрх зүйг эдийн засгийн аргаар шинжлэхүй)=LAW AND ECONOMICS (эрх зүй ба эдийн засаг), LAW AND DEVELOPMENT (эрх зүй ба хөгжил) гэсэн үг хэллэг өргөн хэрэглэгдэх болсон байна. Эрх зүй ба эдийн засгийн ухааны тулгуур ойлголтуудыг давын өмнө орчуулан хэвшүүлэх нь зүйтэй. Тухайлбал, costs and benefits (rap, олз), transaction cost (хэлцлээс үүсэх rap), efficiency (үр ашиг), opportunism (шударга бусаар ашиг олох), profit-seeking behavior (ашигийн төлөө зан үйл) гэх мэт.

Манай иргэний эрх зүйн нэр томьёоны санд хараахан орж амжаагүй байгаа REMEDY хэмээх үгийг тайлбарлаа, Эрх нь зөрчигдсөн этгээд өөрийгөө хамгаалах хуулиар зөвшөөрөгдсөн арга хэлбэрийг remedy гэдэг. Жишээ нь, гэрээний нэг тал үүргээ нойчтой зөрчсөн бол нөгөө тал нь гэрээг цуцлаж болдог. Энэ тохиолдолд гэрээ цуцлах нь нэг төрлийн remedy болно. Харьцуулсан иргэний эрх зүйн энэ тулгуур ойлголтыг Монгол хэлний үг хэллэгээр дүйлгэж орчуулах нэн шаардлагатай байна.

Манай эрх зүйн тогтолцоонд үүсч тогтсон зарим өвөрмөц онцлог нэр томьёог англиар хэрхэн орчуулж болох талаар саналаа хэлье. Үүнд: хэрэг бүртгэх ажиллагаа (primary investigation), мөрдөн байцаах ажиллагаа (secondary investigation), шүүхийн бие даасан байдал (the autonomy of the judiciary), шүүгчийн хараат бус байдал (the independence of judges), эрх зүйн зохицуулалт (legal regulation), эрх зүйн орчин (legal framework), хууль тогтоомж (legislation), хууль (law, statute), журам (procedure), дүрэм (charter), хэм хэмжээний акт (a piece of delegated legislation (эсвэл secondary legislation, subordinate legislation)).

Хуульчдын байнгын анхаарлын төвд байх ёстой нэг асуудал бол хууль зүйн нэр томьёог нэг мөр болгож цэгцлэх явдал билээ.

Монгол Улсын Иргэний эрх зүйд хэрэглэдэг зарим чухал ойлголтыг харьцуулсан эрх зүйн үүднээс судлахад гадаадын, ялангуяа, англи хэлээр дүйх ойлголт, нэр томъёог мэдэх шаардлага гардаг. Англи хэлэнд хамгийн түгээмэл хэрэглэдэг бөгөөд ойролцоо ойлголтуудыг ялгаж нэрлэсэн зарим нэр томъёог эрх зүй судалж буй оюутан залууст тус болох буйзаа хэмээн дор толилуулав.

Д/д	Нэр томъёо /Монгол/	Англи
1.	компани	company / corporation
2.	нөхөрлөл	partnership
3.	хоршоо	cooperative
4.	хуулийн этгээд	legal person
5.	хэлцэл	juristic act / juridical act
6.	гэрээ	contract
7.	өмч	property
8.	хөрөнгө	asset
9.	өмчлөл	ownership
10.	эзэмшил	possession
11.	үүрэг	obligation
12.	эрх	right
13.	үүргийн гүйцэтгэл	performance of obligation
14.	үүрэг гүйцэтгэгч	obligor / debtor
15.	үүрэг гүйцэтгүүлэгч	obligee / creditor
16.	холимог гэрээ	mixed contract
17.	гэрээний үүрэг	contractual obligation
18.	ажил гүйцэтгэх гэрээ	contract of work
19.	хөдөлмөрийн гэрээ	employment contract
20.	даалгаврын гэрээ	contract of mandate
21.	төлөөлөлт	representation / agency
22.	түрээсийн гэрээ	contract of lease
23.	худалдах, худалдан авах гэрээ	contract of sale
24.	эрх шилжүүлэх	transfer of rights
25.	хохирол	damages
26.	хохирлын хэмжээ	measure of damages
27.	гэм хор	delict / tort
28.	хариуцлага	liability
29.	гэм буруу	fault
30.	гэм хор учруулагч	tortfeasor
31.	бусдын үүргийг даалгаваргүйгээр гүйцэтгэх	benevolent intervention in another's affairs
32.	үндэслэлгүйгээр хөрөнгөжих	unjust / unjustified enrichment
33.	хууль бус	unlawful / illegal
34.	гэрээ байгуулах санал	offer
35.	саналын хариу	acceptance
36.	ердийн боломжит	reasonable
37.	өв залгамжлал	succession





Энэхүү Монгол Улсын хууль 4 боть эмхтгэлд 2009 оны 12 дугаар сар хүртэлх хугацаанд орсон хуулийн бүх нэмэлт, өөрчлөлтийг эмхтгэтгэж гаргалаа.

Монгол Улсын хууль 4 боть эмхтгэлийг хэрэглэхэд хялбар, цаашид нэмэлт, өөрчлөлтийг оруулан сольж болохуйц сугалбар хуудас, төмөр цоожлогч бүхий хатуу хавтастайгаар хэвлэсэн.

Дээрх 4 ботид цаашид орох өөрчлөлтийг жилд хоёр удаа нэг багц болгон хэвлэж захиалгын дагуу түгээх юм.

Монгол Улсын хууль 4 боть эмхтгэлийн 2009 оны өөрчлөлтийн багцыг бэлтгэн хэвлэж Та бүхэнд хүргэхэд бэлэн болоод байгаа тул тус 4 боть эмхтгэлээс худалдан авсан, байгууллага, иргэд манайд хандан өөрчлөлтийн багцыг худалдан авна уу.


Үнэ: 15 000 төгрөг, Дансны дугаар: Төрийн сан-900012009

Та бүхэн дээрх 4 боть эмхтгэл болон, эдгээр ботиудын өөрчлөлтийн багцыг захиалан авахыг хүсвэл доорхи хаяг, утсаар хандана уу.

**Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Сүхбаатарын талбай 7, Хууль зүйн үндэсний хүрээлэн
Утас: 315736, 315735, 1982, 8800-7557
Факс: 315735**




Монгол Улсын хууль тогтоомжийн үндсэн эх сурвалж болох Үндсэн хуулийг (1992 он) уйгаржин монгол бичиг-кирилл үсгээр бичиж судар хэлбэрээр хэвлүүлэн, баринтагаан бүтээжээ. Эртний Энэтхэг, Төвдөөс дамжин Монголд орж ирсэн гэх судрын загварыг ашиглан эх нутгийнхаа хөх тэнгэрийг бэлгэдэн баринтагны гадрыг хөх торгоор, газар нутгаа дүрсэлэн дотрыг ногоон торгоор хийн, баринтагны оосорт шинээр зоос үйлдэн бүтээжээ.



хууль зүйн үндэсний хүрээлэн
www.nli.gov.mn

Хууль зүйн үндэсний хүрээлэн, Монгол Улсын Их сургууль, Шинжлэх ухааны академиас эрхлэн хэвлүүлсэн Монголчуудын хэрэглэж ирсэн үсэг бичгээр бүтээсэн Монгол Улсын Үндсэн хуулийг танд толилуулж байна. "Монгол Улсын Үндсэн хууль"-ийн эхийг Монголчуудын хэрэглэж ирсэн зургаан гол зүйл бичиг үсэг, арван зүйл тиг хэлбэрээр бүтээжээ. Энэхүү номд хэрэглэж ирсэн бичиг үсгийн дараахь дарааллаар оруулсан байна.

- Их Монгол Улсын үеийн монгол бичгийн тиг;
- Монгол бичгийн модон барын тиг;
- Монгол бичгийн бийрийн тиг;
- Монгол бичгийн эвхмэл тиг;
- Монгол бичгийн төмөр барын тиг;
- Монгол дөрвөрлжин бичиг;
- Тод бичиг;
- Соёмбо бичиг;
- Латин бичиг;
- Монгол кирилл бичиг.



1924, 1940, 1960, 1992 оны Үндсэн хууль тэдгээрт орсон нэмэлт, өөрчлөлтийг эмхтгэн Англи хэлээр орчуулан хэвлүүлжээ. Үг бүтээлд 1924, 1940, 1960, 1992 оны Үндсэн хуулийн жинхэнэ анхаагч эхийг хуулбар хувь, тухайн цаг үед хэвлэгдэн гарч байсан анхны хэвлэмэл хуулбарыг багтаасан байна.